



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭ**

2024

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

X сар

Улаанбаатар хот



Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

Судалгааны багийн гишүүд:

М.Түвшинжаргал


Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (Ph.D.)

О.Энххүслэн

Хувийн эрх зүйн секторын Эрдэм
шинжилгээний ахлах ажилтан (LL.M.)

Б.Ариунжаргал

Эрүүгийн эрх зүй, криминологийн
секторын Эрдэм шинжилгээний ажилтан
(LL.M.)



ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
УДИРТГАЛ	5
НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ	10
ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ	11
2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	11
2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	12
2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	12
2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	13
2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	13
ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ.....	15
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	17
3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	33
3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	76
3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	78
3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	109
ДӨРӨВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ.....	111
ТАВ. СУДАЛГААНЫ ЭХ СУРВАЛЖ.....	116



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улсын
АТГ	Авлигатай Тэмцэх Газар
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНЭсУ	Бүгд Найрамдах Эстони Улс
ЕП	Европын Парламент
ЕХ	Европын Холбоо
ЗХШХШТХ	Захиргааны Хэрэг Шүүхэд Хянан Шийдвэрлэх тухай Хууль
ИХШХШТХ	Иргэний Хэрэг Шүүхэд Хянан Шийдвэрлэх тухай Хууль
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман улс
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ОУБХ	Олон Улсын Бага Хурал
УДШ	Улсын Дээд Шүүх
ХЗДХС	Хууль зүй, Дотоод хэргийн Сайд
ШССМХ	Шүүхийн Сургалт, Судалгаа Мэдээллийн Хүрээлэн
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий Газар
УИХ	Улсын Их Хурал
ЭХАШШ	Эрүүгийн Хэргийн Анхан Шатны Шүүх
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
CERT	Computer Emergency Response Team
CSIRT	Computer Security Incident Response Team
CSIRT	Electronic Case File
NYSCEF	New York State Courts Electronic Filing System



УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 18 дугаар тогтоолын 1-д хүний эрхийг хангахтай холбоотой 14 асуудлыг судалж, холбогдох хуулийн төслийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгод нийцүүлэн боловсруулж 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлд “3(b). Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр өмгөөлүүлэх ажлаа бэлтгэх хүрэлцээтэй хугацаа, бололцоотой байх, сонгож авсан өмгөөлөгчтэйгээ харилцах баталгаагаар хангагдах эрхтэй” гэж заасан¹.

НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн дүгнэлт болон Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 22 дахь илтгэлд тусгасан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлага тулгараад байна.

Тухайлбал, НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгээс өгсөн дүгнэлтэд “Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 10 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 (1) ба 14 (3) (b) зүйлд нийцүүлэн өмгөөлөгч шүүхийн өмнөх шатны ажиллагаа зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бүх шатанд хэргийн материалтай танилцах адил тэгш эрхээр хангах, өмгөөлөгч хэргийн материалыг хуулбарлах боломжийг олгох,” гэж зөвлөсөн².


Улсын Их Хурлын 2024 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 05 дугаар тогтоолын 1 дэх заалтын 1 дүгээрт “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага хоорондоо цахим хэлбэрээр харилцах боломжийг олгосон зохицуулалтыг Иргэний хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид тусгах талаар хуулийн төсөл боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх,” гэж тусгасан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дараах практик хэрэгцээ, шаардлага тулгараад байна.

-Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 10 дугаар дүгнэлтэд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг үндэслэлгүй хязгаарласан шинжгүй, хууль зүйн процессын суурь зарчмуудад нийцсэн байх ёстой. Энэ утгаараа хуульд гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа этгээдийн эрх зүйн байдлыг дээрх хуулиар нарийвчлан зохицуулж өгөөгүйн улмаас

¹ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 14 дүгээр зүйл 3 дахь хэсэг.

² Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг: Монголд хийсэн айлчлалын урьдчилсан дүгнэлт, https://www.ohchr.org/sites/default/files/documents/issues/detention-wg/country-visit/2022-10-13/EOM_statement_Visit_Mongolia_14Oct2022_Mongolian.pdf



тухайн этгээдээс гэрчийн мэдүүлэг авч, түүний эрхийг хөндөх байдал гаргахаар байгааг хууль тогтоогч анхаарч, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байна..." гэж дүгнэсэн байдаг.

Хүнийг гэмт хэрэгт сэжиглэх илэрхий, хангалттай үндэслэл байсаар атал гэрчээр мэдүүлэг авсаны дараа баривчлах, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэний дараа сэжигтэн болгох нь Үндсэн хуулиар баталгаажсан "өөрийгөө өмгөөлөх" эрх, "өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно" гэж заасантай нийцэхгүй тул гэрчээр мэдүүлэг авч байх үед гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл тогтоогдвол мэдүүлэг авах ажиллагааг зогсоож, сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг хуульд заасны дагуу явуулах зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

-Практикт хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд мэдүүлэг авах ажиллагааг өмгөөлөгчгүйгээр явуулж, хууль бусаар хэрэг хүлээлгэх, өөрийнх нь эсрэг мэдүүлэг авах тохиолдлууд цөөнгүй гарч байгаатай холбоотойгоор сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах тохиолдолд өмгөөлөгч заавал оролцуулах асуудлыг хуулиар баталгаажуулах шаардлага тулгараад байна.

-Шүүх хуралдаан хойшилж буй шалтгаан нөхцөлийн дийлэнх нь өмгөөлөгчтэй холбоотой болох нь шүүхийн практикт хийсэн судалгаагаар харагддаг бөгөөд шүүх хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа хойшлуулж байгаа нөхцөл байдлыг хязгаарлах үүднээс өмгөөлөгчийн хариуцлагатай холбоотой асуудлыг хуульчлах шаардлагатай байна.

Түүнчлэн шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг хянан хэлэлцэх үндсэн шүүх хуралдааны бэлтгэлийг талуудын оролцоотой хангаж, шүүх хуралдаан хойшлогдох явдлыг багасгах зорилгоор 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах журмыг шинээр хуульчилсан бөгөөд мөн хуулийн 33.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт "Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцох хүсэлт гаргасан тохиолдолд хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулж болно. Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй." гэж заасан.

Ийнхүү шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүх нэг удаа явуулах агуулгаар дээрх заалтыг хуульчилсан боловч хуулийн буруу хэрэглээ тогтож, оролцогч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг удаа дараа хойшлуулах шалтгаан болсоор байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Шүүх хуралдааныг хойшлуулахад талуудын санал, хүсэлтийг харгалзан дараагийн шүүх хуралдааны товыг тогтоож, хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг авна." гэж заасан ба шүүхийн практикт шүүх хуралдааныг 1 сар, түүнээс илүү хугацаагаар хойшлуулах явдал гарсаар байна.

Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх ашигт сөргөөр нөлөөлж байх тул шүүх хуралдааныг түргэн, шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

-Тухайн хэргийн ээдрээ төвөгтэй байдал, эсхүл ажиллагаа ихтэй, олон яллагдагчтай, эсхүл олон үйлдэлтэй зэрэг нөхцөл байдлыг харгалзан шаардлагатай тохиолдолд мөрдөн байцаалт явуулах хугацааг сунгаж болох зохицуулалтыг хуульчилсан боловч олон оролцогчтой хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг хэрхэн, ямар журмаар явуулах нь тодорхойгүй байх тул нарийвчлан зохицуулах



шаардлагатай байна.

-Хавтаст хэргийг цахимжуулах, цахим хэрэгсэл ашиглаж нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, үнэлэх хэрэгцээ, шаардлага нь өнөө цагт тулгамдсан асуудал болж байгаа бөгөөд хавтаст хэргийг цахимжуулах нь цаасан суурьтай бичиг баримт, нотлох баримтыг боловсруулахад шаардагдах зардал, цаг хугацааг бууруулах ач холбогдолтой юм.

Иймд тус ажиллагааг процессжуулах, хуульчлах хэрэгцээ, шаардлага тулгараад байна. Тухайлбал, олон оролцогчтой хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд прокурорын яллах дүгнэлтийг хуулбарлан гардуулж өгөхөд ихээхэн зардал, цаг хугацаа шаардагддаг.


-Шүүхийн шийдвэрийг оролцогчид гардуулах харилцааг журамласан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.5 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, 36.13 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 39.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 40.8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн зохицуулалтаас үзэхэд Төрийн болон албаны нууц мэдээлэл агуулсан шийдвэрийг оролцогчид хэрхэн танилцуулах, эсхүл гардуулах асуудлыг хуульд нарийвчлан зохицуулаагүй байна.

-Мөрдөн шалгах ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдэж цагдан хоригдсон тохиолдолд цагдан хорих хугацааг тусад нь тоолох эсэх нь тодорхой зохицуулагдаагүй байна.

-Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг хавтаст хэрэгт нотлох баримтаар хавсаргаж, хэргийн хамт хадгалагддаг. Ингэхдээ хэргийн оролцогчоос мэдүүлэг авах процессыг бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг ямар хугацаанд хэрхэн хадгалах талаар зохицуулаагүй байна. Мэдүүлгийн тэмдэглэлүүд дууны болон дуу-дүрсний бичлэгээс зөрөх тохиолдол практикт гардаг бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.7 дугаар зүйлийн 2-т “Мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгагдсан нөхцөл байдал нь дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгээс зөрсөн тохиолдолд шүүх, прокурор дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг нотлох баримтаар тооцно.” гэж заасан тул дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг тодорхой хугацаагаар хадгалах зохицуулалтыг хуульчлах шаардлагатай байна.

-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хамаарах Өмгөөллийн тухай хуульд заасан өмгөөлөгчийн зарим эрх процессын хуульд тодорхой тусгагдаагүйгээс мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэгчийн зүгээс хуулийн зохицуулалтыг зөрүүтэй ойлгох, хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх, хэргийн бодит байдлыг тогтооход чухал ач холбогдол бүхий баримтыг шүүхэд гарган өгөх боломжгүй болох тохиолдлууд гарч байх тул эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн эрх, үүргийг Өмгөөллийн тухай хуулийн зохицуулалттай уялдуулан нарийвчлан тусгах шаардлагатай байна.

-Хүний эрхийн Үндэсний Комиссын хийсэн судалгаагаар шүүхийн хэлэлцүүлэг үр дүнтэй явагддаггүй, шүүх мэтгэлцээнд үндэслэсэн хөндлөнгийн шийдвэр гаргадаггүй, өмгөөлөгчийн оролцоо хангалтгүй байгаа нь тогтоогдсон. Тодруулбал, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацаа сунгах эсэхийг шийдвэрлэх шүүхийн хэлэлцүүлэгт “өмгөөлөгчийн оролцоо, мэтгэлцэх зарчим хангагдаж байгаа эсэх” талаар судалгаанд оролцсон шүүгч, прокуроруудын 46 хувь нь “дунджаас дээгүүр” гэж хариулсан бол “хангалттай сайн” гэж шүүгчдийн 3.8 хувь,



прокуроруудын 10.3 хувь нь тус тус үзжээ. Харин өмгөөлөгчдийн 72.1 хувь нь “өмгөөлөгчийн оролцоо туйлын хангалтгүй” байдаг талаар дурджээ.³

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хэлэлцүүлэгт оролцох өмгөөлөгчийн оролцоо хангалтгүй, өмгөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлж чадахгүй байгаа шалтгааныг “цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахаар гаргаж буй саналын үндэслэл, түүнийг нотолсон нотлох баримттай өмгөөлөгчийг танилцуулдаггүй, талуудыг мэтгэлцэх боломж олгодоггүй” гэж тайлбарласан байна.

Түүнчлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг ихэвчлэн мөрдөн байцаалтын шатанд авдаг бөгөөд мөрдөн байцаалтын ажиллагаа дуусаагүй гэх шалтгаанаар цагдан хорих арга хэмжээ авах, сунгах, өөрчлөх үндэслэл болж буй нотлох баримтыг өмгөөлөгчид танилцуулдаггүй, мөрдөн шалгах ажиллагааны нууц алдагдах гэсэн шалтгаанаар хаалттай бөгөөд эргэлзээтэй байдлаар шүүхийн хэлэлцүүлэг явагдаж байгаа нь НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлтэд мөн дурдагдсан.


Иймд мөрдөн шалгах ажиллагаанд хүний эрхийн зөрчил гарахаас урьдчилсан сэргийлэх зорилгоор сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авах болсон үндэслэлд хамаарах нотлох баримттай танилцуулах замаар шүүхийн хэлэлцүүлгийг талуудын мэтгэлцээний үндсэн дээр явуулах эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай байна.

-Анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн шүүгдэгчийн хувьд прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийн хүрээнд явагдахаар хуульчлагдсан бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа прокурорын удирдлага, хяналтад явдаг, өмгөөлөгчийн зүгээс гаргадаг нэмэлт нотлох баримт цуглуулахтай холбоотой хүсэлтийг хангалттай шийдвэрлэдэггүй тул өмгөөлөх тал шүүхэд нэмэлт нотлох баримт гаргаж өгөх боломжийг нээх нь зүйтэй байна.

-Хуульд ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхийн хэрэгжилтийг бодитойгоор хангах хүрээнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татагдсан тогтоолын хувийг авах эрхийг яллагдагчид олгох шаардлагатай байна. Олон үйлдэлтэй, мөн Эрүүгийн хуульд заасан олон зүйл хэсэгт буруутгагдаж байгаа хүний тухайд яллагдагчаар татах тогтоол хэдэн зуун хуудастай, шууд танилцаж, юунд буруутгагдаж байгаагаа ойлгоход төвөгтэй байдгаас хуулиар баталгаажсан эрхийг нь хангах боломж хязгаарлагддаг.

-Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокуророос гарч байгаа, тэр тусмаа мөрдөн шалгах ажиллагаа явуулах, нотлох баримттай холбоотой шийдвэрүүд хууль зүйн болон нотолгооны үндэслэлтэй байх зайлшгүй шаардлагатай. Дээрх асуудлаар хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэхдээ прокурор, мөрдөгч хангаагүй, татгалзсан үндэслэлээ тодорхой заахгүй, зөвхөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байгаа талаарх хариу өгч хэвших хандлагатай байна. Энэ нь Үндсэн хуульд заасан “... албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага албан тушаалтан нь иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй” гэсэн заалтыг бодитоор хэрэгжих боломжийг хааж, үндэслэлгүй, ёс төдий, ажил хэрэгч бус хандлагыг бүрдүүлж байна.

³ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, URL: <https://nhrcm.gov.mn/assets/img/58c1302622c8c88d036544f656fdff5d.pdf>



Иймд хүсэлтийг хангахаас татгалзаж байгаа үндэслэлийг тухайн шийдвэртээ тодорхой тусгах зохицуулалтыг хуульчлах шаардлагатай байна.

Дээр дурдсан хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Энэхүү судалгааны зорилго нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал /цаашид “Аргачлал” гэх/-ын дагуу тус “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийн үр нөлөөг үнэлэхэд оршино. Ийнхүү үнэлэхдээ “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийн зохицуулалт, агуулга нь өөрчлөлтийн үзэл баримтлал, зорилгод нийцэж буй эсэх, зохион байгуулалтыг өөрчилж буй зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх, шинээр тусгагдсан зохицуулалтууд нь хүлээн зөвшөөрөгдсөн эсэх, хуулийн төсөл нь хууль зүйн техникийн хувьд алдаатай эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгсөн болно.

“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасны дагуу дараах үе шаттайгаар үнэллээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ сонгох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.



НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 6 шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
4. Ойлгомжтой байдал
5. Зардал⁴
6. Харилцан уялдаа

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн. Тухайлбал,

1. Хуулийн төслийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах зохицуулалт, сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголттой холбоотой зохицуулалт, шүүх хуралдааныг хойшлуулахтай холбоотой зохицуулалт нь өөрчлөлтийн үзэл баримтлал, зорилго, хууль батлагдах хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх;
2. Хуулийн төсөлд өөрчлөгдсөн зохицуулалт болох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах зохицуулалт, сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголттой холбоотой зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх;
3. Хуулийн төсөлд тусгагдсан нэр томъёонууд нь ойлгомжтой эсэх, мөн хууль зүйн техникийн алдаа бий эсэх;
4. Хуулийн төсөлд шинээр тусгагдсан бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн талаар зохицуулалт, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь төрийн болон албаны нууцтай холбоотой зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх;
5. Хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх зэргийг шалгах;

⁴ Хуулийн төслийн “Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийн зардлын тооцоо сэдэвт судалгаа гүйцэтгэсэн байх тул дэлгэрэнгүйг тус судалгаанаас үзнэ үү.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авлаа. Өөрөөр хэлбэл, тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төсөлд шинээр орж буй, голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож үр нөлөө үнэлнэ.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсгэж болохуйц, эсхүл тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой, мөн тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинээр үүрэг хүлээлгэж байгаа, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинэ хэлтэс, нэгж байгууллага бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөө тооцох хэсгээ тогтоосон.

Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт бүрээр тус бүрд нь авч үзье.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтээр хууль тогтоомжийн төслийн зохицуулалтыг шалгаж, үр нөлөөг нь үнэлэх бол тухайн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн эсхүл түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зүйл, заалтыг сонгоно. Үүний тулд тухайн төслийн үзэл баримтлалтай сайтар танилцаж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг хэрхэн тодорхойлсон, энэхүү үндэслэл, шаардлага нь зорилгыг хэрхэн илэрхийлж байгаа эсэхийг судалдаг.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс дээрх асуудлын дагуу зорилгодоо хүрсэн эсэхийг “зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах байдлаар үр нөлөөг тооцно. Үүнд:

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл заалт
1.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах зохицуулалт нь зорилгод хүрч байгаа эсэх	Төслийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг Төслийн 1.16 дугаар зүйл
2.	Хуулийн төслийн сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголттой холбоотой зохицуулалт ЭХХШТХ-ийн зорилгод хүрч байгаа эсэх	Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.38 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 4.7 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 10 дахь хэсэг Төслийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэг Төслийн 31.2 дугаар зүйлийн 9-12 дахь хэсэг Төслийн 31.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг Төслийн 31.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Төслийн 31.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг
3.	Шүүх хуралдааныг хойшлуулахтай холбоотой зохицуулалт нь нэмэлт, өөрчлөлтийн зорилгод нийцэж буй эсэх	Төслийн 34.9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг

		Төслийн 34.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Төслийн 34.16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг Төслийн 34.16 дугаар зүйлийн 9 дэх хэсэг Төслийн 34.19 дүгээр зүйлийн 1.9 дэх заалт Төслийн 35.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг
--	--	--

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг сонгон авдаг. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах агуулгын хүрээнд зохицуулалтуудыг сонгон “Практикт хэрэгжих боломж” гэх шалгуурын үр нөлөөг тооцсон болно.

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл заалт
1.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх	Төслийн 1.16 дугаар зүйл Төслийн 11.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг Төслийн 11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг
2.	Хуулийн төслийн сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголттой холбоотой зохицуулалт ЭХХШТХ-ийн практикт хэрэгжих боломжтой эсэх	Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.38 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 4.7 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 10 дахь хэсэг Төслийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэг Төслийн 31.2 дугаар зүйлийн 9-12 дахь хэсэг Төслийн 31.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг Төслийн 31.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Төслийн 31.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд хууль тогтоомжийн төслөөс тодорхой заалтыг, эсхүл бүхэлд нь сонгон авч шалгах боломжтой. Хууль тогтоомжийн төсөлд хэрэглэсэн нэр томъёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг шалгаж үнэлнэ. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс нэр томъёоны тодорхойлолттой холбоотой хэсгийг болон хууль зүйн техникийн алдаатай зохицуулалтыг сонгон авч үнэллээ.

№	Ойлгомжтой байдал	Сонгосон зүйл заалт
---	-------------------	---------------------

1.	Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг үнэлэх	Хуулийн төслийн бүх зүйл, заалт
----	---	---------------------------------

2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал


“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэх байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлэх учраас тодорхой байгууллага, иргэний эрх ашиг хөндөгдөж буй зохицуулалтыг сонгон авах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, тухайн төслөөр зохицуулж буй эсхүл шинээр оруулсан зохицуулалтыг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх эсэхийг үнэлэх учраас иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын эрх үүрэг, тэдгээрийн ашиг сонирхол хөндөгдөх зохицуулалтыг сонгон авлаа.

№	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Сонгосон зүйл заалт
1.	Бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн талаар зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх	Төслийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг
2.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь төрийн болон албаны нууцтай холбоотой зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх	Төслийн 32.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэг Төслийн 36.13 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг Төслийн 3.2 дугаар зүйл Төслийн 31.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах учраас шалгах хэсгээ сонгохдоо хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг бус тухайн төслийг бүхэлд нь сонгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд бид тухайн зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцтэй байдлыг шалгадаг.

№	Харилцан уялдаа	Сонгосон зүйл заалт
1.	Хуулийн төслийн зүйл, заалт хуулийн төслийн болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа эсэх	Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.38 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 4.7 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 10 дахь хэсэг Төслийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэг Төслийн 31.2 дугаар зүйлийн 9-12 дахь хэсэг Төслийн 31.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг Төслийн 31.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Төслийн 31.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг



2.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах зохицуулалт нь харилцан уялдаатай эсэх	Төслийн 1.16 дугаар зүйл Төслийн 11.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг Төслийн 11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг
----	--	--


ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Тохирох шалгах хэрэгсэл нь урьдчилан тогтоосон шалгуур үзүүлэлтээс шалтгаалан харилцан адилгүй байх бөгөөд шалгуур үзүүлэлт тус бүрд нийцсэн дараах шалгах хэрэгслийн дагуу үнэлгээ өгөхөөр тогтлоо.

Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл
Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх
Практикт хэрэгжих боломж	Практикт турших
Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах
Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх
Харилцан уялдаа	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Өмнөх үе шатуудад журмын төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтсон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Төслийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг Төслийн 1.16 дугаар зүйл Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.38 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 4.7 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 10 дахь хэсэг Төслийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэг Төслийн 31.2 дугаар зүйлийн 9-12 дахь хэсэг Төслийн 31.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг Төслийн 31.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Төслийн 31.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 34.9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 34.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Төслийн 34.16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг Төслийн 34.16 дугаар зүйлийн 9 дэх хэсэг Төслийн 34.19 дүгээр зүйлийн 1.9 дэх заалт Төслийн 35.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Хуулийн төслийн зорилго, үзэл баримтлал, хууль боловсруулах хэрэгцээ, шаардлага болон тус хуулийн хуулийн төслийн зорилт, холбогдох зохицуулалтын зорилго, үзэл баримтлалд дүн шинжилгээ хийх
2.	Практикт хэрэгжих боломж	Төслийн 1.16 дугаар зүйл Төслийн 11.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг Төслийн 11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.38 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 4.7 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 10 дахь хэсэг Төслийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэг Төслийн 31.2 дугаар зүйлийн 9-12 дахь хэсэг Төслийн 31.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг Төслийн 31.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Төслийн 31.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг	Практикт хэрэгжих байдлыг баримт, бичигт дүн шинжилгээ хийх замаар хэрэгжих эсэхийг судлах
3.	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл	Тодорхойлоогүй нэр томъёонуудыг тайлбарлах байдлаар санал болгох, хуулийн төсөл боловсруулах нийтлэг шаардлагад нийцүүлэх саналыг гаргах



4.	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Төслийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 32.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэг Төслийн 36.13 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг Төслийн 3.2 дугаар зүйл Төслийн 31.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх асуудлын хүрээнд баримт бичгийн судалгаа хийж дүгнэх
5.	Харилцан уялдаа	Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.38 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 4.7 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 10 дахь хэсэг Төслийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэг Төслийн 31.2 дугаар зүйлийн 9-12 дахь хэсэг Төслийн 31.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг Төслийн 31.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Төслийн 31.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 1.16 дугаар зүйл Төслийн 11.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг Төслийн 11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг	Харилцан уялдааг судлах, ингэхдээ холбогдох хуулийн зохицуулалтуудад дүн шинжилгээ хийх

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэлэв.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Зорилгод хүрэх байдал”-ыг үнэлэхдээ хуулийн төсөл нь хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх, хуулийг батлан хэрэгжүүлснээр хүрэх үр дүн тодорхой байдлаар томъёологдож чадсан эсэхийг тухайн хуулийн төсөл, дээд эрэмбийн хуулийн үзэл баримтлал, түүний агуулгыг хуулийн төслийн үр нөлөөг үнэлж буй зохицуулалттай харьцуулан дүн шинжилгээ хийдэг. Энэ хүрээнд хуулийн төслийн холбогдох зохицуулалтад дүн шинжилгээ хийнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах зохицуулалт нь зорилгод хүрч байгаа эсэхэд хийсэн дүн шинжилгээ
--

Төслийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөтлөх баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байна.” гэх нэмэлтийг оруулсан байна. Мөн түүнчлэн төслөөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.16 дугаар зүйлийг нэмж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулахыг дараах байдлаар зохицуулжээ.

- Шүүх хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах, баримт бичиг хүлээн авах, хүргэх ажиллагааг цахим платформ ашиглан цахимаар явуулж болно.

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хавтаст хэрэг нь шүүхийн цахим платформын техникийн шаардлагад нийцсэн байна.

- Хэргийн оролцогчтой цахимаар харилцахад төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, мэдэгдэл хүргэх систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, мэдэгдэл хүргэх системд иргэний үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, тухайн этгээдийг таньж, баталгаажуулах боломжтой бусад цахим систем, өмгөөлөгчийн Монголын Өмгөөлөгчдийн Холбооны цахим системд бүртгүүлж холбогдсон цахим шууданг ашиглана.

- Өмгөөлөгч тайлбар, гомдол, хүсэлт зэрэг баримт бичгийг цахим баримт бичгээр хүргүүлнэ. Техникийн шалтгаанаар ийнхүү хүргүүлэх боломжгүй тохиолдолд цаасан баримт бичгээр ирүүлж болох бөгөөд энэ тохиолдолд техникийн боломжгүй байсан шалтгаанаа нотолж цахим баримт бичгээр нөхөн ирүүлж болно.

- Мөрдөгч, прокуророос шүүхэд хүргүүлэх эрүүгийн хэрэг, баримт бичгийг шүүхийн цахим платформын техникийн шаардлагад нийцүүлж цахим баримт бичгийн хэлбэрт хөрвүүлж, албан тушаалтны цахим гарын үсгээр баталгаажуулан хүргүүлнэ. Шүүхийн шатанд цахим баримт бичгээр хүргүүлэх боломжгүй цаасан баримт бичгийг шүүхийн захиргааны ажилтан цахим баримт бичигт хөрвүүлнэ.

Энэ тухай тус хуулийн дэлгэрэнгүй танилцуулгад дараах байдлаар авч үзсэн байна.

Хавтаст хэргийг цахимжуулах, цахим хэрэгсэл ашиглаж нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, үнэлэх хэрэгцээ, шаардлага нь өнөө цагт тулгамдсан асуудал болж байгаа бөгөөд тус ажиллагааг процессжуулах, хуульчлах хэрэгцээ, шаардлага тулгараад байна. Тухайлбал, олон оролцогчтой хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд прокурорын яллах дүгнэлтийг хуулбарлан гардуулж өгөхөд ихээхэн зардал, цаг хугацаа шаардагддаг. Иймд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөтлөх баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байхаар тусгаж, шүүх хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах,
--

баримт бичиг хүлээн авах, хүргэх ажиллагааг цахим платформ ашиглан цахимаар явуулж болохоор тусгалаа.

Хавтаст хэргийг цахимжуулах нь цаасан суурьтай бичиг баримт, нотлох баримтыг боловсруулахад шаардагдах зардал, цаг хугацааг бууруулах ач холбогдолтой юм⁵.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах болон цахим нотлох баримтыг бий болгох талаар хэрэгцээ, шаардлага манай улсад бий болоод байна. Үүнийг нарийвчлан авч үзье.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах талаар хэрэгцээ, шаардлага:

Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал болон дэлхий нийтээрээ цахим шилжилтэд шилжиж буй өнөө үед харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшил нь хөгжлийн хурдасгуур, цахим үндэстнийг цогцлоон хөгжүүлэх гол хүчин зүйл болж байна⁶. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 3-т “...Шүүх улсын төсвөөс санхүүжинэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана...” гэж, мөн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжихээр заасан. Ингэхдээ 2021-2030 он төрийн албаны хувьд төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх үе гэж тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, Монгол Улс ойрын жилүүдэд төрийн алба, мөн түүний нэг төрөл болох шүүхийн албаны үр дүн, үр нөлөөг дээшлүүлэхийг зорьж байна. Төрийн үйлчилгээг ийнхүү үр дүн, үр нөлөөгөөр (output/outcome) хэмжиж дээшлүүлэх нь New public management буюу нийтийн албаны шинэ менежментийн ухаанаас улбаатай гэж үзэх бөгөөд энэ нь бизнесийн салбарын удирдлагын “багаар ихийг хийх” (do more with less) -тэй холбоотой зарим арга зүйг төрийн буюу нийтийн албанд нэвтрүүлж үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэжээ⁷. Энэ хүрээнд шүүхийн цахимжилтын асуудал нэн тэргүүнд хөндөгдөж байна.

Түүнчлэн, шүүхийн цахимжилт нь дан ганц шүүхийн асуудал биш шүүх эрх мэдлийн бүхий л байгууллага, цагдаа, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, улсын бүртгэлийн газар гэх мэт олон талын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох интеграци учир хууль, эрх зүйн орчинд ач холбогдол өгөх ёстой. Тодруулбал, иргэн, эрүү, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх процессын хуулиудад цахимаар мэдүүлэх, цахим нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, үнэлэх, цахим хавтаст хэрэг үүсгэх, цахимаар мэтгэлцэх эрх зүйн орчныг бүрдүүлж өгөх хэрэгцээ шаардлага тулгараад байна⁸.

Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн хэрэг, цагдан хорих гэх мэт асуудлыг цахимжуулах боломжтой. Гадаад орнуудын туршлагаас харахад процессын хуулиудад ерөнхий зохицуулалтыг тусгаж, нарийвчилсан зохицуулалтыг журам батлан хэрэгжүүлдэг туршлага нийтлэг байна. Манай улс хуулиндаа цахимаар


⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга, 2024

⁶ Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 5 сарын 18-ны өдрийн А/24 тушаалаар баталсан “Цахим үндэстэн” баримтлах чиглэл (2022-2027)

⁷ 2023 оны 3 сарын 23-24-ний өдөр зохион байгуулагдсан “Монгол Улсын Шүүхийн цахимжуулалт” ОУБХ-д Н.Отгончимэгийн хэлэлцүүлсэн “Шүүхийн санхүүжилтийн механизмыг шинэчлэх шаардлага” сэдэвт илтгэлээс.

<https://docs.google.com/document/d/10Dj6LDSgTdrjOyp8UkrRIZ0z3Bq-DyvcagLBsJSrEAW/edit>

⁸ Г.Даваадорж: Шүүхийн цахимжилтад хууль эрх зүйн орчин ус агаар мэт хэрэгтэй байна, https://www.judcouncil.mn/site/news_full/13818



мэдүүлэх, цахим хавтаст хэрэгтэй холбоотой ерөнхий зохицуулалтыг тусгах нь цаашдын шүүх болон бусад хуулийн байгууллагын цахимжилтад эергээр нөлөөлөх боломжтой⁹.

Улсын Их Хурлын Байнгын хороо 2015 онд “Шүүх хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн цахим нэгдсэн сүлжээ бүрдүүлэх тухай” 23 дугаар тогтоол гарсан. Энэ тогтоолыг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн яам, шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон ХБНГУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хамтран хэрэгжүүлсэн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах” төслөөс шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудыг нэгдсэн сүлжээнд холбосон¹⁰.

2020-2021 онд “Ковид-19” цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд шүүхээс хэрэг, нэхэмжлэл, гомдлыг цахимаар хүлээн авах, хэргийн оролцогчдыг цахимаар шүүх хуралдаанд оруулах, зарим нотлох баримтыг төрийн эрх бүхий байгууллагуудаас авах, солилцох зэргээр үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг цахимд шилжүүлэн, шүүн таслах ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулж байсан¹¹.


Өөрөөр хэлбэл, Коронавирус цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор шүүх эрх мэдлийн байгууллагын хүрээнд үүссэн шүүхийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, шүүхийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх, шүүхийн байранд аюулгүй байдлыг хангах, хамгаалах, удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ шүүхийн зарим үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн. Энэ нь шүүхийн ачаалал, цаг хугацаа, хөрөнгө санхүү, хүний нөөц, шүүх хурлын танхим зэрэг олон асуудлыг бууруулахад эерэг нөлөөлөл үзүүлж байсан тиймээс ч цаашид шүүхийн цахимжилтийн эрчимжүүлэх хэрэгцээ шаардлага байгааг практикт ажиллаж буй шүүх, прокурор, өмгөөлөгч, хууль сахиулах байгууллагын төлөөллүүд олон удаагийн хурал, сургалт, хэлэлцүүлгийн явцад хөндсөөр байна.

Энэ талаар сүүлийн жилүүдэд шүүхийн цахимжилт, цахим нотлох баримттай холбоотой олон улсын бага хурал, хэлэлцүүлэг, сургалтууд цөөнгүй зохион байгуулагдаж байгаагаас харж болох юм. Тухайлбал, 2022 оны 3 сарын 28, 29-ний өдрүүдэд АНУ-ын Элчин Сайдын яамны Нууц албанаас УЕПГ, АТГ, Цагдаагийн байгууллагын алба хаагчдад “Цахим нотлох баримт, криптовалюта” сэдэвт мэргэшүүлэх сургалт, 2023 оны 5 сарын 15-18-ны өдрүүдэд УЕПГ, АНУ-ын Хууль зүйн яамны Прокурорын хөгжил, туслалцаа, сургалтын газрын хамтын ажиллагааны хүрээнд “Дижитал нотлох баримт болон Зэрлэг ан амьтдыг худалдаалах, Мөнгө угаах гэмт хэргийг шалгаж шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт сургалт, 2023 оны 9 сарын 16-ны өдөр УДШ-ийн дэргэдэх ШССМХ-гээс Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн шүүгч нарт “Цахим нотлох баримт” сэдэвт сургалт, 2023 оны 3 сарын 2-ны өдөр “Шүүх эрх мэдлийн байгууллагуудын цахимжилт ба шинэчлэлт” сэдэвт хэлэлцүүлэг, 2023 оны 9 сарын 3-16-ны өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотод зохион байгуулагдсан “Мөнгө угаах гэмт хэрэг ба цахим нотлох баримт” сэдэвт сургалт, 2023 оны 3 сарын 23-24-ний өдрүүдэд “Монгол Улсын шүүхийн цахимжуулалт” ОУБХ, 2024 оны 3 сарын 25-28-ны өдрүүдэд Монголын Хуульчдын холбоо, АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран хэрэгжүүлж буй “US speaker”

⁹ Г.Даваадорж: Шүүхийн цахимжилтад хууль эрх зүйн орчин ус агаар мэт хэрэгтэй байна, https://www.judcouncil.mn/site/news_full/13818

¹⁰ Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын төсөлд хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ /Хөндлөнгийн судалгаа/, УБ, 2023, 86-87 дахь тал.

¹¹ Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын төсөлд хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ /Хөндлөнгийн судалгаа/, УБ, 2023, 87 дахь тал.



хөтөлбөрийн хүрээнд “Шүүхийн цахимжилт ба тулгамдсан асуудал” сэдэвт хэлэлцүүлэг тус тус зохион байгуулагдсан байна.

Үүнээс 2023 оны 3 сарын 23-24-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Монгол Улсын шүүхийн цахимжуулалт” ОУБХ-д хэлэлцүүлсэн зарим илтгэлүүдээс онцлох зүйлийг дурдвал:

Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар “Монгол Улсын Шүүх эрх мэдлийн байгууллага болон бусад холбогдох байгууллагуудын цахимжуулалт, уялдаа холбоог хангах нь” сэдэвт илтгэлдээ “...Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай буюу цахим хэлбэрээр хүргэх нөхцөлийг бүрдүүлж, цахим гэрээ, хэлцлийн хууль, эрх зүйн орчныг сайжруулан цахим орчинд хийгдсэн гэрээ, хэлцлийг шүүхэд нотлох баримтаар тооцох, шүүхийн зарим үйл ажиллагааг цахимжуулж, баялаг бүтээгч, хувийн хэвшлийг дэмжих хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хууль ёсыг бэхжүүлнэ...” гэжээ.¹²

Мөн тус олон улсын бага хурлын үеэр шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын төлөөллүүд цахимжилттай холбоотойгоор санал, дүгнэлтээ танилцуулснаас дурдвал:

Шигтгээ 1.

Цахимжилттай холбоотойгоор шинэ, шинэ нэр томъёо хэрэглэгдэх болсон. Тухайн нэр томъёог анхнаас нь зөв тодорхойлж, нэр мөр ойлгох нь маш чухал. Нөгөөтээгүүр, цахимжих үйл явц нь цахим гарын үсгийн хэрэглээтэй нягт уялдаа холбоотой бөгөөд манай улсын хувьд цахим багц хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан цахим гарын үсгийн хэрэглээ эрс нэмэгдэж байна.

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч

Шигтгээ 2.

Хавтаст хэргийг цахимжуулах нь маш чухал хэрэгжүүлэх шаардлагатай ажлын нэг болоод байна. Хэрэв цахим хавтаст хэрэгтэй байсан бол шүүхийн нотлох баримт шинжлэн судлан үе шатанд гэхэд дан ганц прокурор хавтаст хэргийн ... хуудас гээд тухайн судалж буй нотлох баримтыг ганцаар уншиж танилцуулахгүйгээр тухайн шүүх хуралдааны танхимд сууж буй хүн бүрд нээлттэй, үнэн зөв байх боломжийг бүрдүүлнэ. Нөгөөтээгүүр, хэрэг маргаан олон жил шалгагдан үргэлжилж байгаа тохиолдолд цаасан суурьтай баримт дэс дараалалгүйгээр үдэгдэж хавсрагддаг. Цахим хавтаст хэрэгт бол тухайн нотлох баримтыг төрөлжүүлэх, шүүгч, прокурор өмгөөлөгчдийн хувьд ч тухайн хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтуудын уялдаа холбоотой байдлыг шалгах, танилцахад хялбар болно.

Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга, УЕП-ын туслах прокурор


Шигтгээ 3.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах ажлыг эхлүүлээд байна. Тухайлбал, 2023 оны 3 сарын 20-ны өдрөөс эхлээд ЧД-ийн Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Замын цагдаагийн хэлтэстэй хамтраад 100 орчим эрх бүхий албан тушаалтанд эрх олгож шинэ программыг үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашиглаж эхлээд байна.

ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Статистик мэдээллийн хэлтсийн дарга, Цагдаагийн дэд хурандаа

2024 оны 3 сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан “Шүүхийн цахимжилт ба тулгамдсан асуудал” сэдэвт хэлэлцүүлэгт ЦХХХ-ны сайд Н.Учрал хэлсэн үгэндээ “...Цахим шилжилт нь зөвхөн технологийн асуудал биш юм. Холбогдох харилцааг

¹² Г.Даваадорж: Шүүхийн цахимжилтад хууль эрх зүйн орчин ус агаар мэт хэрэгтэй байна, https://www.judcouncil.mn/site/news_full/12923



зохицуулсан хууль тогтоомж, дүрэм журам буюу процесс, ажиллуулж чаддаг, ашиглаж чаддаг хэрэглэгч, тохиромжтой технологийн шийдэл нийлж байж цахим шилжилт амжилттай хэрэгжинэ. Тиймээс өнөөдөр манай улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй 109 хуульд цахим шилжилтийг тусгасан нэмэлт, өөрчлөлтийг боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлэн батлуулж, энэ жилийн 3 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөж эхлээд байна. 109 хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр шийдсэн гол өөрчлөлтүүдийн нэг нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд цаасан болон цахим эх хувийг адил тэнцүү, аль түрүүлж үүссэн хэлбэрийг нь эх нотлох баримтаар тооцох зохицуулалтыг тусгасан. Энэ өөрчлөлт нь шүүхийн цахим шилжилтэд маш том дэмжлэг, суурь нөхцөлийг нь хангаж өгч байна. Тухайлбал шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргахдаа цахим хэлбэрээр, “e-Mongolia”-аар, киоскоор дамжуулан гаргаж болно. Үүнийг хэвлэхгүй, цахим хэлбэрээр нь ХУР-аар дамжуулан шүүхийн системд илгээх, бусад нотлох баримт, лавлагаа тодорхойлолтыг албаны цахим шуудан, лавлагаа системээс мөн цахим хэлбэрээр нь бүрдүүлэн авч цахим хавтаст хэрэг бүрдүүлэх боломжтой. Цаашид хэрэг хянан шийдвэрлэх процессын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа юм...” талаар дурджээ.

Мөн ЧД-ийн ЭХАШШ-ийн шүүгч Л.Галбадар “Эрүүгийн шүүхийн цахимжилт, тулгамдсан асуудал” сэдэвт илтгэлдээ “...Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлдээ цахимжих боломжгүй. Зарим цахимжих боломжгүй ажиллагаа байгаа харин шүүхийн зөвшөөрөл, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэрэг, зөрчлийн хэргийн хүрээнд цахимжилт хийгдэх бүрэн боломжтой. Үүний тулд Цагдаагийн байгууллага зөрчил, гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл ирэхэд тухайн гомдол, мэдээллийн дагуу хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа сонголттойгоор буюу цахимаар эсвэл уламжлалт цаасан суурьтайгаар нотлох баримт бүрдүүлэх боломжийг хуульд тусгаж өгөх нь зүйтэй. Монголын хөрөнгө, хохирол үнэлэгчдийн холбоо цахимаар хохирлынхоо үнэлгээг гаргаад тоон гарын үсгээр баталгаажуулан явуулж болдог болсон гэсэн ч одоогийн байдлаар үүнийг шууд хэвлээд хавтаст хэрэгт хийх боломжгүй. Хэрэв цахим хавтаст хэрэгтэй байсан бол шууд татаад хавтаст хэрэгт хавсаргах боломжтой. Иймээс хэдийгээр нэг талдаа цахимаар нотлох баримт цуглуулах боломж байгаа боловч одоогийн практикт заавал цаасан хэлбэрт буулгаж, нотлох баримтаа бүрдүүлж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим суурьтай нотлох баримт, цахим хавтаст хэрэг бүрдүүлэх зохицуулалтыг тусгаж өгөх шаардлагатай. Энэ нь хуульдаа тусгагдаж байж практикт хэрэгжих боломж нь бүрдэнэ. Түүнээс хууль заагаагүй эх сурвалж нотлох баримт болохгүй, нотолгооны чанараа алдана. Үүнийг анхаарах зайлшгүй шаардлагатай. Түүнчлэн, шүүх хуралдааны цахимаар явуулах асуудлыг журмаар бус хуульдаа тусгаж өгөх хэрэгтэй...” гэжээ.

Дээрх хурал, хэлэлцүүлгийн үр дүнгээс харахад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас мөрдөгч нотлох баримт цуглуулж, хавтаст хэрэг бүрдүүлдэгээрээ ялгаатай болохын хувьд шүүхийн цахимжилт нь цагдаагийн байгууллага, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цахимжилт өөр хоорондоо шууд харилцан хамааралтай байна.

Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн ач холбогдол, хэрэгцээ, шаардлага нөхцөл байдлын талаар холбогдох мэргэжилтэн, судлаач дараах мэдээллийг өгсөн юм.

Шигтгээ 4.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахимжилтын нөхцөл байдлыг авч үзвэл одоогоор хавтаст хэргийг цахим байдлаар аривлаж буй үйл ажиллагаа хамаарч байна. Мөн түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 18 төрлийн баримт бичгийг шүүхээс цахимаар (Үүнд е-

mongolia системээс авч болох иргэний үнэмлэхний лавлагаа, төрсний бүртгэлийн лавлагаа гэх мэт) шүүхийн тамгын газраар дамжуулан авч байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хавтаст хэргийг цахимаар бүрдүүлэх нь тухайн үйл ажиллагааны ил тод байдал, хэргийг талуудад танилцуулах ач холбогдолтой.

Нийгэмд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хавтаст хэрэг, баримт бичгийг ашиглах хэрэгцээ, шаардлага бий болоод байгаа. Тухайн харилцааг хуульчлахаас илүү нийгмийн харилцаанд цахим үйл ажиллагаа ихээр бий болоод байгааг хүлээн зөвшөөрөх ёстой. Тухайлбал, одоогийн байдлаар хүмүүсийн цахим хэрэглээ ихэсч эмнэлэгт цаг авахаас эхлүүлээд хэрэглээний зээлийг хүртэл цахимаар авахаар болсон. Ковид-19 цар тахлын үед цахим хэрэглээ хурдацтай нэмэгдэж ихэнх үйл ажиллагааг цахимаар явуулах практик суусан. Үүнээс гадна цахим багц хууль батлагдсан нь энэ төрлийн харилцааг зохицуулах шаардлагатайг харуулж байна.

Гэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хавтаст хэргийг цахимжуулах тал дээр хэд хэдэн хүндрэлтэй асуудлууд бий болж болох юм. Тодруулбал, хавтаст хэргийг цахимжуулсны дараа мэргэжлийн оролцогч болон энгийн оролцогчдыг тусад нь ялгаж авч үзэх; хэрэгжүүлэгч байгууллагуудын цахим системийн хоорондын уялдаа холбоог хангах, аюулгүй байдлыг хангах, программ хангамжийг сайжруулах, хадгалах багтаамж (storage)-ийг нэмэгдүүлэх гэх мэт. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулахдаа нэгэнт бий болоод байгаа нэгдсэн платформууд болох e-mongolia систем, ХУР систем, Дан системийг ашиглах шаардлагатай.


Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гишүүнтэй хийсэн ярилцлагын хэсгээс...

Түүнчлэн, цахим нотлох баримт, цахимжуулсан нотлох баримт, цахим хавтаст хэргийн асуудал нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлэх буюу гомдол, мэдээлэл хүлээн авахаас эхлэн цахим эсвэл цаасан суурьтай хавтаст хэрэг бүрдүүлэх сонгох боломжийг хуульд тусгах, хэргийн оролцогч, өмгөөлөгч, прокуророос шүүхэд хандаж буй гомдол, хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх журмыг хуульд тусгах, зарим төрлийн /зөрчил, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэрэг/ хэрэгт цахим хавтаст хэрэг үүсгэх боломжийг сонголттойгоор хуульчлах гэх мэт асуудлыг цахимжилтын хүрээнд нэн тэргүүнд шийдвэрлэж, хэрэгжүүлэх боломжтой.

Цахим нотлох баримтыг бий болгох талаар хэрэгцээ, шаардлага:

Ковид 19 цар тахлын нөлөөгөөр цахим харилцаа холбоо, цахимжилт нийгмийн олон талт харилцаанд томоохон нөлөө үзүүлсэн. Ийнхүү цахим харилцаа холбоо өргөжин тэлэхийн хэрээр Монгол Улсад төдийгүй олон улсын хэмжээнд шинэ төрлийн гэмт хэргүүд бүртгэгдэж, цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн тоо өсөх, зарим гэмт хэргийг урьд тогтсон уламжлалт хандлагаар авч үзэх боломжгүй байдлаар хувьсан өөрчлөгдөж агуулга, хэлбэр, хор уршиг, хохирлын хэмжээ нэмэгдэж байна. Иймээс ч тухайн гэмт хэргийг илрүүлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж, хэргийн бодит байдлыг тогтооход цахим нотлох баримт чухал ач холбогдолтой болоод байна.

Тухайлбал, 2022 онд Прокурорын байгууллага Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэгт заасан Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хамаарах нийт 751 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьж ажилласан бөгөөд Эрүүгийн хуулийн 26.1 дүгээр зүйлд заасан Кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан 750 хэрэг, мөн хуулийн 26.3 дугаар зүйлд заасан Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан 1 хэрэг байна. Энэхүү 751 хэргийн 2 хэргийг хэрэгсэхгүй болгож, 37 хэргийг шүүхэд шилжүүлж, 202 хэргийг нэгтгэн, 71 хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэжээ.



Энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд цахим нотлох баримт чухал үүрэгтэй боловч цахим суурьтай нотлох баримтыг бэхжүүлэх, цуглуулах, хадгалах, шинжлэн судлах зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цаасан суурьтай нотлох баримттай ижил түвшинд үнэлэхгүй байх, цахим нотлох баримтыг заавал цаасан суурьтай нотлох баримт болгох, цаасан хэлбэрт буулгаж хавтаст хэрэгт хавсаргах зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна.

Гэтэл кибер гэмт хэрэг үйлдэж буй орон зай, тухайн хэрэгт ашиглаж буй төхөөрөмж, хэрэгсэл, халдлагын зүйлээс шалтгаалж, зөвхөн уламжлалт нотлох баримт (бичгэн болон эд мөрийн баримт)-уудад тулгуурлан тухайн үйл явдал болсныг нотлох, эсвэл үгүйсгэх боломжгүй тул цахим нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах ажиллагаа чухал байр суурь эзэлдэг. Хэрэгт ач холбогдол бүхий цахим, аналог, дижитал (тоон) баримтуудыг хамтад нь “цахим баримт” гэж нэрлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нийтлэг байдлаар хэрэглэж байна.

Цахимаар мэдүүлэх, цахим хавтаст хэрэг үүсгэх, цахим нотлох баримт, нотлох баримтыг цахим хэлбэрт оруулснаар цаасан суурьтай бичиг баримт бүрдүүлэх шаардлагагүй болж, байгаль орчинд эергээр нөлөөлнө. Мөн цахимаар шүүхэд мэдүүлэх, цахим хавтаст хэрэг үүсгэх зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулснаар шүүхийн хүртээмж илүү нэмэгдэж, хэрэг маргаан хянан шийдвэрлүүлж буй этгээдийн хувьд цаг хугацаа, зардал хэмнэгдэж, шүүхэд итгэх иргэдийн итгэл нэмэгдэн шүүх эрх мэдэл улам бэхжих юм.¹³

Түүнчлэн, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээр цаасан суурьтай баримт бичиг шаардахгүй байх үндэслэл бий болно. Ингэснээр иргэд заавал өөрийн биеэр очиж, хэн нэгэн албан тушаалтны хаалга үүдийг сахиж, цаас бүрдүүлэх шаардлагагүй болно. Нөгөөтээгүүр, цахим баримт бичгийг нотлох баримт бичгийн хэмжээнд хүлээн зөвшөөрдөг болох юм. Практикт төрийн байгууллагын үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэхэд цахим баримт бичгийг нотлох баримтын хэмжээнд үнэлдэггүй, цаасан баримт бичгийг л нотлох баримтын хэмжээнд хүлээн зөвшөөрдөг.¹⁴

Шигтгээ 5.

Цахим нотлох баримтын одоогийн практикийн хувьд ИХШХШТХ-ийн жишгээр буюу баримт бичгийн эх хувь нь цахим бол шүүх түүнийг нотлох баримтад тооцож байна. Гэвч цахим нотлох баримтыг үнэлэхэд шүүхэд тулгарч буй гол асуудал түүнийг үнэлэх, үнэн зөвийг нь тогтооход төвөгтэй, цаг хугацаа шаарддаг, зарим тохиолдолд нарийн мэргэжлийн мэдлэг, технологи шаардлагатай байдаг. Иймд шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь цахим нотлох баримтын үнэлэх чадавхийг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм.

Цахим нотлох баримтын тал дээр одоо хэрэгжиж байгаа туршлага гэвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай улсын мэдээллийн санд буй 18 төрлийн мэдээллийг шүүх нь тамгын газрын даргаар дамжуулан шууд авч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглаж байгааг дурдаж болно. Гэхдээ ийнхүү төрд цахимаар байгаа мэдээллийг шүүх шууд хандан авах практикийг цаашид эрүүгийн болон зарим тохиолдолд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илүү ашиглах, нэвтрүүлэх шаардлагатай бөгөөд учир нь ийнхүү нотлох баримтыг шүүх өөрөө цуглуулах нь иргэний эрх зүйн мэтгэлцэх зарчимтай харшлах магадлалтай юм.

Мөн энэ тал дээр бас нэг анхаарах чухал асуудал бол цахим буюу дижитал архивыг бий болгох, үйл ажиллагааг нь зохион байгуулах, ажиллах журмыг боловсруулах асуудал юм.

¹³ Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын төсөлд хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ /Хөндлөнгийн судалгаа/, УБ, 2023, 47 дахь тал.

¹⁴ М.Бямбасүрэн, Цахим баримт бичгийг нотлох баримтын хэмжээнд үнэлдэг байх шаардлагатай нийтлэл, 2024.01.29,

<https://business.mn/2024/01/29/m-byambasuren-tsahim-barimt-bichgiig-notloh-barimtiin-hemjeend-uneldeg-baih-shaardlagatai/>

Ер нь ЭХХШТХ-д цахим нотлох баримтын хэлбэрийн шаардлага болон хэрхэн үнэлэх журам, цахим хавтаст хэргийн тодорхойлолт, түүнийг хөтлөх журам зэрэг нарийвчилсан зохицуулалтыг шууд хуульчлан тусгахын оронд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримтыг үнэлэх, хавтаст хэргийн цахимаар хөтлөж болох тухай ерөнхий зохицуулалтыг хийж цахим нотлох баримт, түүнийг баталгаажуулах, үнэлэх, цахим хавтаст хэргийг хөтлөх зэрэг ажлыг аргачлалаар хангах ажлыг зохион байгуулах боломж бий. Нэгэнт байгуулагдсан ШЕЗ гэх мэт институцид даалгах нь илүү оновчтой шийдэл байж болох юм.

Гэхдээ ийнхүү ажлыг зохион байгуулахдаа ХБНГУ зэрэг улсын жишгийн дагуу, хавтаст хэргийг цахимаар хөтлөх, нотлох баримтыг цахимаар авах, цахим хэлбэрт байгаа хавтаст хэрэгт хэргийн оролцогчид хандах, шүүх хуралдаанд эдгээр цахим баримтыг танилцуулах, үнэлэх зэрэг ажлыг аль болох хэргийн оролцогчид шууд хандаж ойлгох, ашиглахад хялбар хэлбэр бүхий технологийг ашиглах нь зүйтэй.

Мөн шүүхийн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар нэвтрүүлэх хэрэгтэй. Жишээлбэл, бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг шийдэх, таслан сэргийлэх арга хэмжээ авах, шүүгч ээлжээр ажиллах ажлыг цахимаар явуулахаар бол тодорхой хугацаа зааж, уг хугацааны хүрээнд уг ажлыг зохион байгуулна гээд тэр хугацаанд нь мэргэжлийн оролцогчдын тоон гарын үсгийг ашиглаж сурах боломжийг бүрдүүлэх гэх мэт.

Ийнхүү шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим болгож буй гол үндсэн зорилго нь шүүхийн ажиллагааг хурдан шуурхай болгож, иргэдийн шударгаар шүүллэх эрхийг хангах, ил тод байдлыг хангах бөгөөд хэрэгцээ шаарлагын хувьд өнөө үед нотлох баримт цахим байх, түүнийг үнэлэх, хавтаст хэргийг цахимаар хөтлөх зэрэг нь боломжтой, зарим тохиолдолд зайлшгүй цахим хэрэглээнд тохирсон зохицуулалт байх тул нийгмийн энэ хөгжлийг дагасан зохицуулалт хийх шаардлагатай.

Цахим хавтаст хэрэг, нотлох баримтыг хадгалах, архивлах ажлын хувьд тэдгээрийг хэрхэн хадгалах технолги (scanner), хадгалалтын хугацаанд тохирсон хэлбэр (pdf) зэргийг анхаарч үзэх мөн зарим төрлийн гэмт хэрэгтэй холбоотой хэргийн материал, хавтаст хэрэг зэргийг цаасаар байх эсэх гэх мэт зохицуулалтыг ч анхаарах шаардлагатай.


Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гишүүнтэй хийсэн ярилцлагын хэсгээс...

Цахим нотлох баримт, цахим хавтаст хэрэг, цахимжуулсан хавтаст хэрэг гэх мэт цахимжуулалттай холбоотой асуудлыг шийдвэрлэхийн тулд юун түүрүүнд эрх зүйн орчин, дата бааз, хадгалах сервер, технологийн шийдэл, бүрдүүлэх нь чухал.

Тухайлбал, цахим хавтаст хэрэг үүсгэснээр маш их хэмжээний дата буюу өгөгдөл бий болно. Иймд шүүхийн их өгөгдлийн сан буюу Big data-г үүсгэх нь чухал. Их өгөгдөл бол компьютерын шинжлэх ухаан, статистик хоёртой салшгүй холбоотой бөгөөд мэдээллүүдийг нэгтгэж, хооронд нь холбож, богино хугацааны давтамжтайгаар, олон үзүүлэлтээр боловсруулах, нарийвчлан задлах зэргээр маш хурдтай, цаг хугацааны алдагдалгүй, байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглах, иргэд олон нийтэд мэдээлэх, оновчтой бодлого шийдвэр гаргахад зориулагдсан технологийн \hadoop зэрэг\ шийдэл юм.¹⁵

Дээрхээс дүгнэвэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах, ялангуяа цахим хавтаст хэргийг бий болгох, цахим нотлох баримтын талаар зохицуулах нь одоогийн хэрэгцээ, шаардлагад нийцэхүйц байна. Өөрөөр хэлбэл орчин үед цахим хөгжил эрчимтэй явагдаж буй энэ үед эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох, хялбарчлах, хэмнэлттэй, үр дүнтэй байх ач холбогдлыг бий болгож байна. Хуулийн төслийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 1.16 дугаар зүйл, 11.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг болон бусад цахимжуулахтай холбоотой зохицуулалт нь тус хэрэгцээ, шаардлага, зорилгод ерөнхийдөө нийцэж буй боловч цахим нотлох баримтыг хуулийн төсөлд тусгаж нарийвчлан зохицуулаагүйгээрээ нэмэлт, өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлага, зорилгод

¹⁵ Г.Даваадорж: Шүүхийн цахимжилтад хууль эрх зүйн орчин ус агаар мэт хэрэгтэй байна, https://www.judcouncil.mn/site/news_full/13818



нийцэхгүй байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд цахим нотлох баримтын талаар нарийвчлан зохицуулах шаардлагатай.

Хуулийн төсөлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах талаар тусгасан нь зорилгод нийцэхээс гадна цахим хэлбэртэй байхаас гадна цаасан хэлбэртэй байхаар тусгасан нь зорилгод нийцэж байна. Учир нь 2020 онд батлагдсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд дараах зохицуулалтуудыг тусгасан.

- 14.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг. Архивын баримтын тоо бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл цаасан болон цахим хэлбэрээр байх бөгөөд уг санг ашиглан төрийн архивууд хооронд мэдээлэл солилцох нөхцөл бүрдүүлсэн байна.
- 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг. Байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд захирамжлалын, зохион байгуулалтын болон мэдээлэл, лавлагааны баримт бичгийг хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр, шаардлагатай тохиолдолд цаасан хэлбэрээр үйлдэнэ.
- 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэг. Хуульд өөрөөр заагаагүй бол цаасан болон цахим баримт бичиг нь хууль тогтоомж болон стандартаар тогтоосон баримт бичгийн бүрдлээр баталгаажна гэх мэт.


Дээрх байдлаар цаасан болон цахим суурьтай байх нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийн шаардлага юм. Түүнчлэн зохицуулалтын практик хэрэгжилт бий болох хүртэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийн найдвартай байдлыг хангах хөшүүрэг болохоор байна.

Хуулийн төслийн сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголттой холбоотой зохицуулалт ЭХХШТХ-ийн зорилгод хүрч байгаа эсэхэд хийсэн дүн шинжилгээ

2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль батлагдсантай холбогдуулан 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг шинэчлэн найруулах асуудал зүй ёсоор хөндөгдөж байсан. ЭБШХ-ийг шинэчлэн найруулахдаа нэрний хувьд ч “байцаан шийтгэх” бус “хэрэг хянан шийдвэрлэх” гэж өөрчлөн, агуулга, зүйл, заалтыг өөрчлөн сайжруулж, гадаад орны сайн туршлагыг судлан нэлээд олон зохицуулалтыг шинээр тусгаж, зарим зохицуулалтыг халсан билээ.

Тус хуулиас халсан зохицуулалтын нэг нь “сэжигтэн” юм. 2015 онд шинэчлэн найруулсан ЭХХШТХ-ийн төсөл хэлэлцэгдэж байх үед тухайн үеийн Хууль зүйн сайд Д.Дорлигжав хэвлэлд өгсөн ярилцлагадаа “...Сэжигтэн гэсэн ойлголт үгүй болно. Хэн нэгнийг ямар нэг гэмт хэрэгт сэжиглэсэн тохиолдолд дуудаж байцаадаг, хорьж цагддаг явдал эцэс болно. Мөрдөн байцаагч гагцхүү нотлох баримт цуглуулах бөгөөд нотлох баримт бүрдүүлсний дараа прокурорт танилцуулан, түүнийг нь прокурор хангалттай гэж үзсэн тохиолдолд тухайн хүнийг яллагдагчаар тооцон байцаалт явуулах эрхтэй. Өөрөөр хэлбэл, хангалттай нотлох баримтгүй атлаа дуудаж байцаадаг, сэжигтнээр тооцуулан авчраад өрөөнийхөө үүдэнд байцаалт авах нэрээр хэдэн цагаар суулгадаг, хорьдог явдлыг эцэслэнэ...”¹⁶ гэжээ.

¹⁶ Шинэ хуулиар сэжигтэн гэх ойлголт үгүй болно нийтлэл, 2015.05.06, <https://qogo.mn/r/qo8v7>




Тиймээс ч ЭХХШТХ-аар сэжигтэн гэх ойлголтыг халж, хүний эрхийг хангах боломжийг бүрдүүлнэ хэмээн үзэж байсан ч ЭХХШТХ-ийн зарим зүйл, заалтад сэжигтэн гэх ойлголт тусгагдсан бөгөөд үүнээс үүдэн практикт сэжигтэнтэй холбоотой зохицуулалт дутуу, хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй эрх зүйн хийдэлтэй хуульчлагдсны улмаас хүний эрхийг ноцтой зөрчих үндэслэл болоод байна. Энэ талаар салбарын судлаач, эрдэмтэд хурал, хэлэлцүүлгээр олонтоо хөндөж, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, ярилцлага өгсөн байдаг.

Тухайлбал, Хууль зүйн ухааны доктор Б.Өнөрмаа “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “оролцогч биш” оролцогч буюу “сэжигтний” талаарх зохицуулалтын ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн /сро/ зохицуулалттай харьцуулах нь” сэдэвт өгүүлэлдээ “...Монгол Улсын ЭХХШТХ-д сэжигтнийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч гэж хуульчилсан атлаа сэжигтнээс мэдүүлэг авах ажиллагаа зохицуулагдаагүй бөгөөд хэрэгт сэрдэгдэж буй хүнээс гэрчийн мэдүүлэг авах нь түүний үндсэн эрхийг ноцтой зөрчиж “сэжигтэн”- ий статус, эрх үүргийг тодорхойлоогүй нь Монгол Улсын Үндсэн хуульд харшилж байна. Сэжигтэн нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол оролцогчийн хувьд гэрчийн мэдүүлэг өгч байгаа нь гэм буруугүй болохоо өөрөө нотлох үүрэг хүлээж буй үйлдэл юм. Энэ нь Монгол Улсын ЭХХШТХийн 1.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүх, прокурор, мөрдөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар шаардахыг хориглоно” гэж заасантай зөрчилдөж байна...” гэжээ.

Нээлттэй нийгэм форумаас 2022 онд зохион байгуулсан “Чухал сэдэв” хэлэлцүүлгийн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр бүлэг” тэмдэглэлд “...Өмнөх хуулийн хүрээнд байсан хүний эрхийг сэжиг таамгаар хязгаарлахыг таслан зогсоох зорилгоор сэжигтэн гэх нэршлийг эрүүгийн процессын оролцогчоор тооцохоо больсон. Учир нь сэжигтэнд хугацаагүйгээр хилийн хориг тавих, батлан даалт, барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авах, хамгийн ноцтой нь хүнийг зүгээр л сэжиглээд 14 хоног хорьдог, 72 цагтайгаа нийлэх юм бол 17 хоног хорьж саатуулах нөхцөл бүрдсэн байсан. Тиймээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31-р бүлэгт бүхэлд нь ямар тохиолдолд хүнийг сэжигтнээр дуудах, баривчлахыг нарийвчлан заасан. Гэтэл энэ бүлгийг хэрэглэхийн оронд хүнийг гэрчээр дуудаад өөрийнх нь эсрэг мэдүүлэг авч, улмаар яллагдагчаар татаж байна. Нэг ёсондоо сэжигтнээр оролцох ёстой хүнийг гэрчээр оролцуулсны улмаас Монгол Улсын Үндсэн хуульд заасан гомдол гаргах эрх нь автоматаар хасагдаж байгаа буюу “гэрч” болсноор гомдол гаргах, мөрдөгч, прокуророос татгалзах, өөрөө өөрийгөө өмгөөлөх эрхгүй болж байна...” гэжээ.

Мөн Нээлттэй нийгэм форумаас МХХ-ны Эрүүгийн эрх зүйн хороотой хамтран “Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал” сэдэвт цуврал хэлэлцүүлгийн хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хэлэлцүүлэг зохион байгуулахад оролцогчид “...Сэжигтний асуудал байхгүй явж байгаад сүүлд нь сэжигтний өмгөөлөгч, баривчлагдсан сэжигтэн гэж гарч ирээд байгаа нь хуулийг нэг мөр ойлгож хэрэглэхэд хүндрэл учруулж байна. Аливаа гэмт хэрэгт сэжигтнээр татаж байгаа этгээдийг шинэ хуулиар гэрчээр асуугаад, хууль сануулаад, худал мэдүүлэг өгч болохгүй гэгчээд, дараа нь буцаагаад яг тэр үндэслэлээр яллагдагчаар татаж байна. Энэ нь Үндсэн хуульд заасан өөрөө өөрийнхөө



эсрэг мэдүүлэг өгөхгүй байх гэсэн зарчимтай зөрчилдөж байна. Иймд сэжигтэн гэсэн томъёолол орж ирвэл, дагаад эрх, үүрэг нь тодорхой болох боломжтой...”¹⁷ гэжээ.

Дүгнэвэл, ЭХХШТХ-д заасан сэжигтэнтэй холбоотой зохицуулалтууд зорилгод хүрэх байдал, практикт хэрэгжих боломжийн хувьд хязгаарлагдмал байдалтай байна.

Сэжигтэн гэх нэр томъёо дэлхийн олон орны эрүүгийн процессийн ажиллагаанд түгээмэл хэрэглэдэг бөгөөд 2002 оны ЭБШХ-ийг хэрэгжүүлэхэд үүсээд байсан асуудал нь “сэжигтэн” гэх нэр томъёонд биш харин сэжигтэнтэй холбоотой эрх зүйн зохицуулалт, харилцааг практикт өрөөсгөл байдлаар хэрэгжүүлж байсантай холбоотой гэж үзэх болох юм. Тиймээс ч сэжигтэн гэх нэр томъёог зөв зүйтэй тодорхойлон хуульчилж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сэжигтнийг эрхийг хангах, зөрчигдөхөөс сэргийлэх, тухайн зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх асуудлыг нарийвчлан зөв хуульчлах нь тус нэр томъёог халахаас илүү оновчтой сонголт байсан болох нь ЭХХШТХ хэрэгжиж эхэлснээс хойш өнөөдрийг хүртэлх сэжигтэнтэй холбоотой хуулийн зохицуулалтын хэрэгжилтээс харагдаж байна.

ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд сэжигтэнтэй холбоотой зохицуулалтаас гадна шинээр “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэх ойлголтыг тодорхойлж, холбогдох зохицуулалтуудыг төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.38 дахь заалт, 16.3 дугаар зүйлийн 4.7 дахь заалт, мөн зүйлийн 10 дахь хэсэг, 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэг, 31.2 дугаар зүйлийн 9-12 дахь хэсэг, 31.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 31.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 31.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт тусгажээ.

“Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэдгийг энэ хуульд заасан үндэслэлээр гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгагдах нотлох баримт, хавтаст хэрэгт тусгагдсан, эсхүл мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдож байгаа хүн гэж хуулийн төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.38-д тодорхойлжээ. Тус тодорхойлолтоос үзвэл “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэдэгт:

1/ гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгагдах нотлох баримт, хавтаст хэрэгт тусгагдсан;

Гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгагдах нотлох баримт хавтаст хэрэгт тусгагдсан гэдэгт ЭХХША явуулж, хуульд заасан үндэслэл журмын дагуу нотлох баримт цуглуулж, тухайн нотлох баримтад үндэслэн тухайн хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх үндэслэл тогтоогдож байхыг ойлгож болох юм.

2/ мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдож байгаа хүн хамаарч байна.

Мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдож байгаа хүн гэдгийг хуульд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулж, тухайн ажиллагааны үр дүнд гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдож байгаа хүн гэж ойлгож болох юм.

¹⁷ Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хуулийн шүүмж, Цуврал 22, УБ, ННФ, 2018, 9 дэх тал.

Харин ЭХХШТХ-ийн 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт сэжигтэн гэдгийг энэ хуульд заасны дагуу **баривчлагдсан**, эсхүл **яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан** хүн гэж заажээ. Үүнээс үзвэл, сэжигтэнд:

1/ баривчлагдсан;

/ЭХХШТХ-ийн 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас дүгнэвэл, сэжигтэнд зөвхөн баривчлагдсан хүн хамаарах бөгөөд баривчлагдаагүй хүн сэжигтэн биш/

2/ яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүн хамаарч байна.

/Энэхүү тодорхойлолтоор яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүн буюу сэжигтэн маш богино хугацааны ойлголт болоод байна. Учир нь мөрдөгч яллагдагчаар татах тогтоол танилцуулах тухай мэдэгдэж, тухайн хүн тус тогтоолтой танилцахаар ирж буй хугацаандаа л “сэжигтэн” гэх статустай байх бөгөөд яллагдагчаар татах тогтоол танилцуулсны дараа яллагдагч болно/


<p align="center">Сэжигтэн /ЭХХШТХ-ийн 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг</p>	<p align="center">Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн /Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.38 дахь заалт/</p>
<p>Энэ хуульд заасны дагуу баривчлагдсан</p>	<p>Энэ хуульд заасан үндэслэлээр гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгагдах нотлох баримт, хавтаст хэрэгт тусгагдсан</p>
<p>Яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүн</p>	<p>Мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдож байгаа</p>

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “баривчлагдсан” гэсний дараа “эсхүл гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэж нэмэхээр тусгасан нь сэжигтэн гэх ойлголтод “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” хамааруулж байгаа мэт харагдаж байгаа ч хуулийн төслийн бусад зүйл, заалтад тусгасан “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэх ойлголт нь сэжигтнээс ялгаатай зохицуулалт мэт ойлгогдож байна. Тухайлбал, хуулийн төслийн 16.3 дугаар зүйлийн 4.7 дугаар зүйл.

Учир нь ЭХХШТХ-ийн 16.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “дараахь хүнээс гэрчийн мэдүүлэг авч болохгүй” гэж тусгасан бөгөөд тус үндэслэлүүд дээр “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэж нэмж оруулахаар хуулийн төслийн 16.3 дугаар зүйлийн 4.7-д тусгажээ. Мөн хуулийн төсөлд “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн”-ийг гэрчээр дуудан ирүүлэхийг хориглох заалтыг тусгасан байна.

Хэрэв хуулийн төсөлд тусгаснаар “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” сэжигтэнд хамаарч байсан бол сэжигтнээс гэрчийн мэдүүлэг авахгүй нь хэн хүнд ойлгомжтой. Энэ мэтчилэн “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” нь сэжигтэн биш, түүнээс ялгаатай мэт ойлгогдох зохицуулалтууд хуулийн төсөлд тусгагдсан нь тухайн зохицуулалтын зорилгыг алдагдуулж байна.

Мөн ЭХХШТХ-ийн 31.11 дүгээр зүйлийн нэр нь “Сэжигтнээс мэдүүлэг авах” бөгөөд хуулийн төслийн 2 дугаар зүйлд зааснаар 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг заасан сэжигтэнд “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” үнэхээр хамаарч байгаа бол үүнийг



сэжигтнээс ялгаатай байдлаар “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэж хуулийн төслийн 31.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт тусгах шаардлагагүй байсан. Зүй нь хуулийн төсөлд “сэжигтэн” гэх нэр томъёонд хамааруулсан бол сэжигтэн гэх нэр томъёог хэрэглэх нь оновчтой байжээ.

Түүнчлэн, ЭХХШТХ болон хуулийн төсөлд “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн”-ий эрх, үүргийн талаар тусдаа тусгагдаагүй. Дээр дурдсанчлан хуулийн төслийн 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн сэжигтэнд хамаарч байгаа учир сэжигтний адил эрх эдлэхээр байна. Гэтэл хуулийн төслийн бусад зохицуулалтад сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголтыг өөр хоорондоо ялгаатай мэтээр тусгаснаас үзвэл гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн сэжигтний хуульд заасан эрхийг түүнтэй адил эдлэх эсэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрхэн явуулах нь ойлгомжгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд зааснаар 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “баривчлагдсан,” гэсний дараа “эсхүл гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэж нэмэхээр заасан бөгөөд тус нэмэлт орвол сэжигтэнд:

- Баривчлагдсан
- гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн
- яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүн хамаарахаар байна.

Одоогийн ЭХХШТХ-ийн зохицуулалтаас үзвэл, сэжигтэн нь баривчлагдсан эсхүл яллагдагчаар татах тогтоол танилцуулахаар дуудагдсан буюу маш богино хугацааны ойлголт бөгөөд яллагдагчаар татах тогтоолтой танилцсанаар яллагдагч болж байна.

Харин “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэх тодорхойлолтоос харвал, мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдож байгаа хүн буюу харьцангуй нотлогдсон ЭХХШТХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.23-т заасан үндэслэл бүхий сэжигээс илүү гэмт хэрэг үйлдсэн нь баримтаар нотлогдож, тогтоогдож байгаа хүн байхаар тодорхойлжээ.

Дээрхээс тодорхойлолтоос үзвэл, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголт одоогийн ЭХХШТХ-д заасан сэжигтнээс илүү тухайн гэмт хэргийг үйлдсэн болох нь нотлогдож байгаа хүнийг тодорхойлсон байна. Нөгөөтээгүүр, “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэдгийг сэжигтнээс ялгамжтай байдлаар тусгасны ач холбогдол хуулийн төслөөс харагдахгүй байгааг дурдах нь зүйтэй.

Түүнчлэн, хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасанчлан 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нэмэлт оруулахдаа “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэх ойлголтыг сэжигтэнд хамааруулсан аталаа хуулийн төслийн бусад зохицуулалтад ялгаатай ойлголт мэтээр тусгасан нь тухайн зохицуулалтын зорилгод хүрэх байдлыг алдагдуулж байна.

Дээрхээс дүгнэвэл, ЭХХШТХ-д сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэж ЭХХША-ны нэг субъектыг ялгамжтай байдлаар тусгаж хуульчлах нь хуулийн нэр томъёог нэг мөр ойлгон хэрэглэх, ойлгомжтой байдал, хууль хоорондын уялдаа холбоог хангахад сөргөөр нөлөөлөхөөр байна. Иймд одоо байгаа хуулийн зохицуулалт буюу сэжигтэнтэй холбоотой зохицуулалтаа засаж сайжруулах, эрх зүйн хийдлийг арилгахад чиглэсэн зохицуулалтуудыг хуулийн төсөлд тусгаж, сэжигтэнг тодорхойлон хуульчлах нь илүү оновчтой байж болох юм.

Шүүх хуралдааныг хойшлуулахтай холбоотой зохицуулалт нь нэмэлт, өөрчлөлтийн зорилгод нийцэж буй эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Тус хуулийн төслийн 34.9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 34.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 34.16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 34.16 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, 34.19 дүгээр зүйлийн 1.9 дэх заалт, 35.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт дараах зохицуулалтыг нэмсэн байна

- Шүүгдэгч энэ хуулийн 35.9 дүгээр зүйлд заасны дагуу шүүх хуралдаанд оролцож, шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэг өгөх эсэх эрхээ эдэлсний дараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдааныг орхин явж, шүүх хуралдаанд оролцохоос санаатай зайлсхийсэн бол шүүх түүний эзгүйд шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулж, шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг эцэслэн шийдвэрлэж болно. Шүүгдэгчийн эзгүйд шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулахад шүүгдэгчийн өмгөөлөгчийг оролцуулна.

- Улсын яллагч, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нь гэрч, шинжээч оролцуулах хүсэлтээсээ татгалзаагүй тохиолдолд шүүх талуудын хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг хойшлуулах эсэхийг шийдвэрлэнэ.

- Прокурор энэ хуулийн 5 дахь хэсэгт заасан ажиллагааг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлэх боломжгүй бол шүүх хуралдааныг 30 хүртэл хоногоор хойшлуулж болно.

- Шүүгдэгчийн сонгож авсан өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй, эсхүл шүүгдэгч өмгөөлөгчөөс татгалзсан тохиолдолд энэ хуулийн 5.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу шүүх хуралдаанд өөр өмгөөлөгчийг томилж оролцуулна.

- Шүүх хэд хэдэн шүүгдэгчид холбогдох хэрэгт энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүхийн хэлэлцүүлэг явуулах дарааллыг тогтоохдоо өөрийнх нь хууль ёсны ашиг, сонирхол хөндөгдөхгүй шүүхийн хэлэлцүүлэг явагдах үед шүүх хуралдааны танхимд байлцахгүй байх талаар оролцогчийн гаргасан хүсэлтийг талуудын саналыг харгалзан шийдвэрлэж болно. Шүүх хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн бол энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд тусгаж, шүүх хуралдаанд үргэлжлүүлэн оролцох товыг оролцогчид мэдэгдэнэ.

- Хохирогчийг шүүх хуралдаанд оролцуулахаар шүүх шийдвэрлэсэн бол хохирогч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болно.

Энэ тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад дараах байдлаар авч үзсэн.

Шүүх хуралдаан хойшилж буй шалтгаан нөхцөлийн дийлэнх нь өмгөөлөгчтэй холбоотой болох нь шүүхийн практикт хийсэн судалгаагаар харагддаг. Өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх эрхээр хангагдах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчтэй оролцох нь яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчийн хувьд Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар баталгаажуулсан үндсэн эрхийн нэг юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийн оролцоог хангах нь хүн хилсээр ял шийтгэгдэхгүй байх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан журмын дагуу явагдах чухал баталгаа юм. Шүүх хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа хойшлуулж байгаа нөхцөл байдлыг хязгаарлах үүднээс өмгөөлөгчид хариуцлага тооцох зохицуулалтыг тусгасан бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, хариуцлага хүлээлгэх талаарх мэдээллийг Монголын өмгөөлөгчдийн холбоонд даруй хүргүүлэхээр тусгалаа. Тус зохицуулалт нь улсын

ялагчид мөн хамаарах бөгөөд энэ тохиолдолд харьяалах прокурорын байгууллагад мэдэгдэж, мэдээллийг даруй хүргүүлэхээр зохицуулсан болно.

Түүнчлэн шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг хянан хэлэлцэх үндсэн шүүх хуралдааны бэлтгэлийг талуудын оролцоотой хангаж, шүүх хуралдаан хойшлогдох явдлыг багасгах зорилгоор 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах журмыг шинээр хуульчилсан бөгөөд мөн хуулийн 33.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт “Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцох хүсэлт гаргасан тохиолдолд хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулж болно. Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.” гэж заасан.

Ийнхүү шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүх нэг удаа явуулах агуулгаар дээрх заалтыг хуульчилсан боловч хуулийн буруу хэрэглээ тогтож, оролцогч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг удаа дараа хойшлуулах шалтгаан болсоор байна.

Иймд прокурор, оролцогч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй байх зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлд тусгалаа.

Түүнчлэн шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулахгүй бөгөөд шүүгдэгч шүүх хуралдаанд оролцож, шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэг өгөх эрхээ эдэлсний дараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдааныг орхин явж, шүүх хуралдаанд оролцохоос санаатай зайлсхийсэн бол шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулж, гэм буруутай эсэхийг эцэслэн шийдвэрлэхээр тусгалаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүх хуралдааныг хойшлуулахад талуудын санал, хүсэлтийг харгалзан дараагийн шүүх хуралдааны товыг тогтоож, хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг авна.” гэж заасан ба шүүхийн практикт шүүх хуралдааныг 1 сар, түүнээс илүү хугацаагаар хойшлуулах явдал гарсаар байна.

Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх ашигт сөргөөр нөлөөлж байх тул шүүх хуралдааныг 14 хүртэл хоногийн хугацаагаар хойшлуулдаг практик тогтоож хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн, шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар “...Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.9 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт болон 40.8 дугаар зүйлийн 1.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсон” бөгөөд анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаас хэргийг прокурорт буцаах, түүнчлэн давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр доод шатны шүүхэд буцаах эрх хэмжээгүй болсон.

Зөвхөн анхан шатны шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэх шаардлагатай болсон, эсхүл хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан болон нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхэд хуульд заасан журам зөрчигдсөн талаар талуудын гаргасан гомдлыг шийдвэрлэх шаардлагатай нөхцөлд шүүх хуралдааныг нэг удаа 60 хүртэл хоногийн хугацаагаар хойшлуулж, шаардлагатай ажиллагаа явуулахыг прокурорт даалгах замаар мөрдөн байцаалтын шатанд гарсан хууль хэрэглээний алдааг зөвтгөх зохицуулалт үйлчилж байна.

Хэргийн бүрдэл хангагдаагүй буюу мөрдөн шалгах ажиллагааны явцад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих байдлыг дутуу шалгасан, хэрэгт цугларсан нотлох баримтууд нь гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг хөдөлбөргүй тогтооход хүрэлцэхүйц байх нотолгооны стандартыг хангаагүй, түүнчлэн мөрдөн байцаалтын шатанд оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан болон нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчсөн алдааг шүүхийн шатанд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 5, 6, 7 дахь хэсэгт заасан журмын дагуу 60 хоногт багтаан нөхөн гүйцэтгэх боломжгүй, хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэн өөрчилж, эсхүл зарчмын өөр агуулгатай ял сонсгох шаардлагатай нөхцөлд хуулийн зорилт, нийтлэг зарчмуудад нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг тусгах шаардлага үүсээд байна.

Иймд шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхээр бол, эсхүл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14-т заасан гомдлыг шийдвэрлэх зорилгоор шүүх хэргийг хянан хэлэлцэхийг зөвхөн нэг удаа 60 хүртэл хоногийн хугацаагаар хойшлуулдаг байсан зохицуулалтыг өөрчилж, шүүхээс даалгасан ажиллагааг прокурор

шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлэх боломжгүй бол шүүх хуралдааныг 60 хүртэл хоногоор хойшлуулсаныг дахин 30 хүртэл хоногоор нэмж хойшлуулах зохицуулалтыг тусгалаа¹⁸.

Мөн тус хуулийн төслийн үзэл баримтлалд дараах байдлаар авч үзжээ.

-Шүүх хуралдаан хойшилж буй шалтгаан нөхцөлийн дийлэнх нь өмгөөлөгчтэй холбоотой болох нь шүүхийн практикт хийсэн судалгаагаар харагддаг бөгөөд шүүх хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа хойшлуулж байгаа нөхцөл байдлыг хязгаарлах үүднээс өмгөөлөгчийн хариуцлагатай холбоотой асуудлыг хуульчлах шаардлагатай байна.

Түүнчлэн шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг хянан хэлэлцэх үндсэн шүүх хуралдааны бэлтгэлийг талуудын оролцоотой хангаж, шүүх хуралдаан хойшлогдох явдлыг багасгах зорилгоор 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах журмыг шинээр хуульчилсан бөгөөд мөн хуулийн 33.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт “Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцох хүсэлт гаргасан тохиолдолд хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулж болно. Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.” гэж заасан.

Ийнхүү шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүх нэг удаа явуулах агуулгаар дээрх заалтыг хуульчилсан боловч хуулийн буруу хэрэглээ тогтож, оролцогч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг удаа дараа хойшлуулах шалтгаан болсоор байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүх хуралдааныг хойшлуулахад талуудын санал, хүсэлтийг харгалзан дараагийн шүүх хуралдааны товыг тогтоож, хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг авна.” гэж заасан ба шүүхийн практикт шүүх хуралдааныг 1 сар, түүнээс илүү хугацаагаар хойшлуулах явдал гарсаар байна.

Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх ашигт сөргөөр нөлөөлж байх тул шүүх хуралдааныг түргэн, шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

-Тухайн хэргийн ээдрээ төвөгтэй байдал, эсхүл ажиллагаа ихтэй, олон яллагдагчтай, эсхүл олон үйлдэлтэй зэрэг нөхцөл байдлыг харгалзан шаардлагатай тохиолдолд мөрдөн байцаалт явуулах хугацааг сунгаж болох зохицуулалтыг хуульчилсан боловч олон оролцогчтой хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг хэрхэн, ямар журмаар явуулах нь тодорхойгүй байх тул нарийвчлан зохицуулах шаардлагатай байна¹⁹.

Дээрхээс дүгнэвэл, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь шүүх хуралдааныг үндэслэлгүйгээр хойшлуулж байгаатай холбоотойгоор өмгөөлөгчид хариуцлага тооцох, шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулахгүй байх, прокурор шүүхээс тогтоосон хугацаанд даалгаврыг биелүүлэх боломжгүй бол дахин сунгах зэрэг зохицуулалтыг тусгасан нь хуулийн төслийн өөрчлөлтийн зорилго, үзэл баримтлалд нийцэж байна.


Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төвөөс хийсэн “Шүүх хурал хойшлох шалтгаан, нөхцөлийг тодруулах нь” судалгааны тайланд шүүх хуралдаан хойшлох нөхцөл байдлыг дараах байдлаар авч үзсэн.

Шүүх хуралдаан хойшлоход нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг тодорхойлох зорилтын хүрээнд:

- Шүүх хурал дор хаяж 2-3 удаа хойшлох магадлал өндөр бөгөөд шүүх хурал хойшилсноор хүндрэл үүссэн гэж 87.5 хувь нь үзсэн байна. Ихэвчлэн анхан шатны иргэний хэрэг дээр хүндрэл үүсдэг байна.

¹⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга, 2024

¹⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2024



- Хэрэг хянан шийдвэрлэх хугацааны хувьд дийлэнх иргэд хэрэг маргаанаа 1-5 сарын хугацаанд асуудлаа шийдвэрлүүлж байна.

- Шүүх хуралдаан хойшилсноор онлайн судалгаанд оролцогчийн 34 хувь нь, цаасан судалгаанд оролцогчдын 53 хувь нь маш их болон нэлээн хүндрэл үүсгэсэн гэжээ.

- Эрүү, иргэн, захиргааны хэргийн төрлөөс үл хамааран өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, өмгөөлөгч өвчтэй, хэргийн материалтай танилцах хүсэлт гаргасан болон өмгөөлөгчийн хурал давхацсан гэсэн шалтгаанаар ихэнх хурлууд хойшилж байна.

- Мөн шүүх хурлын 48.1-56.7 хувь нь хэргийн оролцогч талуудаас хамаарч байгаа бол 41.1-42.7 хувь нь өмгөөлөгчтэй холбоотой асуудлаас харин 1.2-9.2 хувь нь шүүх болон хууль зүйн байгууллагууд хамааралтай асуудлаас болж хойшилж байна.

Шүүх хуралдаан хойшлоход үүсэх үр дагаврыг тодорхойлох зорилтын хүрээнд:

- Онлайн судалгааны хувьд олонх нь шүүх хуралдааныг үргэлжлүүлэх нь зөв гэсэн бол харин цаасан суурьт судалгааны хувьд хойшлуулах нь зөв байсан гэжээ.

- Тийм зөв гэж хариулсан хүмүүсийн олонх нь эрэгтэйчүүд харин үргэлжлэх нь буруу гэж хариулсан хүмүүсийн дийлэнх нь эмэгтэйчүүд байв.

- Шүүх хуралдаан хойшилсноор хохирлоо төлүүлэх цаг хугацаа алдсан, олон удаа нааш цааш явж зардал их гаргасан, дараа дараагийн төлөвлөсөн ажилд сөргөөр нөлөөлсөн гэх хувилбарууд нийт 15 сөрөг үр дагаврын дийлэнх хувь болох 67.9 хувийг эзэлж байгаа бөгөөд онлайн судалгааны үр дүнтэй ижил байна. Үүнээс шүүхтэй шууд холбоотой байж болох сөрөг үр дагаврын 2.2 хувь нь шүүгчийн бие даасан байдалд эргэлзсэн, 1.7 хувь нь шүүх, шүүгчийн ачаалал нэмэгдэх, 1.7 хувь нь шүүгчийн мэргэжлийн ур чадварт эргэлзсэн байна²⁰.

Тус нэмэлт, өөрчлөлтийн зохицуулалт нь тус практик судалгааны үр дүнд тогтоосон асуудлыг шийдэхэд мөн түлхэц үзүүлэх тул зорилгодоо нийцсэн гэж үзэхээр байна.


3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомжийн төслийн зохицуулалт нь тодорхой тохиолдолд үйлчлэх, бодит байдал дээр хэрэгжих эсэхийг үнэлнэ. Энэхүү хүрээнд хуулийн төслийн холбогдох зохицуулалтад баримтын судалгааны аргад тулгуурлан дүн шинжилгээ хийлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Тус төслөөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.16 дугаар зүйлийг нэмж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулахыг дараах байдлаар зохицуулжээ.

²⁰ Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв, “Шүүх хурал хойшлох шалтгаан, нөхцөлийг тодруулах нь”, УБ, 2023, 40 дэх тал.



- Шүүх хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах, баримт бичиг хүлээн авах, хүргэх ажиллагааг цахим платформ ашиглан цахимаар явуулж болно.

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хавтаст хэрэг нь шүүхийн цахим платформын техникийн шаардлагад нийцсэн байна.

- Хэргийн оролцогчтой цахимаар харилцахад төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, мэдэгдэл хүргэх систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, мэдэгдэл хүргэх системд иргэний үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, тухайн этгээдийг таньж, баталгаажуулах боломжтой бусад цахим систем, өмгөөлөгчийн Монголын Өмгөөлөгчдийн Холбооны цахим системд бүртгүүлж холбогдсон цахим шууданг ашиглана.

- Өмгөөлөгч тайлбар, гомдол, хүсэлт зэрэг баримт бичгийг цахим баримт бичгээр хүргүүлнэ. Техникийн шалтгаанаар ийнхүү хүргүүлэх боломжгүй тохиолдолд цаасан баримт бичгээр ирүүлж болох бөгөөд энэ тохиолдолд техникийн боломжгүй байсан шалтгаанаа нотолж цахим баримт бичгээр нөхөн ирүүлж болно.

- Мөрдөгч, прокуророос шүүхэд хүргүүлэх эрүүгийн хэрэг, баримт бичгийг шүүхийн цахим платформын техникийн шаардлагад нийцүүлж цахим баримт бичгийн хэлбэрт хөрвүүлж, албан тушаалтны цахим гарын үсгээр баталгаажуулан хүргүүлнэ. Шүүхийн шатанд цахим баримт бичгээр хүргүүлэх боломжгүй цаасан баримт бичгийг шүүхийн захиргааны ажилтан цахим баримт бичигт хөрвүүлнэ.

Түүнчлэн 11.11 дүгээр зүйлийн 2, 7 дахь хэсэгт дараах зохицуулалтыг нэмсэн.

- Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хавтаст хэрэг нь мэдээллийн системийг ашиглан үүсгэх, боловсруулах, хадгалах, илгээх болон хүлээн авах боломжтой цахим хэлбэртэй байж болно

- Хавтаст хэргийг цахимжуулах, шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагуудын нэгдсэн системд холбох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

Хуулийн төсөлд дээрх байдлаар зохицуулсан нь практикт хэрэгжих боломжтой эсэхийг гадаадын эрх зүйн өндөр хөгжилтэй зарим улс, орнуудтай харьцуулан авч үзье.

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах талаар:

ХБНГУ-ийн туршлага

ХБНГУ-ын хувьд анхлан “Шүүх байгууллагын цахим үйл ажиллагааг дэмжих тухай хууль”-ийг²¹ Холбооны засгийн газрын санаачилгаар “*Орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглан цахим хууль зүйн үйл ажиллагааг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд таниулан сурталчлах, шүүх эрх мэдлийн байгууллагын цахимаар үйл ажиллагаа явуулахад учирч буй хүндрэлийг бууруулах, харилцааны шинэ сувагтай харьцах хэрэглэгчдийн итгэлийг бэхжүүлэхэд чиглэсэн хууль эрх зүйн арга*

²¹ Шүүх байгууллагын цахим үйл ажиллагааг дэмжих тухай хууль (Gesetz zur Förderung des elektronischen Rechtsverkehrs mit den Gerichten, 2013)

хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх...”²² зорилгоор боловсруулж, Бундестагаас 2013 оны 10 дугаар сарын 10-ны өдөр батлан гаргасан бөгөөд ХБНГУ-ын холбооны засгийн газраас уг хуулийг дагаж мөрдөх зардал нь улсын төсөвт дарамт учруулахгүй буюу шүүхийн үйл ажиллагаа цахимжсанаар шуудангаар (шуудан, факсын хураамж) болон цаасаар харилцах, үйл ажиллагаа явуулахтай харьцуулахад хэмнэлттэй, зардал буурна гэж үзсэн байна.²³

Уг хуулийн дагуу,

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (ZPO);
- Гэр бүлийн шүүхийн тухай хууль (FamFG);
- Хөдөлмөрийн шүүхийн тухай хууль (ArbGG);
- Нийгмийн шүүхийн тухай хууль (SGG);
- Захиргааны хэргийн шүүхийн хууль (VwGO);
- Санхүүгийн шүүхийн тухай хууль (FGO)

зэрэг нийт ХБНГУ-ын 23 хууль тогтоомжид өөрчлөлт орж дээрх салбар эрх зүйн шүүх байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулах буюу хуульч, эрх бүхий байгууллагууд шүүхүүдтэй харилцахдаа цахим хэлбэрээр харилцах, шүүхийн үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичгийг цахимаар дамжуулах арга, хэрэгслийг тодорхойлох зэрэг асуудлын эрх зүйн үндсийг тавьсан боловч уг хуулийн үйлчлэх хүрээнд үндсэн хуулийн болон ЭХХШТХ багтаагүй байна.

Ийнхүү олонх салбар эрх зүйн шүүх байгууллагын үйл ажиллагаанд цахим хэлбэрийг нэвтрүүлэх ажил үе шаттайгаар хэрэгжиж 2017 оны 7 дугаар сарын 12-ний өдөр Бундестагаас нэмэлтээр “Шүүхийн үйл ажиллагаанд цахим хавтаст хэргийг нэвтрүүлэх, цаашид цахим хууль зүйн үйл ажиллагааг дэмжих тухай хууль”-ийг²⁴ нэмэлтээр баталж 2018 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон байна. Уг хуулийн төслийг боловсруулсан ажлын хэсгийн зөвлөмж, тайланд уг хуулийг баталан гаргах замаар холбогдох салбар эрх зүйн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хавтаст хэргийн удирдлагыг нэвтрүүлэх нэмэлт өөрчлөлтийг хийх болсон шалтгаан буюу тулгамдаж буй асуудал, түүний шийдлийг дараах байдлаар тусгасан байна.

2017 оны 4-р сарын 28-ны ХБНГУ-ын засгийн газрын хуулийн төслийн талаарх хууль зүйн болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах хорооны (6-р хороо) тогтоолын зөвлөмж, тайлан /18/9416/ ²⁵

Асуудал

²² Beschlussempfehlung und Bericht des Rechtsausschusses zu dem Gesetzentwurf der Bundesregierung Drucksache 17/12634 – vom 12. Juni 2013, Verfügbar um <https://dserver.bundestag.de/btd/17/139/1713948.pdf>

²³ Gesetzentwurf der Bundesregierung BT-Drucksache 17/12634 vom 6. März 2013, S. 3 ff, Verfügbar um <https://dserver.bundestag.de/btd/17/126/1712634.pdf>

²⁴ ХБНГУ-ын Шүүхийн үйл ажиллагаанд цахим хавтаст хэргийг нэвтрүүлэх, цаашид цахим хууль зүйн үйл ажиллагааг дэмжих тухай хууль (Gesetz zur Einführung der elektronischen Akte in der Justiz und zur weiteren Förderung des elektronischen Rechtsverkehrs, 2017).

²⁵ Beschlussempfehlung und Bericht des Ausschusses für Recht und Verbraucherschutz (6. Ausschuss) zu dem Gesetzentwurf der Bundesregierung, Deutscher Bundestag, Drucksache 18/12203, Wahlperiode 28.04.2017. Verfügbar um <https://dserver.bundestag.de/btd/18/122/1812203.pdf>

Шүүхийн байгууллагын эрхлэн явуулдаг ихэнх хянан шийдвэрлэх ажиллагаа нь олон жилийн турш цахим хэлбэрийн сонголттой байсаар ирсэн бөгөөд 2013 оны 10-р сарын 10-ны өдрийн “Шүүх байгууллагын цахим үйл ажиллагааг дэмжих тухай хууль”-иар цахим хууль зүйн үйл ажиллагааны зохицуулалтыг үндсээр нь шинэчилж, шүүх байгууллагуудын эрхлэн явуулдаг ихэнх хянан шийдвэрлэх ажиллагаа нь олон жилийн турш цахим хэлбэрийн сонголттой байсаар ирсэн. Харин эрүүгийн хавтаст хэрэг өнөөг хүртэл цаасан хэлбэрээр байгаа боловч тэдгээрт агуулагдаж буй баримт бичгийн дийлэнх нь цахим мэдээлэл боловсруулалтыг ашиглан үүсгэгдсэн байх бөгөөд өдөр ирэх тусам цахимаар дамжуулагдах зэргээр цахимжсаар байна. Энэ нь одоогийн эрх зүйн зохицуулалтаар эцсийн үр дүн нь цаасан баримт бичиг боловч шүүх хавтаст хэргийг хөтлөн явуулах үйл ажиллагаагаа цахимаар явуулах бүрэн боломжтой болсон гэсэн үг юм.

Холбооны засгийн газар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ч мөн техник технологийн дэвшлийг тусгах, эрүүгийн эрх зүйн тогтолцоог шинэчлэх зорилготой медиа сувгийг өөрчлөх урьдчилсан нөхцөл болгон цахим хавтаст хэргийг нэвтрүүлэх эрх зүйн үндсийг бий болгохоор зорьж байна. Уг ажлын хүрээнд эрүүгийн хэргийн цахим хавтаст хэрэг, үйл ажиллагааны зохицуулалтыг бусад харьяалах эрх зүйн салбартай нэгэн адил буюу 2013 онд бий болгосон эрх зүйн зохицуулалттай нийцүүлэхээр төлөвлөж байна. Мөн хууль зүйн мэргэжлийн хэрэглэгчийн давхар сувгаар дамжилгүйгээр цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны порталд шууд хандан хавтаст хэрэгтэй танилцах, ашиглах үүргийг өргөжүүлэх үүднээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд ч холбогдох нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай байна.

Шийдэл

Хуулийн төслийг нэмэлт, өөрчлөлтөөр батлах тухай. Тодруулбал, Хорооноос цахим хавтаст хэргийн удирдлагыг зөвхөн Эрүүгийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд төдийгүй бусад процессийн хууль тогтоомжид (11-23-р зүйл) тусгаж өгөхийг зөвлөж байна. Энэ нь шүүхийн байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь цахимжуулах ажлыг дуусгах сүүлийн хугацаа нь 2026 он юм. Нэмж дурдахад баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэх журмыг бүх процедурын зохицуулалтад стандартчилж, үйлчилгээнд тавигдах шаардлагын талаар хялбаршуулсан байх ёстой (StPO – Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн §32e(3); ZPO – Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §§ 169, 298a(2); VwGO – Захиргааны хэргийн шүүхийн тухай хуулийн § 55b(6) хэсгийн тус тус үзнэ үү). Шүүх, прокурорууд хавтаст хэрэгт хандах эрх олгоход илүү уян хатан хандах боломжийг олгохын тулд хавтаст хэрэгт хандах журамд өөрчлөлт оруулах шаардлагатай (StPO-E-ийн 32f хэсэг, 299-р зүйлийн (3) дахь хэсэг, VwGO-ийн 100-р зүйлийн (2) дахь хэсгийг үзнэ үү). Эцэст нь тус хорооноос Шүүхийн Үндсэн хуулийн хуульд заасан харьяаллын төвлөрөлтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шилжүүлэхийг зөвшөөрөх тухай тодорхой заалт оруулахыг зөвлөж байна (28 дугаар зүйл).

(Хэсэгчлэн авав)

Уг хуулийн холбогдох хэсгийн дагуу ХБНГУ-ын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт орсон байна. Тухайлбал тус хуулийн 1, 2 дугаар зүйлийн дагуу тус тус ЭХХШТХ-ийн 1-р бүлгийн “Хавтаст хэргийн удирдлага (менежмент) ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь харилцаа холбоо” гэсэн 4-р дэд бүлэгт “Цахим хавтаст хэргийн удирдлага (менежмент), түүнтэй холбоотой хуульд заасан арга хэмжээ авах бүрэн эрх” гэсэн 32 дугаар зүйлийг 32a, 32b, 32c, 32d, 32f, 32e гэсэн 6 дэд зүйлийн хамтаар; 8-р бүлэгт “Цахим хавтаст хэрэг дэх хувийн мэдээллийг хамгаалах; цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувийн мэдээллийг

ашиглах” гэсэн 4 зүйл (496, 497, 498, 499-р зүйл) бүхий 4-р дэд бүлгийг тус тус нэмсэн байна. Ийнхүү шүүх, прокурорын байгууллагын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны материалыг цахим хэлбэрээр ашиглах, хадгалах, дамжуулах журам, тэдгээрийн эрх зүйн үндсийг ЭХХША-ны хууль тогтоомжид баталгаажуулсан байна.

ХБНГУ-ын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль” дахь цахим хавтаст хэргийн зохицуулалтын агуулга (гарчиг)²⁶

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Дэд бүлэг 4. Хавтаст хэргийн удирдлага ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь харилцаа холбоо

- *32-р зүйл Цахим хавтаст хэргийн удирдлага, түүнтэй холбоотой хуульд заасан арга хэмжээ авах бүрэн эрх*
- *Зүйл 32а Прокурорын байгууллагууд болон шүүхүүдийн цахим харилцаа холбоо; хуульд заасан арга хэмжээ авах бүрэн эрх*
- *Зүйл 32b Прокурорын байгууллага, шүүхийн ашиглаж буй цахим баримт бичгийг бүрдүүлэх, дамжуулах; хуульд заасан арга хэмжээ авах эрх*
- *Зүйл 32с Цахим хэлбэр; хуульд заасан арга хэмжээ авах эрх*
- *Зүйл 32d Цахим дамжуулалтын үүрэг*
- *Зүйл 32e Хавтаст хэргийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор баримт бичгийг хувиргах (хөрвүүлэх)*
- *Зүйл 32f Хавтаст хэргийн шалгалт (Танилцах буюу хандах эрх); хуульд заасан арга хэмжээ авах эрх*

НАЙМДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН ХАМГААЛАЛТ БА ХЭРЭГЛЭЭ


Дэд бүлэг 4. Цахим хавтаст хэрэг дэх хувийн мэдээллийг хамгаалах; цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувийн мэдээллийг ашиглах

- *496-р хэсэг Цахим хавтаст хэрэг дэх хувийн мэдээллийг ашиглах*
- *497-р хэсэг Мэдээллийг (өгөдлийг) түүний хянах этгээдийн нэрийн өмнөөс боловсруулах*
- *498-р хэсэг Цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувь хүний мэдээллийг ашиглах*
- *499-р хэсэг Хавтаст хэргийн цахим хуулбарыг устгах*

ХБНГУ-ын Хамбург мужийн түршлага

Дээр дурдсанчлан Холбооны Бундестагаас 2017 оны 7 дугаар сарын 12-ний өдөр баталсан “Шүүхийн үйл ажиллагаанд цахим хавтаст хэргийг нэвтрүүлэх, цаашид цахим хууль зүйн үйл ажиллагааг дэмжих тухай хууль”-иар холбооны ЭХХШТХ-д эрүүгийн хавтаст хэргийг цахимаар хөтлөх хууль зүйн зохицуулалтын үндсийг тавьснаас гадна муж улсын засгийн газруудад цахим хавтаст хэргийг хадгалах хугацаа, түүнчлэн цахим хавтаст хэрэг үүсгэх, удирдах, хадгалахад хамаарах зохион байгуулалт, техникийн тогтолцооны нөхцөл, журам зэргийг батлан гаргах муж улсын хэмжээнд мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, үүнтэй холбоотой зарим бүрэн

²⁶ ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Strafprozeßordnung – StPO, 1987)



эрхийг холбогдох муж улсын яамдад шилжүүлэх бүрэн эрхийг олгосон байна. Мөн муж улс бүр цахим хавтаст хэрэгтэй холбоотой холбогдох эрх зүйн зохицуулалт, дүрэм, журмыг батлах, дагаж мөрдөх ажлыг холбооны улсын хэмжээнд 2026 оны 1-р сарын 1-ний өдөр гэхэд зохион байгуулж дуусгахаар дээрх хуульд зохицуулсан.

Дээрх зохицуулалтын дагуу ХБНГУ-ын муж улс бүр уг ажлыг өөр хоорондоо харилцан адилгүйгээр хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа олон жишээ байна (Хамбург, Баден-Вюртемберг, Байерн г.м). Эдгээр мужуудаас энд ХБНГУ-ын Хамбург мужийн туршлагыг энд дурдаж болно.

Хамбург мужийн засгийн газраас (парламент) 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр “Хамбург мужийн шүүхүүд дэх цахим хавтаст хэргийн удирдлагын тухай журам”-ыг батлан гаргасан байна²⁷. Уг журмаар цахим хавтаст хэргийн удирдлагын талаар илүү нарийн зохицуулалтыг хийсэн бөгөөд тухайлбал,

- Эрүүгийн хэрэг болон зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль (StPO, OWiG);
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (ZPO);
- Гэр бүлийн маргаан болон маргаангүй харьяал бүхий нэхэмжлэл хянан шийдвэрлэх тухай хууль (FamFG);
- Хөдөлмөрийн шүүхэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль (ArbGG);
- Нийгмийн шүүхийн тухай хууль (SGG);
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (VwGO);
- Санхүүгийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (FGO) зэрэг хуулиудтай холбоотой цахим хавтаст хэргийн удирдлага болон гомдол, нэхэмжлэлийг цахимаар гаргах журмыг нарийвчлан зохицуулсан байна.

Ийнхүү Хамбург мужид 2019 оноос цахим хавтаст хэргийн удирдлагыг шүүхийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн, хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаандаа ашиглаж нэвтрүүлэх ажил амжилттай явагдаж байна. Үүнийг “Хамбург мужийн шүүхүүд дэх цахим хавтаст хэргийн удирдлагын тухай журам”-ын хавсралт 1 дүгээр хавсралт дахь уг журам үйлчлэх мужийн шүүх болон прокурорын байгууллагуудын жагсаалтаас харж болох бөгөөд тус мужийн цахим хавтаст хэргийн удирдлагатай холбоотой журам, зохицуулалт улам бүр нарийвчилсан болж шинэчлэгдсээр байна²⁸.

ХБНГУ-ын Хамбург мужийн “Хамбург мужийн шүүхүүд дэх цахим хавтаст хэргийн удирдлагын тухай журам”-ын агуулга (гарчиг)²⁹

- § 1. Цахим хавтаст хэргийн хөтлөх журам
- § 2. Цахим хавтаст хэрэг үүсгэх
- § 3. Цаасан баримт бичгийг цахим хэлбэрт хувиргах
- § 4. Цахим хавтаст хэргийг дамжуулах
- § 5. Орлуулах арга хэмжээ

²⁷Verordnung über die elektronische Aktenführung in der Hamburger Justiz (HmbEAktFVO, 2019) Verfügbar um <https://www.landesrecht-hamburg.de/bsha/document/jlr-JElektAktfVHAV9Anlage1/part/X>

²⁸ Elektronische Akte in der Justiz, 2024.02.28, <https://justiz.hamburg.de/e-justice/elektronische-akte-in-der-justiz> zuletzt besucht 2024.03.20.

²⁹ Elektronische Akte in der Justiz, 2024.02.28, <https://justiz.hamburg.de/e-justice/elektronische-akte-in-der-justiz> zuletzt besucht 2024.03.20.

§ 6. Хүртээмжтэй байдал

Хавсралт 1 - Журам үйлчлэх шүүх, прокурорын байгууллагуудын жагсаалт

Хавсралт 2 - Журам үйлчлэх Хамбург мужийн дээд шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаа, үйлчилж эхлэх хугацаа

Хавсралт 3 - Цахим хэлбэрт шилжүүлэх цаасан хэлбэрээр байгаа үндсэн хавтаст хэрэг/бүртгэлийн хавтаст хэргийн жагсаалт


Хавсралт 4 - Цаасан хэлбэрээр үүсгэсэн хавтаст хэргийг цахим үргэлжлэлийг 1-р хэсгийн 1-р зүйлийн 4-р зүйлийн 1-р зүйлийн дагуу захиалах журам, хугацаа

Дээрхээс дүгнэвэл, ХБНГУ-ын хувьд олон тооны хууль тогтоомжид өөрчлөлт оруулж шүүх байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулах буюу хуульч, эрх бүхий байгууллагууд шүүхүүдтэй харилцахдаа цахим хэлбэрээр харилцах, шүүхийн үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичгийг цахимаар дамжуулах арга, хэрэгслийг тодорхойлох зэрэг асуудлын эрх зүйн үндсийг тавьсан боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд төдийлэн өөрчлөлт ороогүй байсан. Улмаар 2017 оны 7 дугаар сарын 12-ний өдөр Бундестагаас нэмэлтээр “Шүүхийн үйл ажиллагаанд цахим хавтаст хэргийг нэвтрүүлэх, цаашид цахим хууль зүйн үйл ажиллагааг дэмжих тухай хууль”-д нэмэлт оруулж үүний дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар цахим хавтаст хэргийн зохицуулалт бий болсон байна. Энэхүү зохицуулалтад цахим хавтаст хэргийн удирдлага, түүнтэй холбоотой хуульд заасан арга хэмжээ авах бүрэн эрх, прокурорын байгууллагууд болон шүүхүүдийн цахим харилцаа холбоо, прокурорын байгууллага, шүүхийн ашиглаж буй цахим баримт бичгийг бүрдүүлэх, дамжуулах; хуульд заасан арга хэмжээ авах эрх, цахим хавтаст хэрэг дэх хувийн мэдээллийг ашиглах, мэдээллийг түүний хянах этгээдийн нэрийн өмнөөс боловсруулах, цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувь хүний мэдээллийг ашиглах гэх мэт боловсронгуй, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, үйл ажиллагааг үр дүнтэй болгоход чиглэсэн олон нарийвчилсан зохицуулалт орсон нь сайн жишиг болж байна. Мөн түүнчлэн холбооны хэмжээнд бус мужийн хэмжээнд нарийвчилсан, боловсронгуй зохицуулалтууд бий болсон байна. Тухайлбал, Хамбург мужийн засгийн газраас 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан “Хамбург мужийн шүүхүүд дэх цахим хавтаст хэргийн удирдлагын тухай журам”.

Монгол Улсын хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим хавтаст хэргийн талаар тусгахдаа ХБНГУ-тай адилаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн зохицуулалтыг сүүлд нь зохицуулж байгаа тул ХБНГУ-ын сайн жишгийг баримтлах нь зүйтэй байна. Тодруулбал, цахим хавтаст хэргийн удирдлага, түүнтэй холбоотой хуульд заасан арга хэмжээ, прокурорын байгууллагууд болон шүүхүүдийн цахим харилцаа холбоо, прокурорын байгууллага, шүүхийн ашиглаж буй цахим баримт бичгийг бүрдүүлэх, дамжуулах; хуульд заасан арга хэмжээ, цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувь хүний мэдээллийг ашиглах гэх мэт боловсронгуй зохицуулалтын агуулга, зарчмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн тусгах шаардлагатай.

Бүгд Найрамдах Эстони Улсын сайн туршлага

Эстони улсын хувьд бусад улс орнуудтай харьцуулхад шүүхийн байгууллагын үйл ажиллагаа харьцангуй эрт буюу 2009 оноос нэвтэрч эхэлсэн бөгөөд шүүхийн үйл ажиллагааг дижитал болгосноор улс орны эдийн засаг, төрийн үйлчилгээний чанар,



хөдөлмөрийн зах зээл, бизнесийн өсөлт зэргийг нэмэгдүүлнэ хэмээн үзсэн байна. Сүүлийн 15 жилийн хугацаанд Эстони улс шүүхийн тогтолцоог дижитал болгоход ихээхэн хүчин чармайлт гаргасан бөгөөд шүүхийн удирдлага, үйл ажиллагаа, шүүх болон бусад талуудын харилцаа холбоонд мэдээлэл, харилцаа холбооны хамгийн сүүлийн үеийн технологийг нэвтрүүлсэн орны нэг юм³⁰.

Эстони улсын шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагын цахимжуулалт

Эстони улс шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааныхаа хурдаараа Европт хоёр дугаарт ордог. Эстони улсын цахимжуулсан шүүхийн систем нь цахим хавтаст хэргийн төв мэдээллийн систем (e-File), шүүхийн мэдээллийн систем (KIS), иргэд болон бусад талуудад зориулсан олон нийтийн портал гэсэн үндсэн гурван хэсгээс бүрддэг.

Цахим хавтаст хэргийн систем буюу e-File нь Эстонийн шүүхийн системийн хамгийн чухал нь юм. Энэхүү төв мэдээллийн систем нь шүүхийн мэдээллийн систем болох KIS2, цагдаа, хорих байгууллага, прокурор, эрүүгийн хавтаст хэргийн удирдлагын мэдээллийн системийг датагаар хангадаг. Мэдээллийг нэг л удаа оруулдаг тул цахим хавтаст хэрэг (e-File) нь цаг хугацаа, мөнгө хэмнэдэг бөгөөд талуудын хоорондын бүх харилцаа цахим хэлбэрээр явагддаг.

Эстонийн **шүүхийн мэдээллийн систем KIS2**³¹ нь шүүхийн бүхий л хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдах цогц шийдэл юм. Энэхүү цогц шийдлийг Хууль зүйн яам Эстонийн шүүхүүдэд хариуцан хэрэгжүүлсэн бөгөөд 2014 оноос эхлэн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.

Эстонийн шүүхүүдэд тулгарч байсан хамгийн том хүндрэл бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чухал баримт бичгүүдийг талуудад хүргэх явдал байсан. Энэхүү асуудлыг шүүхийн **олон нийттэй харилцах портал e-File**³² шийдэж, шүүхэд виртуал хэлбэрээр олон нийттэй харилцах боломжийг олгосон. Энэхүү портал дээр тал бүрийн хэрэг үүсгэж, аливаа баримт бичигт хандаж, илгээх боломжтой. Анхны нэхэмжлэлийг 24/7 нийтийн порталаар дамжуулан гаргаж болно. Ажлын урсгалын хөдөлгүүр нь хуваарилагдсан шүүгчид шаардлагатай өгөгдлийг порталаар дамжуулан хүргэдэг.

Эстонийн шүүхүүд дэх мэдээлэл, харилцаа холбооны технологийн (ICT) түүх

- 2002 он – Шүүхийн шийдвэрүүд болон статистик тоо баримт нийтлэх зорилгоор анхны шүүхийн цахим мэдлээллийн систем KOLA нэвтрүүлэв.
- 2006 он – Баримт бичгийн удирдлагыг хэрэгжүүлэх, автоматжуулсан мэдэгдэл, урилга зэргийг илгээх үндсэн чиг үүрэг бүхий 1-р үеийн цогц шүүхийн мэдээллийн систем KIS-г хэрэглээнд нэвтрүүлэв.
- 2009 он – анхны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талууд (цагдаа, прокурор, хуульч, өмгөөлөгч, иргэд г.м) хороондоо харилцах боломж бүхий олон нийттэй харилцах порталыг хэрэглээнд нэвтрүүлэв.

³⁰ Factsheet E-Justice. Available at <https://e-estonia.com/wp-content/uploads/2020mar-facts-a4-v04-e-justice.pdf>

³¹ БНЭСУ-ын Шүүхийн мэдээллийн системийн, <https://www.rik.ee/en/international/court-information-system>

³² БНЭСУ-ын Шүүхийн олон нийттэй харилцах порталын вебийн <https://www.rik.ee/en/international/public-e-file>

- 2013-2014 он – 2-р үеийн шүүхийн мэдээлэл KIS2 системийг хэрэглээнд нэвтрүүлэв.
- 2015 он – Цаасгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэв.
2017 он – Торгуулийг автоматаар хураадаг болов.

Эстони улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дахь цахим хавтаст хэргийн зохицуулалт

Өмнөх хэсэгт дурдсанчлан Эстони улс нь шүүхийн үйл ажиллагаа буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаа бүрэн цахимжуулсан бөгөөд ЭХХША-нд хавтаст хэргийн E-File системийг нэвтрүүлсэн байна. Эстони улсын ЭХХШТХ-даа Цахим хавтаст хэргийн систем E-file-н (210-р зүйл) талаар болон бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе дэх цахим хавтаст хэргийн системийг ашиглах зохицуулалтын тус тус хийсэн байна.

БНЭсУ-ын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль” дахь цахим хавтаст хэргийн (E-File) зохицуулалт³³

§ 149. Гэрэл зураг

(3) Дижитал гэрэл зургийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аливаа шийдвэрт тусгаж, эсхүл хавсралт болгон танилцуулж, компьютерийн файл хэлбэрээр цахим хавтаст хэргийн системд (E-File) хадгална. Дижитал гэрэл зураг нь видео бичлэгээс авсан дан зураг (скрийн шот) байж болно.

[RT I 2008, 28, 180 - 2008.07.15 хүчин төгөлдөр болсон]

§ 156¹. Шүүх хуралдааны бичлэг, тэмдэглэлийг шалгах

(4) Шүүх хуралдааны дууны (аудио) бичлэгийн хуулбарыг шүүхийн байгууллага холбогдох хүсэлтийг гаргаснаас хойш гурав хоногийн дотор дижитал мэдээллийн хэрэгслээр гаргах буюу цахим хэрэгслээр илгээнэ. Шүүх хуралдааны аудио бичлэгийг цахим хавтаст хэргийн системээр (E-File) прокурорт нээлттэй болгож байна.

§ 156². Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг шүүх хуралдаанд бэлэн болгох

(1) Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх баримт бичгийг шүүх хуралдааны оролцогчдод хэрхэн хүргэж байгаагаас үл хамааран E-File систем дэх шүүх хуралдаанд оролцогчдод нэн даруй нээлттэй болгоно.

§ 160¹. Хавтаст хэрэг

(5) Шүүхийн хэргийг дижитал хэлбэрээр хөтөлж байгаа бол цаасан баримтыг сканнердаж, холбогдох журмын дагуу цахим файлын системд хадгална. E-File систем нь баримт бичгийн хадгалагдсан хугацаа, түүнийг хадгалж буй хүний мэдээллийг автоматаар бүртгэнэ. Цахим файлын системд хадгалагдсан баримт бичиг цаасан баримтыг орлоно.

§ 160². Цахим (дижитал) баримт бичгийг дамжуулах

(1) Энэ хуульд өөрөөр заагаагүй бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахим (дижитал) хүсэлт, давж заалдах болон бусад баримт бичгийг шууд буюу цахим хавтаст хэргийн системээр (E-File) дамжуулна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллага нь шууд илгээсэн цахим баримт бичгийг (дижитал) цахим хавтаст хэргийн системд (E-File) оруулна.

³³ БНЭсУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Kriminaalmenetluse seadustik, 2003) <https://www.riigiteataja.ee/akt/104102013004>

[RT I 2008, 28, 180 - 2008.07.15 хүчин төгөлдөр болсон]

(2) Цахим (дигитал) баримт бичгийг эрүүгийн хавтаст хэрэгт хавсаргахын тулд баримт бичгийг хэвлэж, хавтаст хэрэгт оруулна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллага нь хэвлэсэн баримт бичгийн үнэн зөв, тоон баримт бичигтэй тохирч байгааг өөрийн гарын үсгээр баталгаажуулж, цахим хавтаст хэргийн системд (E-File) тухайн баримт бичгийн таних дугаарыг нэмж оруулна.

[RT I 2008, 28, 180 - 2008.07.15 хүчин төгөлдөр болсон]

§ 165. Бичгээр зарлан дуудах хуудас хүргэх журам

(4) Хэрэв зарлан дуудах хуудсыг цахим хавтаст хэргийн системээр (E-File) дамжуулан авах боломжтой бол дуудагдсан этгээдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичигт заасан цахим шуудангийн хаягаар нь зарлан дуудах хуудас байгаа тухай мэдэгдэнэ. Ийнхүү шүүхийн зарлан дуудаж байгаа мэдэгдэлд цахим хавтаст хэргийн (E-File) систем дэх тоон (дигитал) зарлан дуудах хуудасны лавлагааг хавсаргах бөгөөд түүнд хандах хугацаа нь зарлан дуудах хуудас илгээсэн өдрөөс хойш гурав хоног байна. Илгээгч болон түүнийг илгээсэн цагийг E-File системээр тодорхойлох боломжтой бол зарлан дуудах хуудасны хамт тоон гарын үсэг оруулахгүй. Хүлээн авагч нь баримт бичгийг нээлгүйгээр мэдээллийн системд нээсэн буюу мэдээллийн системд хүлээн авснаа баталгаажуулсан бол цахим файлын системээр дамжуулан авах боломжтой зарлан дуудах хуудсыг хүргүүлсэн гэж үзнэ. Мэдээллийн систем дэх баримт бичгийг хүлээн авагч идэвхжүүлсэн. Хэрэв зарлан дуудах хуудсыг илгээсэн өдрөөс хойш гурав хоногийн дотор цахим хавтаст хэргийн системээр хүлээн аваагүй бол зарлан дуудах хуудсыг шуудангаар илгээх, эсхүл зарлан дуудагдаж буй этгээдэд өөр нь гардуулна. [ТХГН-ийн I, 2013.03.22, 9 - хүчин төгөлдөр болох 2013.04.01]

(5) Гарын үсгийн эсрэг зарлан дуудах хуудас гардуулах тухай мэдэгдэл, шуудангийн үйлчилгээ үзүүлэгчээс гаргасан хүргэлтийн мэдэгдэл, зарлан дуудах хуудас олгох тухай цахим шуудангийн хэвлэмэл материал, зарлан дуудах хуудсыг хүлээн авсныг баталгаажуулсан цахим шуудангийн хэвлэмэл материалууд зэргийг хавтаст хэрэгт хавсаргана. E-File системээр дамжуулан зарлан дуудах хуудас хүлээн авсан бол хүлээн авсан тухай баримтыг цахим хавтаст хэргийн системд бүртгэж, хэвлэмэл хэлбэрээр хавтаст хэрэгт тусгахгүй.

[RT I, 2011.02.23, 1 - 2011.09.01 хүчин төгөлдөр болсон]

(6) Хууль зүйн сайд нь шүүх хуралдааны явцад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг цахим хавтаст хэргээр (E-File) дамжуулан хүргэхэд илүү тодорхой шаардлагыг журмаар тогтоож болно.

[ТХГН-ийн I, 2013.03.22, 9 - хүчин төгөлдөр болох 2013.04.01]

§ 210. Цахим хавтаст хэргийг боловсруулах мэдээллийн систем (E-File)

(1) Цахим хавтаст хэргийг боловсруулах мэдээллийн систем (цаашид энд E-File гэнэ) нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээлэл, хувийн увийн мэдээллийг боловсруулахад зориулагдсан төрийн мэдээллийн системд хамаарах мэдээллийн сан бөгөөд дараахь зорилготой.

- 1) Мөрдөн шөлгөх байгууллага, прокурор, шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа, түүнчлэн эхлээгүй эрүүгийн хэргийн талаархи тоймыг өгөх;
- 2) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гүйцэтгэгдсэн ажиллагааны мэдээллийг тусгах;
- 3) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллагуудын үйл ажиллагааг зохион байгуулах боломжийг олгох;
- 4) эрүүгийн бодлогын талаар шийдвэр гаргахад шаардлагатай гэмт хэрэгтэй холбоотой статистик мэдээллийг цуглуулах;
- 5) өгөгдөл, баримт бичгийг цахим хэлбэрээр дамжуулах боломжийг бүрдүүлэх.

(2) Мэдээллийн санд дараах мэдээллийг оруулна.


- 1) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй эрүүгийн хэрэг, эхлээгүй, дуусгавар болсон эрүүгийн хэргийн талаархи мэдээлэл;
 - 2) эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гүйцэтгэгдсэн ажиллагааны талаарх мэдээлэл;
 - 3) энэ хуульд заасан тохиолдолд цахим (дигитал) баримт бичиг;
 - 4) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллага, хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид, ял шийтгүүлсэн этгээд, шинжээч, гэрчийн талаарх мэдээлэл; [RT I, 2011.02.23, 1 - 2011.09.01 хүчин төгөлдөр болсон]
 - 5) Шийдвэрүүд.
- (3) Цахим хавтаст хэргийн системийг бий болгох, түүний ажиллагааны журмыг батлах ажлыг Бүгд Найрамдах Улсын Засгийн газар гүйцэтгэнэ.
 - (4) Цахим хавтаст хэргийн системийн ерөнхий процессор (боловсруулагч) нь Хууль зүйн яам юм. E-File системийн эрх бүхий процессор нь Хууль зүйн сайдын томилсон хүн байна.
 - (5) Хууль зүйн сайдын зүгээс E-File системийн үйл ажиллагааны зохион байгуулалтын журмыг батлан гаргаж болно.
 - (6) Хууль зүйн яам E-File системийн мэдээлэлд үндэслэн жил бүрийн 3-р сарын 1-ний дотор өмнөх оны гэмт хэргийн тайланг нийтэлнэ.
 - (7) Гэмт хэргийн статистик мэдээллийг Хууль зүйн яам нийтэлнэ.
 - (8) Гэмт хэргийн статистик мэдээг нийтлэх журмыг Бүгд Найрамдах Улсын Засгийн газар тогтооно. [RT I 2008, 28, 180 - 2008.07.15 хүчин төгөлдөр болсон]

Дээрхээс дүгнэвэл, Бүгд Найрамдах Эстони Улс нь цахим хавтаст хэргийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд чухалчилж авч үздэг болох нь тодорхойлогдож байна. Тус улс нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульдаа энэ тухай хуульчилж гэрэл зураг, шүүх хуралдааны бичлэг, тэмдэглэлийг шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг шүүх хуралдаанд бэлэн болгох, цахим хавтаст хэргийн ерөнхий зохицуулалт, цахим баримт бичгийг дамжуулах, бичгээр зарлан дуудах хуудас хүргэх журам, цахим хавтаст хэргийг боловсруулах мэдээллийн системийн талаар нарийвчлан авч үзсэн нь сайн жишиг болохоор байна. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим хавтаст хэргийн зохицуулалтыг тусгахдаа тус улсын жишгийг харгалзан үзэх нь зүйтэй.

Америкийн Нэгдсэн Улсын сайн туршлага

New York-д e filing(цахим хавтас хэрэг, бүртгэл) нь анх 1999 онд хязгаарлагдмал тооны газруудад жижиг ангиллын хэрэгт хэрэглэх эрхтэй болсон. 1999 онд цахим хэлбэрээр хэрэг ирүүлээгүй. 13 жилийн дараа Хууль тогтоох байгууллага цахим мэдүүлгийг ашиглах зөвшөөрлийг аажмаар өргөжүүлснээр ихээхэн ахиц дэвшил гарсан. Нью-Йорк мужын шүүхийн цахим мэдүүлгийн системийн бүртгэлтэй 21,000 гаруй хэрэглэгчийн 350,000 орчим хэрэгт 1,3 сая гаруй баримт бичгийг Нью-Йоркийн шүүхэд цахим хэлбэрээр ("NYSCEF") өгсөн байна.

Нью-Йоркт үүсгэн байгуулагдсанаасаа хойш цахим хавтаст хэрэг нь найдвартай, үр ашигтай, тохиромжтой, аюулгүй болох нь батлагдсан. NYSCEF хөтөлбөр нь шүүхийн байр руу явах шаардлагагүйгээр шүүхийн баримт бичгийг бараг л агшин зуур, хүссэн үедээ, хаанаас ч гаргаж өгөх боломжийг олгодог. Өмгөөлөгч нар өдөр, шөнийн аль ч цагт, интернэт холболттой аль ч газраас онлайнаар хэргийн материалаа үзэх боломжтой. Цахим мэдүүлэг нь баримт бичгийг хадгалах, сэргээх, хуулбарлах зардлыг эрс багасгах, эсрэг талуудад бичиг баримт өгөх ачаа, зардлыг ихээхэн хэмжээгээр



арилгах, баримт бичгийг бүрдүүлэх, авахын тулд шүүхийн байранд очиход зарцуулах үнэ цэнэтэй алдагдсан цагийг арилгах боломжтой юм. Цахим мэдүүлэг нь шүүхийн оролцогчид, өмгөөлөгчид, шүүхүүд болон дүүргийн бичиг хэргийн ажилтнуудад ихээхэн хэмжээний зардлыг хэмнэх мөн бүх нийтийн цахим мэдүүлэг нь Нью-Йоркийн шүүхэд зарга мэдүүлж буй хувь хүмүүс, аж ахуйн нэгжүүд, муж, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын зардлыг хэдэн зуун сая доллараар бууруулах боломжтой гэж тооцоолж байна. Мөн цахим мэдүүлэг нь хууль зүйн тогтолцооноос илүү ногоон, байгаль орчинд ээлтэй хандлагыг тусгаж, жил бүр олон мянган тонн цаасны хэрэглээг арилгах юм.

Холбооны шүүхэд цахим хавтаст нь Нью Йоркоос илүү хурдацтай явагдаж байна. АНУ-ын дүүргийн шүүхүүдэд 2002 онд, давж заалдах шатны шүүхүүдэд 2005 онд хэрэгжиж эхэлсэн. Холбооны шүүхэд цахим мэдүүлэг гаргах нь заавал байх ёстой бөгөөд холбооны шүүхийн үйл ажиллагаа болон холбооны хуулийн практикт үндсэн бөгөөд хүлээн зөвшөөрөгдсөн бүрэлдэхүүн хэсэг болсон. ECF системийг иргэний болон эрүүгийн хэргийн бүх дүүргийн шүүх, улсын хэмжээнд дампуурлын шүүх, бүх бүс нутгийн давж заалдах шатны шүүх, Холбооны нэхэмжлэлийн шүүх, Олон улсын худалдааны шүүхэд ашиглаж байна. Холбооны шүүхэд сар бүр зургаан сая гаруй баримт бичгийг цахим хэлбэрээр илгээдэг бөгөөд 500,000 гаруй өмгөөлөгч цахим мэдүүлгийн системийг ашигладаг.


Улсын хэмжээнд улсын шүүхэд цахим мэдүүлэг гаргах нь жишиг болж байна. Одоогоор 41 мужид зөвшөөрөгдсөн бөгөөд үлдсэн ихэнх мужид хэрэгжих төлөвтэй байна. АНУ-ын мужын анхан шатны шүүхүүдийн ихэнх нь орон нутгийн удирдлагатай байдаг тул эдгээр шүүхэд цахим мэдүүлгийг хэрэгжүүлэх нь муж тус бүрээр явагддаг бөгөөд ихэвчлэн туршилтын хөтөлбөрүүдэд зориулсан шүүхийн дүрэм мөн хуулиар тогтоосон зөвшөөрөл дагалддаг³⁴.

Case Management/Electronic Case Files Хэргийн менежмент/Цахим хэргийн файлууд (CM/ECF) нь нэхэмжлэл, хүсэлт, өргөдөл зэрэг хэргийн баримт бичгийг шүүхэд онлайнаар илгээх боломжийг олгодог холбооны шүүхийн систем юм. CM/ECF-ийг өмгөөлөгчид, АНУ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч, дампуурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч нар ихэвчлэн ашигладаг. Зарим шүүхүүд дампуурлын нэхэмжлэгч болон нэхэмжлэлийн шаардлагыг хангаж буй хүмүүст CM/ECF ашиглан мэдүүлэг гаргахыг зөвшөөрдөг³⁵.

NYSCEF хөтөлбөр нь өмгөөлөгчид болон өөрийгөө төлөөлж буй заргалдагч тал шүүхийн байр руу явах шаардлагагүйгээр өдрийн аль ч цагт, аль ч газраас шүүхийн баримт бичгийг бүрдүүлж, үйлчлэх боломжийг олгодог. Мөн NYSCEF нь интернетэд холбогдсон өмгөөлөгчдөд хавтаст хэргийг хүссэн үедээ хаанаас ч үзэх боломжийг олгодог. NYSCEF нь тусгай техник хангамж, програм хангамж шаарддаггүй. Харин цахим мэдүүлэг гаргахад шаардлагатай тоног төхөөрөмж нь : компьютер, үндсэн (software) программ хангамж (вэб хөтөч болон Adobe гэх мэт PDF/A уншигч/ бичигч), интернет холболт, сканнер. Баримт бичгийг бүрдүүлэхийн тулд өмгөөлөгч эсвэл өөрийгөө төлөөлж буй шүүхийн оролцогч нь хэрэглэгчийн ID, нууц үг авах ёстой бөгөөд энэ нь онлайнаар хийгддэг энгийн процесс юм. Ганц хэрэглэгчийн ID болон нууц үг нь Нью-Йоркт бүртгэлтэй өмгөөлөгчид аль ч муж, шүүх, цахим мэдүүлэг өгөх эрх бүхий хэрэгт цахим мэдүүлэг гаргах боломжийг олгодог. NYSCEF-ийн иргэний хэргийн хавтаст хэрэгт

³⁴ Electronic Filing in Criminal Actions and Proceedings: A REPORT TO THE GOVERNOR, LEGISLATURE AND CHIEF JUDGE, page 10
https://ww2.nycourts.gov/sites/default/files/document/files/2018-06/eFile_Criminal_Report%20April%2019.pdf

³⁵ Electronic Filing (CM/ECF), <https://www.uscourts.gov/court-records/electronic-filing-cmecf>



байгаа нууцлалгүй, битүүмжлэлгүй баримт бичгүүдийг онлайн зочноор үзэхийн тулд хэрэглэгчийн ID болон нууц үг шаардлагагүй байдаг (олон нийт гэр бүлийн болон эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд цахимаар бүрдүүлсэн баримт бичигт хандах боломжгүй). Шүүхийн ердийн хураамжаас гадна NYSCEF-ийг ашиглахад ямар ч төлбөр байдаггүй байна.

NYSCEF нь хэрэглэгчдэд ээлтэй ба цахимаар мэдүүлэх баримт бичгүүдийг эхлээд баримт бичгийг боловсруулсны дараа PDF/A формат руу программ хангамжийн хөрвүүлэлт эсвэл сканнераар дамжуулан хөрвүүлдэг бөгөөд энэ нь өнөөгийн ихэнх өмгөөлөгчдийн мэддэг энгийн процесс юм. Цахим файл үүсгэгч нь хэрэглэгчийн ID болон нууц үгээр NYSCEF-д нэвтэрч, дэлгэцэн дээрх зааврыг дагаж баримтыг NYSCEF систем рүү оруулна. Баримт бичгийг дамжуулсны дараа NYSCEF нь цахим файл илгээгч болон хэргийн бусад цахим мэдүүлэг гаргагч талуудад хүлээн авсан тухай имэйл мэдэгдлийг автоматаар үүсгэдэг. Шинээр бүрдүүлсэн баримт бичгийн аюулгүй холбоосыг агуулсан эдгээр мэдэгдэл нь тухайн баримт бичгийн оролцогч хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээг бүрдүүлдэг. Цахим хэлбэрээр эхэлсэн тохиолдолд ч гэсэн цаасан хэлбэрээр биечлэн ирүүлэх ёстой баримт бичгээс бусад тохиолдолд талууд эсрэг талуудад бичиг баримт өгөх ачааллаас чөлөөлөгддөг - NYSCEF нь энэ үүргийг автоматаар гүйцэтгэж, бүртгэдэг.³⁶


Дээрхээс дүгнэвэл, АНУ-ын хэмжээнд шүүхэд цахим мэдүүлэг гаргах, цахим хавтаст хэрэг бүрдүүлэх нь жишиг болж байна. Одоогоор 41 мужид зөвшөөрөгдсөн бөгөөд үлдсэн ихэнх мужид хэрэгжих төлөвтэй байна. Тус шинэчлэлт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хөнгөвчилж, хэргийн оролцогч, өмгөөлөгчдөд бий болох саад бэрхшээлийг арилгах үр дүнтэй өөрчлөлт болсон байна. Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн боловсруулалтыг техник технологи талаас нь боловсронгуй болгосон ба үүнийг ашиглахад ямар нэг төлбөр хураамж авдаггүй нь сайн жишиг болж байна.

Бүгд Найрамдах Солонгос Улсын сайн туршлага

Бүгд Найрамдах Солонгос Улсад цахим хавтаст хэрэг нь эрүүгийн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүрэлдэхүүнд хамаардаг. Эрүүгийн хэргийн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэдэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг цахим баримт хэлбэрээр бэлтгэх, ирүүлэх, удирдах, үйлчлэх, үзэх, хадгалах зэрэг үйл ажиллагааг хамаардаг. Эрүүгийн хэргийн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь цаасан баримтаас илүү цахим баримт дээр суурилдаг тул талууд баримт бичгийг цахим хэлбэрээр бүрдүүлж, хүлээн авч, шүүх нь цаасан хэрэг хөтлөлтийн оронд цахим бүртгэл үүсгэж, удирддаг.

2010 онд патентын маргаанаас эхлэн иргэний хэрэг, захиргааны хэрэг, ахуйн хэрэг, дампуурлын хэрэг зэрэг эрүүгийн хэргээс бусад шүүхийн ихэнх ажиллагаанд цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем хэрэгжиж эхэлсэн байна. Гэвч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хараахан нэвтрээгүй байгаа нь олон чирэгдэл учруулж байна.

³⁶ Electronic Filing in Criminal Actions and Proceedings: A REPORT TO THE GOVERNOR, LEGISLATURE AND CHIEF JUDGE, page 8
https://ww2.nycourts.gov/sites/default/files/document/files/2018-06/eFile_Criminal_Report%20April%202019.pdf



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэвтрүүлэх шаардлагатай гэдэг дээр нэгдсэн байр суурь бий болж байгаатай байгаатай холбогдуулан 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн БНСУ-ын парламентын чуулганы нэгдсэн хуралдаанаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хуулийг баталсан. Улмаар үүний дагуу 2024 оны 10-р сарын 20-ны өдрөөс эхлэн бүрэн хэмжээний эрүүгийн цахим шүүх хуралдааныг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Эрүүгийн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэвтрүүлэхийн ач холбогдол:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх.

Цахим эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэвтрүүлснээр шүүх хуралдааны оролцогчид цаг хугацаа, газар нутгаас үл хамааран эрүүгийн хэргийн талаарх мэдээллийг хялбархан авах боломжтой болно. Эрүүгийн хэргийн талаарх мэдээллийг ил тод, системтэй, эргэлт буцалтгүй удирддаг тул эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа илүү ил тод, шударга явагдах боломжтой.

- Шүүгчдийн үндсэн эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахим хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цахим бүртгэлээр хэрэг бүртгэлтийг шуурхай үзэж, удирдаж, хэргийн гол асуудлуудыг түргэн шуурхай тодорхойлох боломжтой болж, улмаар шүүгчдийн шүүх хурлыг шударгаар, шуурхай шийдвэрлүүлэх, шүүх хуралдаанд оролцогч талуудын эрх ашгийг дээшлүүлэх, өмгөөлөх эрх, хохирогчийн үйл ажиллагаанд оролцох эрх зэрэг багтана. Үндсэн эрхийг илүү өндөр түвшинд баталгаажуулсан.

- Цаасан бүртгэлийн хязгаарлалтыг даван туулах хурдан бөгөөд үр дүнтэй журам

Цахим эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд шүүхийн гишүүд болон шүүгчдэгч, өмгөөлөгч, прокурор хэрэгтэй зэрэгцэн танилцах боломжтой болж, шүүх хуралдааныг илүү нарийвчилсан байдлаар явуулах боломжтой болсон. Цахим хэрэг бүртгэлийг удирдан, цахим баримт бичгийг хүргэснээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа илүү хурдан, үр дүнтэй явагдаж, цаасан хэрэг үүсгэх, хүргэх, хадгалахад шаардагдах хугацаа, зардлыг бууруулах боломжтой³⁷.

2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хуулийн зорилго нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт бичгийг ашиглах, удирдах үндсэн зарчим, журмыг тогтоосноор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай, ил тод байдлыг нэмэгдүүлэх, иргэдийн эрх ашгийг хамгаалах юм. Тус хуулийн 2 дугаар зүйлд “Цахим хавтаст хэрэг” болон “Цахимжуулсан хавтаст” хэргийг дараах байдлаар тодорхойлсон.

³⁷ 미리 보는 형사전자소송, https://help.scourt.go.kr/nm/min_9/min_9_9/index.html

Цахим хавтаст хэрэг - Цахим баримт болон цахим гүйлгээний суурь хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу мэдээлэл боловсруулах системээр цахим хэлбэрээр бэлтгэсэн, дамжуулсан, хүлээн авсан, хадгалсан мэдээлэл³⁸

Цахимжуулсан хавтаст хэрэг - Цаасан баримт болон бусад хэлбэрээр цахим байдлаар бэлтгээгүй баримт, эсхүл зураг, гэрэл зураг, дуу, дүрсний өгөгдөл гэх мэт /цаашид “дигитал баримт бичиг” гэх/-ийг цахим хэлбэрт шилжүүлж, компьютержсэн мэдээлэл болгон боловсруулах. Энэ нь системд бүртгэгдсэн цахим баримт бичигт хамаарна³⁹.

2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хуульд дараах үйл ажиллагааг тусгасан⁴⁰.

БНСУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хуулийн зохицуулалт

Зүйл заалт, агуулга	Зохицуулалтын агуулга
5 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим баримт бичгээр гүйцэтгэх	<ul style="list-style-type: none"> - Сэжигтэн, шүүгдэгч, хохирогч, гомдол гаргагч, мэдээлэгч, өмгөөлөгч болон Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн журамд заасан бусад этгээд 7 дугаар зүйлд заасны дагуу хэрэглэгчээр бүртгүүлсэн бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарна. Баримт бичиг, зураг, гэрэл зураг, аудио, дүрс бичлэгийн материалыг Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасны дагуу мэдээлэл боловсруулах цахим системээр дамжуулан цахим баримт бичиг хэлбэрээр гаргаж болно. - Шаардлагыг хангасан цахим баримт бичгийг энэ хуульд заасны дагуу бэлтгэж, ирүүлсэн, хүргүүлсэн, хадгалсан бол тухайн баримт бичгийг бэлтгэсэн, ирүүлсэн, хүргүүлсэн, хадгалсанд тооцно. - Энэ хуулийн дагуу цахимжуулсан, бүртгүүлсэн баримт бичиг нь дигитал хэлбэрт шилжих баримт бичигтэй адил байна. - Энэхүү хуульд заасны дагуу компьютержсэн мэдээлэл боловсруулах системээр цахим баримт бичиг хэлбэрээр хэвлэсэн баримт бичгийг цахим баримт бичигтэй адилтгана. - 3 дугаар зүйлийн дэд хэсэг бүрт баримт бичгийн хуулбарыг олгох, хүргүүлэх, хадгалах гэх мэтээр заасан тохиолдолд мэдээллийн компьютержсэн системээр цахим баримт хэлбэрээр хэвлэсэн баримт бичиг нь баримт бичгийн эх хувь байх ёстой.

³⁸ Framework act on electronic documents and transactions of Korea, https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=27334&type=part&key=28

³⁹ Act on the Use of Electronic Documents in Criminal Judicial Procedures [Enforced into force on October 20, 2024] [Law No. 18485, enacted on October 19, 2021], [https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EC%82%AC%EC%82%AC%EB%B2%95%EC%A0%88%EC%B0%A8%EC%97%90%EC%84%9C%EC%9D%98%EC%A0%84%EC%9E%90%EB%AC%B8%EC%84%9C%EC%9D%B4%EC%9A%A9%EB%93%B1%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2%95%EB%A5%A0/\(18485,20211019\)](https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EC%82%AC%EC%82%AC%EB%B2%95%EC%A0%88%EC%B0%A8%EC%97%90%EC%84%9C%EC%9D%98%EC%A0%84%EC%9E%90%EB%AC%B8%EC%84%9C%EC%9D%B4%EC%9A%A9%EB%93%B1%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2%95%EB%A5%A0/(18485,20211019))

⁴⁰ Act on the Use of Electronic Documents in Criminal Judicial Procedures [Enforced into force on October 20, 2024] [Law No. 18485, enacted on October 19, 2021], [https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EC%82%AC%EC%82%AC%EB%B2%95%EC%A0%88%EC%B0%A8%EC%97%90%EC%84%9C%EC%9D%98%EC%A0%84%EC%9E%90%EB%AC%B8%EC%84%9C%EC%9D%B4%EC%9A%A9%EB%93%B1%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2%95%EB%A5%A0/\(18485,20211019\)](https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EC%82%AC%EC%82%AC%EB%B2%95%EC%A0%88%EC%B0%A8%EC%97%90%EC%84%9C%EC%9D%98%EC%A0%84%EC%9E%90%EB%AC%B8%EC%84%9C%EC%9D%B4%EC%9A%A9%EB%93%B1%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2%95%EB%A5%A0/(18485,20211019))

<p>6 дугаар зүйл. Компьютержсэн мэдээлэл боловсруулах системийг ажиллуулах</p>	<p>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага бүрийн дарга мэдээлэл боловсруулах компьютержүүлсэн системийг суурилуулж ажиллуулна.</p> <p>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллагууд цахим баримт бичгийн ашиглалт, менежментийн стандартыг бий болгохын тулд бие биетэйгээ хамтран ажиллах ёстой.</p> <p>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага нь энэхүү хуулийг хэрэглэх буюу компьютержсэн мэдээлэл боловсруулах системийг ажиллуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настан гэх мэт хүмүүст эрхээ бүрэн эдлэх боломжийг хангахыг хичээнэ.</p>
<p>7 дугаар зүйл. Хэрэглэгчийн бүртгэл</p>	<p>- Мэдээлэл боловсруулах компьютержүүлсэн системийг ашиглахыг хүссэн хүн бүр (эрүүгийн шүүх хянан шийдвэрлэх байгууллагад харьяалагддаг төрийн албан тушаалтнуудаас бусад) Ерөнхийлөгчийн зарлиг болон Улсын дээд шүүхийн дүрмийн дагуу хэрэглэгчээр бүртгүүлэх ёстой.</p> <p>- (1)-д заасны дагуу хэрэглэгчээр бүртгүүлсэн (цаашид “хэрэглэгчийн бүртгэл” гэх) хүн /цаашид “бүртгүүлсэн хэрэглэгч” гэх/ Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн тогтоолоор тогтоосон хэрэглэгчийн бүртгэлээ цуцалж болно.</p> <p>- Дараах шалтгааны аль нэг нь байвал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх албаны дарга Ерөнхийлөгчийн зарлиг болон Улсын дээд шүүхийн дүрэмд заасан бүртгэлтэй хэрэглэгчийн компьютержсэн мэдээлэл боловсруулах системийг ашиглахыг түдгэлзүүлэх, хэрэглэгчийн бүртгэлийг цуцалж болно.</p> <ol style="list-style-type: none"> 1. Бүртгүүлсэн хэрэглэгчийн биеийн байцаалт танигдаагүй үед; 2. Хэрэглэгчийн бүртгэлд бүртгүүлэх, хэрэглэгчийн мэдээллийг өөрчлөхдөө мэдээлэл боловсруулах компьютержсэн системд худал мэдээлэл оруулсан бол; 3. Мэдээлэл боловсруулах компьютержсэн системийг ашиглан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад саад учруулах, тухайлбал, бүртгэлтэй бусад хэрэглэгчийн мэдээллийг компьютержүүлсэн мэдээлэл боловсруулах системийг ашиглахад саад учруулсан, бусад бүртгэлтэй хэрэглэгчийн мэдээллийг хулгайлсан тохиолдолд; 4. Санаатай болон илт хайхрамжгүй байдлаас болж мэдээлэл боловсруулах компьютержсэн системд гэмтэл гарсан тохиолдолд; 5. Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн журамд заасан 1-4 дэх хэсэгт заасан бусад шалтгаан байгаа тохиолдолд;
<p>8 дугаар зүйл. Цахим гарын үсэг</p>	<p>- Эрүүгийн байцаан шийтгэх байгууллагад цахим баримт бичгийг ирүүлэхийг хүссэн хүн цахим баримт бичигт цахим гарын үсэг (гарын үсэг зурсан хүний жинхэнэ нэрийг баталгаажуулах боломжтой, цаашид энэ хэсэгт мөн адил хамаарна) байрлуулах ёстой. Харин цахим гарын үсгийг ашиглах боломжгүй, ирүүлсэн этгээдийн биеийн байцаалтыг баталгаажуулсан, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасан тохиолдолд цахим гарын үсэг ашиглахыг хориглоно.</p> <p>- Шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар шүүхийн шийдвэр, тэмдэглэл зэргийг цахим баримт бичигт бэлтгэхдээ Улсын дээд шүүхийн журамд заасан шүүхийн цахим гарын үсэгт гарын үсэг зурна. Энэ тохиолдолд 3 дугаар зүйлд заасан хуульд заасны дагуу мэдэгдэл гаргаж</p>



	<p>байгаа этгээдийн гарын үсэг шаардлагатай бол цахим хэлбэрээр гарын үсэг зурна.</p> <ul style="list-style-type: none">- Шүүхээс бусад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд харьяалагддаг төрийн албан тушаалтнууд цахим баримт бичигт шийдвэр, тэмдэглэл, тайлан гаргахдаа Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу захиргааны цахим гарын үсэг зурах ёстой. Энэ тохиолдолд 3 дугаар зүйлд заасан хуульд заасны дагуу мэдэгдэл гаргаж байгаа этгээдийн гарын үсэг шаардлагатай бол цахим хэлбэрээр гарын үсэг зурна.- Хэрэв 1-3 дахь хэсэгт заасны дагуу цахим гарын үсэг, шүүхийн цахим гарын үсэг, захиргааны цахим гарын үсэг хийгдсэн бол гарын үсэг, нэрийн тамга нь хуулийн дагуу хийгдсэн гэж үзнэ.- Хэрэв 1-ээс 3 дахь хэсэгт заасны дагуу ирүүлсэн буюу бэлтгэсэн цахим баримт бичигт хуудасны тоог заасан бол 3 дугаар зүйлийн дэд зүйл бүрийн дагуу хууль тогтоомжийн дагуу тамга дарсан гэж үзнэ.
9 дүгээр зүйл. Цахим баримт бичгийг хүлээн авах	<ul style="list-style-type: none">- Цахим баримт бичгийг компьютержсэн мэдээлэл боловсруулах системд цахим хэлбэрээр бүртгэсэн тохиолдолд хүлээн авсанд тооцогдоно.- Компьютержсэн мэдээлэл боловсруулах системээр ирүүлсэн цахим баримт бичгийг хүлээн авах журам, аргыг Ерөнхийлөгчийн зарлигаар буюу Улсын дээд шүүхийн дүрмээр тогтооно. Энэ тохиолдолд ирүүлсэн цахим баримт бичгийн хувийн шинж чанарыг хадгалах техникийн арга хэмжээний тухай асуудлыг агуулгад оруулах ёстой.- 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу цахим баримт бичгийг ирүүлсэн бүртгэлтэй хэрэглэгч нь хүлээн авсан цахим баримт бичгийг баталгаажуулах хүсэлт гаргавал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн журамд заасан баталгаажуулах боломжийг олгох ёстой.- Хэрэв 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу ирүүлсэн цахим баримт бичгийн агуулга нь хүлээн авсан цахим баримт бичгийн агуулгатай таарахгүй бол бүртгэлтэй хэрэглэгч Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасны дагуу холбогдох байгууллагад засвар оруулах хүсэлт гаргаж болно.- Хүлээн авсан цахим баримт бичгийг хуурамчаар үйлдсэн эсвэл өөрчилсөн эсэхийг шалгах шаардлагатай бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага нь 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу цахим баримт бичгийг ирүүлсэн бүртгэлтэй хэрэглэгчээс эх хувийг нь гаргаж өгөхийг хүсч болно.
10 дугаар зүйл. Цахим баримт бичгийг бэлтгэх	<ul style="list-style-type: none">- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны байгууллагад харьяалагддаг төрийн албан тушаалтнууд шүүх хуралдааны тэмдэглэл, яллах дүгнэлт, шилжүүлсэн шийдвэр, сэжигтэн байцаалтын бүртгэл зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичгүүдийг бүрдүүлэхдээ цахим баримт бичиг болгон бэлтгэдэг. Гэхдээ дараах тохиолдлуудын аль нэг нь Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасан үндэслэл байвал энэ нь хамаарахгүй. <ol style="list-style-type: none">1. Компьютержсэн мэдээлэл боловсруулах системд асуудал гарсан тохиолдолд;2. Цахим баримт бичгийг бэлтгэхэд ихээхэн хүндрэлтэй буюу зохисгүй тохиолдолд.

	<p>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллагад харьяалагддаг төрийн албан тушаалтан сэжигтний байцаалтын тэмдэглэлийг (1) дэх заалт бүрийн текстийн дагуу цахим баримт бичиг болгон бэлтгэсэн бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан сэжигтэн байцаалтын тэмдэглэлийг бүрдүүлэх журам, аргачлалыг Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу хэрэгжүүлэх ёстой.</p>
11. дүгээр зүйл. Дижитал баримт бичгийг бэлтгэх	<p>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд харьяалагдах төрийн албан тушаалтан дижитал баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээлэл боловсруулан цахим системд бүртгүүлнэ. Харин цахимжуулах баримт бичгийг дижитал хэлбэрт шилжүүлэхэд ихээхэн хүндрэлтэй, тохиромжгүй үед Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн журамд заасны дагуу хөрвүүлэх, бүртгэхийг хориглоно.</p> <p>- Цахим хэлбэрт шилжүүлэх баримт бичгийг дижитал хэлбэрт шилжүүлэх, мэдээлэл боловсруулах цахим системд бүртгэх журам, аргыг Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрмээр тогтооно. Энэ тохиолдолд дижитал хэлбэрт оруулах баримт бичгийн онцлог байдлыг хадгалах техникийн арга хэмжээний тухай асуудлыг агуулгад оруулах ёстой.</p>
12 дугаар зүйл. Дижитал хэлбэрт шилжүүлсэн баримт бичгийг хадгалах	<p>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага нь 11 дүгээр зүйлд заасны дагуу цахим хэлбэрт шилжүүлж, бүртгүүлсэн баримт бичгийг Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн журамд заасан хугацаа хүртэл хадгална.</p> <p>- 1 дэх хэсгийг үл харгалзан цахим хэлбэрт шилжүүлэх баримт бичгийг ирүүлсэн этгээдээс хүсэлт гаргавал байгууллага цахим хэлбэрт шилжүүлэх баримт бичгийг буцааж болно.</p> <p>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага нь 2 дахь хэсэгт заасны дагуу цахимжуулах баримт бичгийг ирүүлсэн этгээдэд буцааж өгөхдөө цахим хэлбэрт шилжүүлэх баримт бичиг болон цахимжуулах баримт бичгийг мөн адил баталгаажуулах боломжийг олгоно.</p>
13 дугаар зүйл. Цахим баримт бичиг тараах	<p>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бэлтгэсэн цахим баримт бичгийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад байгууллагад илгээхдээ компьютержсэн мэдээлэл боловсруулах системээр дамжуулан явуулах ёстой.</p> <p>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллагаас өөр байгууллагад шилжүүлэх тохиолдолд цахим баримт бичгийг мэдээлэл боловсруулах компьютержуулсан системээр хэвлэж, бичгийн баримтыг илгээдэг. Харин цахим баримт бичгийг цахим баримт бичгийг илгээх, хүлээн авах системээр тоноглогдсон байгууллагын хувьд Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасан байгууллагад шилжүүлэх, дамжуулахдаа цахим баримт бичгийг цахим хэлбэрээр илгээж болно.</p> <p>2 дахь хэсгийн үндсэн бичвэрт заасны дагуу цахим баримт бичгийг хэвлэх журам, аргыг Ерөнхийлөгчийн зарлигаар буюу Дээд шүүхийн дүрмээр тогтооно. Энэ тохиолдолд цахим баримт бичгийн үнэмлэхийг хадгалах техникийн арга хэмжээний тухай асуудлыг агуулгад оруулах ёстой.</p>
14 дүгээр зүйл. Цахим үйлчилгээ эсвэл мэдэгдэл	<p>Үйлчилгээ, мэдэгдэл хүлээн авах этгээд нь дор дурдсан зүйлсийн аль нэгэнд хамаарах бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага мэдээлэл боловсруулах цахим</p>

	<p>системээр дамжуулан үйлчилгээ, мэдэгдлийг цахим хэлбэрээр хийж болно.</p> <p>1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллагын хувьд</p> <p>2. Хэрэв та эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллагад харьяалагддаг төрийн албан тушаалтан бол</p> <p>3. Цахим хүргэлт, мэдэгдлийг зөвшөөрсөн бүртгэлтэй хэрэглэгч, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасан этгээд бол.</p> <p>- (1)-д заасны дагуу үйлчилгээ, мэдэгдлийг эрүүгийн байцаан шийтгэх байгууллага цахим баримт бичгийг мэдээлэл боловсруулах цахим системд бүртгэж, тухайн баримт бичгийг гардуулах буюу мэдэгдэх этгээдэд цахимаар мэдэгдэнэ.</p>
<p>15 дугаар зүйл. Хэвлэсэн цахим баримтыг хүргүүлэх</p>	<p>- Дараах тохиолдлын аль нэгэнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу цахим баримт бичгийг компьютержсэн мэдээлэл боловсруулах системээр дамжуулан илгээнэ.</p> <p>- (1)-д заасны дагуу цахим баримт бичгийг хэвлэх журам, аргыг Ерөнхийлөгчийн зарлигаар эсвэл Дээд шүүхийн дүрмээр тогтооно. Энэ тохиолдолд цахим баримт бичгийн танилтыг хадгалах техникийн арга хэмжээний тухай асуудлыг агуулгад оруулах ёстой.</p>
<p>16 дугаар зүйл. Цахим баримт бичгийг үзэх, хуулбарлах гэх мэт</p>	<p>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 35, 55, 59-2, 59-3, 174, 185, 200-4, 262 дугаар зүйлийн 2, 266-3 дугаар зүйл, 266-4 дүгээр зүйл, 266-11 дүгээр зүйл, 294-4 дүгээр зүйлд заасныг үл харгалзан энэ хуулийн дагуу бэлтгэсэн цахим баримт бичгийг үзэх, хуулбарлахдаа интернет, эсвэл компьютержсэн мэдээлэл боловсруулах системийг ашиглах ба цахим хэлбэрээр үзэх, хуулах, дамжуулах замаар хийж болно.</p> <p>- 1-р хэсгийг үл харгалзан, бүртгэлтэй хэрэглэгчээс өөр хүн цахим баримтыг үзэх, хуулбарлах хүсэлт гаргасан тохиолдолд компьютержсэн мэдээлэл боловсруулах системээр дамжуулан баримт бичгийг хэвлэн гаргаж болно.</p> <p>- (1)-д заасны дагуу цахим баримт бичгийг үзэх, хуулбарлах, дамжуулах журам, аргыг Ерөнхийлөгчийн зарлигаар эсвэл Дээд шүүхийн дүрмээр тогтооно. Энэ тохиолдолд цахим баримт бичгийн танилтыг хадгалах техникийн арга хэмжээний тухай асуудлыг агуулгад оруулах ёстой.</p> <p>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 266-3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүгдэгч (шүүгдэгч байсан этгээдийг оролцуулан), өмгөөлөгч (өмгөөлөгч байсан этгээдийг оролцуулан) баримт бичгийг үзэх, хуулбарлах, дамжуулах боломжтой. Цахим баримт бичгийг зориулалтын бус зорилгоор интернет эсвэл компьютержсэн мэдээлэл боловсруулах системээр дамжуулан өөр этгээдэд дамжуулах, олгох (цахим баримт бичгийг хэвлэх, бичгээр олгох гэх мэт) холбогдох хэрэг болон холбогдох хэргийн шүүх хуралдаанд бэлтгэх тухай танилцуулахыг хориглоно (цахим баримт бичгийг хэвлэх, бичгээр танилцуулах, харилцаа холбооны хэрэгслээр хангах гэх мэт).</p>
<p>17 дугаар зүйл. Зөвшөөрлийг гүйцэтгэх тусгай заалтууд</p>	<p>Дараахь батлан даалт, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ, зөвшөөрөл, хүсэлт зэргийг /цаашид “зөвшөөрөл” гэх/ цахим хэлбэрээр олгосон бол прокурор, шүүхийн цагдаагийн ажилтан: Улсын дээд шүүхийн журамд заасны</p>



	<p>дагуу; баталгаа гэх мэтийг цахим баримт бичгийг танилцуулах, дамжуулах замаар гүйцэтгэж болно.</p> <ol style="list-style-type: none">1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 73, 113, 200-2, 201, 215 дугаар зүйлд заасны дагуу баталгаа гаргах.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 172, 221-3 дугаар зүйлд заасан үнэлгээний цагдан хорих байр3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 173 дугаар зүйл, 221-4 дүгээр зүйлд зааснаар зөвшөөрлийн бичиг.4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 473 дугаар зүйлд заасан гүйцэтгэх хуудас5. Жинхэнэ нэрийн санхүүгийн гүйлгээ, нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу баталгаа.6. Харилцаа холбооны нууцыг хамгаалах тухай хуулийн 6, 8 дугаар зүйлд заасны дагуу харилцаа холбоог хязгаарлах арга хэмжээ авах зөвшөөрөл7. Харилцаа холбооны нууцыг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу харилцаа холбоог баталгаажуулах мэдээлэл өгөх хүсэлт8. Харилцаа холбооны нууцыг хамгаалах тухай хуулийн 13-2 дугаар зүйлд заасны дагуу харилцаа холбоог баталгаажуулах мэдээлэл өгөх хүсэлт <p>- (1)-д заасны дагуу цахим баримт бичиг хэлбэрээр гаргасан хүсэлт гэх мэтийг гүйцэтгэхэд ихээхэн хүндрэлтэй, зохисгүй тохиолдолд цахим баримт бичиг хэлбэрээр олгосон хүсэлт гэх мэтийг компьютерийн цахим хэрэгслээр хэвлэсэн бичгээр үйлдэж болно.</p> <p>- Мэдээлэл боловсруулах компьютержсэн системээр 2 дахь хэсэгт заасны дагуу цахим баримт хэлбэрээр олгох батлан даалт зэргийг хэвлэх журам, аргыг Улсын дээд шүүхийн журмаар тогтооно. Энэ тохиолдолд агуулга нь цахим баримт бичгийн хувийн шинж чанарыг хадгалах, олон хуулбарыг шүүгчийн гаргасан зориулалтаас өөрөөр гаргахаас урьдчилан сэргийлэх техникийн арга хэмжээг агуулсан байх ёстой.</p>
18 дугаар зүйл. Нотлох баримтыг шалгах тусгай заалтууд	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 292, 292-3 дугаар зүйлийг үл харгалзан эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд цахим баримт бичгийн нотлох баримтыг шалгах ажиллагааг дараах байдлаар хийж болно.</p> <ol style="list-style-type: none">1. Захидал, бусад тэмдэгт, зураг, гэрэл зураг гэх мэтийн нотлох баримтыг судлах: Холбогдох цахим баримт бичгийг дэлгэц, дэлгэц гэх мэтээр үзэх арга.2. Аудио, дүрс бичлэгийн мэдээллийг нотлох баримт шалгах: Холбогдох цахим баримт бичгийн аудио сонсох, дүрс бичлэгийг тоглуулах арга
19 дүгээр зүйл. Шүүх хуралдааны гүйцэтгэлийг удирдах аргын талаархи тусгай заалтууд	<p>- Шүүхийн шийдвэр, шүүх хуралдааны тэмдэглэлийг цахим баримтаар бүрдүүлсэн бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 461 дүгээр зүйлийн үндсэн бичгийг үл харгалзан прокурор шүүх хуралдааны гүйцэтгэлийг цахим баримтаар удирдана.</p>

	<p>- (1)-ээс үл хамааран шүүхийн гүйцэтгэлийг цахим баримтаар удирдан чиглүүлэхэд хүндрэлтэй байгаа бол шүүхийн гүйцэтгэлийг цахим баримт бичигт бэлтгэсэн бичгээр гаргасан шүүхийн шийдвэрээр, эсхүл компьютерийн төхөөрөмжөөр хэвлэсэн шүүхийн протоколоор дамжуулан шийдвэрлэнэ.</p> <p>- 2 дахь хэсэгт заасны дагуу цахим баримт бичгийг хэвлэх журам, аргыг Ерөнхийлөгчийн зарлигаар буюу Дээд шүүхийн дүрмээр тогтооно. Энэ тохиолдолд цахим баримт бичгийн үнэмлэхийг хадгалах техникийн арга хэмжээний тухай асуудлыг агуулгад оруулах ёстой.</p>
<p>20 дугаар зүйл. Цахим баримт бичгийг устгах</p>	<p>- Мэдээлэл боловсруулах компьютержсэн системээр бий болсон цахим баримт бичгийг дараах ангиллын дагуу тогтоосон хугацаанд устгана.</p> <p>1. Ял оногдуулсан шүүх хуралдааныг баталгаажуулсан хэрэг: Шийтгэх хөөн хэлэлцэх хугацаа дууссан бол; Харин цагдан хорих, хөнгөн торгох ял оногдуулсан бол шийдвэр гарсан өдрөөс хойш гурван жил өнгөрсний дараа;</p> <p>2. Цагаатгах, ялаас чөлөөлөх, яллах дүгнэлт үйлдүүлэхийг хэрэгсэхгүй болгох, хорих ялыг хойшлуулах тогтоол батлагдсан тохиолдолд: Яллах хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа</p> <p>3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 245 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2-т зааснаар яллагдагчаар татаагүй, шилжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн хэргүүд: Хөөн хэлэлцэх хугацаа дууссан тохиолдолд.</p> <p>- 1 дэх хэсгийг үл харгалзан Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасан хэргүүд, тухайлбал, дотоод, олон улсын ноцтой хэрэг, хамсаатнуудыг мөрдөн шалгах шаардлагатай тохиолдолд цахим баримт бичгийг Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн журмын дагуу байнга хадгалж болно. Эсвэл 1 дэх хэсэгт заасны дагуу устгах хугацаа хойшлогдож болно.</p>

Дээрхээс дүгнэвэл, БНСУ-ын тухайд 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн БНСУ-ын парламентын чуулганы нэгдсэн хуралдаанаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хуулийг баталж нарийвчилсан хуулиар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хавтаст хэргийг зохицуулж байгаа нь сайн жишиг бүхий боловсронгуй зохицуулалт болж байна. Тус хуульд "цахим хавтаст хэрэг", "цахимжуулсан хавтаст хэрэг" гэх нэр томъёог нарийвчлан тодорхойлсноос гадна эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим баримт бичгээр гүйцэтгэх, компьютержсэн мэдээлэл боловсруулах системийг ажиллуулах, цахим баримт бичгийг хүлээн авах, цахим баримт бичгийг бэлтгэх, цахим баримт бичгийг үзэх, хуулбарлах, цахим баримт бичгийг устгах гэх мэт зохицуулалтыг тусгасан байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим хавтаст хэргийн зохицуулалтыг тусгахдаа дээрх зохицуулалтын агуулгыг тусгах талаар авч үзэх хэрэгтэй.

2. Цахим нотлох баримтын зохицуулалтын талаар:

Олон улсын гэрээ, конвенцийн зохицуулалт

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримт, хавтаст хэрэг, түүний хадгалалтын талаар дараах олон улсын гэрээ, конвенцүүд хүчин төгөлдөр үйлчилж байна.

- Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтыг бий болгох, хадгалах журам (EU) 2023/154;

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт цуглуулах үүрэг бүхий байгууллагыг үүсгэн байгуулах, түүний хууль ёсны төлөөлөгчдийг томилох зохицуулалтыг ижилтгэх удирдамж (EU) 2023/154;

- Кибер гэмт хэргийн тухай Будапештийн конвенц (ETS No. 185);

- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц ба түүнд заасан протоколууд (55/255)

- Истанбулын протокол (Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг гутаан харьцах, шийтгэхийг үр дүнтэй мөрдөн шалгах, баримтжуулах гарын авлага)

- Хувийн мэдээллийг автоматаар боловсруулахтай холбоотой хувь хүнийг хамгаалах тухай Европын зөвлөлийн конвенц гэх мэт.

1. "Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтыг бий болгох, хадгалах журам"⁴¹ болон "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт цуглуулах үүрэг бүхий байгууллагыг үүсгэн байгуулах, түүний хууль ёсны төлөөлөгчдийг томилох зохицуулалтыг ижилтгэх удирдамж"⁴²-ийн гол зорилго нь цахим нотлох баримтын тогтворгүй шинж чанар, хадгалагдсан өгөгдлийн (дата) "байршлын алдагдлаас" үүссэн асуудлуудыг тусгайлан шийдвэрлэхийн тулд одоо байгаа олон улсын хамтын ажиллагаа, эрх зүйн харилцан туслалцааны хэрэгслүүдээс илүү хурдан, илүү үр дүнтэй механизмыг бий болгох явдал юм. Уг журамд гишүүн улсын эрх бүхий байгууллага эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Европын нотлох баримт бий болгох захиалга эсвэл хадгалалтын захиалга гаргаж, үүгээрээ Холбооны нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлж буй болон өөр гишүүн улсад байгуулагдсан үйлчилгээ үзүүлэгчээс (шууд), эсхүл ийм байгууллага байгуулаагүй бол өөр гишүүн улсын хууль ёсны төлөөлөгчөөр төлөөлүүлэн мэдээллийн байршлаас үл хамааран цахим нотлох баримтыг захиалж авах, бүрдүүлж болох юм.

Цахим нотлох баримтыг олж авах буюу түүнд хандах эрхийг олж авах эрх бүхий байгууллагын хувьд төвөгтэй, урт удаан процесс бөгөөд учир нь уг цахим өгөгдөл, түүнд

⁴¹ Regulation (EU) 2023/1543 of the European Parliament and of the Council of 12 July 2023 on European Production Orders and European Preservation Orders for electronic evidence in criminal proceedings and for the execution of custodial sentences following criminal proceedings, https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv%3AOJ.L_.2023.191.01.0118.01.ENG

⁴² Directive (EU) 2023/1544 of the European Parliament and of the Council of 12 July 2023 laying down harmonised rules on the designation of designated establishments and the appointment of legal representatives for the purpose of gathering electronic evidence in criminal proceedings, https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv%3AOJ.L_.2023.191.01.0181.01.ENG

хандах эрх нь ихэвчлэн өөр улсад байдаг. Онлайн үйлчилгээ үзүүлэгчид Европын холбооны доторх болон гаднах хэд хэдэн улс оронд байрлах серверүүд дээр хэрэглэгчдийн мэдээллийг хадгалдаг бөгөөд энэ нь цахим нотлох баримт, түүнд хандах эрхийг шүүх олж авах ажлыг илүү удаа төвөгтэй болгодог. Европын холбооны гишүүн орнууд даяар явагдаж буй нийт ЭХХША-ны 50 хувь гадаад дахь цахим нотлох баримтын авах, түүнд хандах зөвшөөрлийг хүссэн хүсэлт гадаад орнуудад гаргасан байдаг.

Дээрх шалтгаануудыг үндэслэн 2018 оны 4-р сард Европын Зөвлөл болон Зөвлөлийн уриалгын дагуу Европын Комисс эрх баригчдад мэдээллийн байршлаас үл хамааран цахим нотлох баримтад хандахад хялбар, хурдан болгох шинэ зохицуулалтыг бий болгохыг санал болгосон байна. Ийнхүү ЕХ-ны хувьд таван жил үргэлжилсэн хэлэлцээний эцэст Европын Зөвлөл болон Европын парламент (ЕП) Европын холбооны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт цуглуулах шинэ тогтолцоог нэвтрүүлэх хууль тогтоомжийн актууд болох дээрх зохицуулалтыг баталжээ⁴³.

“Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтыг бий болгох, хадгалах журам”⁴⁴-ын 3 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт “цахим нотлох баримт”-ыг Европын нотлох баримтын захиалгын гэрчилгээ (ЕРОС) эсвэл Европын хадгалалтын захиалгын гэрчилгээг хүлээн авах үед үйлчилгээ үзүүлэгчээс эсвэл түүний өмнөөс цахим хэлбэрээр хадгалсан захиалагчийн өгөгдөл, шилжүүлгийн өгөгдөл эсвэл контентын өгөгдөл байхаар томъёологджээ. Мөн үүнтэй холбогдуулан дараах харилцааг зохицуулжээ.

I БҮЛЭГ. ЗОХИЦУУЛАХ АСУУДАЛ, ХАМРАХ ХҮРЭЭ БА НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 1- р зүйл. Зохицуулах асуудал
- 2- р зүйл. Хамрах хүрээ
- 3- р зүйл. Нэр томьёоны тодорхойлолт

II БҮЛЭГ. ЕВРОПЫН ЦАХИМ НОТЛОХ БАРИМТ БИЙ БОЛГОХ БОЛОН ХАДГАЛАХ ЗАХИАЛГА, ГЭРЧИЛГЭЭ

- 4- р зүйл. Эрх бүхий байгууллага
- 5- р зүйл. Цахим нотлох баримт бий болгох захиалга хийх нөхцөл /журам/
- 6- р зүйл. Цахим нотлох баримт хадгалах захиалга хийх нөхцөл /журам/
- 7- р зүйл. Европын цахим нотлох баримт бий болгох, хадгалах захиалга гаргах хаяг
- 8- р зүйл. Хууль сахиулах байгууллагад мэдэгдэх
- 9- р зүйл. Европын цахим нотлох баримт бий болгох, хадгалах захиалгын гэрчилгээ
- 10- р зүйл. Цахим нотлох баримт бий болгох захиалгыг гүйцэтгэх
- 11- р зүйл.
- 12- р зүйл. Европын цахим нотлох баримт бий болгох захиалгаас татгалзах үндэслэл
- 13- р зүйл. Хэрэглэгчийн мэдээлэл ба нууцлал
- 14- р зүйл. Зардлын нөхөн төлбөр

III БҮЛЭГ. ТОРГУУЛЬ БА АЛБАДАН ГҮЙЦЭТГЭЛ

- 15- р зүйл. Торгууль
- 16- р зүйл. Албадан гүйцэтгүүлэх процесс

IV БҮЛЭГ. ЗӨРЧИЛДӨӨНИЙ ХЭМ ХЭМЖЭЭ БА АРГА ХЭМЖЭЭ

- 17- р зүйл. Зөрчилдөөнтэй үүрэг үүссэн тохиолдолд хянан шалгах процесс

⁴³ E-evidence - cross-border access to electronic evidence Improving cross-border access to electronic evidence, https://commission.europa.eu/law/cross-border-cases/judicial-cooperation/types-judicial-cooperation/e-evidence-cross-border-access-electronic-evidence_en

⁴⁴ Regulation (EU) 2023/1543 of the European Parliament and of the Council of 12 July 2023 on European Production Orders and European Preservation Orders for electronic evidence in criminal proceedings and for the execution of custodial sentences following criminal proceedings, https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv%3AOJ.L_.2023.191.01.0118.01.ENG

18- р зүйл. Үр дүн бүхий арга хэмжээ
V БҮЛЭГ. ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ ТОГТОЛЦОО
19- р зүйл. Эрх бүхий байгууллага, үйлчилгээ үзүүлэгч болон эрх бүхий байгууллагуудын хооронд дижитал харилцаа холбоо, мэдээлэл солилцох аюулгүй байдлыг хангах
20- р зүйл. Цахим баримт бичгийн эрх зүйн үр нөлөө
21- р зүйл. Цахим гарын үсэг ба тамга
22- р зүйл. Лавлагаа хэрэгжүүлэх програм хангамж
23- р зүйл. Төвлөрлийг бууруулах IT системийн зардал
24- р зүйл. Шилжилтийн үе
25- р зүйл. Актыг хэрэгжүүлэх

2. Кибер гэмт хэргийн тухай Будапештийн конвенц нь интернэт болон бусад компьютерийн сүлжээгээр үйлдэгдсэн гэмт хэргийн тухай, ялангуяа зохиогчийн эрхийг зөрчих, компьютертэй холбоотой луйвар, хүүхдийн садар самууныг сурталчлах, сүлжээний аюулгүй байдлыг зөрчих зэрэг гэмт хэргийн тухай олон улсын анхны гэрээ юм. Энэ нь мөн компьютерийн сүлжээг хайх, саатуулах зэрэг хэд хэдэн зохицуулалт, процедурыг агуулдаг. Оршил хэсэгт тусгагдсан гол зорилго нь нийгмийг цахим гэмт хэргээс хамгаалах, ялангуяа зохих хууль тогтоомжийг баталж, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн эрүүгийн нийтлэг бодлогыг хэрэгжүүлэх явдал юм⁴⁵. Тус конвенцын 14, 35 дугаар зүйлд оролцогч тал бүр эрүүгийн гэмт хэргийн нотлох баримтыг цахим хэлбэрээр цуглуулахыг үүрэг болгосон ба 23, 25 дугаар зүйлд зааснаар цахим нотлох баримтын талаар өргөн хүрээнд хамтран ажиллана. Мөн түүнчлэн 46 дугаар зүйлд нотлох баримтыг цахим хэлбэрээр цуглуулах чиглэлээр талууд хамтарч ажиллахаар тусгажээ⁴⁶.

3. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн 20, 29 дүгээр зүйлд үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд цахим тандалт, мөрдөх ажиллагааг хэрэгжүүлж орчин үеийн арга барил хэрэглэхийг талуудад үүрэг болгожээ⁴⁷.


4. Истанбулын протокол (Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг гутаан харьцах, шийтгэхийг үр дүнтэй мөрдөн шалгах, баримтжуулах гарын авлага)-ын 232 дугаар зүйлд дараах зохицуулалтыг мөн тусгажээ.

- Мөрдөгч цахим төхөөрөмж дээр хадгалагдаж, хүлээн авсан эсвэл дамжуулсан аливаа нотлох мэдээллийг баталгаажуулахыг эрэлхийлэх ёстой. Ялангуяа компьютер, гар утас зэрэг электрон төхөөрөмжүүдийг хураан авах, нээлттэй эх сурвалжийн мэдээллийг интернетээр үзэх замаар цахим нотлох баримтыг олж авч болно. Хэрэв хураан авсан цахим хэрэгслээс дижитал нотлох баримтыг олж авбал эдгээр төхөөрөмжийг эд мөрийн баримт болгон хадгалах шаардлагатай бөгөөд мэдээллийг гаргаж авсан дижитал шинжээч шүүхэд ашиглах боломжтой тайлан эсвэл нотлох баримтыг бэлтгэх ёстой. Дижитал нотолгоонд дараахь зүйлс орно: (а) эрүүл мэндийн цахим бүртгэл; (б) хаалттай камераар бичигдсэн видео; (в) дижитал камер, ухаалаг утас зэрэг хөдөлгөөнт хэрэгслээр авсан зөрчил, бие махбодид гэмтэл учруулсан газар гэх мэтийг агуулсан зураг, видео; (г) олон нийтийн мэдээллийн хэрэгслээр байршуулсан зураг, видео болон бусад мэдээлэл; (д) санах ойн карт, USB хөтөч, CD-ROM гэх мэт компьютерийн хатуу диск болон бусад дагалдах төхөөрөмжид хадгалагдсан мэдээлэл;

⁴⁵ Details of Treaty No.185, <https://www.coe.int/en/web/conventions/full-list?module=treaty-detail&treatynum=185>

⁴⁶ Convention on Cybercrime Budapest, 23.XI.2001, <https://rm.coe.int/1680081561>

⁴⁷ United Nations Convention against Transnational Organized Crime and the Protocols Thereto, <https://www.unodc.org/unodc/en/organized-crime/intro/UNTOC.html>



(е) имэйл, текст болон шуурхай мессеж; (ж) агаарын болон сансрын хиймэл дагуулаас авсан зураг, тухайлбал, нууц саатуулах төв эсвэл зөрчлийн бусад газар; (ж) гар утас эсвэл олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хадгалагдсан байршлын мэдээлэл; ба (и) мета өгөгдөл, өөрөөр хэлбэл файлын талаарх мэдээлэл (жишээ нь дижитал гэрэл зураг авсан цаг хугацаа, байршил гэх мэт). Дижитал нотлох баримтын жинхэнэ байдал нь түүнийг нотлох баримт болгон ашиглахад чухал ач холбогдолтой юм. Тиймээс түүний жинхэнэ эсэхийг дижитал шүүх эмнэлгийн хүлээн зөвшөөрөгдсөн арга техникийг ашиглан шалгах хэрэгтэй⁴⁸.

5. Хувийн мэдээллийг автоматаар боловсруулахтай холбоотой хувь хүнийг хамгаалах тухай Европын зөвлөлийн конвенцийн зорилго нь оролцогч улс бүрийн нутаг дэвсгэрийн харьяалал, оршин суугаа газраас үл хамааран хүний хувийн халдашгүй байх эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх ("өгөгдлийн хамгаалалт"), ялангуяа хувийн нууцыг хамгаалах эрхийг хангахад оршино. Тус конвенцийн 5 дугаар зүйлийн е хэсэгт агуулгыг таних боломжтой хэлбэрээр хадгалагдсан өгөгдлийг тухайн өгөгдлийг хадгалах зорилгод шаардагдах хугацаанаас илүүгээр хадгалж болохгүй талаар мөн зохицуулжээ⁴⁹.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын сайн туршлага

Цахим нотлох баримт гэдэг нь тодорхой эрүүгийн мөрдөн байцаалтад хамаарах тоон (дижитал) хэлбэрээр хадгалагдсан эсвэл дамжуулсан бүх мэдээллийг хэлэх бөгөөд цахим нотлох баримтыг дижитал өгөгдөл хаана хадгалагдаж байгаа зөөвөрлөгчийг хайх, хураах, үйлчилгээ үзүүлэгчийн оролцоотойгоор дижитал өгөгдөл (захиалагчийн мэдээлэл, хөдөлгөөний мэдээлэл, агуулгын өгөгдөл) цуглуулах замаар олж авдаг.⁵⁰

ХБНГУ-ын хувьд эрүүгийн процессын эрх зүй буюу ЭХХШТХ-даа цахим нотлох баримтыг тусгайлан тодорхойлж, зохицуулаагүй байна. Харин нотлох баримтын хувьд дараах нотлох баримтуудыг ЭХХША-нд хатуу (Strengbeweis) нотлох баримтаар тооцон үнэлнэ гэж заасан байдаг. Эдгээрт

- Шинжээчийн дүгнэлт (§§ ЭХХШТХ-ийн 72);
- Шүүхийн хяналт, шалгалт хийсэн баримт бичиг (§ ЭХХШТХ-ийн 86);
- Баримтат нотлох баримт (§ ЭХХШТХ-ийн 249);
- Гэрч (§§ ЭХХШТХ-ийн 48) зэрэг нотлох баримтын төрлүүд тус тус багтана.


Эдгээрээс “Унших замаар нотлох баримтыг баримтжуулах; хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед уншиж танилцуулсан нотлох баримт” гэсэн ЭХХШТХ-ийн 249-р зүйлийн (1)-т “...Цахим баримт бичгийг уншиж танилцах боломжтой бол баримт бичиг гэж үзнэ.”⁵¹ гэж заасан байна.

⁴⁸ Manual on the Effective Investigation and Documentation of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, https://www.ohchr.org/sites/default/files/documents/publications/2022-06-29/Istanbul-Protocol_Rev2_EN.pdf

⁴⁹ Convention for the Protection of Individuals with regard to Automatic Processing of Personal Data Strasbourg, 28.I.1981, <https://rm.coe.int/1680078b37>

⁵⁰ European Judicial Network, Fiches Belges on electronic evidence Germany. Available at <https://www.ejn-crimjust.europa.eu/ejnupload/DynamicPages/FB-EEGermany.pdf>

⁵¹ European Judicial Network, Fiches Belges on electronic evidence Germany. Available at <https://www.ejn-crimjust.europa.eu/ejnupload/DynamicPages/FB-EEGermany.pdf>



Дээрхээс үзэхэд ХБНГУ-ын ЭХХШТХ-д цахим нотлох баримтыг тусгайлан тодорхойлж зохицуулаагүй ч ЭХХША-нд цахим нотлох баримтыг ашиглах, үнэлэхийг хориглосон аливаа хязгаарлалт байхгүй буюу хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд ЭХХША-нд ашиглах боломжтой байна. Өөрөөр хэлбэл Герман улсын ЭХХША-ны нотлох баримтад хэлбэрийн шаардлага тавьдаггүй буюу цахим нотлох баримтыг хэлбэрийн хувьд тусгайлан авч үзэх, эсхүл хязгаарласан хязгаарлалт байхгүй.

ХБНГУ-ын нэгдэн орсон цахим нотлох баримт, түүнийг цуглуулах, олж авах асуудалд хамаарах олон улсын хууль тогтоомж, гэрээ, конвенц.

- “Цахим (Кибер) гэмт хэргийн тухай” 2001 оны Будапештын конвенц;
- Эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны Европын журам (EU 2014);
- Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих ял эдлүүлэх ажиллагааны цахим нотлох баримтыг бий болгох, хадгалах журам (EU) 2023/1543;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт цуглуулах үүрэг бүхий байгууллагыг үүсгэн байгуулах, түүний хууль ёсны төлөөлөгчдийг томилох зохицуулалтыг ижилтгэх удирдамж (EU) 2023/1544 .

Цахим нотлох баримтыг ЭХХША-нд үнэнийг тогтоох зорилгоор Үндсэн хуулийн шаардлагыг хүрээнд ашиглах нь (ХБНГУ-ын практик туршлага)

Дээр дурдсанчлан ХБНГУ-д цахим нотлох баримтыг ЭХХША-нд үнэнийг тогтоох зорилгоор ашиглах боломжтой боловч ийнхүү ашиглахдаа хуульд заасан аливаа хязгаарлалтын хүрээнд буюу хуулийн шаардлагад нийцүүлэн ашиглах шаардлагатай юм. Ийнхүү нотлох баримтыг ЭХХША-нд үндсэн хуулийн шаардлагад нийцүүлэн ашиглах техник буюу ХБНГУ-ын практик туршлагыг энд танилцуулъя.⁵²


Цахим нотлох баримтыг ЭХХША-нд Германы шүүхүүд цуглуулах, олж авах, үнэлэхдээ дараах шинжилгээний үндсэн бүтцийг (үе шатыг) ашигладаг. Үүнд:

- Үндсэн эрхийн нөхцөл байдал;
- Нотлох баримт бүрдүүлэх;
- Үнэлэх;
- Шүүх хуралдаанд оруулан танилцуулах.

Үндсэн эрхийн анхдагч нөхцөл (түүний хязгаарлаж болох нөхцөлүүд):

- /Зайнаас харилцахад/ харилцаа холбооны нууц, Германы Үндсэн Хуулийн 10 /GG/ *Зөвхөн дамжуулах явцад хамаарах бөгөөд үндсэн эрхийг хязгаарлаж болно.*
- Хүний нэр төр /хүн байх үнэ цэнэ, хүний эрхэмсэг оршихуй/ Германы Үндсэн Хуулийн 1 /GG/

⁵² Уг ХБНГУ-ын практикийг ХБНГУ-ын Бавари мужийн Цахим хувьслын судалгааны хүрээлэнгийн захирал, тус мужийн Хиймэл оюун ухааны зөвлөлийн гишүүн, Вюрцбург хотын Юлиус-Максимилианс Их Сургуулийн доктор, профессор Эрик Хилгендорфын Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Ханнс-Зайделийн сантай хамтран “Цахим нотлох баримт” уулзалт, хэлэлцүүлгийн үеэр хийсэн танилцуулгаас авсан болно.
Эрик Хилгендорф, “Цахим нотлох баримт танилцуулга” сургалтын орчуулга, 2023.09.15.



Хувь хүний мөн чанарын үндсэн цөм хэсгийг хамгаалалтдаа авсан, хязгаарлах боломжгүй.

- Хувийн мэдээллийг хэрхэхээ өөрөө тодорхойлох эрх, Германы Үндсэн Хуулийн 2-р зүйлийн 1 дэх хэсэг +1-р зүйлийн 1 дэх хэсэг *хувийн мэдээллээ хамгаалах; хязгаарлах боломжтой.*
- Мэдээллийн технологийн систем дэх халдашгүй байх эрх, Германы Үндсэн Хуулийн 2-р зүйлийн 1 дэх хэсэг +1-р зүйлийн 1 дэх хэсэг *Компьютер зэрэгт зөвшөөрөлгүй нэвтрэхээс хамгаалах, хязгаарлаж болно.*

Хуулиар зохицуулсан мэдээлэл цуглуулах боломжтой тусгай тохиолдлууд (нотлох баримт цуглуулах):

- Утасны яриаг хянах, бичиж авах, Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §100a
- Кодыг тайлан и-мэйлийг нууцаар үзэх ажиллагаа , Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §100a
- Цахим холбоо харилцааны холболтын өгөгдөлд нэвтрэх, Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §100g
- Гар утасны мэдээллийг байршлыг тодорхойлох, Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §100i
- Хяналтын программд нууцаар нэвтрэх, Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §100b

Хуулийн шаардлага:

- Тодорхой заасан хүнд гэмт хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд ашиглах
- Шүүгчийн захирамж гарсан байх.

Уламжлалт хандалтын аргууд:


- Эд юмсыг хураах, нэгжлэг хийх (Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §§ 94, 102): компьютер, гар утас зэрэгт мөн хэрэглэнэ.
- Хууль сахиулах байгууллагын хүсэлтийн дагуу цахим /сүлжээний/ үйлчилгээ эрхлэгч эсвэл үүлэн операторуудаас сэжигтний мэдээллийг авах, Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §103

Хуулийн шаардлага:

- Эдгээр ажиллагаа нь далд бус, ил хэлбэрээр явагддаг учраас хөнгөн шаардлага тавигддаг.

Хувийн нууцыг хамгаалах

- Харилцаа холбооны хэрэгслийг хянах ажиглах болон хадгалагдсан өгөгдлийг нууцаар хайхад хүний хувийн амьдралын хүрээний үндсэн цөм хэсэгт хамаарах мэдээлэл/өгөгдлийг ашиглаж үл болно.
 - Өдрийн тэмдэглэлийн хэсэг
 - Эрүүгийн хуульд хамааралгүй сэдвээр эхнэр, нөхөртэйгөө ярилцах
 - Ажиглалтад буй этгээд нь эмч, хуульч гэх мэт тодорхой мэргэжлийн бүлгийн гишүүдтэй харилцсан яриа
- Өөрөө өөрийгөө буруутгах нөхцөл байдлыг дэлгэхгүй байх эрх ("nemo tenetur se ipsum accusare") нь гар утасны өгөгдлийг нотлох баримтаар үнэлэх үед



хамгаалагдаж байна уу? Гар утас нь хэрэглэгчийн өөрийн "хадгалагдсан санах ой" юм.

Нотлох баримтыг үнэлэх:

- Үндсэн асуудал: цуглуулсан мэдээллийн жин хэт их
- Дагах асуудлууд:
 - Хэн үнэлэх вэ?
 - Тусгай албаныхан уу?
 - тэдгээрийн хэлтэс үү? Хууль ёсны зарчмын улмаас үүсэх ачаалал, Германы ЭХХШТХ-ийн /StPO/ §160.1, 163.
- Хэрхэн үнэлэх вэ?
 - тус бүрнээ шалгалт хийх, дээж авах, автомат хянах ажиллагаа, KI
- Мэдээллийг хэнд нээлттэй байлгах вэ?
 - Шүүх
 - Хууль зүйн туслалцаа үзүүлэгч: ямар хэлбэрээр? процесст оролцох "зэвсэг" тэгш байх тухай асуудал
- Мэдээллийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрхэн оруулж ирэх вэ?

Тусгай асуудал I: Өгөгдлийн шинжилгээнд хиймэл оюун ухааныг ашиглах

- Жишээ нь хүүхдийн садар самууныг сурталчлах болон бусад сэтгэлзүйн хувьд дарамттай мэдээллүүд
- Одоогоор Германы ЭХХШТХ-ийн /StPO/-д зохицуулалт байхгүй

Тусгай асуудал II: Батлан хамгаалах эрх

- Германы ЭХХШТХ-ийн /StPO/ §147.1: Өмгөөлөгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн материалтай танилцах, "албан журмаар хадгалагдаж буй нотлох баримттай танилцах" эрхтэй.
- Хэргийн материалтай танилцах эрхийн хүрээнд Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр -BVerfGE 63, 65-с.
- Хууль зүйн туслалцаа үзүүлэгчийн чадлаас хир давсан ойлголт вэ?
- Өмгөөлөгч хиймэл оюун ухаантай байх, түүнд олгох ёстой юу?
- Хиймэл оюун ухаан үйлдвэрлэгчдийн бизнесийн нууц яах вэ?
- Холбооны Үндсэн хуулийн шүүхийн /BVerfG/-ийн 2020 оны 11-р сарын 12-ны өдрийн шийдвэр, AZ 2 BvR 1616/18, NZV 2021, 41: Яллагдагч нь замын хөдөлгөөнд хурдны хязгаарыг хэтрүүлж байгааг нотлох зорилготой хяналтын камер ашиглах нөхцөлд түүнд камер хэрхэн ажилладаг талаар шаардлагатай бүх мэдээллийг өгөх ёстой.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зүйл болгох (Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зүйл болгох):

- Нотлох баримтын уламжлалт хэлбэрүүд: үзлэг, гэрч, баримт бичиг, шинжээч
- Эдгээр нотлох баримтын хэлбэрүүд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нээлттэй байдал, ил тод байдал, түүнийг хянах боломжийг баталгаажуулах зорилготой

- Цахим нотлох баримтыг уламжлалт нотлох баримтын адилаар шалгах:
 - Хэвлэх
 - Графикт оруулах
 - Шинжээчдийн дүгнэлт •
 - Хиймэл оюун ухаанаар үүсгэсэн өгөгдөлтэй ажиллах? Ийм мэдээллийг шалгах боломжтой юу?

Бүгд Найрамдах Эстони Улсын сайн туршлага

Эстони улсын ЭХХША-нд цахим (дижитал) нотлох баримт улам бүр нэмэгдэж байгаа боловч одоогийн хууль тогтоомжид ийм нотлох баримтыг олж авах, цуглуулах асуудлыг тодорхой журамлаагүй тул уламжлалт нотлох баримтыг цуглуулах, мөрдөн шалгах тухай заалтууд нь цахим нотлох баримтын үндэс зохицуулалт хэвээр байна.⁵³ Цахим нотлох баримт гэдгийг цахим хэлбэрээр (компьютерын өгөгдөл) байгаа нотлох ач холбогдолтой мэдээлэл гэж үзнэ.⁵⁴

Эстони улсын ЭХХШТХ-ийн Нотолгоо гэсэн 3-р бүлэгт ЭХХША-ний нотлох баримтын зохицуулалтыг тусгасан байдаг бөгөөд “Нотлох баримт” гэсэн 63 -р зүйлд *“Нотлох баримт гэж сэжигтэн, яллагдагч, хохирогчийн мэдүүлэг, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, шинжээчийн дүгнэлтийн талаар тайлбар гаргасны дагуу шинжээчийн өгсөн мэдүүлэг, эд мөрийн баримт, мөрдөн байцаалтын ажиллагааны тайлан, шүүх хуралдааны тэмдэглэл, тайлан, тандалтын үйл ажиллагаа, бусад баримт бичиг, гэрэл зураг, кино эсвэл бусад мэдээллийн бичлэг.”*⁵⁵ Гэж тодорхойлсон байна. Ерөнхийдөө, уг 63 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан нотлох баримтын төрлийг (хатуу нотлох баримт гэж нэрлэдэг) нотлох үндэслэлээр ЭХХША-нд ашиглаж болно.

Мөн уг 63 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт ороогүй нотлох баримтыг хэргийн үндсэн үйл баримтыг тогтоох зорилгоор бус ЭХХША-тай холбоотой баримтуудыг нотлох зорилгоор ашиглаж болно. 62 дугаар зүйлд заасан нотлох баримтаар ашиглах үндэслэлд дараах үндэслэлүүд хамаарна.

1. гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа, газар, арга хэлбэр, гэмт хэрэгтэй холбоотой бусад баримт;
2. Гэмт хэргийн зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг (элемент);
3. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруутай эсэх;
4. гэмт хэрэг үйлдсэн этгээд болон тухайн этгээдийн хариуцлагад нөлөөлж буй бусад нөхцөл байдлын талаарх мэдээлэл.

Энэхүү нотлох баримтын систем нь хүлээн зөвшөөрөгдөх янз бүрийн нотлох баримтууд болон нотлох баримтын янз бүрийн эх сурвалжуудын хооронд тодорхой ялгааг харуулж байгааг Эстонийн Дээд шүүх тогтоосон⁵⁶.


Эстонийн хууль тогтоох байгууллага ЭХХША-ны явцад нотлох баримтын зөвшөөрөгдөх хэлбэрийг тодорхойлсон. Дээрх заалт (63(1)) нь Эстонийн ЭХХШТХ-ийн

⁵³ Eneli Lauritis, “Criminal procedure and digital evidence in Estonia”, Digital Evidence and Electronic Signature Law Review, 13 (2016), P.113

⁵⁴European Judicial Network, Fiches Belges on electronic evidence Estonia. Available at <https://www.ejn-crimjust.europa.eu/ejnupload/DynamicPages/EE%20electronic%20evidence%20fb.pdf>

⁵⁵ БНЭСҮ-ийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Kriminaalmenetluse seadustik, 2003)

⁵⁶ Eneli Lauritis, “Criminal procedure and digital evidence in Estonia”, Digital Evidence and Electronic Signature Law Review, 13 (2016), P.113



нотлох баримтын төрлийг тодорхойлсон цорын ганц заалт юм. Нотолгооны зүйл болон нотлох баримтаар авах ерөнхий нөхцөлд тусад нь тодорхойлолт эсхүл тусгай журам тогтоогоогүй болно. Үүнтэй холбоотой дараах заалтууд ЭХХШТХ-д байдаг. Үүнд:

64-р зүйл. ЭХХША-нд нотлох баримтаар тогтоох (хэрэгт авах) ерөнхий нөхцөл⁵⁷


- (1) Нотлох баримтыг авахад оролцсон хүмүүсийн нэр төр, алдар хүндэд харшлахгүй, амь нас, эрүүл мэндэд нь аюул учруулахгүй, үндэслэлгүй эд хөрөнгийн хохирол учруулахгүй байхаар нотлох баримтыг авна. Хүнийг эрүүдэн шүүх, түүний эсрэг бусад хэлбэрээр хүчирхийлэх, ой санамжид нь нөлөөлөх, хүний нэр төрийг гутаан доромжлох зэргээр нотлох баримтыг авч болохгүй.*
- (2) Эрэн сурвалжлах, биет үзлэг хийх, харьцуулсан дээж авах явцад хүний хувцсыг тайлах шаардлагатай бол эрүүл мэндийн мэргэжилтэн, шүүх эмнэлгийн эмчээс бусад мөрдөн байцаах байгууллагын албан тушаалтан, прокурор, процесс ажиллагаанд оролцогчид тухайн хүнтэй ижил хүйсийн хүн байна.*
- (3) Нотлох баримт авах явцад техникийн хэрэгсэл ашигласан бол энэ тухай ЭХХША-нд оролцогчдод урьдчилан мэдэгдэж, техникийн хэрэгслийг ашиглах зорилгыг тайлбарлана.*
- (4) [Хүчингүй болсон - 2011.02.23-ны өдрийн 1 дүгээр тогтоол, 2011.09.01-ний өдөр хүчин төгөлдөр болсон.]*
- (5) Шаардлагатай бол энэ хуулийн § 214-д заасны дагуу шүүхийн өмнөх ажиллагаатай холбоотой мэдээллийг задруулахыг хориглохыг процессын ажиллагаанд оролцогчдод анхааруулна.*
- (6) Нууцаар ажиглах ажиглалтын үйл ажиллагаагаар нотлох баримт авах асуудлыг энэ хуулийн 31 дүгээр бүлгээр зохицуулна.*

Эндээс үзэхэд Эстонийн ЭХХШТХ-д заасан нотлох баримтын төрлийг ерөнхийд нь тодорхойлсон тул энэхүү заалтыг үндэслэн цахим хэлбэрийн нотлох баримтыг ЭХХША-нд ашиглах боломжтой гэсэн үг юм.⁵⁸ Үүний зэрэгцээ, Эстонийн хууль эрх зүйн орчинд цахим (дигитал) нотлох баримтын талаар тусгай журам, тодорхой заалтууд зайлшгүй шаардлагатай байгаа тухай хэлэлцүүлэг хэсэг хугацаанд явагдсан байна. Жишээлбэл, Эстонийн Хууль зүйн асуудал хариуцсан канцлер цахим харилцааны өргөн хэрэглээ, цахим мэдээллийн хэрэгсэлд агуулагдаж буй мэдээллийг задруулснаас үүдэлтэй үндсэн эрхийн зөрчлийн цар хүрээг харгалзан үзэж, уг зөрчигдөж буй үндсэн эрх, эрх чөлөөг илүү сайн хамгаалах чадвартай илүү нарийн зохицуулалт (шаардлагатай процедурын хамгаалалтыг дагалдсан) хийхийг санал болгож байв.⁵⁹ Эстонийн Хуульчдын холбооны зүгээс мөн нэгжлэг хийх явцад хураан авсан цахим мэдээлэл нь олон эрүүгийн хэрэгт нотлох баримт болж, ийм нотлох баримтын ач холбогдол улам бүр нэмэгдсээр байгааг олж тогтоосон бөгөөд Хуульчдын холбооноос цахим (дигитал) нотлох баримтыг олж авах, түүнийг ЭХХША-нд ашиглах асуудлыг уламжлалт нотлох баримтаас тусад нь зохицуулах нь зүйтэй гэж үзсэн байна. Учир нь уламжлалт нотлох баримттай холбоотой заалтуудыг цахим (дигитал) нотлох баримт дээр ашиглах нь

⁵⁷ БНЭсУ-ийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Kriminaalmenetluse seadustik, 2003)

⁵⁸ Эстонийн Дээд шүүх гар утасны зурвас болон цахим шуудангийн захидал харилцааны аль алиныг нь нотлох баримт болгон хүлээн зөвшөөрдөг боловч хувийн ярианы бичлэгийг ЭХХШТХ-ийн 63 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдээллийн бичлэг гэж үнэлдэг.

⁵⁹ Eneli Lauritis, "Criminal procedure and digital evidence in Estonia", Digital Evidence and Electronic Signature Law Review, 13 (2016)



ЭХХША-н дахь хүний эрх, түүнчлэн ийм нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх, найдвартай байдал, баталгаажуулалт зэрэгтэй бүрэн нийцэхгүй юм⁶⁰ гэж үсэн байна.

Эстонид Цахим (дигитал) нотлох баримтыг ЭХХШТХ дээр үндэслэн мөрдөн шалгах ажиллагааны процесс эсвэл нууцаар явуулсан сэжигтнийг ажиглах процесс ажиллагааны тусламжтайгаар олж авдаг ч цахим нотлох баримтыг уламжлалт нотлох баримтыг олж, цуглуулах процедурын дарааллын дагуу олж авч, цуглуулж, хэрэгт авдаг⁶¹ хэвээр байна.

БНЭсУ-ын нэгдэн орсон цахим нотлох баримт, түүнийг цуглуулах, олж авах асуудалд хамаарах олон улсын хууль тогтоомж, гэрээ, конвенц.

- “Цахим (Кибер) гэмт хэргийн тухай” 2001 оны Будапештын конвенц;
- Эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны Европын журам (EU 2014);
- Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих ял эдлүүлэх ажиллагааны цахим нотлох баримтыг бий болгох, хадгалах журам (EU) 2023/1543;

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт цуглуулах үүрэг бүхий байгууллагыг үүсгэн байгуулах, түүний хууль ёсны төлөөлөгчдийг томилох зохицуулалтыг ижилтгэх удирдамж (EU) 2023/1544 .

Америкийн Нэгдсэн Улсын сайн туршлага

Цахим нотлох баримт нь бусад нотлох баримтуудтай үзэл баримтлалын хувьд ижил байдаг—энэ нь гэмт хэргийн учир шалтгааны холбоог тогтоохын тулд хүмүүс, үйл явдлыг цаг хугацаа, орон зайд байрлуулахыг оролдсон мэдээлэл юм. Гэсэн хэдий ч цахим нотлох баримт нь биет нотлох баримттай харьцуулахад илүү өргөн цар хүрээтэй, илүү хувийн хүрээнд эмзэг, уян хатан, хөдөлгөөнт шинж чанартай, өөр бэлтгэл, багаж хэрэгсэл шаарддаг.

Цахим нотлох баримт нь "цахим төхөөрөмж дээр хадгалагдаж, хүлээн авсан эсвэл дамжуулсан мөрдөн байцаалтын явцад үнэ цэнтэй мэдээлэл, өгөгдөл юм" (National Institute of Justice [NIJ], 2008) . Ийм нотлох баримтууд үндсэн компьютер, телефон утасны систем гэх мэт хязгаарлагдмал хэлбэрээр олон арван жилийн турш оршин тогтнож байсан ч хувийн электрон төхөөрөмжүүд хурдацтай тархах тусам цахим нотлох баримтыг боловсруулахын ач холбогдол нэмэгдсээр байна. 21-р зууныг зөөврийн хөгжим тоглуулагч, гар утас, компьютерын төхөөрөмжүүдийн дэвшил тодорхойлсон. АНУ-ын Дээд шүүх саяхан гар утас нь ганц харилцаа холбооны хэрэгсэл биш, харин утас, календарь, өдрийн тэмдэглэл, цахим шуудангийн системийн үүрэг гүйцэтгэдэг микрокомпьютер юм гэж тайлбарласан; цахим нотлох баримт нь уламжлалт биет бүртгэл, нотлох баримтаас хэрхэн ялгаатай болохыг ойлгоход орчин үеийн технологи гурван шинж чанарыг бий болгодог: (1) Цахим нотлох баримт нь илүү өргөн хүрээг хамардаг, (2) биет болон хувийн нууц мэдээллийг хоёуланд нь авч үздэг, (3) хууль сахиулах байгууллагын нотлох баримт цуглуулах ердийн чиг үүргээс гадна эрүүгийн эрх зүйн харилцан уялдаатай асуудлуудыг хамардаг.

⁶⁰ Мөн тэнд.

⁶¹ Мөн тэнд.



Цахим нотлох баримтын төрлүүд

Интернет

Хууль сахиулах байгууллагын мөрдөн байцаалтад ашигладаг зарим дижитал нотлох баримтууд нь харилцаа холбооны вэбсайтууд, ялангуяа мессежний самбар, чат өрөөнүүдээс гаралтай. Эдгээр төрлийн сайтууд нь одоогийн мөрдөн байцаалтын мэдээллийн эх сурвалж байсаар байгаа ч бусад интернэт болон интернетэд холбогдсон технологиуд тархаж байгаа нь нотлох баримтын олон эх сурвалжийн тоонд багтаж байна гэсэн үг. Мессежний самбар болон чат өрөөнүүд нь хэрэглэгчдэд архив эсвэл тухайн цаг үеийн харилцаа холбоог уншиж, хариулах боломжийг олгодог. Эдгээр эх сурвалжийг ашиглахад хэд хэдэн бэрхшээл тулгардаг. Ийм сайтуудын байршил, хаяг нь олон нийтэд үргэлж мэдэгддэггүй, учир нь сайтуудыг олохын тулд анхан шатны мэдээлэл цуглуулах ажил эсвэл онлайн хайлт хийх шаардлагатай байдаг. Уншигчид чат харилцааг ойлгох, оролцогчдыг танихаас сэргийлэхийн тулд хэрэглэгчид нэрээ нууцлах, кодлогдсон эсвэл шифрлэгдсэн харилцаа холбоог ашигладаг. Интернэтийн дэлхий даяарх мөн чанар нь үүнийг улам хүндрүүлдэг, учир нь амжилттай танигдсан ч тухайн хүн нь мөрдөн байцаагчийн эрх мэдлээс гадуур байж болох юм. Мөрдөн байцаалтын явцад ашигладаг өөр нэг гол эх сурвалж бол файл хуваалцах сүлжээ юм. Эдгээр сүлжээнүүд нь зураг, видео зэрэг өгөгдлийн файлуудыг дамжуулахын тулд хэрэглэгчдийг холбодог. Хууль сахиулах байгууллагын мөрдөн шалгах ажиллагаа, хуулийн арга хэмжээ, ялангуяа зохиогчийн эрхийн зөрчил болон бусад хууль бус материал солилцохтой холбогдуулан олон тооны файл хуваалцах сүлжээг хаасан эсвэл шинэчилсэн байдаг. Хэрэглэгчдийг хянах боломжтой бөгөөд татаж авсан файлуудыг ихэвчлэн тодорхой IP хаягтай нь холбож болдог. Жишээлбэл, хөгжмийн зохиогчийн эрхийн хэрэг нь зохиогчийн эрхийг хуулиар зөрчсөн, ямар хэрэглэгчид оролцсон гэхээсээ илүү тодорхой хөгжмийн файльтай холбоотой байж болно. Гэсэн хэдий ч шилжүүлгийн агуулга нь хүүхдийн садар самууныг мөрдөн шалгах гэх мэт хэрэгт хамааралтай байж болно.

Компьютер


Хувийн компьютер дээр олон тооны цахим нотлох баримтууд байдаг. Эдгээр зүйлсийн ихэнхийг гар аргаар эсвэл logical аргаар гаргаж авч болно. Зарим нотлох баримтууд нь интернетээс олж авсан мэдээлэлтэй давхцаж байгаа ч Интернетээс бус биет төхөөрөмжөөс олж болох хэд хэдэн нэртэй эх сурвалжууд байдаг.

Интернэтээр аялж байхад програмууд нь ихэвчлэн түр зуурын интернет файл, (cookie) күүки болон хайлтын түүхийг хадгалдаг. Эдгээрийг хэрэглэгчийн веб түүхийг тодорхойлохын тулд мөрдөн байцаалтын явцад ашиглаж болно. Түр зуурын файлууд болон күүкиг ихэвчлэн вэбсайтууд өөрсдөө хэрэглэгчдийг хянах, мэдээлэл хадгалахад ашигладаг байна.

Имэйл болон бусад мессежийг биет компьютер дээрээс олж болно. Хэдийгээр Google болон Microsoft-ын эсрэг сүүлийн үеийн хэргүүдээс харахад ихэнх цахим шуудан нь интернэт серверүүд дээр хадгалагддаг боловч зарим харилцаа холбооны программ хангамж нь өмнөх мессежнүүдийг компьютерын хатуу диск рүү архивладаг.

Зөөврийн электрон хэрэгсэл

Одоогийн байдлаар гар утас гэх мэт зөөврийн электроник хэрэгслээс цахим нотлох баримт гаргаж авах нь эксперт, судлаачдын анхаарлын төвд байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд ийм төхөөрөмжүүдийн хэрэглээ ба нөлөө нь эрс нэмэгдэж, электрон



болон биет эх сурвалжийн өмнөх хослолоос илүү хувийн мэдээллийг агуулсан жижиг электрон төхөөрөмжүүдийг нийлүүлэхэд хүргэсэн.

Цахим нотлох баримтын салбарт гар утас зонхилох сонирхлыг татаж байгаа нь гайхах зүйл биш юм. Эдгээр төхөөрөмжүүд нь орчин үеийн нийгэмд бараг хаа сайгүй байгаа бөгөөд 21-р зуунд үзүүлэлтийн хувьд хувьсгал хийж, хууль эрх зүйн шинэ сорилтуудыг дагуулж байгаа тул АНУ-ын Дээд шүүх саяхан хэргийн газарт ихэнх гар утсыг нэгжиж шалгахад зөвшөөрөл шаардлагатай гэж шийдвэрлэсэн. Салбарын судалгаанаас үзэхэд АНУ-ын утасгүй сүлжээний захиалгын тоо одоогийн байдлаар нийт хүн амаас давж байна (336 сая хүн амтай, 313 сая хүн); Энэ захиалгын тооцоо нь арван жилийн өмнө байсан 159 сая байснаас хоёр дахин их байна (Утасгүй сүлжээний салбарын жилийн судалгаа, 2014). Ерөнхий шүүгч Жон Робертс Райлигийн шийдвэрт гар утас нь хүмүүсийн олон тооны чухал хэрэгцээг хангадаг "микрокомпьютер" юм гэж дурдсан. Нэг шалтгаан нь хэргийн газарт гар утсыг нэгжиж шалгахад хууль сахиулах байгууллага нь зөвшөөрөлтэй байх ёстой гэж шүүх шийдвэрлэсэн -цаас эсвэл бусад зөврийн зүйлээс ялгаатай нь гар утасны мэдээлэл нь дэвтэр, өдрийн тэмдэглэл, хувийн компьютер гэх мэт зөврийн бус том эд зүйлстэй адилхан байж болно. Гар утаснууд нь зураг авах, байршил тогтоох систем (GPS), имэйл болон бусад баримт бичгүүдээс ялгаатай текст мессеж илгээх зэрэг онцлогтой. Мөн гар утас нь ихэвчлэн утасны жагсаалт, дуудлага хийсэн болон хүлээн авсан бүртгэл, дуудлагын үргэлжлэх хугацаа зэргийг багтаасан байдаг.


Цахим нотлох баримттай холбоотой хууль эрх зүйн асуудлууд

Технологийн байнгын өөрчлөлтийн үед хуулийн байгууллагууд цахим нотлох баримттай холбоотой асуудлуудыг шийдвэрлэхийн тулд цаг үетэй нийцсэн бодлогын төслийг боловсруулах ёстой. Бодлого тогтоохын тулд хууль сахиулах байгууллага нь шүүх, прокурор зэрэг талуудтай хамтран хэрэг бүртгэл мөн хүлээн зөвшөөрөгдөх эсэх нь хууль ёсны шаардлага хангаж байгаа эсэхийг тодорхойлох ёстой. Нотлох баримт нь хэргийн дараа зохисгүй олж авсан гэж үзвэл эрүүгийн эрх зүйн тогтолцоонд төдийлөн ач холбогдолгүй. Хууль сахиулах байгууллага мөн хамтарч буй байгууллагууд нь цахим нотлох баримтад нийцсэн хүлээлт тавих хэрэгтэй ба цахим бус нотлох баримтын процесс бодлого нь ялгаатай байдаг.

Үзлэг нэгжлэг хийх

АНУ-ын Дөрөв дэх нэмэлт өөрчлөлт нь төрийн эрх баригчдын үндэслэлгүй нэгжлэг, хураан авахаас хамгаалдаг. Шүүх нь цахим төхөөрөмж, цахим мэдээллийн өвөрмөц шинж чанарыг судалж Дөрөвдүгээр нэмэлт өөрчлөлт нь цахим мэдээлэлд хэрхэн үйлчлэх талаар тайлбарлахаар зорьж байна. Дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлт үйлчилж байгаа тохиолдолд хууль сахиулах албан хаагч нь нэгжлэг хийхийн тулд зохих шүүхээс нэгжлэг хийх зөвшөөрөл авах ёстой боловч зарим үл хамаарах зүйлс байдаг. Зөвшөөрөлгүй нэгжлэгийг зохих этгээдийн зөвшөөрлөөр хийж болох ч хойшлуулшгүй нөхцөл байдал эсвэл нотлох баримт устах аюултай үед нь цахим хадгалах төхөөрөмжийг хязгаартайгаар үзлэг нэгжлэг хийх шалтгаан болдог. Хууль сахиулах ажилтнуудыг хамгаалах, нотлох баримт устахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай үед баривчлах ажиллагааны хүрээнд хязгаартай нэгжлэг хийж болно.

Хянан шалгагчид ил тод харагдах нотлох баримтууд нь үзлэг нэгжлэг хийхэд зөвшөөрөл авах шаардлагаас үл хамаарч болдог (Horton v California, 1990). Гэсэн хэдий ч цахим хэлбэрээр хадгалагдсан мэдээллийн хувьд энэ зарчмыг хэрэгжүүлэх нь илүү




төвөгтэй болдог. Мерфи, Эсворти нар (2012) цахим нотлох баримт цуглуулах үйл явцыг хоёр үе шаттай үйл явц гэж үзэхийг зөвлөдөг. Эхний шат бол зөвшөөрөлд хамаарч төхөөрөмж эсвэл төхөөрөмжид байгаа мэдээллийг хураан авах явдал юм. Мерфи, Эсворти нарын хэлснээр, эхний хураан авалт нь хэт өргөн хүрээтэй бөгөөд нэгжлэг хийх зөвшөөрөлд хамраагүй олон мэдээллийг агуулж болохыг шүүх зөвшөөрсөн. Тиймээс хууль сахиулахын албан хаагчид нэгжих зөвшөөрлийн хүрээнд хураан авсан мэдээллийг шалгаж ялгаж авах хоёр дахь үе шат байх ёстой. Үүний тулд хураан авсан төхөөрөмжүүд дээрх файлуудыг шалгах шаардлагатай: Ийм шалгалтын явцад нэгжлэг хийх зөвшөөрлөөс гадуур гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагааны нэмэлт нотлох баримтууд илэрч болно.

АНУ-д Конгресс Дөрөвдүгээр нэмэлт өөрчлөлтийн шаардлага болон эрүүгийн мөрдөн байцаалтын хэрэгцээг тэнцвэржүүлэхийн тулд олон хууль баталсан. АНУ-ын хуулийн дөрвөн хэсэг нь цахим нотлох баримтад онцгой хамаатай: Wiretap Act (18 U.S.C. §2510 et seq.); the Pen Registers and Trap and Trace Device Statute (18 U.S.C. §3121 et seq.); Цахим харилцааны нууцлалын тухай хууль (ECPA) (18 U.S.C. §2701 гэх мэт); болон Нууцлалыг хамгаалах тухай хууль (PPA) (42 U.S.C. §2000aa ба бусад).

The Wiretap Act нь утсаар, амаар эсвэл цахим харилцаанд оролцогч талуудыг харилцаа холбоог гаднын этгээд чагнахаас хамгаалдаг. Уг үйлдэл нь аман харилцаа холбоо, утасны дуут болон текст мессеж, эсвэл шууд мессеж, цахим шуудан гэх мэт компьютероор үүсгэсэн мессежийг чагнах зориулалттай төхөөрөмжид хамаарна. Үндэслэлтэй бол шүүхээс хууль сахиулах байгууллагад хөндлөнгөөс оролцохыг зөвшөөрсөн захирамж гаргаж болдог. Шүүхийн захирамжгүйгээр харилцаа холбоог чагнах засгийн газрын оролдлого нь иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээлгэж, нотлох баримтыг таслан зогсооход хүргэдэг.

The Pen Registers and Trap and Trace Device Statute нь утас, интернэт холболттой холбоотой мета өгөгдөл цуглуулахыг хязгаарладаг. Харилцааны агуулгыг зохицуулдаг The Wiretap Act-с ялгаатай нь The Pen Registers and Trap and Trace Device Statute нь имэйл хаяг, залгасан утасны дугаар эсвэл хүлээн авсан дуудлагын утасны дугаар зэрэг мэдээллийг хамардаг. Хэрэв хуульд үл хамаарах зүйл байхгүй бол хууль сахиулах ажилтнууд харилцааны холбооны мета өгөгдлийг хайхаасаа өмнө шүүхийн захирамж авах ёстой.

Цахим харилцааны нууцлалын тухай хууль (ECPA) нь сүлжээ нийлүүлэгчийн хадгалсан бүртгэл, файлуудтай холбоотой заалтыг агуулдаг. Энэ нь интернэт сүлжээ нийлүүлэгчийн (ISP) хадгалсан имэйл болон бусад захиалагчийн мэдээллийг хууль ёсны зөвшөөрөлгүйгээр задруулахаас хамгаалдаг. Хадгалсан мэдээлэлд хандахын тулд хууль сахиулах байгууллагаас шаардагдах зөвшөөрлийн төрөл нь хайж буй мэдээллийн нууцлалаас хамааран шүүхэд дуудах хуудаснаас авхуулаад үзлэг нэгжлэг хийх зөвшөөрөл хүртэл байдаг. Уг хууль нь сэжигтний хувийн компьютерт хадгалагдсан харилцаа холбоотой мэдээлэлд хамаарахгүй. Боловсронгүй болж хууль нь хэт өргөн хүрээний иргэний зарлан дуудах хуудас нь интернэт сүлжээ нийлүүлэгч ISP-ийг хэрэглэгчийн хувийн мэдээллийг өгөхийг албадахад хангалтгүй байж магадгүй гэж үзэж байна (Мэрфи ба Эсворти, 2012). Гэсэн хэдий ч Цахим харилцааны нууцлалын тухай хууль нь гуравдагч этгээдийн сервер дээр 180 хоногоос дээш хугацаагаар хадгалагдсан материалыг орхигдуулсан гэж үздэг тул хууль сахиулах байгууллагын ажилтнууд зөвхөн мөрдөн байцаалтад хамааралтай болохыг нотолсон бичгээр мэдэгдэл өгөхөд л хангалттай. Өнөөдөр хэрэглэгчид гуравдагч этгээдийн сервер дээр имэйлээ тодорхойгүй хугацаагаар хадгалах магадлалтай бөгөөд энэ нь хууль сахиулах байгууллагад асар их



давуу тал болж өгдөг, учир нь өөр тохиолдолд хэрэглэгчийн хувийн төхөөрөмжөөс ижил мэдээлэл авахад зөвшөөрөл авах шаардлагатай ба 180 хоногийн дүрмийг хасах талаар нэлээд маргаантай байдаг байна.

PPA нь зохиогчийн бүтээсэн бүтээгдэхүүн (онлайн мэдээллийн товхимол, блог гэх мэт), мөн тухайн бүтээгдэхүүнийг бүтээхэд ашигласан материалыг хамгаалдаг. PPA-д хамаарах материалууд нь нэгжлэг хийх зөвшөөрөлд хамаарахгүй. Гэсэн хэдий ч, материал нь гэмт хэрэг үйлдэхтэй холбоотой эсвэл хураан авах нь амь нас аврах, бие махбодод ноцтой гэмтэл учруулахаас сэргийлэх тохиолдолд үл хамаарах юм.


Баримтжуулах

Цахим нотлох баримтыг баримтжуулах нь гэрчлэх, баримт бичгийн бүртгэлийн хоёр асуудлыг багтаадаг. Баталгаажуулалт нь нотлох баримт нь түүнийг санал болгогчийн үзэж байгаа зүйл мөн болохыг тогтоох үйл явц юм. Нотлох баримт гаргаж буй тал нь тухайн зүйл жинхэнэ гэдгийг нотлох шаардлагатай. Цахим нотлох баримтыг баталгаажуулах гол асуудал бол цахим баримтын зохиогчийн хэн болохыг тогтоох явдал юм. Жишээлбэл, хариуцагчаас хохирогчид бичсэн цахим шуудан нь хариуцагч өөрөө бичсэн гэдгийг нотлох баримтыг прокурор нотлох шаардлагатай. Олон мужийн шүүхээс баталсан Холбооны нотлох баримтын дүрэмд компьютер, гар утас хураан авсан хууль сахиулах албан хаагч гэх мэт мэдлэгтэй гэрчийн мэдүүлгээр нотлох баримтыг тогтоохыг зөвшөөрдөг бөгөөд файлуудыг хаанаас авсан болохыг гэрчлэх боломжтой юм. И-мэйл нь хариуцагчийн мэддэг байсан мэдээлэл эсвэл мессежийг илгээсэн төхөөрөмжид анх хандсан хүн нь хариуцагч байсан тухай гэрчлэх гэх мэт янз бүрийн арга хэрэгслээр дамжуулан баталгаажуулж болно. Баталгаажуулах үйл явцын нэг хэсэг болгон баримт бичгийн бүртгэл нь цахим нотлох баримтыг анхны хэлбэрээр нь хадгалж баталгаажуулдаг. Энэ нь нотлох баримтыг хэзээ цуглуулсан, хаанаас цуглуулсан (төхөөрөмжийн төрөл, таних тэмдэг, өмчлөгч гэх мэт), төхөөрөмжийг хэн эзэмшиж байсан, хэн түүнд хандах эрхтэй болохыг баримтжуулах боломжтой болно. Энэ нь нотлох баримтыг хэрхэн цуглуулсан (жишээ нь ямар арга хэрэгсэл, процедур ашигласан) зэргийг багтаана. Эцэст нь, баримт бичгийн бүртгэл нь нотлох баримт хэрхэн хадгалагдсан, хэн нотлох баримттай харьцсан, хэн нэвтэрч байсан талаар баримтжуулсан байдаг⁶².

Дээрхээс дүгнэвэл АНУ-д цахим нотлох баримтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах нь түгээмэл болох нь харагдаж байна. Мөн “цахим нотлох баримт” гэдгийг тодорхойлж өгснөөс гадна үзлэг нэгжлэг хийх, баримтжуулах үйл ажиллагааг Wiretap Act (18 U.S.C. §2510 et seq.); the Pen Registers and Trap and Trace Device Statute (18 U.S.C. §3121 et seq.); Цахим харилцааны нууцлалын тухай хууль (ECPA) (18 U.S.C. §2701 гэх мэт); болон Нууцлалыг хамгаалах тухай хууль (PPA) (42 U.S.C. §2000aa ба бусад) гэх хуулиудаар нарийвчлан зохицуулсан нь боловсронгуй зохицуулалт болжээ. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим нотлох баримтыг тусгахдаа дээрх боловсронгуй зохицуулалтыг жишиг болгон авч үзэх нь зүйтэй.

Бүгд Найрамдах Солонгос Улсын сайн туршлага

⁶² Digital Evidence and the U.S. Criminal Justice System: Identifying Technology and Other Needs to More Effectively Acquire and Utilize Digital Evidence. Sean E. Goodison, Robert C. Davis, and Brian A. Jackson. <https://www.ojp.gov/pdffiles1/nij/grants/248770.pdf>




Одоогийн байдлаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим нотлох баримт болон түүнийг хураан авах, нэгжлэг хийх талаар ямар ч зохицуулалтыг тусгаагүй байна⁶³.

Мөн цахим мэдээлэл гэдэг нь компьютер гэх мэт мэдээлэл боловсруулах системээр боловсруулагдсан мэдээллийг хэлдэг бөгөөд үүнийг цахим нотлох баримт гэж нэрлэдэг. Цахим мэдээлэл нь компьютерийн диск гэх мэт мэдээллийн хадгалах хэрэгсэлд хадгалагддаг. Цахим мэдээлэл нь биет бус боловч мэдээлэл хадгалах хэрэгсэл нь биет юм. Компьютер нь аж ахуйн нэгжийн болон хувь хүмүүсийн үйл ажиллагааны чухал хэрэгсэл болсон тул цахим мэдээллийг хадгалах, хайх хэрэгцээ улам бүр өргөжиж байна.

Цахим нотлох баримт гэдэг нэр томъёо нь гэмт хэрэг үйлдсэнийг нотлох эсвэл гэмт хэрэг болон түүний хохирогч, гэмт хэрэг болон түүнийг үйлдэгч хоёрын хооронд холбоо тогтоох боломжтой аливаа цахим өгөгдлийг агуулсан ойлголт юм. Цахим нотлох баримт нь үндсэндээ баримт бичиг, зураг, аудио, видео зэрэг мэдээллийн хэлбэрүүд ба нэмж дурдахад энэ нь хэл, тоонуудын өвөрмөц хослол хэлбэрээр компьютер дээр хуулбарлагддаг. Заримдаа цахим нотлох баримт нь соронзон орон, электрон импульсээс бүрдэх тул биет бус, бодитой бус нотлох баримт болох тохиолдол байдаг. Үүнийг тусгай багаж, тусгай техник ашиглан цуглуулж, шинжилж болдог. Үүнийг илрүүлэх, цуглуулах, ашиглах байдлын хувьд мэргэжлийн мэдлэг, тусгай багаж хэрэгсэл шаарддагийг эс тооцвол эд мөрийн баримтаас нэг их ялгагдахгүй. Харин эд мөрийн баримт нь гэмт хэрэгтэн устгасан тохиолдолд нөхөн сэргээх боломжгүй тохиолдол байдаг бол цахим нотлох баримтын хувьд нотлох баримтыг устгасан ч нотлох баримтын зарим хэсэг буюу хуулбар нь үлддэг.

Өнөөдрийн байдлаар олон янз илэрч буй кибер гэмт хэрэг нь түүнд тохирсон цахим нотлох баримтын янз бүрийн хэлбэрийг бий болгож байна. Жишээлбэл, кибер мөшгигчид хохирогчдоо бэлгийн дарамт үзүүлэхийн тулд цахим шуудан ашигладаг, компьютерийн хакерууд нэвтэрсэн ул мөрийг бүртгэлийн файлд үлдээдэг, хүүхдийн садар самууныг сонирхогчид компьютер дээрээ хүүхдийн садар самууныг харуулсан дижитал видео файлуудыг хадгалдаг. Тэдгээр нь амархан танигдахгүй янз бүрийн хэлбэрээр байдаг. Цахим нотлох баримтыг хэд хэдэн шалгуурт үндэслэн дараах байдлаар ангилдаг. Нэгдүгээрт, хүний оролцоотой боловсруулалтын процесс байсан эсэхээс хамаараад компьютероор хувиргасан нотлох баримт, компьютерийн тусламжтай бий болсон нотлох баримт гэж бий. Эхнийх нь компьютер ажиллаж эхлэх үед өгөгдөл оруулах гэх мэт хүний оролцоогүйгээр тодорхой программыг хэвийн ажиллуулж, бие даан гүйцэтгэсэн ажлыг бүртгэдэг компьютерээр үүсгэгдсэн нотлох баримт гэж хэлж болно. Тухайлбал, онгоцонд суурилуулсан хар хайрцганд нислэгийн бүртгэл автоматаар бүртгэгддэг бол хүний гараар өгөгдөл оруулах, командыг гүйцэтгэх явцад компьютерийн боловсруулалт хийх замаар өгөгдөл бүрдүүлдэг тохиолдол байдаг. Тодруулбал компьютерээр залилангийн гэмт хэрэг хийх үеийн нотолгоо үүнд хамаарна. Үүнийг компьютерт хадгалагдсан нотлох баримт, компьютерийн симуляци гэж хуваагддаг. Компьютерт хадгалагдсан нотлох баримт гэдэг нь хүний гараар дамжуулан компьютерт хадгалагдаж, төрийн байгууллага эсвэл компаниудад ашиглагдаж буй өгөгдлийг хэлнэ. Жишээлбэл нягтлан бодох бүртгэлийн төрөл бүрийн программууд эсвэл статистикийн программууд гэх мэт. Компьютерийн симуляци гэдэг нь зам тээврийн осол, онгоцны ослын үед хоёр талын зам, хурд зэрэг виртуал өгөгдлийг оруулах замаар

⁶³ 형사절차상 digital evidence에 관한 연구 - 압수, 수색을 중심으로 - Digital Evidence in Criminal Procedure, pp.21, https://www.kicj.re.kr/boardDownload.es?bid=0001&list_no=9714&seq=1



компьютерийн программын үр дүнд бий болсон өгөгдлийг хэлнэ. Энэ нь голчлон тодорхой нөхцлөөр боловсруулагдах үр дүнг шүүх хуралдаанд нотлох баримт болгон ашиглах нотлох баримт болгон гаргаж ирсэн тохиолдлуудад хамаарна. Гэсэн хэдий ч компьютерийн симуляцийн хувьд загварчлалд ашигласан шинжлэх ухааны зарчмуудын үнэн зөв, зохистой байдлыг хүлээн зөвшөөрсөн ч загварчлал нь өөрөө өөр алдаа гаргавал эсэргүүцэлтэй тулгарах болно. Үүнийг хязгаарлах ёстой. Учир нь шинжээч шүүх хуралдаанд дүгнэлтээ хэлж, ийм симуляцийг өөрийн дүгнэлтийг батлах үндэслэл болгон ашиглахад нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй. Нэгдүгээрт, компьютерээр үүсгэсэн нотлох баримтууд нь хүний амнаас гарсан нотлох баримт биш тул хүний амаар ярьсан нотлох баримт болохгүй, мөн бичлэг өөрөө найдвартай өндөр зэрэгтэй тул тухайн хэрэгт хамааралтай, үнэн зөв эсэх асуудлыг хөнддөггүй. Асуудлыг даван туулсан тохиолдолд үүнийг нотлох баримт болгон ашиглаж болно гэж хэлж болох ч компьютерийн тусламжтай нотлох баримтыг мэдээлэл оруулагч эсвэл өгөгдөл нийлүүлэгчийн мэдэгдэл гэж хүлээн зөвшөөрч, дуу ярианы нотлох баримт гэж ангилдаг.


Цахим нотлох баримтын байгаа хэлбэрээс хамааран төрлийг дараах байдлаар ангилж болно. Өөрөөр хэлбэл, соронзон хальс, соронзон дискэнд хадгалагдсан цахим бичлэг, цахим бичлэгийг тодорхой цахим мэдээлэл боловсруулах төхөөрөмж, түүний тусламжтайгаар гаргаж, үүсгэсэн тохиолдол гэж хувааж болно. Энэ нь бичгийн нотлох баримт ба нотлох баримтыг ялгах тухай онолоос санаа авсан дүгнэлт бөгөөд нотлох баримтыг судлах арга гэж хэлж болно. Энэ ангиллын арга нь эцсийн дүндээ цахим нотлох баримтыг баримтжуулж чадах эсэхээс хамаарна гэж хэлж болно. Эхнийх нь баримтжуулах боломжгүй төдийгүй харагдахуйц, уншигдахуйц хэлбэрээр үзүүлэхэд хэцүү бөгөөд тодорхой биет хэлбэрт хувиргах боломжгүй өгөгдөл юм. Сүүлийнх нь тодорхой агуулгатай, харагдахуйц, унших боломжтой баримт бичиг, зураг хэлбэрээр гаргаж болох, баримтжуулж болох, тиймээс шалгах шаардлагатай нотлох баримт бичигтэй дүйцэх мэдээллийн төрөл юм.

Эцэст нь цахим нотлох баримтыг хадгалсан эсэхээс нь хамааруулан төрөл болгон ангилж болно. Нарийн утгаараа цахим нотлох баримтыг хувийн компьютерээс сүлжээний сервер эсвэл интернетийн виртуал санах ойд хадгалах, мэдээлэл, харилцаа холбооны сүлжээгээр дамжуулж болно. Эхний тохиолдолд дижитал нотлох баримт хаана хадгалагдаж байгааг олж тогтоовол гэмт хэргийн нотлох баримт болгон нэгжлэг хийж хурааж авдаг бол сүүлийн тохиолдолд мэдээлэл, харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн талаар мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг⁶⁴.

Цахим мэдээлэл хадгалах хэрэгсэлд хадгалагдаж буй цахим мэдээлэл нь асар том хэмжээтэй бөгөөд эрүүгийн хариуцлагатай холбоотой цахим мэдээллээс гадна компанийн худалдааны нууц, хувийн нууц зэрэг эрүүгийн хариуцлагатай холбоогүй контентыг хадгалах шинж чанартай байдаг. Иймд цахим мэдээллийг хураан авах, нэгжихдээ бусад албадлагаас илүү болгоомжтой байж тухайн субъектийн үндсэн эрхийг зөрчихгүй байх шаардлагатай.

Хураан авч буй зүйл нь компьютерийн диск болон түүнтэй адилтгах бусад мэдээлэл хадгалах хэрэгсэл бол хадгалагдаж буй мэдээллийн хамрах хүрээг тодорхойлж, хэвлэж, эсхүл хуулбарлан ирүүлэх ёстой. Харин мэдээлэл хадгалах зөвөрлөгч зэргийг хязгаарлагдмал хүрээнд хэвлэх, хуулбарлах боломжгүй буюу хураах

⁶⁴ 형사절차상 digital evidence에 관한 연구 - 압수, 수색을 중심으로 - Digital Evidence in Criminal Procedure, pp.26-29, https://www.kicj.re.kr/boardDownload.es?bid=0001&list_no=9714&seq=1



зорилгодоо хүрэхэд ихээхэн хүндрэлтэй гэж үзвэл хурааж авч болно (БНСУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 3, 219 дүгээр зүйл).

Энэ мэтчилэн мөрдөн байцаах байгууллага цахим мэдээллийг хураан авч, нэгжлэг хийх нь зарчмын хувьд 1) зөвхөн нотолгоо гаргах үндэслэл болсон гэмт хэрэгт холбогдсон хэсгийг хэвлэмэл баримт болгон цуглуулах, 2) Газар дээрх нөхцөл байдал, их хэмжээний цахим мэдээллийн улмаас холбогдох мэдээллийг олж авахад удаан хугацаа шаардагдах, мэргэжлийн боловсон хүчин техникийн арга хэмжээ авах шаардлагатай зэрэг онцгой тохиолдолд холбогдох файлыг мөрдөн байцаах газрын зөөвөрлөдөг хадгалах хэрэгсэлд хуулбарлах 3) мэдээлэл хадгалах хэрэгслийг шууд хураан авах, 4) мэдээлэл хадгалах хэрэгсэлд агуулагдах бүх цахим файлыг цаасан хуулбар, дүрс бичлэг гэх мэт хэлбэрээр хураах байдлаар ангилж болно. Энэ тухай эрэн сурвалжлах зөвшөөрөлд заасан байх ёстой.


Мэдээлэл хадгалах хэрэгслээс хууль ёсны дагуу олж авсан хуулбарыг хайж олох, сэжиглэгдсэн баримттай холбоотой цахим мэдээллийг баримт болгон гаргах, файл болгон хуулбарлах зэрэг үйл явц нь мөн зөвшөөрлийн дагуу хураан авах, нэгжлэг хийх ажиллагааны нэг хэсэг гэж тооцогддог. Тиймээс ийм тохиолдолд баримт бичгийг хэвлэх, хуулбарлах объект, тухайлбал мэдээлэл хадгалах хэрэгслийн байршилд хураан авах, нэгжлэг хийх зэрэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 114, 215 дугаар зүйл болон Үндсэн хуулийн 12 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэгд заасны дагуу сэжиглэгдсэн хэсгүүдээр хязгаарлагдах ёстой. Энэ нь процедурын зарчмууд ба пропорциональ байдлын үүднээс энэ нь зүй ёсны хэрэг юм. Иймд мэдээлэл хадгалах хэрэгсэлд хадгалагдаж байгаа цахим мэдээллийг, эсхүл мөрдөн байцаах газрын албанд авч явсан хуулбарыг дур мэдэн баримт болгон хэвлэх, эсхүл хэрэгт авагдсан баримтад хамааралгүйгээр хуулбарлан файл болгон хуулж байгаа үйлдэл нь зарчмын хувьд хууль бус хураан авах ажиллагаа юм.

Түүнчлэн дээрх цуврал ажиллагаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 219, 121 дүгээр зүйлд заасан эрэн сурвалжлагдаж байгаа болон хураагдсан цахим мэдээллийг эзэмшигч этгээд, тэдгээрийн өмгөөлөгчийг оролцуулах боломжийг хангах, хамааралгүй цахим мэдээллийг дур зоргоороо давхардуулахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохих арга хэмжээг авч байна. Хэрэв ийм арга хэмжээ аваагүй бол сэжигтэн этгээд, эсхүл уг хэргийн мөн чанар, агуулгыг харгалзан хурааж авсан зүйлийн эзэмшигч этгээдийн процессын баталгааг хангах зорилгыг ноцтой зөрчсөн гэж үзэж болно.

Мөрдөн шалгах байгууллага, шүүх нь мэдээлэл хадгалах хэрэгслийг хураан авах замаар тодорхой мэдээлэл хүлээн авсан тохиолдолд тухайн мэдээллийн субъект болох, холбогдох баримтыг мэдээллээр таньж болох этгээдэд нэн даруй мэдэгдэх ёстой (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 219 дүгээр зүйлийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг)⁶⁵.

Дээрхээс дүгнэвэл, БНСУ-ын тухайд цахим нотлох баримтыг ангилан тодорхойлдог нь сайн жишиг бүхий зохицуулалт байх ба Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нотлох баримттай холбоотой нийтлэг зохицуулалтуудад цахим нотлох баримтыг хамааруулж уялдуулан хуулийг хэрэглэдэг сайн туршлагатай байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим нотлох баримтын

⁶⁵ 출처 : 법률저널(<http://www.lec.co.kr>)



талаар тусгахдаа түүний ангилал болон хууль хэрэглээний талаар сайн жишгийг авч үзэх нь зүйтэй.

Хуулийн төслийн сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголттой холбоотой зохицуулалт ЭХХШТХ-ийн практикт хэрэгжих боломжтой эсэх


Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-т “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно...” гэж мөн зүйлийн 14-т “ өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно...” гэж хүний халдашгүй байх, өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх үндсэн эрхийг баталгаажуулсан. Мөн ЭХХШТХ-ийн 1.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “...Шүүх прокурор, мөрдөгч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар, шаардахыг хориглоно...” гээд тодорхой заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 11 сарын 4-ний өдрийн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн зарим хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 10 дугаартай дүгнэлтийн 3-т “...Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг үндэслэлгүй хязгаарласан шинжгүй, хууль зүйн процессын суурь зарчмуудад нийцсэн байх ёстой. Энэ утгаараа хуульд гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа этгээдийн эрх зүйн байдлыг дээрх хуулиар нарийвчлан зохицуулж өгөөгүйн улмаас тухайн этгээдээс гэрчийн мэдүүлэг авч, түүний эрхийг хөндөх байдал гаргахаар байгааг хууль тогтоогч анхаарч, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байна...” гэж дүгнэсэн.⁶⁶

ЭХХШТХ 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээс хойш нийт 16 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд хамгийн сүүлд 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оржээ. 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар ЭХХШТХ-д сэжигтэнтэй холбоотой зарим зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт орсон. Тухайлбал, ЭХХШТХ-ийн 31.5 дугаар зүйлийг өөрчлөн найруулж, зүйлийн нэрийг “Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах” байсныг “Сэжигтнийг хойшлуулахгүйгээр баривчлах” болгон өөрчилж, тухайн зүйлийн зохицуулалтыг өөрчлөн найруулжээ. Мөн ЭХХШТХ-ийн 2.2 дугаар зүйлийн 10-12 дахь хэсэг, 5.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 16.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч тус өөрчлөлт нь 2024 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэх юм.

Хуульд ийнхүү өөрчлөлт оруулах болсон үндэслэл, шаардлагаа “...Сэжигтнийг баривчлах ажиллагааны 98-99 хувийг шүүхийн зөвшөөрөлгүй явуулж буй өнөөгийн нөхцөл байдлаас харахад Монгол Улсад баривчлах ажиллагаа үндсэндээ шүүхийн

⁶⁶ ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга, ХЗДХЯ, 2024 он.



хяналтаас гадуур хэрэгжиж байна.⁶⁷ Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан үндэслэлүүдийг 2020, 2021, 2022 оны байдлаар авч үзвэл, нийт баривчлах ажиллагааны 60-аас дээш хувийг “хойшлуулшгүй тохиолдолд” гэсэн үндэслэлээр баривчилсан байна⁶⁸. Шүүхийн зөвшөөрөлгүй баривчлаад үргэлжлүүлэн цагдан хорьсон тохиолдол 2020 онд 448 буюу 56.4 хувь, 2021 онд 496 буюу 61.3 хувь, 2022 онд 595 буюу 55.5 хувийг тус тус эзэлж байна. Шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан сэжигтний 42.1 орчим хувийг 24-48 цаг хорьсны дараа суллажээ⁶⁹. Иймд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа явуулахад практикт хамгийн их хэрэглэгддэг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан “хойшлуулшгүй тохиолдол” гэх үндэслэлийг “өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, эсхүл оргон зайлах, эсхүл хэргийн ул мөр, эд мөрийн баримт, нотлох баримтыг устгах, өөрчлөх, зөвөөрлөх, нуун далдлах, үрэгдүүлэх, хуурамчаар үйлдэх, гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргээ төгсгөх, эсхүл гэрч, хохирогч, хамтран гэмт хэрэг үйлдсэн хүнд хууль бусаар нөлөөлөх үндэслэл илэрсэн” гэж шинжийг өргөжүүлж, нарийвчлан⁷⁰ тусгаж ЭХХШТХ-ийн холбогдох зүйл, заалтад нэмэлт өөрчлөлт оруулсан гэжээ.

Тус нэмэлт, өөрчлөлтөөс өмнө 2020 оны ЭХХШТХ-ийн нэмэлт, өөрчлөлтөөр тус хуулийн 31.8 дугаар зүйлд “Баривчлагдсан сэжигтний эрх”-ийг засаж сайжруулан “Сэжигтнийг эрх” болгон өөрчилсөн боловч тус нэмэлт, өөрчлөлтөөр сэжигтэнтэй холбоотой асуудлыг бүхэлд нь шийдвэрлэж чадаагүй юм.

Энэ мэтчилэн, ЭХХШТХ-ийн сэжигтэнтэй холбоотой зохицуулалтад хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч өнөөдрийг хүртэл тухайн асуудлыг бүрэн шийдвэрлэж чадаагүй байна. Нөгөөтээгүүр, 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар оруулсан сэжигтэнтэй холбоотой нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөгдөж эхлээгүй байгаа учир энэхүү хуулийн төсөлд сэжигтэнтэй холбоотой зохицуулагдаагүй үлдсэн, засаж сайжруулбал зохих бүх асуудлыг цогц байдлаар судлан тусгаж хуульчлах нь нэн чухал юм.


Энэхүү хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад “...Хүнийг гэмт хэрэгт сэжиглэх илэрхий, хангалттай үндэслэл байсаар атал гэрчээр мэдүүлэг авсаны дараа баривчлах, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэний дараа сэжигтэн болгох нь Үндсэн хуулиар баталгаажсан “өөрийгөө өмгөөлөх” эрх, “өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байх тул гэрчээр мэдүүлэг авч байх үед гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл тогтоогдвол мэдүүлэг авах ажиллагааг зогсоож, сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг хуульд заасны дагуу явуулах зохицуулалтыг тусгах шаардлагатай байна. Иймд хүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл байгаа бол түүнийг гэрчээр дуудах, эсхүл түүнээс гэрчийн мэдүүлэг авахгүй байх, гэрчийн мэдүүлэг авах үед түүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрсэн бол гэрчийн мэдүүлэг авахыг даруй зогсоож, сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг хуульд

⁶⁷ Мөн тэнд.

⁶⁸ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 02/311 дүгээр албан бичиг.

⁶⁹ Мөн тэнд.

⁷⁰ ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга, ХЗДХЯ, 2024.



заасны дагуу явуулах зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.3 дугаар зүйлд тусгалаа...” гэжээ.

Хуулийн төслийн 16.3 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт “...Гэрчээр мэдүүлэг авч байх үед энэ зүйлийн 4.7-д заасан үндэслэл илэрвэл энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрхийг сануулж мэдүүлэг авах ажиллагааг зогсоож, сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг энэ хуульд заасны дагуу явуулна...” гэж заажээ.

Практикт сэжигтнийг баривчилсан тохиолдолд л сэжигтнээр, бусад үед гэрчээр мэдүүлэг авч байна. Учир нь ЭХХШТХ-ийн ЭХХШТХ-ийн 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 1/ баривчлагдсан, 2/ яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүнийг сэжигтэн гэнэ гэж тодорхойлсон. Иймээс баривчлагдсан тохиолдолд сэжигтэн, баривчлагдаагүй бол сэжигтэн биш учраас гэрчээр мэдүүлэг авдаг.

Нөгөөтээгүүр, гэмт хэрэг үйлдэгдсэний дараа тухайн иргэнийг гэмт хэрэгт холбогдуулан сэжигтэн, эсхүл яллагдагчаар татаж шалгах үндэслэл бүхий нөхцөл байдал тогтоогдсон байхад мөрдөгч нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.6 дугаар зүйлийн 31.6.4-д заасны дагуу сэжигтнээр мэдүүлэг авах ёстой байтал өөрийнх нь эсрэг гэрчээр мэдүүлэг авч, уг мэдүүлгийг нотлох баримтаар тооцож прокурор яллах дүгнэлт үйлдсэн тохиолдол гарч байна.⁷¹


ХБНГУ-ын эрүүгийн эрх зүйд гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй сэрдэгдэж буй хүн /Verdächtiger/, сэжигтэн, /Beschuldigter/, яллагдагч /Angeschuldigte/ гэсэн нэр томъёо байдаг бөгөөд Verdächtiger буюу сэрдэгдэж буй хүн нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч биш тул хуульд тухайн субъектийн талаар зохицуулалт байдаггүй.⁷²

Хуулийн төсөлд шинээр тусгагдаж буй “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэх нэр томъёо нь ХБНГУ-ын гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй сэрдэгдэж буй хүн гэх ойлголттой төстэй мэт боловч хуулийн төслийн “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэх нэр томъёог гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгах нотлох баримт хавтаст хэрэгт тусгагдсан, мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдсон гэж тодорхойлсон учир ХБНГУ-ын гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй сэрдэгдэж буй хүнээс илүү гэмт хэрэг үйлдсэн нь баримтаар тогтоогдсон хүнийг тодорхойлсон байна. Энэ утгаараа “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэх ойлголт ЭХХШТХ-д заасан сэжигтэнтэй ойролцоо утга агуулгатай болж байна.

Монгол Улсын ЭХХШТХ-д “сэжигтэн”-г эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч байхаар тус хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.13 дахь заалтад тодорхойлсон бөгөөд гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй гэж хуульд заасан үндэслэлээр сэрдэгдсэн, хууль ёсны эрх ашиг, сонирхлоо хамгаалуулах, хууль зүйн туслалцаа авах эрхтэй субъект юм. Хууль заасан үндэслэлээр сэрдэгдэнэ гэдэг нь ЭХХШТХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.23 дахь заалтад заасан “үндэслэл бүхий сэжиг” гэж энэ хуульд заасан тодорхой ажиллагаа явуулах нөхцөл үүссэн, эсхүл үйлдэгдэж

⁷¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь өмгөөлөгчийн оролцооны эрх зүйн асуудал, ННФ, УБ, 2024, 44 дэх тал.

⁷² Мөн тэнд.



болзошгүй гэмт хэргийн талаарх мэдээлэл, хэргийн нөхцөл байдалд тулгуурласан мөрдөгч, прокурор, шүүгчийн дотоод итгэлийг хэлнэ гэжээ.⁷³

Шүүгч, прокурор, мөрдөгчийн дотоод итгэл гэдэг нь хувь хүний асуудалд хандах сэтгэл зүйн хандлага ч биш хувийн итгэл үнэмшил ч биш бөгөөд аливаа хэрэг, маргааныг шийдвэрлэхэд ач холбогдолтой баримтын хүрээг зөв тодорхойлж эх сурвалжийг тогтоосон, тэдгээр нь хөдөлбөргүй нотлогдсон талаар мэргэжлийн ур чадварт тулгуурласан итгэл үнэмшил бөгөөд уг итгэл үнэмшилдээ хуульд нийцүүлж гаргасан шийдвэрээр баталгаажуулж байдаг. Эрх бүхий албан тушаалтан хуулиар бусдыг гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй гэж сэжиглэх үндэслэл буюу эрхийг баталгаажуулснаар хүний эрхэнд халдах боломж, нөхцөл бүрдэж байгаа бол нөгөө талдаа сэжиглэгдэж буй хүнд өөрийгөө хамгаалах эрх буюу боломж нь давхар үүсч байх ёстой.⁷⁴

Харин сэжигтэн */Beschuldiger/* гэсэн нэр томъёо нь прокурор, мөрдөгчийн дотоод итгэлээр гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй гэсэн хангалттай үндэслэлээр хүнээс мэдүүлэг авсан тэр цаг мөчөөс тухайн хүн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болж ирдэг. Сэжигтнээр тооцох эсхүл тогтоох гэсэн шийдвэр гардаггүй бөгөөд мэдүүлэг авахдаа эрх үүргийг нь шууд тайлбарлан өгдөг.

ХБНГУ-ын ЭХХШТХ-ийн */STPO/* 133 дугаар зүйлд сэжигтнийг мэдүүлэг авахаар бичгээр дуудан ирүүлэх ажиллагааг, 134 дүгээр зүйлд түүнийг баривчлах хангалттай үндэслэл байгаа тохиолдолд шууд албадан ирүүлэх ажиллагааг зохицуулсан байдаг. Сэжигтнийг ямар хэрэгт буруутгаж байгааг эхэлж тайлбарлахдаа мөрдөгч, прокурор түүнийг холбогдуулан шалгаж байгаа хэргийн талаар тодорхой тайлбарлах үүрэгтэй бөгөөд ингэхдээ тодорхой бус, битүүлэг эсхүл үл ойлгогдох байдлаар илэрхийлж болохгүй.

Монгол Улсын ЭХХШТХ-д сэжигтнийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч гэж хуульчилсан атлаа сэжигтнээс мэдүүлэг авах ажиллагаа зохицуулагдаагүй бөгөөд хэрэгт сэрдэгдэж буй хүнээс гэрчийн мэдүүлэг авах нь түүний үндсэн эрхийг ноцтой зөрчиж “сэжигтэн”-ий статус, эрх үүргийг тодорхойлоогүй нь Үндсэн хуульд харшилж байна.⁷⁵


Иргэдийн хувьд “гэрч” нэртэй ямар хэрэгт сэжиглэгдэж байгаагаа мэдэхгүй “сэжигтэн” яваад байдаг. Гэрчийн эрх, үүрэг өөр, өөрийгөө өмгөөлөх эрхийн асуудал яригдахгүй. Статус тодорхой бол ямар хэрэгт сэжиглэгдэж шалгагдаж байгаагаа эрт мэдэж, өөрийгөө өмгөөлөх эрхээ шаардах боломжтой.⁷⁶ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гол оролцогч атлаа эрх үүрэг нь тодорхой бус оролцогч “сэжигтэн”-ий эрх зүйн байдлыг тодорхойлох, тухайлбал сэжигтэн нь дээрх ажиллагааны гол оролцогчийн хувьд гэрчийн мэдүүлэг өгч байгаа нь гэм буруугүйгээ өөрөө нотлох үүрэг хүлээж буй хуулийн хийдлийг арилгах зохицуулалт хийх буюу сэжигтнээс мэдүүлэг

⁷³ Б.Өнөрмаа, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “оролцогч биш” оролцогч буюу “сэжигтний” талаарх зохицуулалтын ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн */stpo/* зохицуулалттай харьцуулах нь”, Хууль дээдлэх ёс сэтгүүл, УБ, 2019, №1, (71), 18 дахь тал.

⁷⁴ Мөн тэнд.

⁷⁵ Мөн тэнд..

⁷⁶ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь өмгөөлөгчийн оролцооны эрх зүйн асуудал, ННФ, УБ, 2024, 43-44 дэх тал.



авах, эрх, үүргийг нь танилцуулах тодорхой заалтыг хуульд тусгаж өгөх шаардлагатай байна.⁷⁷

Түүнчлэн, НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан ажлын хэсгийн ахлагч Элина Штайнертегийн мэдээлснээр олон тохиолдолд цагдаа гэрчээр мэдүүлэг өгүүлэхээр дууддаг ч сэжигтэн болж хувирдаг байдал газар авсан. Цагдаагийн байгууллагад байцаалт өгөхөөр дуудагдсан иргэд олон цагаар хүлээж, хүнд сурталд өртдөг, дээр нь, цагдаа иргэнийг сэжигтэн эсхүл гэрчээр дуудаж мэдүүлэг авч байгаа эсэх нь ихэнх тохиолдолд тодорхой бус байдаг гэжээ. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэн өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх үндсэн эрхтэй гэсэн баталгаа нь бодит байдал дээр хэрэгжилт тааруу байгааг харуулж буй нэг жишээ юм. Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдээс гэрчийн мэдүүлэг авдаг, түүнийг өөрийнх нь эсрэг нотлох баримт болгож ашигладаг, худал гэрчийн мэдүүлэг өгсөн гэх зэргээр яллах буруу практик бодитой бий.⁷⁸

Процессын шударга байдал нь шударгаар шүүгдэх эрхийн суурь юм. Гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа хүнийг хууль, эрх зүйн мэдлэг, ойлголт бага байгааг ашиглан гэрчээр мэдүүлэг авч өөрийгөө өмгөөлөх боломжийг хаадаг, дараа нь тухайн иргэнийг сэжигтэн, яллагдагчаар татсаны дараа мэдүүлэг зөрвөл гэрчийн мэдүүлэг худал өгсөн гэж яллаж буруутгадаг явдал оршсоор байна. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөгчийн эрх, оролцоо хязгаарлагдмал байдгаас өмгөөлөгч шүүхийн өмнөх шатанд нотлох ажиллагаа явуулах боломж бага, яллах тал болох прокурорын яллах нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажил давамгайлсан байдаг.⁷⁹


Тиймээс ч дээрх асуудлуудыг шийдвэрлэх үүднээс энэ хуулийн төсөлд сэжигтэнтэй холбоотой хэд хэдэн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгажээ. Гэхдээ хуулийн төсөлд дан ганц сэжигтэн бус “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэх нэр томъёог тусгасан нь практикт хуулийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэхэд хүндрэлтэй зохицуулалт болохоор байна.

Учир нь хуулийн төслийн 2 дугаар зүйлд зааснаар 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “баривчлагдсан,” гэсний дараа “эсхүл гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэж нэмэхээр заасан бөгөөд энэхүү заалтаас харвал сэжигтэн гэх ойлголтод гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн хамаарч байна. Дээрх зохицуулалтаас бусад гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх нэр томъёо орсон хуулийн төслийн зохицуулалтуудыг харвал сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн нь өөр хоорондоо ялгаатай зохицуулалт болоод байна. Энэ нь хуулийн төслийн тухайн асуудалтай холбоотой зохицуулалтын зорилгод хүрэх байдал, практикт хэрэгжих боломж, хүлээн зөвшөөрөгдөх байдал, ойлгомжтой байдал, харилцан уялдааг алдагдуулж байна. Өөрөөр хэлбэл, хуулийн төслийн сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголттой холбоотой зохицуулалтууд нь бүхэлдээ төслийн үр нөлөөг алдагдуулж байна.

⁷⁷Б.Өнөрмаа, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “оролцогч биш” оролцогч буюу “сэжигтний” талаарх зохицуулалтын ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн /stro/ зохицуулалттай харьцуулах нь”, Хууль дээдлэх ёс сэтгүүл, УБ, 2019, №1, (71), 18 дахь тал.

⁷⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь өмгөөлөгчийн оролцооны эрх зүйн асуудал, ННФ, УБ, 2024, 18 дахь тал.

⁷⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь өмгөөлөгчийн оролцооны эрх зүйн асуудал, ННФ, УБ, 2024, 43-44 дэх тал.



Тухайлбал, хуулийн төсөлд 31.2 дугаар зүйлийн 9-12 дахь хэсгийг нэмэхээр тусгасан бөгөөд тухайн зүйлийн 9 дэх хэсэгт “Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнийг дуудан ирүүлэхэд энэ зүйлд заасан журмыг баримтлахгүй” гэж, 10 дахь хэсэгт “Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнийг мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлж болох ба энэ хуульд заасан албадлага хэрэглэх, шөнийн цагт дуудан ирүүлэхийг хориглоно” гэж, 11 дэх хэсэгт “Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн өөрөө сайн дураараа хүрэлцэн ирж мэдүүлэг өгөхөө зөвшөөрсөн тохиолдолд энэ бүлэгт заасан ажиллагааг явуулж болно” гэж, 12 дахь хэсэгт “Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, баривчлах энэ хуульд заасан үндэслэл тогтоогдвол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмыг баримтлан явуулна” гэж тус тус заажээ.

Тухайн заалтууд нь ЭХХШТХ-ийн 31.2 дугаар зүйл буюу “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэний дараа хийгдэх ажиллагаа” хэсэгт тусгагдсан байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлд зааснаар 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан сэжигтэнд “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн”-ийг хамааруулахаар тусгасан хэрнээ хуулийн төсөлд тухайн зүйлд 9-12 дахь хэсэг нэмэхээр тусгахдаа сэжигтэн биш “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэж тусгасан нь сэжигтнээс ялгаатай ойлголт мэт харагдаж байна.

Мөн ЭХХШТХ-ийн 16.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэрчээр мэдүүлэг авч болохгүй хүнд хуулийн төслийн 16.3 дугаар зүйлийн 4.7 дахь хэсэг зааснаар “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэж нэмэхээр тусгажээ. Өөрөөр хэлбэл, төслийн 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” сэжигтэнд хамаарахаар тусгасан хэрнээ тухайн ойлголтыг сэжигтнээс ялгаатай мэтээр хуульд ялгамжтай байдлаар тусгаж байгаа нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна.

Түүнчлэн, хуулийн төслийн 31.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “...Сэжигтэн эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцах, гардан авахаас татгалзсан нь мөрдөн шалгах ажиллагаа явуулахад саад болохгүй” гэсний сэжигтэн гэдэгт “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” хамаарч байна. Гэвч ЭХХШТХ-д заасан сэжигтэнтэй холбоотой бүх зохицуулалт “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн”-д хамаарах эсэх нь эргэлзээтэй байна.

Иймд хуулийн төсөл тусгагдсан “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэх ойлголттой холбоотой зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэл учруулахаар байна.

Нэгэнт сэжигтний шинжийг агуулж буй субъект болохын хувьд “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэх ойлголтыг сэжигтнээс ялгаатай мэтээр хуулийн төсөлд тусгасан хэдий ч тухайн зохицуулалтыг тухайлан тусгасны ач холбогдол, хэрэгцээ шаардлага, ялгагдах онцлог, давуу тал гэх мэт зүйл байхгүй байгааг дурдах нь зүйтэй.

Иймд гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголтыг хасаж, сэжигтэнг хуулийн нэр томъёо хэсэгт тодорхойлон хуульчилж, сэжигтэнтэй холбоотой зохицуулалтыг засаж сайжруулах нь илүү оновчтой.

3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Тус шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийн зүйл, заалт нь найруулга, хэл зүйн болон агуулгын хувьд ойлгомжтой байдлаар томъёологдсон болон логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг шалгана. Ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан болон “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэхийг нарийвчлан давхар шалгана. Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд бүхэлд нь дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн зохицуулалт нь ойлгомжтой, хууль зүйн техникийн шаардлагад нийцсэн эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Тухайн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дараах байдлаар дүн шинжилгээ хийж холбогдох дүгнэлт, саналыг боловсрууллаа.

№	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Санал
1.	Төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэг	ЭХХШТХ-ийн 25.1 дүгээр зүйлд “Мэдүүлэг авах” зохицуулалтыг хуульчилсан бөгөөд төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэгт “Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнийг гэрчээр дуудан ирүүлэхийг хориглоно” гэж заасан нь хуулийн 25.1 дүгээр зүйлд хамаарахгүй байна.	Төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь заалтыг хамаарал бүхий ЭХХШТХ-ийн холбогдох зүйл, заалтад нэмж тусгах нь зүйтэй.
2.	Төслийн 32.5 дугаар зүйлийн 1.7 дахь хэсэг	ЭХХШТХ-ийн 32.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...Мөрдөн шалгах ажиллагааг явуулсан боловч яллагдагчийн гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдохгүй бол эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгож, хавтаст хэргийн материалыг хэрэг бүртгэлтэд буцаана...” гэж заасан бөгөөд төслийн 32.5 дугаар зүйлийн 1.7 дахь заалтад тус зохицуулалттай агуулгын хувьд төстэй буюу “...нэмэлт нотлох баримтыг цуглуулах бүхий л ажиллагааг хийсэн боловч яллагдагч гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдоогүй...” гэх үндэслэлээр прокурорын хэргийг хэрэгсэхгүй болгох зохицуулалтыг нэмэхээр тусгажээ.	ЭХХШТХ-д агуулгын хувьд төстэй зохицуулалт байгааг харгалзан үзэж, тухайн зохицуулалтыг нэмж хуульд тусгах шаардлагатай эсэхийг нягтлан үзэх нь зүйтэй.
3.	Төслийн 2 дугаар зүйлд заасан 7.3 дугаар зүйл	Төслийн 2 дугаар зүйлд 7.3 дугаар зүйлийн “танилцах,” гэсний дараа “хувийг авах” гэж нэмэхээр тусгажээ. Гэвч ЭХХШТХ-ийн 7.3 дугаар зүйлийн аль хэсэгт заасан “танилцах” гэсний дараа “хувийг авах” гэж нэмэхийг орхигдуулан бичжээ.	Төслийн 2 дугаар зүйлд заасан 7.3 дугаар зүйлийн “танилцах” гэсний дараа “хувийг авах” гэснийг 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “танилцах” гэсний дараа “хувийг авах” гэж өөрчлөх.
4.	Төслийн 2 дугаар зүйлд заасан 14.13 дугаар зүйл	Төслийн 2 дугаар зүйлд 14.13 дугаар зүйлийн “прокурор” гэсний дараа “яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч” гэж нэмэхээр тусгажээ. Гэвч ЭХХШТХ-ийн 14.13 дугаар зүйл нь 12 хэсгээс бүрдэж байна. Харин тус 12 хэсгийн аль хэсэг дэх “прокурор” гэсний дараа “яллагдагч, түүний хууль ёсны	Төслийн 14.13 дугаар зүйлийн аль хэсэг дэх “прокурор” гэсний дараа “яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч” гэж нэмэх нь ойлгомжгүй байна. Иймд хэсгийн дугаарыг

		төлөөлөгч” гэж нэмэх нь ойлгомжгүй байна.	ойлгомжтой байдлаар тусгах.
5.	Төслийн 2 дугаар зүйлд заасан 34.1 дүгээр зүйл	Төслийн 2 дугаар зүйлд 34.1 дүгээр зүйлийн “болохгүй.” гэсний дараа “Шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй нь шүүх хуралдаан хойшлуулах үндэслэл болохгүй” гэж нэмэхээр тусгажээ. Гэвч төсөлд 34.1 дүгээр зүйлийн хэд дэх хэсэгт заасан “болохгүй.” гэсний дараа нэмж оруулахаар заагаагүй байна. ЭХХШТХ-ийн 34.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “болохгүй.” гэх үг тусгагдсан байна.	ЭХХШТХ-ийн 34.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “болохгүй.” гэх үг тусгагдсан байна. Иймд төслийн 34.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “болохгүй.” гэсний дараа “Шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй нь шүүх хуралдаан хойшлуулах үндэслэл болохгүй” гэж өөрчлөх.
6.	Төслийн 4 дүгээр зүйлд заасан 5.1 дүгээр зүйлийн 2.10-2.15 дахь заалтыг 2.12-2.16	Төслийн 4 дүгээр зүйлд заасан 5.1 дүгээр зүйлийн 2.10-2.15 дахь заалтын дугаарыг 2.12-2.16 гэж өөрчлөх талаар тусгажээ. Гэвч 2.10-2.15-д нийт 6 заалт хамаарч байх бөгөөд 2.12-2.16 гэж өөрчилснөөр нийт 5 зохицуулалтын дугаарыг өөрчлөхөөр тусгаж, нэг зохицуулалтын дугаарыг орхигдуулсан байна.	Төслийн 4 дүгээр зүйлд заасан 5.1 дүгээр зүйлийн “2.10-2.15 заалтын дугаарыг 2.12-2.16 гэж” гэсний орхигдуулсан дугаарыг оруулж “2.10-2.15 дахь заалтын дугаарыг “2.12-2.17” гэж өөрчлөх.
7.	Төслийн 4 дүгээр зүйлд заасан 32.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	Төслийн 4 дүгээр зүйлд заасан 32.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “тэдний өмгөөлөгчид” гэснийг “тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид” гэж өөрчлөх талаар тусгажээ. Гэвч ЭХХШТХ-ийн 32.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Мөрдөгч мөрдөн шалгах бүх ажиллагааг хийж дууссан, хэргийн бодит байдлыг бүрэн нотолж тогтоосон гэж үзвэл яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид хавтаст хэргийн материалтай танилцахыг мэдэгдэнэ.” гэж заасан. Өөрөөр хэлбэл, ЭХХШТХ-д оруулахаар тусгасан өөрчлөлт нь энэ хуулийн зохицуулалттай ижил байна.	ЭХХШТХ-ийн 32.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “тэдний өмгөөлөгчид” гэж бус өөрчлөлт оруулахаар тусгасан ““тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид” гэх ойлголт ЭХХШТХ-д хуульчлагдсан байх тул тус зохицуулалтыг өөрчлөхөөр тусгасан нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна. Иймд төслийн тус зохицуулалтыг хасах.

3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Тухайн хууль тогтоомжийн төсөлд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуй, байгууллагын салбарт хүндрэл үүсгэх зохицуулалт байх тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон үнэлгээ хийнэ. Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд шинээр тусгасан зохицуулалт болох хуулийн төслийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 32.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, 36.13 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг, 3.2 дугаар зүйл, 31.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дүн шинжилгээ хийлээ.

Бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн талаар зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Тус хуулийн төслөөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт дараах нэмэлтийг оруулсан.

- Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хувийг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл, эсхүл хэрэг бүртгэлтийн хэргийг хаах, хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг давж заалдах хугацаа дуустал хадгална.

Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад энэ зохицуулалтыг дараах байдлаар тодорхойлсон.

Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг хавтаст хэрэгт нотлох баримтаар хавсаргаж, хэргийн хамт хадгалагддаг. Ингэхдээ хэргийн оролцогчоос мэдүүлэг авах процессыг бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг ямар хугацаанд хэрхэн хадгалах талаар зохицуулаагүй байна. Иймд мэдүүлгийн тэмдэглэлүүд дууны болон дуу-дүрсний бичлэгээс зөрөх тохиолдол практикт гардаг бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.7 дугаар зүйлийн 2-т "Мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгагдсан нөхцөл байдал нь дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгээс зөрсөн тохиолдолд шүүх, прокурор дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг нотлох баримтаар тооцно." гэж заасан тул бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хувийг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл, эсхүл хэрэг бүртгэлтийн хэргийг хаах, хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг давж заалдах хугацаа дуустал хадгалах зохицуулалтыг тусгалаа⁸⁰.


Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цахим нотлох баримт, түүнийг цуглуулах, бэхжүүлэх, шинжлэх судлах, үнэлэхтэй холбоотой холбогдох байгууллагуудаас гаргасан эрх зүйн акт, журмыг судлан үзвэл:

1. 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 31 дүгээр тогтоол, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбарт:

Хуульд нэрлэн зааснаас бусад бичмэл болон цахим баримт, бусад эд зүйл нь хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих байдал, эсхүл гэм бурууг үгүйсгэхэд ач холбогдолтой тохиолдолд эд мөрийн баримт гэж үзэх бөгөөд зөвхөн нотлох ажиллагаанд ашиглаж, гэм буруутай эсэхийг эцэслэн шийдвэрлэсний дараа хууль ёсны өмчлөгч, эзэмшигчид нь буцаан өгөх, гүйлгээнд хориглосон болон цаашид ашиглах боломжгүй эд зүйлийг устгах буюу зохих байгууллагад шилжүүлэх, бичмэл эд мөрийн баримтыг хэрэгт хавсарган үлдээх зэргээр шийдвэрлэдэг онцлогтой. Хуульд "... бичмэл болон цахим баримт ..." гэж ерөнхий агуулгаар тусгагдсанаас тус бүрийн онцлог, нотлох баримтын бие даасан төрөл болох баримт бичгээс ялгагдах шинжийг тодорхойлох шаардлага үүсч байна.

Цахим төхөөрөмжид үүсгэсэн, боловсруулсан, хадгалсан, өөрчилсөн, илгээсэн, дамжуулсан, хүлээн авсан бүх хэлбэрийн мэдээлэл нь гэмт хэрэг үйлдэхэд, эсхүл гэмт хэрэгт бэлтгэх, завдахад ашигласан, гэмт хэргийн ул мөр үлдсэн, агуулсан тохиолдолд эд мөрийн баримт болно.

⁸⁰ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2024



Цахим баримт нь биет бус, олон байршилд хадгалах, олон хэрэглэгч зэрэг нэвтрэх боломжтой, тогтвортой бус түргэн хугацаанд хувирч өөрчлөгдөх, устах эрсдэлтэй, технологийн хурдацтай хөгжил мөрдөн шалгах ажиллагаанд нөлөөлдөг зэрэг онцлог шинж чанартай эд мөрийн баримтын төрөл юм. Энэ төрлийн баримтыг хайх, олж илрүүлэх, бэхжүүлэх, хадгалах, зөөвөрлөх, шалгах ажиллагаанд цахим мэдээллийн бүрэн бүтэн, найдвартай байдал нь нотлох баримтаар үнэлэхэд чухал ач холбогдолтой.

Цахим төхөөрөмжид агуулагдаж буй мэдээлэл нь түүний онцлог шинж чанараас шалтгаалан эх хувийг тогтооход бэршээлтэй, цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, зөөвөрлөх явцад амархан өөрчлөгдөх, устах эрсдэлтэй тул энэ төрлийн эд мөрийн баримтыг илрүүлэх, бэхжүүлэхдээ хуулийн 9.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тусгай мэдлэг, туршлага бүхий хүнийг мэргэжилтнээр оролцуулбал зохино.

Мэргэжлийн байгууллага, ур чадвар бүхий мэргэжилтнийг цахим баримтыг эрж хайх, олж илрүүлэх, бэхжүүлэх ажиллагаанд оролцуулсан бол тэдний хийсэн үйлдэл, үйл ажиллагаа бүрийг нэг бүрчлэн тэмдэглэлд тусгана. Цахим төхөөрөмжөөс өөрчлөгдсөн, устгасан мэдээллийг нарийн мэргэшсэн шинжээчийн тусламжтайгаар сэргээсэн тохиолдолд нотлох баримтад тооцогдоно⁸¹ гэж тусгажээ.

2. Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны 5 сарын 20-ны өдрийн А/69 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүгийн хэрэгт хөрөнгө, орлого, эд мөрийн баримт, эд зүйлийг хураан авах, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, шийдвэрлэх журам”

Тус журмын 7 дугаар зүйлд “Онцлог эд мөрийн баримтыг хураан авах, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, шийдвэрлэх” ажиллагааг тусгайлан тусгасан бөгөөд тус журмын 7.2.9. “цахим төхөөрөмж” гэж суурин болон гар утас, гэрэл зургийн аппарат, дүрс бичлэгийн камер, таблет, сканнер, факсын машин, хэвлэгч, хувилагч, бусад төхөөрөмжийг, 7.2.10. “мэдээлэл хадгалах хэрэгсэл” гэж хард диск, флаш диск, санах ой бүхий картууд, CD, DVD болон бусад хэрэгслийг гэж тус тус тодорхойлжээ. Мөн энэхүү журмын 7.12-д цахим баримтын талаар дараах байдлаар тусгажээ.

7.12.1. цахим баримтыг мэргэжилтний тусламжтайгаар тусгай техник хэрэгсэл, программ ашиглан хуулбарлан авч, энэ тухай тэмдэглэл үйлдэж, үйл явцыг гэрэл зураг, дуу дүрсний бичлэгээр бэхжүүлнэ. Шаардлагатай тохиолдолд цахим төхөөрөмж, мэдээлэл хадгалах хэрэгслийг хураан авна.

7.12.2. мэдээллийг хуулбарлахдаа хөндлөнгийн хоёроос доошгүй гэрчийг байлцуулан засварлаж өөрчлөх боломжгүйгээр код үүсгэн “hash” /хэшлэх-тусгай программ ашиглах/, тэмдэглэж хөтөлж, түүнд байлцсан хүмүүсээр гарын үсэг зуруулна.

7.12.3. цахим төхөөрөмж, мэдээлэл хадгалах хэрэгслийг хураан авахад ул мөр үлдсэн, интернэт холболтын модем, кабель шугам, бусад төхөөрөмжтэй холбогдсон эсэхийг шалгана.

7.12.4. шаардлагатай бол модем, свитч рүтер зэрэг сүлжээний төхөөрөмжийг хураан авч, тэмдэглэл үйлдэнэ.

7.12.5. тэмдэглэлд цахим төхөөрөмжийг хураан авах үед асаалттай ажиллагаатай байсан эсэх, тухайн үед хэн, хэрхэн ашиглаж байсан талаарх мэдээллийг тусгана.

7.12.6. компьютер, цахим төхөөрөмжид хадгалагдаж байгаа бүх төрлийн мэдээлэл нь устах, гэмтэх эрсдэлтэй тул үзлэг хийхээс өмнө төхөөрөмжид байгаа мэдээллийг үзэх, агуулгыг хайх, асаах, унтраах зэргээр дур мэдэн оролдохыг хориглоно.

7.12.7. компьютер, цахим төхөөрөмжийн дэлгэц дээрх мэдээлэл өгөгдлийг устгаж байгаа шинж тэмдэг илэрсэн тохиолдолд шууд унтраана.

7.12.8. хэргийн газраас нууц үг бүхий цаас, программ, техник хангамжийн гарын авлага, компьютероос хэвлэсэн бичвэр болон график материалыг хураан авна.

7.12.9. цахим төхөөрөмж, гар утасны нууц үгийг эд зүйлээ хураалгаж буй этгээд буюу өмчлөгч, эзэмшигчээр бичүүлж, эд зүйлийн хамт уут, саванд битүүмжилнэ.

⁸¹ 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол, Дугаар 31, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар

7.12.10. цахим эд мөрийн баримтыг зөвхөн цаасан уут, хайрцаг зэрэг саванд хийж, тээвэрлэх явцад доргилтоос хамгаална.

7.12.11. савлахын өмнө шошго тавьж, хоорондоо холбогдсон төхөөрөмжүүдийн холболтуудыг дараа нь угсарч ажиллуулах зорилгоор ойлгомжтой хэлбэрээр хаяглаж, үйл явцыг гэрэл зураг, дуу дүрсний бичлэгээр бэхжүүлнэ.

7.12.12. цахим баримтыг соронзон орон бүхий цахилгаан үүсгэх боломжтой аливаа төхөөрөмж материалаас хол, аюулгүй байдлын хамгаалалттай, температурын хяналт бүхий орчин, чийгшилгүй газарт зориулалтын хамгаалалтын уут эсхүл хайрцагт хадгална.

7.12.13. цахим мэдээлэл хадгалах хэрэгслийн мэдээлэл устгах, гэмтэхээс сэрэмжилж цахилгаан үүсгүүр, радио дамжуулагч зэрэг соронзон орны орчин үүсгэх, ердийн дулаанаас хэт өндөр температур, чийгшил, тоосжилт, доргилт ихтэй газарт хадгалахыг хориглоно.

Монгол Улсын хувьд цахим нотлох баримт хураан авах, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах үйл ажиллагааны дараалал, аргачлалыг журамлахдаа цахим баримт хадгалагдаж буй төхөөрөмж бүрд ялгаатай байдлаар бус, нийтлэг байдлаар журамласан.⁸²

3. 2019 оны 12 сарын 5-ны өдрийн Дугаар 246, А/80 Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан захирамж, тушаалын⁸³ нэгдүгээр хавсралтаар “Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”, хоёрдугаар хавсралтаар “Хавтаст хэргийг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх журам”-ыг тус тус шинэчлэн баталсан.

Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журмын 3.5-д “...Эд мөрийн баримт болон мэдээллийн техник, технологийн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл /бүх төрлийн CD, зөөврийн хатуу диск, хатуу диск, флаш.../ зэргийг хүлээн авахдаа хавтаст хэргийн онцлогоос шалтгаалан тухайн тоног төхөөрөмж нь хэвийн ажиллаж байгаа эсэх, гэмтэлтэй эсэх, серийн дугаар тохирч буй эсэхийг шалгана...” гэж заажээ.

4. Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2022 оны 4 сарын 15-ны өдөр дугаар А/42 тушаалын нэгдүгээр хавсралтаар “Эрүүгийн хэргийн тусгай, салбар архивт баримт хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх, хадгалах, ашиглуулах журам”, хоёрдугаар хавсралтаар “Архивт хөтлөгдөх тоо бүртгэлийн баримт бичиг, мэдээний жагсаалт, загвар”-ыг тус тус баталжээ.

Эрүүгийн хэргийн тусгай, салбар архивт баримт хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх, хадгалах, ашиглуулах журамд:

3.8 дугаар зүйл. Цахим хэлбэрт шилжүүлэх

1. Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим мэдээллийн сан үүсгэх аргачлалыг Улсын ерөнхий прокурорын тушаалаар батална;

2. Баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, тоо бүртгэл, эрэлт хайлт, ашиглалтын үйл ажиллагааг хөнгөн шуурхай болгох, эх баримтыг ашиглалтаас чөлөөлөх зорилгоор баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим мэдээллийн сан үүсгэнэ;

3. Баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажилтантай нууц хадгалалтын гэрээ байгуулна.

3.9 дүгээр зүйл. Баримтыг цахим хэлбэрт шилжүүлэхдээ

1. Баримтын мэдээллийг алдагдуулахгүй, бодит байдлыг өөрчлөхгүй байх;

⁸² ННФ, Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа /Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд/, УБ, 2022, 62 дахь тал.

⁸³ “Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”, “Хавтаст хэргийг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх журам” <http://old.supremecourt.mn/act/view/266>

- 2.Баримтыг гэмтээхгүй байх;
- 3.Баримтын онцлог шинжийг хэвээр хадгалах;
- 4.Мэдээлэл тээгчийн шинж чанарыг муутгахгүй байх;
- 5.Баримтын үндсэн дарааллыг алдагдуулахгүй;
- 6.Ажлын явцад баримтын бүрэн бүтэн байдлыг цахим хэлбэрт шилжүүлж байгаа ажилтан хариуцна.

3.10 дугаар зүйл. Бусад

1.Цахим баримтыг хөмрөг үүсгэгч байгууллагын хөмрөгт хамааруулж, цаасан суурьтай баримтаас тусад нь хадгална;

2.Цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын мэдээг хариуцсан ажилтан сар бүрийн 05-ны дотор гаргаж, тусгай архивт ирүүлнэ;

3.Мэдээг удаа дараа буруу ирүүлсэн, хугацаа хожимдуулсан, алдаатай, худал ташаа ирүүлсэн, мэдээг огт ирүүлээгүй, зохих журмын дагуу серверт байршуулаагүй ажилтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцуулах албан бичгийг байгууллагын удирдлагад хүргүүлнэ;

4.Байгууллагын удирдлага нь цахим мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас хамгаалах, мэдээлэл алдагдахаас сэргийлэх зорилгоор техник хэрэгслийн найдвартай байдал, сүлжээ, серверийн аюулгүй байдлыг хангах, хорт код вирусээс хамгаалах арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллана.

4.4 дүгээр зүйл. Хадгалалт

2.Цахим мэдээлэл хадгалах хэрэгслийн мэдээлэл устах, гэмтэхээс сэрэмжилж цахилгаан үүсгүүр, радио дамжуулагч зэрэг соронзон орны орчин үүсгэх, ердийн дулаанаас хэт өндөр температур, чийгшил, тоосжилт, доргилт ихтэй газарт хадгалахыг хориглоно.

4.6 дугаар зүйл. Баримтын шинж чанарыг тодорхойлох

6.Тусгай тээгчтэй болон цахим баримтын хадгалалтын байдалд 2 жил тутам нягтлан шалгалт хийж, шаардлагатай тохиолдолд цахим баримтын файлыг ашиглагдаж буй форматад хөрвүүлж, хадгалалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх, солих арга хэмжээ авна;


7.Цахим баримтыг зориулалтын хадгалах төхөөрөмж, бүх төрлийн сервер, компьютер, зөөврийн болон бусад тоон технологийн шийдэл ашиглан тээгчээс хамгийн багадаа гурван өөр тээгчид хуулбарлан хадгална.

5. 2022 оны 1 сарын 6-ны өдрийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоол Дугаар 1 “Журам батлах тухай”

Энэхүү “Шүүхийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлд цахим баримтыг хадгалах талаар тусгасан. Тухайлбал,

Журмын 6.3-т “...Цахим баримтыг тодорхой хугацааны давтамжтайгаар сервер болон тусгай тээгч /CD, DVD, Flash, Portable hard disk/-д хадгална...” гэж, 7.1-д “Цахим баримтын агуулгыг эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг, баримт удирдлагын баримт бичгүүд гэсэн төрлөөр төрөлжүүлэн системд мэдээллийг оруулна”, 7.2-т “Системд оруулсан мэдээлэл болон хавсаргасан цахим файл нь тухайн баримтыг хайхад саадгүй илэрч байхаар зөв тодорхойлж, томъёологдсон байна”, 7.3-т “Цахим баримтаар архивын үйлчилгээ үзүүлэхэд системийг ашиглана. Тусгай архиваас системийг суурилуулах бөгөөд уг систем, программ хангамж дээр ажиллахад шаардлагатай мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгнө” гэж тус тус заажээ.

Дээрх тайлбар, журмуудаас харвал цаашид цахим нотлох баримтыг ЭХХШТХ-д тодорхойлон заах шаардлагатай байна. Энэ нь тухайн нэр томъёог өөр өөрөөр тодорхойлон хэрэглэхээс сэргийлэх, нэр томъёог нэг мөр ойлгон хэрэглэхэд чухал ач холбогдолтой.



Түүнчлэн, шүүхийн цахимжилттай холбогдуулан цахим нотлох баримт, цахим хавтаст хэрэг, цахимжуулсан хавтаст хэрэг зэрэг шинэ шинэ нэр томьёо, ойлголт, ухагдахуун гарч ирж байгаатай холбогдуулан анхнаасаа тухайн нэр томьёог оновчтой зөв тодорхойлж, нэг мөр ойлгон хэрэглэх шаардлага бий болж байгааг дурдах нь зүйтэй.

6. 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн УДШ-ийн Ерөнхий шүүгч, ХЗДХ-ийн Сайд, УЕП-ын хамтарсан Дугаар А/18, 34, А/31 “Заавар батлах тухай”

Тус тушаалаар “Эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох баримтыг архивт хадгалах заавар”-ыг нэгдүгээр, “Эрүүгийн хэргийн төв болон салбар архивт хадгалагдаж байгаа баримтыг хадгалах хугацааны заавар”-ыг хоёрдугаар хавсралтаар баталсан.

Эрүүгийн хэргийн төв болон салбар архивт хадгалагдаж байгаа баримтыг хадгалах хугацааны зааварт:

Хоёр. Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн баримтын хадгалах хугацаа

2.1. Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн баримтыг дор дурдсан хугацаагаар хадгална.

2.1.1. хорихоос өөр төрлийн үндсэн болон нэмэгдэл ялын тухай баримтыг ялыг эдэлж дууссан өдрөөс хойш 10 жил;

2.1.2. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг 1 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг 1 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон эрүүгийн гэмт хэргийн баримтыг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 12 жил;

2.1.3. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 1 жилээс дээш, дээд хэмжээг 8 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг 1 жилээс дээш хугацаагаар тогтоосон эрүүгийн гэмт хэргийн баримтыг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 16 жил;

2.1.4. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 5 жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг 15 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон эрүүгийн хэргийн баримтыг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 жил;

2.1.5. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 12 жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг 20 жил хүртэл тогтоосон ба бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй эрүүгийн гэмт хэргийн баримтыг байнга;

2.1.6. Эрүүгийн хуульд бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг, хүний амь нас хохирсонтой холбоотой, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээдэд холбогдох, нууцад хамаарах баримт, Төв болон салбар архивын БНШАЗК-ын хурлын шийдвэрээр байнга хадгалахаар шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн баримт, баримт бичгийг байнга;

2.2. 1961, 1986 оны Эрүүгийн хуулиар шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн баримтын хадгалах хугацааг тухайн хэргийг шийдвэрлэсэн хуулийн зохих зүйл, хэсэгт заасан ялын дээд хэмжээг 2002 оны Эрүүгийн хуулийн гэмт хэргийн ангилалд хамааруулан тооцож, хадгалах хугацааг нь тогтооно.

2.3. Шүүхээс хэрэгсэхгүй болгосон, цагаатгасан, өршөөж шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн баримтын хадгалах хугацааг энэ зүйлийн 1.1.1-1.1.5 дахь заалтад заасан хугацаагаар хадгална.

2.4. Шүүхээр шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн баримтыг дор дурдсан хугацаагаар хадгална.

2.4.1. хүнд холбогдох хэргийн баримтыг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 жил;

2.4.2. хуулийн этгээдэд холбогдох хэргийн баримтыг байнга;

Гурав. Прокуророос шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн баримт материалыг хадгалах хугацаа

3.1. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн материал – шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 жил;

3.2. Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан болон хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэргийн баримт;

3.2.1. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг 1 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг 1 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэргийн баримтыг – шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 жил;

3.2.2. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 1 жилээс дээш, дээд хэмжээг 8 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг 1 жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэргийн баримтыг – шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 жил;

3.2.3. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 5 жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг 15 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэргийн баримтыг – шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 12 жил;

3.2.4. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 12 жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг 20 жил хүртэл тогтоосон ба бүх насаар нь хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийн баримтыг – шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 20 жил;

3.2.5. Эрүүгийн хуульд бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг болон хүний амь нас хохирсон бүх хэргийн баримт, материал, баримт бичиг – байнга.

3.2.6. Улс төрд нөлөө бүхий хүн, төрийн өндөр албан тушаалтан, дипломат дархан эрх ямба эдэлж байгаа хүн, шүүгч, прокурор болон авлигатай тэмцэх, хил хамгаалах, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах албан тушаалтанд холбогдох хэргийн баримт – байнга.

Практикт шүүхийн шийдвэрээр тухайн хэрэгт хураагдан ирсэн эд мөрийн баримтыг цаашид хадгалах эсэхийг хэрхэн шийдвэрлэснээс хамаарч нотлох баримтыг хадгалах эсхүл устгах арга хэмжээг авдаг. Цахим нотлох баримтын хувьд практикт ихэвчлэн CD дээр хуулбарлан хавтаст хэрэгт хавсаргадаг бөгөөд энэ нь тухайн хавтас хэргийг хадгалах хугацаатай ижил хугацаанд хадгалагдаж байна.

Энэ талаар буюу дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалтын талаар холбогдох мэргэжилтэн, судлаач дараах мэдээллийг өгсөн юм.

Шигтгээ 6.

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хувьд 100% хийгдэж чаддаггүй. Одоогийн байдлаар тус дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуустал хадгалдаг бөгөөд зарим нь богино хугацаанд устгагдах тохиолдол байдаг. Нөхцөл байдлын тухайд дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийг хадгалах сервер, багтаамжийн хүрэлцээ муу байдаг нь асуудал үүсгэж байна. Түүнчлэн бичлэгийн чанар муу байгаа нь хэрэгжүүлж буй зорилготойгоо нийцэхгүй байна.

Шүүхийн цахимжилтын сайн жишгийг авч үзвэл шүүх хуралдаан нь боловсронгуй тоног, төхөөрөмжөөр тоноглогдсон, сайтар бичлэг хийх дуу, дүрсний төхөөрөмжтэй, түүнийг хадгалах багтаамжтай байх нь зүйтэй. Дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн найдвартай байдал нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гишүүнтэй хийсэн ярилцлагын хэсгээс...

Иймд эдгээр зохицуулалтыг нэг мөр болгон хуульчилж дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын талаар тогтсон зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

Гадаадын эрх зүйн өндөр хөгжилтэй зарим улс, орнуудад хэрхэн зохицуулдаг талаар авч үзье.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын сайн туршлага

Ерөнхий зохицуулалт

ХБНГУ-ын ЭХХШТХ-ийн “Хэргээ хүлээсний дараа буюу эсэргүүцсэн тохиолдолд шүүгчийн тэмдэглэлээс уншиж танилцуулах” гэсэн 254-р зүйлийн (1) -т “*Шүүгдэгчийн мэдүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэл, дуу дүрсний бичлэгт тусгагдсан мэдүүлгийг хэргээ хүлээсэн тухай нотлох баримт авах зорилгоор уншиж, сонсгож болно*” мөн “Баримт бичгийг унших замаар баримтат нотлох баримт бүрдүүлэх; баримт бичгийн найруулгыг анхаарч үзэх” гэсэн 249-р зүйлийн (1) хэсэгт “*Баримт бичгийг агуулгынх нь талаар нотлох баримт авах зорилгоор үндсэн шүүх хуралдаанд уншина. Цахим баримт бичгийг уншиж танилцах боломжтой баримт бичиг гэж үзнэ.*” гэж тус тус зааснаас үзэхэд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг нь ЭХХША-нд авах, үнэлэх буюу үнэнийг тогтоох зорилгоор ашиглах боломжтой цахим (дижитал) нотлох баримт буюу цахим баримт бичгийн нэг төрөл юм.

Нарийвчилсан зохицуулалт


ХБНГУ-ын ЭХХШТХ-ийн 1-р бүлгийн “Хавтаст хэргийн удирдлага (менежмент) ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь харилцаа холбоо” гэсэн 4-р дэд бүлэгт “*Хавтаст хэргийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор баримт бичгийг хувиргах (хөрвүүлэх)*” гэсэн 32е зүйлд цахим баримт бичгийг хэрхэн цахим хавтаст хэрэгт хавсаргах, цахим байдалд хөрвүүлэх болон хадгалалтын хугацаа зэргийг зохицуулсан байна. Уг дэлгэрэнгүй зохицуулалтыг доор танилцуулъя.

Хэсэг 32е

Хавтаст хэргийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор баримт бичгийг хувиргах (хөрвүүлэх)⁸⁴

- (1) Тухайн хавтаст хэргийг хадгалж буй хэлбэртэй (эх баримт бичигтэй) баримт бичиг нь тохирохгүй байвал тохирох хэлбэрт тус баримт бичгийг хөрвүүлж болно. Нотлох баримт болгон баталгаажуулсан эх баримт бичгийг зохих шаардлагатай хэлбэрт шилжүүлж болно.
- (2) Баримт бичгийг хөрвүүлэхдээ хөрвүүлсэн баримт бичиг нь харагдах байдал болон агуулгын хувьд эх баримт бичгийн агуулгатай тохирох байдлыг хангахуйц хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглана.

⁸⁴ БНЭсУ-ийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Kriminaalmenetluse seadustik, 2003)

- 
- (3) Цахим бус эх баримт бичгийг цахим баримт бичиг болгон хөрвүүлэхдээ хөрвүүлэхэд ямар процедур ашигласан, энэ нь эх баримт бичигтэй харагдах байдал болон агуулгатай тохирч байгаа зэргийг нотлох баримтыг хавсаргана. Прокурорын байгууллага болон шүүхэд хэрэглэгдэж байсан, хариуцах үүрэг бүхий этгээдийн гарын үсэг зурсан баримт бичгийг хөрвүүлэх тохиолдолд хөрвүүлэлтийг нотлох баримт нь прокурорын газар, шүүхийн бүртгэлийн ажилтны мэргэшсэн цахим гарын үсэгтэй байх ёстой. Мэргэшсэн цахим гарын үсэг бүхий эсхүл дамжуулах аюулгүй аргаар ирүүлсэн цахим эх баримт бичгийг уг баримт бичигт хийсэн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг шалгасан шалгалтын дүнгийн хавтаст хэрэгт бичилт хийн оруулна.
- (4) Үргэлжилж буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтаар хадгалагдаагүй эх баримт бичгийг хөрвүүлснээс хойш дор хаяж зургаан сар хадгална. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссан, эсхүл хугацаа хэтэрсэн тохиолдолд нотлох баримтаар хадгалагдаагүй эх баримт бичгийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссанаас хойшхи хуанлийн хоёр дахь жилийг дуустал хадгалах боломжтой.
- (5) Нотлох баримтаар хадгалагдаагүй эх баримт бичгийг баталгаатай нотлох баримтад хамаарах нөхцөлөөр шалгаж болно. Хавтаст хэргийг шалгах эрх бүхий этгээд нь энэ төрлийн шалгалтыг хийх бүрэн эрхтэй.

Дээрхээс дүгнэвэл, ХБНГУ-ын тухайд дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийг цахим нотлох баримтад хамааруулан зохицуулж, хадгалалт, хамгаалалтын асуудлыг ерөнхий журмаар зохицуулдаг байна. Нарийвчилсан журмын тухайд нотлох баримтаар авагдаагүй эх баримт бичгийг хадгалах журмыг нарийвчлан зохицуулжээ.

Бүгд Найрамдах Эстони Улсын сайн туршлага


Ерөнхий зохицуулалт

Эстониин ЭХХШТХ-ийн “Кино ба дуу, дүрсний бичлэг” гэсэн 150-р зүйлийн (1)-т *“Мөрдөн шалгах ажиллагаа болон бусад процесс ажиллагаа, эсхүл түүний тодорхой хэсгийг камержуулж, дууны, дүрсний бичлэг хийж болно. Мөрдөн шалгах ажиллагаа болон бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэхээс өмнө энэ тухай гэрч, ЭХХША-нд оролцогчид мэдэгдэнэ.”* Гэсэн бол (4)-р зүйлд *“Дууны, дүрсний бичлэгийг эрүүгийн хавтаст хэрэгт хавсаргана. Дууны болон дүрсний бичлэгт өөрчлөлт оруулахыг хориглоно.”* Гэж зохицуулсан байна.

Дээр дурдсанчлан Эстони улсын ЭХХША-нд хавтаст хэргийг цахим хавтаст хэргийн системээр цахимаар хөтлөх (ЭХХШТХ-ийн 160¹ (5), 210-р зүйл) бөгөөд 150-р зүйлийн (4)-т зааснаас үзэхэд ЭХХША-ны явцад бэхжүүлж авсан дуу, дүрсний бичлэг, киног цахим хавтаст хэрэгт цахим хэлбэрээр хавсаргах бололтой гэвч энэ талаар нарийвчлан зохицуулсан зохицуулалт одоогоор алга байх бөгөөд 160¹-р зүйлийн (6),(7)-д шүүхийн хавтаст хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлэх хугацаа, цахим хэрэг хөтлөлт, түүнд хандах, цахим баримт бичгийн хадгалалт түүнд тавигдах техник шаардлага, цахим хавтаст хэргийг архивлах журам зэрэг нарийвчилсан зохицуулалтыг Хууль зүйн сайдын гаргасан журмаар тогтооно⁸⁵ гэж заасан боловч одоогоор тус төрлийн журам батлагдаагүй байна.

Нарийвчилсан зохицуулалт, хугацаа

⁸⁵ Эшлэл 18.



Эстониин ЭХХШТХ-ийн 124-р зүйлд “Биет эд мөрийн баримт гэж эрүүгийн гэмт хэргийн объект болсон зүйл, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан эд зүйл, эрүүгийн гэмт хэргийн нотлох баримт бүхий зүйл, гэмт хэргийн нотлох баримтын ул мөр бүхий сэтгэгдэл, хэвлэмэл, эрүүгийн гэмт хэрэг, эсхүл нотлох баримттай холбоотой үйл баримтыг тогтооход ашиглаж болох эрүүгийн үйлдэлтэй холбоотой бусад чухал объектыг хэлнэ.” Гэж тодорхойлсон бөгөөд уг биет эд мөрийн баримтыг хадгалах журмыг уг хуулийн 125-р зүйлд зохицуулсан байна. Гэвч ЭХХШТХ-ийн 63-р зүйлд “нотлох баримт”-ыг тодорхойлохдоо биет нотлох барим буюу биет эд мөрийн баримтад, дууны, дүрсний болон дуу-дүрсний бичлэгийг багтаалгүй тусад нь тоочин бичсэн байх тул ЭХХШТХ-ийн 125-р зүйлд зохицуулсан “Эд мөрийн баримтыг хадгалах журам” нь дууны, дүрсний болон дуу-дүрсний бичлэгт хамаарах эсэх нь эргэлзээтэй байна.

Хэрэв 125-р зүйлд зохицуулсан “Эд мөрийн баримтыг хадгалах журам” нь дууны, дүрсний болон дуу-дүрсний бичлэгт ижил хамаарах бол 125-р зүйлийн (1)-т заасны дагуу эд мөрийн баримтыг “ЭХХША явуулж буй байгууллагын эд мөрийн баримтын хадгалах газар, эсхүл шүүх эмнэлгийн байгууллагын эзэмшил, хамгаалалтад байгаа бусад байранд” хадгалах бөгөөд хадгалах хугацааны хувьд 6 сар байх бөгөөд прокурор, мөрдөн байцаах байгууллагын хүсэлтээр энэ хэсгийн (4) дэд хэсэгт заасан зургаан сарын хугацааг нэг жил хүртэл хугацаагаар сунгаж болно (ЭХХШТХ-ийн 124-р зүйлийн (4), (5)) гэж тус тус заасан байна.


Нууц мөрдөн шалгах ажиллагааны үед олж авсан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалт

БНЭсУ-ын ЭХХШТХ-ийн “Нууц мөрдөн шалгах ажиллагааны хавтаст хэргийг хадгалах, хөтлөх” гэсэн 126¹¹ – р зүйлийн (1)-т заасны дагуу нууц мөрдөн шалгах ажиллагааны явцад олж авсан аливаа мэдээллийг нууц мөрдөн шалгах ажиллагааны хавтаст хэрэгт хадгалах бөгөөд уг зүйлийн (2)-т ийнхүү “...хадгалах, хөтлөх журмыг Дотоод хэргийн сайдын санал болгосноор Бүгд Найрамдах Улсын Засгийн газар тогтооно” гэж заасан байна. Уг хуулийн зохицуулалтын дагуу Эстони улсын Засгийн газраас 2013 оны 03 дугаар сарын 01-ний өдөр баталсан №3 “Мөрдөн шалгах ажиллагааны хавтаст хэргийг хөтлөх, хадгалах журам”⁸⁶-ын 7-р зүйлийн (5) дахь хэсэгт “Нууц мөрдөн шалгах ажиллагааны явцад авсан гэрэл зураг, кино, дуу авианы болон дүрс бичлэг, бусад мэдээллийг эсхүл түүний зарим хэсгийг болон хавтаст хэргийг нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын нууц мэдээллийг боловсруулах цахим системд эсхүл нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын энэ зорилгоор тусгайлан тохируулсан өрөөнд хадгална” гэж заасан байна.

Дээрхээс үзэхэд Эстони улсад ЭХХША-ны явцад бэхжүүлж авсан болон цахим хавтаст хэрэгт авагдсан аливаа дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг цахим хэлбэрээр цахим хавтаст хэргийн системд болон биет байдлаар эд мөрийн баримт хадгалах тусгай зориулалт бүхий эрх бүхий байгууллагын байранд нийтлэг журмын дагуу хадгалдаг байна.

Америкийн Нэгдсэн Улсын сайн туршлага

⁸⁶ Журмаа мич



Нотлох баримтыг хадгалах гэдэг нь засгийн газар нотлох баримтын бүрэн бүтэн байдлыг дараа нь шалгах эсвэл дүн шинжилгээ хийх зорилгоор хадгалах ёстой байдаг. Ингэхийн тулд эд хөрөнгө, нотлох баримтыг хадгалагч нь хадгалалтын бүртгэлийг үнэн зөв, бүрэн гүйцэд хөтөлж, нотлох баримтыг зохих ёсоор хадгалж, нотлох баримтыг бохирдуулах, гэмтээх, устгахаас урьдчилан сэргийлэх ёстой байдаг. Хадгалалтын протокол нь нотлох баримтын төрлөөс хамаардаг, биологийн дээж эсвэл дижитал нотлох баримтыг хадгалах дүрэм гэх мэт.

Нотлох баримтыг хадгалах үүрэг нь аливаа төрийн байгууллага, эрүүгийн мөрдөн байцаалтын ажиллагааны хүрээнд нотлох баримт цуглуулж, эзэмшиж авснаас хойш эхэлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүгдэгчийн ял хүртэл үргэлжилдэг.

Цагдаа нар ихэвчлэн эрүүгийн хэрэгт ашигласан нотлох баримтыг цуглуулдаг ч нотлох баримтыг хадгалах цорын ганц төрийн байгууллага биш юм. Хадгалах үүрэг нь мөн:

-орон нутаг, муж, муж улсын мөрдөн байцаах агентлагууд—эдгээрт зөвхөн мөрдөгч, мөрдөн байцаагчид төдийгүй захиргааны, бичиг хэргийн болон шүүх эмнэлгийн ажилтнууд ордог.

-Хэргийг хариуцаж байгаа прокурор мөн прокурорын эрх мэдлийн доор ажиллаж байгаа хүмүүс нотлох баримтыг хадгалах үүрэгтэй (жишээлбэл мөрдөн байцаагч, прокурорын томилсон шинжээч)

- Ерөнхий прокурор—ихэнх мужид болон ихэнх тохиолдолд нотлох баримтыг хадгалах үүрэг нь шүүгдэгчийг яллагдсаны дараа ч хэвээр үлдээдэг. Тиймээс, уг үүрэг нь муж улсын Ерөнхий прокурорын газарт (ихэвчлэн давж заалдах болон ял шийтгүүлсний дараах асуудлыг зохицуулдаг) хамаарна.

-Ерөнхий прокурор—ихэнх мужид болон ихэнх тохиолдолд нотлох баримтыг хадгалах үүрэг нь шүүгдэгчийг яллагдсаны дараа ч хэвээр үлддэг. Тиймээс, уг үүрэг нь муж улсын Ерөнхий прокурорын газарт (ихэвчлэн давж заалдах болон ял шийтгүүлсний дараах асуудлыг зохицуулдаг) хамаарна.


Нотлох баримтыг хадгалах үүрэг нь хууль сахиулах байгууллагатай албан ёсны харилцаагүй бол хувь хүмүүс эсвэл агентлагуудад хамаарахгүй. Иймд хэргийн газраас цуглуулсан цусны дээжийг шалгахын тулд ДНХ шинжилдэг хувийн лабораторийг прокурор хөлсөлсөн бол тухайн лаборатори нь нотлох баримт, нотлох баримт дээр хийсэн аливаа шинжилгээний үр дүнг хамгаалж, хадгалах ёстой.

Бүгд Найрамдах Солонгос Улсын сайн туршлага

БНСУ-ын тухайд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг Эрүүгийн процессын хуулийн 311, 312 дугаар зүйлд заасны дагуу нотлох баримтаар тооцдог⁸⁷.

1) Нэгдүгээрт, видео бичлэг нь эх хувь байх ба эсвэл эх хувиас хуулбарласан хуулбарын хувьд хуулбарлах явцад зориудаар засварлах гэх мэт ямар нэгэн зохиомол өөрчлөлтгүйгээр эхийн агуулгын хуулбарлаагүй байх ёстой;

⁸⁷ 전문법칙 관련 비디오테이프 등의 증거능력, <https://blog.naver.com/duckhee2979/220751969840>



2) Хоёрдугаарт, Эрүүгийн процессын хуулийн 313 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүх хуралдаанд бэлтгэх эсвэл шүүх хурлын товын үеэр гэрчийн мэдүүлэгт үндэслэн видеог хуулбарласан байх ёстой. Дуу бичлэгт бичигдсэн хүн бүрийн мэдүүлгийг яг өөрийнх нь хэлсэнчлэн тэмдэглэж авсан гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой

3) Видео бичлэг нь тухайн сэдэв болон зураг авалтын хүний нөхцөл байдалд тулгуурладаг. Энэ нь хүмүүсийн хөдөлгөөн, яриаг бичиж авдаг бөгөөд бичлэг хийгдэж буй хүний хөдөлгөөнийг байгаагаар нь хуулбарлах боломжтой тул бичлэгийн агуулгад ямар нэгэн зохиомол нөлөө үзүүлээгүй гэж үзвэл анхны мэдүүлэг нь тухайн камерт бичигдэж буй хүний гадаад төрх, дуу хоолойг баталж, бичигддэг. Шүүх хуралдаанд бэлтгэгдэж байх үед видео бичлэгт бичигдсэн хүн бүрийн мэдүүлэг яг хэлсэнчлэн бичигдсэн болохыг гэрчлэгч нарын мэдүүлгээр хүлээн зөвшөөрсөн бол видео бичлэгийг нотлох баримт гэж үзнэ⁸⁸.

БНСУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын хувьд шүүх хуралдаан хүртэлх болон нийтлэг нотлох баримт хадгалах журмын дагуу хадгалдаг байна.

Шүүх хуралдаан хүртэл нотлох баримт хадгалах зохицуулалтыг Эрүүгийн процессын хуулийн 15 дугаар бүлгийн 184, 185 дугаар зүйлээр зохицуулдаг байна. Харин нийтлэг нотлох баримт хадгалах журмыг Прокурорын ерөнхий газраас баталсан Хэргийн бүртгэлийг хадгалах журмаар зохицуулдаг байна.

Шүүх хуралдаан хүртэл нотлох баримт хадгалах зохицуулалтыг Эрүүгийн процессын хуулийн 184, 185 дугаар зүйлд зааснаар дараах байдлаар зохицуулж байна.

Энэ нь шүүх хуралдааны үеэр нотлох баримтыг шалгахыг хүлээж байх хугацаанд нотлох баримтыг ашиглахад хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд прокурор, шүүгдэгч (сэжигтэн), өмгөөлөгчийн хүсэлтээр шүүх хуралдаан болохоос өмнө түүнийг шалгах боломжийг олгодог тогтолцоог хэлнэ. Суурь журам нь бол нотлох баримтын шалгалтыг шүүх хурлын өдөр бүх процедурыг дуусгасны дараа хийдэг. Гэхдээ шүүх хурал болтол хүлээвэл нотлох баримтыг ашиглахад хүндрэлтэй байж болно. Тухайлбал, тодорхой хадгалах хугацаатай камерын бичлэгийн хувьд шүүх хурлын товыг хүлээвэл бичлэг алга болох тул шүүх хурлын тов гарахаас өмнө ч нотлох баримтыг шалгаж болно⁸⁹. Үүнийг нарийвчлан авч үзье.

184 дүгээр зүйл. Хүсэлт гаргах, нотлох баримтыг хадгалах журам

(1) Нотлох баримтыг урьдчилан хадгалахаас бусад тохиолдолд ашиглах боломжгүй нөхцөл байдал үүсвэл прокурор, эрүүгийн шүүгдэгч, эрүүгийн сэжигтэн, түүний өмгөөлөгч анхан шатны шүүх хурал болохоос өмнө мөрдөн шалгах, шалгах, гэрчээс байцаалт авах, шинжээчийн дүгнэлт зэргээр нотлох баримтыг хавсаргах арга хэмжээг авах хүсэлтийг гаргана.

(2) Өмнөх хэсэгт заасан хүсэлтийг хүлээн авсан шүүгч ийм хүсэлтийг шийдвэрлэх талаар шүүх эсвэл даргалагч шүүгчийн эрх мэдэлтэй адил эрх эдэлнэ.

(3) (1)-д дурдсан хүсэлтийг гаргахдаа тухайн хүн үндэслэлийн талаар таамагласан нотлох баримтыг бичгээр гаргаж өгнө.

⁸⁸ 성폭행피해아동의 진술녹화 비디오테이프의 증거능력, <https://www.lawtimes.co.kr/news/104776>

⁸⁹ 증거보전, <https://namu.wiki/w/%EC%A6%9D%EA%B1%B0%EB%B3%B4%EC%A0%84>

(4) (1)-д заасан хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан шийдвэрийн эсрэг гомдлыг гурав хоногийн дотор гаргаж болно.

185 дугаар зүйл. Баримт бичгийг шалгах

Прокурор, эрүүгийн яллагдагч, эрүүгийн сэжигтэн, өмгөөлөгч нь шүүгчийн зөвшөөрлөөр өмнөх зүйлд дурдсан захирамжийн талаарх баримт, нотлох баримтыг шалгаж, хуулбарлаж болно⁹⁰.

Харин нийтлэг нотлох баримт хадгалах журмыг Прокурорын ерөнхий газраас баталсан 2010 онд батлагдсан Хэргийн бүртгэлийг хадгалах журмаар зохицуулдаг байна⁹¹. Тус журмын зорилго нь прокурорын байгууллагаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэг бүртгэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, бусад баримт бичгийн хадгалалт, зохицуулалттай холбоотой асуудлыг тогтоож, хадгалалтын үйл ажиллагааг хэвийн явуулахад хувь нэмэр оруулахад оршино. Тухайн журамд дараах нэр томъёог тайлбарласныг анхаарч үзэх нь зүйтэй байна.

- "Хэргийн бүртгэл" гэдэгт мөрдөн байцаалтын ажиллагаа, шүүх хурал, түүнтэй холбоотой баримт бичиг (баримт бичиг, холбогдох бусад баримт бичиг, эд зүйл, зураг, гэрэл зураг, диск, соронзон хальс, кино, слайд, видео бичлэг, цахим бичлэг гэх мэт тусгай мэдээллийн хэрэгслээр бүртгэгдсэн бичлэгүүд) хамаарна) гэж тодорхойлдог.
- "Видео бичлэг" гэж Эрүүгийн процессын хуулийн 221 дүгээр зүйл, 244 дүгээр зүйлийн 244-2-т заасны дагуу мөрдөн байцаалтын явцад сэжигтэн, сэжигтнээс бусад этгээдийн мөрдөн байцаалтын ажиллагааны явцыг дүрс бичлэгт буулгаж, хадгалсан бичлэгийг хэлнэ.
- "Хадгалалт" гэж хэргийн материал (өргөдөл, дотоод мөрдөн байцаалтын хэргийн бүртгэлийг оролцуулан) болон шүүхийн баримт бичгийг эдгээр журамд заасан хадгалах хугацааны дагуу зохион байгуулахыг хэлнэ.

Дараах зохицуулалтыг журамд нарийвчлан тодорхойлсон байна.

БНСУ-ын Хэргийн бүртгэлийг хадгалах журам

Шүүхийн баталгаажуулалтын бүртгэлийг хадгалах	<p>Хадгалах хугацаа: Шүүхийн шийдвэрээр ял оногдуулсан хэргийн материал нь ялын хөөн хэлэлцэх хугацаа дуустал хадгалагдана. Харин баривчлах, хөнгөн торгох ялтай бол 3 жил хэвээр хадгална.</p> <p>Процесс: Хадгалах ажилтан нь шүүхийн баталгаажуулалтын бүртгэлийн хавтасны баруун дээд хэсэгт бүртгэлийн ангиллын хүнийг хэвлэж, шийдвэрийн тэмдэглэлийн дагуу баталгаажуулсан огноо, дүгнэлтийн ангилал (шүүхийн баталгаажуулалтын үр дүн), бүртгэл хадгалах хугацаа, хадгалалтын эцсийн жилийг тэмдэглэнэ. Хадгалалтын асуудал эрхэлсэн ажилтан 1 дэх хэсэгт заасан баримт бичгүүдийг хадгалалтын төрөл, баталгаажсан жилээр нь ангилж, 1-р маягтын дагуу эрүүгийн хэргийн бүртгэлийн хавтас дээр тогтоосон мэдээллийг оруулж, хэд хэдэн бүртгэлийг нэг хадгалах хайрцагт</p>
---	--

⁹⁰ CRIMINAL PROCEDURE ACT OF KOREAN [Enforcement Date 09. Dec, 2021.] [Act No.17572, 08. Dec, 2020., Partial Amendment], <https://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2§ion=lawNm&query=criminal+procedure&x=0&y=0#iBgcolor1>

⁹¹ Prosecutor's Office Preservation Rules Partially revised 2021-01-01 Ministry of Justice Ordinance No. 993 amendment, <http://www.yeslaw.com/lms/front/page/fulltext.html?pAct=view&pLawId=2408#:~:text=%E2%91%A0%20%EC%A7%84%EC%A0%95%EC%82%AC%EA%B1%B4%EA%B8%B0%EB%A1%9D%EC%9D%80,%EC%9D%80%203%EB%85%84%EA%B0%84%20%EB%B3%B4%EC%A1%B4%ED%95%9C%EB%8B%A4>.




	<p>цуглуулна. Тэдгээрийг ангилсны дараа чанарын дугаар олгож, тогтоосон мэдээллийг эрүүгийн хэргийн бүртгэл хадгалах дэвтэрт 2-р маягтаар оруулах ёстой.</p>
Яллагдаагүй хэргийн бүртгэлийг хадгалах	<p>Хадгалах хугацаа: Яллагдаагүй хэргийн бүртгэлийг хөөн хэлэлцэх хугацаа дуусах хүртэл хадгална. Харин 2 жил ба түүнээс доош хөөн хэлэлцэх хугацаатай хэрэгт холбогдсон яллах дүгнэлт үйлдээгүй хэргийн бүртгэлийг 3 жил, 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдсон яллах дүгнэлт үйлдээгүй, ахуйн болон олон улсын ач холбогдол, эсвэл прокурорын ажилд онцгой ач холбогдолтой байх нь хагас байнгын хадгалагдана.</p> <p>Процесс: Яллах дүгнэлт үйлдээгүй хэргийн бүртгэлээс яллах ажиллагааг түдгэлзүүлсэн хэргийн бүртгэлийг тусад нь хадгална. Хадгаламжийн ажилтан нь яллах дүгнэлт үйлдээгүй шийдвэрийн баруун дээд захад хадгалалтын эцсийн жил болон хадгалалтын хугацааг зааж өгөх ёстой. 9 дүгээр зүйлийн заалтыг яллагдаагүй хэргийн бүртгэлийг хадгалах журамд <i>mutatis mutandis</i> хэрэглэнэ.</p>
Гомдол, дотоод хэргийн бүртгэлийг хадгалах	<p>Хадгалах хугацаа: Гомдлын хэргийн бүртгэл гурван жилийн турш хадгалагдана. Дотоод хэргийн хэргийн бүртгэлийг хадгалах хугацаанд яллагдаагүй хэрэгтэй адил зохих ёсоор хамаарна.</p> <p>Процесс: Хэрэг эрхэлсэн ажилтан нь гомдол/дотоод хэргийн бүртгэлийн хавтасны баруун дээд хэсэгт тэмдэглэлийн хадгалалтын хугацаа болон хадгалалтын эцсийн жилийг бичнэ. 1 дэх хэсэгт заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх албаны ажилтан тэмдэглэлийг хадгалахдаа тэдгээрийг хадгалалтын төрөл, хадгалалт дууссан жилээр нь ангилж, эрүүгийн хэргийн бүртгэлийн хавсралтад заасан мэдээллийг хавсралтын маягт 1-д оруулж, олон хэргийг хадгална. Бүртгүүлсэн, хянан шийдвэрлэсэн дотоод хэргийн бүртгэлийг дотоод хэргийн хэлтсийн саналын баганад хэргийн ажилтан “Эрүүгийн хэргийн бүртгэлд хавсаргасан” гэж тэмдэглэнэ.</p>
Видео бичлэгийг хадгалах	<p>Хадгалах хугацаа: Хуулийн 244-2-т заасны дагуу прокурор видео бичлэгийг үүсгэсний дараа хадгалалтын ажилтанд нэн даруй хүлээлгэн өгнө. Прокурорын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 3, 4, 6 дахь хэсэгт заасны дагуу хэргийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хэргийн ажилтан аливаа видео бичлэгийг хадгалалтын ажилтанд нэн даруй хүлээлгэн өгөх ёстой. Хадгаламжийн ажилтнууд видео бичлэгийг 1, 2-т заасны дагуу хүлээн авахдаа хавсаргасан баримт бичгийн 3-2 дугаар маягт дахь видео бичлэгийн түр хадгалалтад заасан мэдээллийг оруулж, дараа нь жил бүр бүртгэнэ. Тэдгээрийг тоон дарааллаар зохион байгуулж, түр хадгална. Прокурор яллах, яллахгүй байх, хэргийг өөр шүүхэд шилжүүлэх шийдвэр гаргахдаа хавсаргасан Хүснэгт 2-ын хавсралтад байгаа “Видео бичлэг байна” гэсэн тамга дарж, хэргийн бүртгэлийн хавтасны баруун доод талд байгаа видео бичлэгийн тоог бичнэ. Прокурор яллах дүгнэлт үйлдээгүй хэргийг дахин нээх үед хадгалалтын ажилтан, хэрэв ямар нэгэн дүрс бичлэг байгаа бол түүний шалтгааныг дүрс бичлэгийн хадгалалтын албаны тайлбар багананд бичиж, 3 дахь хэсэгт заасны дагуу түр хадгалах ёстой.</p> <p>Процесс: Яллахгүй байх, шүүх хуралдааныг явуулахгүй байх тухай шийдвэр батлагдсан тохиолдолд хамгаалалтын ажилтан нь бичлэгийг битүүмжлэн, холбогдох тэмдэглэлийг хадгална. Хамгаалалтын ажилтан нь видео бичлэгийг битүүмжилсэн дугуйны баруун дээд захад хадгалалтын хугацаа болон эцсийн оныг бичих ёстой. Видео бичлэгийг хадгалахдаа хадгалалтын ажилчид хадгалалтын төрөл, хадгалалтын эцсийн жилээр нь ангилж, 3-3 дугаар маягтын видео бичлэгийн хадгалалтын шошгон дээр заасан мэдээллийг бичиж, нэг хадгалах хайрцагт олон видео бичлэг хийнэ. Чанарыг ангилсны дараа чанарын дугаар өгч, тогтоосон мэдээллийг 2-р маягтын эрүүгийн хэргийн бүртгэл хадгалах тасгийн видео бичлэгийн хэсэгт оруулна. Жилд хадгалагдах видео бичлэгийн хэмжээ бага, 3-р зүйлд заасны дагуу чанарын ангилал,</p>

	<p>чанарын дугаар олгох нь тохиромжгүй бол тэдгээрийг орхиж, тусдаа хадгалах хайрцагт хадгалж болно.</p>
<p>Шүүхийн шийдвэрийг хадгалах</p>	<p>Хадгалах хугацаа: Шүүхийн баримт бичгүүдээс 1 дүгээр хавсралтад заасан шүүхийн баримт бичгийг үүрд, шүүхийн бусад баримтыг хэргийн хадгалах хугацааны дагуу хадгална.</p> <p>Процесс: Хадгалах ажилтан нь хавсралт 1-д бичсэн шүүхийн шийдвэрийг хэргийн бүртгэлээс гаргаж авах ёстой. Энэ тохиолдолд хэргийг тусад нь буюу нэгтгэж байгаа эсэхийг шалгаж, шийтгэх тогтоол нь батлагдсан шүүгдэгч нарын шүүх хуралдааны материалыг орхигдуулахгүй байхыг анхаарах шаардлагатай байна. Нэг хэрэгт олон яллагдагч байгаа тохиолдолд хорих ангийн ажилтан шүүгдэгч бүрийн ялыг баталгаажуулсан эсэхийг шалгадаг. Тусдаа шүүх хурал гэх мэт шалтгаанаар ял нь батлагдаагүй хүн байгаа тохиолдолд хадгалалтын асуудал эрхэлсэн ажилтан нь зөвхөн баталгаажуулсан шүүхийн эх хувийг гаргаж, үлдсэн тэмдэглэлийг бүртгэдэг. Хадгалах ажилтан нь эд хөрөнгийн шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэртэй холбогдуулан торгуулийн хэмжээг тохируулсан эсэхийг шалгана. Хамгаалах ажилтан нь шүүлтийн баримтын доод талд анхан шатны шүүхэд харьяалагдах прокурорын хэргийн дугаар, ялтны нэрсийн жагсаалтад байгаа хавтсын тоо, тоог бичнэ. Хадгалах ажилтан нь задлан авсан шүүхийн баримт бичгүүдийг төрлөөр нь ангилж, баталгаажуулсан огнооны дарааллаар эмхлэнэ. Олон шүүгдэгчтэй тохиолдолд шүүгдэгч тус бүрд ялын эцсийн хугацаа өөр өөр байвал эцсийн шийдвэр гарсан өдрөөр ялыг зохион байгуулна. Хадгалах асуудал эрхэлсэн ажилтан нь шийдвэр гарснаас хойш нэг жил өнгөрсөн шүүхийн шийдвэрийн баримт бичгийг жилд нэг удаа хавсаргаж, хавсралтын 4-р маягтын дагуу эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн баримт бичгийн жагсаалтад заасан мэдээллийг оруулна. Хадгалах асуудал эрхэлсэн ажилтан нь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн баримт бичгийн жагсаалтад тухайн хэргийн холбогдох шүүхийн баримт бичгийн хоорондын хамаарлыг тэмдэглэнэ. Хадгалах ажилтан нь задалсан туршилтын файлын хавтсанд серийн дугаар, баталгаажуулсан огноог жилээр нь бичиж, серийн дугаарын дарааллаар жилээр нь эмхэлж, хадгалах ёстой.</p>

Дээрхээс дүгнэвэл, БНСУ-ын тухайд дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, шалгалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ерөнхий зохицуулдаг хэдий ч Ерөнхий прокурорын газраас гаргасан журмаар мөн нарийвчлан зохицуулж байна. Тодруулбал, Шүүхийн баталгаажуулалтын бүртгэлийг хадгалах, яллагдаагүй хэргийн бүртгэлийг хадгалах, гомдол, дотоод хэргийн бүртгэлийг хадгалах, видео бичлэгийг хадгалах, шүүхийн шийдвэрийг хадгалах гэж нарийвчилсан ангиллыг тогтоож өгсөн байна. Мөн түүнчлэн хэргийн төрлөөс хамааруулан баримт бичгийг жилээр, цаашлаад хөөн хэлэлцэх хугацаагаар тогтоон хадгалдаг байна

Иймд хуулийн төслийн тухайд Хувийн мэдээллийг автоматаар боловсруулахтай холбоотой хувь хүнийг хамгаалах тухай Европын зөвлөлийн конвенцийн 5 дугаар зүйлийн е хэсэгт агуулгыг таних боломжтой хэлбэрээр хадгалагдсан өгөгдлийг тухайн өгөгдлийг хадгалах зорилгод шаардагдах хугацаанаас илүүгээр хадгалж болохгүй талаар зохицуулсан байгааг харгалзан бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн зорилгыг сайтар авч үзэх хэрэгтэй. Мөн БНСУ-д хэргийн төрлөөс хамааруулан баримт бичгийг жилээр, цаашлаад хөөн хэлэлцэх хугацааг дуусах хүртэл хадгалдаг болохыг харгалзан үзэх хэрэгтэй. Мөн түүнчлэн нотлох баримт, эд мөрийн баримтын хадгалалт, хамгаалалтын талаар нэгдсэн журам боловсруулан гаргах шаардлагатай болохыг анхаарах нь зүйтэй.



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь төрийн болон албаны нууцтай холбоотой зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төрийн болон албаны нууцтай холбоотой шүүх хуралдаан, шүүхийн шийдвэр, яллах дүгнэлтийн зохицуулалтыг тусгасан байна.

Энэ тухай тус хуулийн төслийн танилцуулгад дараах байдлаар тодорхойлжээ.

“Шүүх хуралдааныг нээлттэй, хаалттай явуулсан, шүүхийн шийдвэрт төрийн болон албаны нууц мэдээлэл агуулагдсан эсэхээс үл хамаарч прокурор, оролцогчийг шүүхийн шийдвэр, түүний үндэслэлтэй бүрэн танилцах, уг шийдвэрийг эс зөвшөөрвөл эсэргүүцэл, гомдол гаргах эрхийг баталгаатай хангах нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан “... шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх...” хүний үндсэн эрхтэй салшгүй холбоотой билээ.

Шүүхийн шийдвэрийг оролцогчид гардуулах харилцааг журамласан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.5 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, 36.13 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 39.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 40.8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн зохицуулалтаас үзэхэд Төрийн болон албаны нууц мэдээлэл агуулсан шийдвэрийг оролцогчид хэрхэн танилцуулах, эсхүл гардуулах асуудлыг хуульд нарийвчлан заахгүй орхигдуулжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтална.” хэмээн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвхөн эрүүгийн процессын хуулийг баримтлах зарчмыг хуульчлан заасан тул төрийн болон албаны нууц мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийг прокурор, оролцогчид гардуулах, танилцуулах талаар эрүүгийн процессын хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, тухайн харилцааг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

Иймд төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүх, прокурорын шийдвэрийг оролцогчид танилцуулах, гардуулан өгөх журмыг нарийвчлан тодорхойлсон.”⁹²

Дээрх байдлаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нарийвчлан зохицуулахдаа 3 төрлийн процессын зохицуулалтыг хамааруулан нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгажээ.

1. Яллах дүгнэлтийг гардуулах талаар

32.10 дугаар зүйлд 9 дэх хэсгийг дараах байдлаар нэмсэн.

“9.Төрийн нууцтай холбоотой хэргийн яллах дүгнэлтийг бүрэн бодитой танилцуулж, төрийн нууц мэдээлэл агуулсан хэсгийг хассан хувийг гардуулан өгнө.”

2. Шүүхийн шийдвэрийн талаар

36.13 дугаар зүйлд 5, 6 дахь хэсгийг дараах байдлаар нэмсэн.

⁹² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга, 2024

“5.Төрийн нууц мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийн нууц агуулаагүй “Удиртгал” болон “Тогтоох” хэсгийг нууцын тэмдэглэлээ, дардас дарахгүйгээр прокурор, оролцогчид гардуулж, нууц мэдээлэл агуулсан “Тодорхойлох” хэсгийг гардуулахгүйгээр, шүүхийн шийдвэрийг бүрэн бодитой танилцуулах арга хэмжээ авна.

6.Шүүхийн шийдвэрийн “Удиртгал” болон “Тогтоох” хэсэгт төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулагдсан бол тэр хэсгийг хасч хэвлэн, прокурор, оролцогчид гардуулна.”

3. Шүүх хуралдааны талаар

3.2 дугаар зүйлд дараах байдлаар өөрчлөлтийг оруулсан.

ОДОО	ӨӨРЧЛӨЛТ
<p>3.2 дугаар зүйл.Шүүх хуралдааныг нээлттэй явуулах 1.Төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг хамгаалах шаардлагатай, өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчтой холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, бүх шатны шүүх хуралдааныг нээлттэй явуулна.</p> <p>2.Өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг нээлттэй явуулж болно.</p> <p>3.Шүүх хуралдааныг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсгоно.</p>	<p>“3.2 дугаар зүйл.Шүүх хуралдааныг нээлттэй, хаалттай явуулах 1.Төрийн болон албаны нууц, хүний эмзэг мэдээллийг хамгаалах шаардлагатай, өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчтой холбогдох болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулахаар хуульд заасан эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, бүх шатны шүүх хуралдааныг нээлттэй явуулна.</p> <p>2.Өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг нээлттэй явуулж болно.</p> <p>3.Хэргийн нотлох баримт, үйл явдал нь хүний эмзэг мэдээллээс бусад хувийн мэдээлэл болон байгууллагын нууц мэдээлэлд хамаарч байвал мэдээллийн эзэн буюу хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр шүүх хуралдааныг бүрэн, эсхүл түүний зарим ажиллагааг хаалттай явуулж болно.</p> <p>4.Мэдээллийн эзэн зөвшөөрсөн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагаан дахь хүний эмзэг мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод байлгаж болно.</p> <p>5.Хаалттай шүүх хуралдааны явцад илэрхий болсон төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний хувийн мэдээллийг шүүгч, шүүх хуралдаанд оролцогч задруулж болохгүй.</p> <p>6.Шүүх хуралдааныг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсгоно.”</p>

Ерөнхийд нь авч үзвэл нэмэлт, өөрчлөлтийн зохицуулалтад “Төрийн нууц”, “Албаны нууц”, “хүний эмзэг мэдээлэл”, “хувийн мэдээлэл”-тэй холбоотой эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар авч үзжээ.

Төрийн нууцын тухайд:

2016 онд батлагдсан Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх хэсэгт зааснаар төрийн нууцыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг хэлэхээр зохицуулжээ.

Мөн тус хуулийн 13 дугаар зүйлд хамаарах мэдээллийг нарийвчлан тусгасан байна.

13 дугаар зүйл. Төрийн нууцад хамааруулах мэдээлэл

13.1.Төрийн нууцад дараахь мэдээллийг хамааруулна:

13.1.1.төрийн бодлогын хүрээнд:

13.1.1.а.Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлал, номлолын нууцалбал зохих хэсэг;

13.1.1.б.Улсын Их Хурлын чуулган, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл;

13.1.1.в.аливаа улстай харилцах Монгол Улсын чиг бодлого, байр суурийг нарийвчлан илэрхийлсэн мэдээлэл, гадаад орнуудаас итгэмжлэгдсэн байдлаар авсан мэдээлэл;

13.1.1.г.Засгийн газар, Төв банкнаас гадаад улс, олон улсын байгууллагатай санхүүгийн салбарт хамтран ажиллах болон өр, зээл, тусламжтай холбоотой гэрээ хэлэлцээрийн төсөл, тэдгээрийн боловсруулалтын шатанд хамаарах мэдээлэл;

13.1.1.д.төрийн дээд, өндөр хэмжээний харилцан айлчлал, хоёр болон олон талын яриа, хэлэлцээрийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл;

13.1.1.е.энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан асуудлаар гадаад улсын Засгийн газар, байгууллагатай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, протокол, тэдгээрийн төсөл, хэрэгжилтийн талаархи дэлгэрэнгүй мэдээлэл;

13.1.1.ё.хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газрын онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах төлөвлөгөө, ажлын удирдамж;

13.1.1.ж.энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан асуудлаар олон улсын хурал зөвлөгөөн, чуулганд оролцох төлөөлөгчдийн ажлын чиглэл, удирдамж.

13.1.1.з.улсын батлан хамгаалах, эдийн засагт чухал ач холбогдол бүхий үйлдвэр, онц чухал объектод гарсан гэмт халдлага, осол, сүйрэл, онцгой нөхцөл байдлын үед эрх бүхий байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээ, түүнтэй холбоотой мэдээллийн нууцалбал зохих хэсэг.

13.1.2.эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологийн хүрээнд:

13.1.2.а.эдийн засгийн аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн нууцалбал зохих хэсэг;

13.1.2.б.мөнгөн тэмдэгтийн нөөц, нөөцийн сангийн байршил, хамгаалалтын тухай мэдээлэл;

13.1.2.в.үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой шинжлэх ухаан, технологийн ололт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, судалгааны туршилт, угсралт, төслийн ажил, технологийн тухай мэдээлэл;

13.1.2.г.мөнгөн тэмдэгтийн эх загвар бүтээх, үйлдвэрлэх, устгах, мөнгөн тэмдэгтийн нийлүүлэлт, солилцоо, гүйлгээнээс гаргах тухай мэдээлэл.

13.1.3.батлан хамгаалах хүрээнд:

13.1.3.а.батлан хамгаалах бодлого, төрийн цэргийн номлолын нууцалбал зохих мэдээлэл;

13.1.3.б.зэвсэгт хүчний тайван цагийн болон дайны байдлын үеийн зохион байгуулалтын бүдүүвч, төрийн цэргийн байгууллагын нэгтгэл, ангийн байлдааны цагийн орон тоо, жинхэнэ нэр, зохион байгуулалт, бүтэц, тэдгээрийн байлдах чадвар, байлдааны бэлэн байдлыг тодорхойлсон нэгдсэн үзүүлэлт, мэдээлэл;

13.1.3.в.төрийн цэргийн байгууллагын стратегийн удирдамж, бэлэн байдлын төлөвлөгөө, тэдгээрийн биелэлт, тооцоо, зэвсэгт хүчнийг бэхжүүлэх, хэрэглэх болон стратегийн төлөвлөлтийн баримт бичиг, бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, байлдаанд бэлтгэх, шилжүүлэн байрлуулах төлөвлөгөө, зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах арга ажиллагааны тактикийн тухай мэдээлэл;

13.1.3.г.байлдааны болон хил хамгаалалтын бэлэн байдлын мэдээ, байлдааны тушаал, захирамж, байлдааны ажиллагааны газар, орныг төхөөрөмжлөхтэй холбогдсон мэдээлэл;

13.1.3.д.батлан хамгаалах болон улсын хил хамгаалах зориулалттай болон энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл агуулсан байр зүйн зураг;

13.1.3.е.улсын болон цэргийн дайчилгааны даалгавар, төлөвлөгөө, нөөц, нөхөн хангах тооцоо, төрийн цэргийн байгууллагын байлдааны техник зэвсэглэл, материал, галт хэрэглэлийн хангалт, захиалга, нөөцийн талаархи мэдээлэл;

13.1.3.ё.төрийн цэргийн байгууллагын бие бүрэлдэхүүний тоо бүртгэл, бэлтгэл үүрэгтэн, цэрэгт татах болон цэргээс халагдах хүмүүсийн нэгдсэн мэдээлэл, цэргийн мэргэжлийн ангилал, оногдуулан данслагдсан хүн, техникийн нэгдсэн дүн, тооцоо /улсын болон нийслэл, аймгийн хэмжээнд/;

13.1.3.ж.төрийн цэргийн байгууллагын автоматжуулсан болон далдуур /удирдлага холбооны/ удирдлагын системийн бүтэц, зохион байгуулалт, хангалтын тухай мэдээлэл;
13.1.3.з.төрийн цэргийн байгууллагын удирдлагын байрны байршил, мэдээлэл, холбооны сүлжээ, радио долгионы давтамжийн хуваарилалтын тухай мэдээлэл;
13.1.3.и.улсын болон цэргийн дайчилгааны зорилго, цар хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээний төрөл, багтаамж, арга хэлбэр, улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгавар, төлөвлөгөөний тухай мэдээлэл;
13.1.3.й.улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албаны арга ажиллагаа, хангалтыг зохион байгуулахтай холбоотой мэдээлэл;
13.1.3.к.улсын болон батлан хамгаалах нөөцийн бодит хэмжээ, байршил, тайлан, санхүүжилтийн тухай мэдээлэл;
13.1.3.л.улсын болон батлан хамгаалах нөөцийн жилийн болон дунд, урт хугацааны үндсэн чиглэлийн төслийн тооцоо, үндэслэл, түүнийг хэрэгжүүлэх талаар төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан баримт бичиг;
13.1.3.м.улс орныг дайны байдалд шилжүүлэх төлөвлөгөө, дайны болон дайн бүхий байдлын үед төрийн байгууллагын ажиллах төлөвлөгөө, түүнд холбогдох мэдээлэл;
13.1.3.н.онцгой байдлын үеийн арга хэмжээний төлөвлөгөө, холбоо, зарлан мэдээллийн үйл ажиллагааны зохион байгуулалт, энэ зорилгоор дэд бүтцийг ашиглах тухай мэдээлэл, удирдлагын хоргодох байр, төсөв, байршил, хүчин чадлын тухай мэдээлэл.
13.1.3.о.Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн орлого, зарлагатай холбоотой нууцалбал зохих мэдээлэл.
13.1.4.тагнуул, сөрөх тагнуул, хууль сахиулах ажлын хүрээнд:
13.1.4.а.тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын мэдээллийн эх сурвалж, тэдгээрийг халхавчлахтай холбоотой мэдээлэл;
13.1.4.б.гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэлийн болон тусгай сангийн мэдээлэл;
13.1.4.в.гүйцэтгэх ажлын мэдээллийн болон тусгай техник хэрэгслийн тоо бүртгэлийн сан, түүнд ашиглагдаж байгаа тусгай зориулалтын техник технологи, программ хангамж, нууцлах код, түлхүүр, өгөгдөл, нууц тээгчид байгаа мэдээлэл;
13.1.4.г.бие бүрэлдэхүүнийг нь нууцалбал зохих тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын салбар нэгж, тэдгээрийн барилга байгууламж, байршил, тээврийн хэрэгслийн улсын дугаар, гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн тухай мэдээлэл;
13.1.4.д.гүйцэтгэх ажлын шугамаар шалгасан болон шалгаж байгаа хэргийн материал, баримт сэлт, мэдээлэл;
13.1.4.е.эрх бүхий байгууллагын удирдлагаас гүйцэтгэх ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар гаргасан шийдвэр, заавар, журам, бусад баримт бичиг;
13.1.4.ё.гүйцэтгэх ажилтны үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө, тайлан, ажлын байрны тодорхойлолтын мэдээлэл;
13.1.4.ж.тагнуул, сөрөх тагнуул, эрх бүхий бусад байгууллагын гүйцэтгэх ажил эрхлэх нэгжийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны тухай мэдээлэл;
13.1.4.з.тагнуулын байгууллагын төсөв, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий бусад байгууллагын гүйцэтгэх ажлын зардал, тэдгээрийн гүйцэтгэлийн тайлангийн мэдээлэл;
13.1.4.и.гүйцэтгэх ажилтан, нууц гүйцэтгэх ажилтны хувийн хэргийн болон тэдний албан ажилтай холбоотой мэдээлэл;
13.1.4.й.тагнуулын байгууллагаас үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд илгээсэн мэдээлэл;
13.1.4.к.гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын тусгай архивын данс, бүртгэл, эд зүйл;
13.1.4.л.гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагыг өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх төлөвлөгөө, террор, хорлон сүйтгэх ажиллагаа, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны төлөвлөгөө, удирдамж, хэрэглэх дохио;
13.1.4.м.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор тагнуулын байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа;
13.1.4.н.тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын өөрийн аюулгүй байдлыг хангах ажлын зохион байгуулалт, арга, тактик, хүч, хэрэгсэл, төлөвлөгөөний мэдээлэл;
13.1.4.о.тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажлын зориулалттай зэвсэг, тусгай хэрэгсэл, материал техникийн хангалт, нөөцийн мэдээлэл;
13.1.4.ө.тагнуулын байгууллагаас гадаад улсын тусгай албатай тогтоосон хамтын ажиллагааны тухай мэдээлэл;

13.1.4.п.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх арга хэмжээний явц, уг арга хэмжээгээр хамгаалагдсан этгээдийн нууцалбал зохих мэдээлэл.

13.1.5.мэдээллийн аюулгүй байдлын болон бусад хүрээнд:

13.1.5.а.төрийн тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны сүлжээний бүтэц, зохион байгуулалт, программ хангамж, мэдээлэл нууцлагч техник хэрэгсэл, тэдгээрийн ажиллагааны зарчим, радио долгионы давтамжийн хуваарилалтын мэдээлэл;

13.1.5.б.төрийн мэдээллийн сүлжээний удирдлагын төвийн тусгай зориулалтын техник, программ хангамж;

13.1.5.в.төрийн шифр харилцааны бодлого, төрийн тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны болон шифрийн криптографын боловсруулалт, сан, нөөц, шифрийн арга ажиллагаа, аргачлал, тэдгээрийг ашиглах заавар, код, түлхүүр, түүнтэй холбоотой мэдээлэл;

13.1.5.г.төрийн шифр мэдээ, шифрийн харилцааны дүрэм, заавар, шифрийн материалын бүртгэл;

13.1.5.д.төрийн нууц тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан тухай мэдээлэл;

13.1.5.е.төрийн нууцад хамаарах мэдээлэл, нууц тээгчийг ашиглан бэлтгэсэн ном, сурах бичиг, бүтээл, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, тайлан, илтгэл, мэдээлэл, дүгнэлт, хурал, зөвлөгөөн, лекц, гүйцэтгэх ажлын сургалтын хөтөлбөр, хичээлийн тэмдэглэл;

13.1.5.ё.энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан асуудлыг шалгасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны нууцалбал зохих баримт бичиг, мэдээлэл;

13.1.5.ж.хуулиар төрийн тусгай хамгаалалтын нэгдүгээр зэрэглэлээр хамгаалуулж байгаа албан тушаалтны эрүүл мэндийн байдлын тухай мэдээлэл;

13.1.5.з.улсын онц чухал болон тусгай объектын байршил, олгосон газрын нэр, зураг, хамгаалалтын зохион байгуулалт, хүч хэрэгслийн тухай мэдээлэл;

13.1.5.и.цэвэр ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн байршлын зураг;

13.1.5.й.энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээ, баримт бичиг, эд зүйлийг битүүмжлэн хүргэх төрийн тусгай болон дипломат шуудан, битүүмжлэхээс хэрэглэгчид хүртэл үйл ажиллагаа;

13.1.5.к.энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан асуудал хэлэлцсэн хаалттай хуралдааны тэмдэглэл, баримт бичиг;

13.1.5.л.хуулиар төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэн болон хурал, чуулган, арга хэмжээ, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийн байнгын болон цаг үеийн хамгаалалтын зохион байгуулалт, хүч, хэрэгслийн болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төсвийн тухай мэдээлэл;

13.1.5.м.улсын онц чухал болон тусгай объект, үйл ажиллагааг халхлах журам.


13.2.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь энэ зүйлийн 13.1-д заасан жагсаалтын хүрээнд салбар, байгууллагын хэмжээнд нууцлах төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг боловсруулж, тагнуулын байгууллагын саналыг авч Засгийн газраар батлуулна.

13.3.Салбарын болон байгууллагын хэмжээнд нууцлах мэдээллийн жагсаалтад тухайн мэдээллийг нууцлах хугацаа, нууцын зэрэглэлийг тусгасан байна.

Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д 2019-2021 онд нийтдээ 10 мэдээллийг нэмж, 1 мэдээллийг өөрчилсөн байна. Уг жагсаалтаар батлагдсан төрийн нууц мэдээллийн тоо:

№	Байгууллага, салбар	Төрийн нууцад хамаарах мэдээллийн тоо
1	Улсын Их хурлын тамгын газар	31
2	Ерөнхийлөгчийн тамгын газар	16
3	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	32

4	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Стратегийн судалгааны хүрээлэн	33
5	Гадаад харилцааны салбар	19
6	Батлан хамгаалах салбар	78
7	Хууль зүй, дотоод хэрэг, хууль сахиулах салбар	56
8	Банк, санхүүгийн салбар	21
9	Байгаль орчин, аялал жуулчлалын салбар	10
10	Барилга, хот байгуулалтын салбар	16
11	Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын салбар	9
12	Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар	11
13	Зам, тээврийн салбар	10
14	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар	10
15	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар	12
16	Эрүүл мэндийн салбар	10
17	Эрчим хүчний салбар	12
18	Авлигатай тэмцэх газар	20
19	Төрийн аудитын байгууллага	6
20	Сонгуулийн ерөнхий хороо	5
21	Санхүүгийн зохицуулах хороо	4
22	Үндэсний статистикийн хороо	5
23	Цөмийн энергийн комисс	6
24	Төрийн албаны зөвлөл	7
25	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбар	9
26	Мэргэжлийн хяналтын байгууллага	5
27	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	7
28	Үндэсний хөгжлийн газар	5
29	Тагнуулын байгууллага, Төрийн тусгай хамгаалалтын газар	60
30	Онцгой байдлын салбар	13
31	Стандарт, хэмжил зүйн газар	4
32	Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын байгууллага	13
33	Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар	17



Засгийн газрын тогтоолоор нийт 575, давхцалгүй тоогоор 404 мэдээллийг төрийн нууцад хамааруулжээ⁹³.

Албаны нууцын тухайд:

2016 онд батлагдсан Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь хэсэгт зааснаар албаны нууцыг задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг хэлэхээр тодорхойлсон.

Мөн тус хуулийн 14 дүгээр зүйлд албаны нууцад хамаарах мэдээллийн талаар дараах байдлаар зохицуулжээ.

14 дүгээр зүйл. Албаны нууцад хамаарах мэдээлэл 14.1.Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална. 14.2.Энэ зүйлийн 14.1-д заасан жагсаалтыг батлахад тагнуулын байгууллагын саналыг авна.


Дээрхээс үзвэл албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хариуцсан байгууллага боловсруулж баталж байгаа нь хууль хэрэглээний асуудал бий болгох боломжийг үүсгэдэг. Тодруулбал, ТБАНТХ дахь албаны нууцын тодорхойлолт нь хэт өргөн, тодорхойгүй бөгөөд ялгаа зааг, шалгуур үзүүлэлтийг тогтоогоогүйгээс үүдэн албаны нууцыг ангилахад хүндрэл учирч байна. Өнөөгийн түвшинд “албаны нууц” гэх ойлголтын хүрээнд төрийн байгууллага бүр өөрсдийн дур зоргоор аливаа мэдээллийг нууцлах байдал үүссэн. Улс, орнуудад “албаны нууц” хэмээх ойлголт төдийлэн байдаггүй. Харин улс орнуудын нийтийн мэдээллийн тухай хууль, мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжид “албан мэдээлэл” гэх ойлголт цөөнгүй тусгагджээ. Төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилтийг бууруулахгүй байх, иргэн, хуулийн этгээдийн нууц мэдээллийг задруулж тэдгээрт хохирол учруулахаас сэргийлэх зорилгоор албан мэдээлэлтэй танилцах иргэний эрхийг хязгаарлах боломжтой ч хязгаарласан мэдээллийг нууц гэж үздэггүй байна.

Иймд Төрийн нууцын хууль тогтоомж дахь “албаны нууц” гэх ойлголтыг халж, Нийтийн мэдээллийн тухай хуулиар үүнд холбогдох харилцааг зохицуулах, хязгаарлаж болох албан мэдээллийн жагсаалтыг байгууллагын дотоод журмаар нэг удаа батлаад орхих бус жил бүр, эсхүл тодорхой давтамжтайгаар шинэчилж байх зохицуулалтыг тусгаж, төрийн байгууллагын мэдээлэл хариуцсан ажилтнуудын ойлголтыг нэгдмэл болгох шаардлагатай. Байгууллагын дотоод журам, жагсаалт нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцсэн байх, хэрэв зөрчилдвөл уг хуулийн давуу байдлыг хангах зохицуулалтыг хуульчилбал өнөөгийн практикт тулгарч буй хууль хэрэглээний хүндрэлийг даван туулахад чухал ач холбогдолтой.

Түүнчлэн төрийн байгууллага, албан хаагч нь иргэний мэдээлэл авах хүсэлтэд татгалзсан хариу өгөх тохиолдолд тухайн мэдээллийг нууцалсан үндэслэлээ тайлбарлах, улмаар татгалзсан шийдвэрт гомдол гаргах боломж бүрдүүлэх нь иргэдийн төрийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлэх, цаашилбал иргэний мэдэх эрхийн баталгааг хангахад чухал нөлөө үзүүлнэ. Түүнчлэн иргэний хүсэлтийг бүртгэх, улмаар хяналтын чиг үүрэг бүхий байгууллагад тоон мэдээллийг тогтмол хугацаанд өгөх чиг үүргийг хуульд тусгах нь зүйтэй юм⁹⁴.

⁹³ Зарим мэдээлэл хэд хэдэн удаа давхацсан байгааг анхаарах нь зүйтэй.

⁹⁴ ХЗҮХ, “Төрийн болон албаны нууцын хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх тайлан”, УБ, 2023, 36 дахь тал.



Хүний эмзэг мэдээллийн тухайд:

2021 онд батлагдсан Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь хэсэгт зааснаар хүний эмзэг мэдээлэл гэдэгт хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг хэлэхээр зохицуулсан.

Хувийн мэдээллийн тухайд:

2021 онд батлагдсан Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх хэсэгт зааснаар хүний хувийн мэдээлэл гэдэгт хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг хамааруулахаар хуульчилсан.

Хуульд дээрх байдлаар нэмэлт, өөрчлөлт оруулсан зохицуулалтын хүрээг 2 хуваан авч үзье.

1. Шүүхийн шийдвэр, яллах дүгнэлттэй холбоотой өөрчлөлтийн талаар

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд буюу яллах дүгнэлт, шүүхийн шийдвэр, шүүх хуралдаанд төрийн болон албаны нууц, хүний эмзэг мэдээлэл, хувийн мэдээллийг нууцлах, хаалттай явуулах нь тухайн субъектуудын эрх ашгийг хамгаалдаг хэдий ч нөгөө талаас ил тод байдлын асуудлыг хөнддөг.


Шүүхийн шийдвэр ил тод байх талаар үзэл баримтлалын дараах асуудлууд байдаг.

Нэгдүгээрт, Шүүхийн шийдвэр бүрэн эхээрээ (бүхэлдээ) ил тод байна. Шүүхийн шийдвэрт дурдагдсан аливаа мэдээлэлд ямар нэгэн өөрчлөлт, нууцлал хийлгүйгээр бүрэн эхээр нь нийтэлж ил тод болгоно. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэр бүхэлдээ ил тод байдаг бөгөөд төрийн мэдээлэл эмхэтгэлд хэвлэн нийтлэгдэхийн зэрэгцээ, эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn болон Үндсэн хуулийн цэцийн www.conscourt.gov.mn цахим хуудаст бүрэн эхээрээ ямар нэгэн засвар, өөрчлөлтгүйгээр нийтэлдэг.

Хоёрдугаарт, Нууц, аюулгүй байдалд хамаарахаас бусад шүүхийн шийдвэр ил тод байна. Шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа хэргийн нотлох баримт ба үйл явдал нь төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хувь хүний эмзэг мэдээллийг агуулсан, түүнчлэн аюулгүй байдалд хамаарах бол тухайн шүүхийн шийдвэрийг ил тод болгохгүй болно.

Гуравдугаарт, Шүүхийн шийдвэрт дурдагдсан хүн, хуулийн этгээд болон тэдгээрийн өмч, хөрөнгийг тодорхойлох мэдээллээс бусад мэдээлэл ил тод байна. Шүүхийн шийдвэр нь ямагт хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой мэдээллийг агуулж байдаг тул тус шийдвэрт дурдагдсан мэдээллийн эзнийг тодорхойлох нэр, регистрийн дугаар, хаяг болон өмч тэдгээрийн талаар мэдэх боломжтой мэдээллийг нууцлах ба бусад мэдээлэлд ямар нэгэн өөрчлөлт оруулахгүй болно.

Дөрөвдүгээрт, Шүүхийн шийдвэр хэргийн оролцогчдоос бусад этгээдэд хаалттай байна. Шүүхийн шийдвэр нь нууцад хамаарах мэдээллийг агуулахын зэрэгцээ хүн,



хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, байр суурийн талаарх мэдээллийг агуулж байдаг тул хэргийн оролцогч болон бусад оролцогчдын хувьд нээлттэй байж болно, харин нийтэд ил тод болгох нь зохистой биш байдаг.

Улс орнууд засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх нийтлэг зарчмыг хүлээн зөвшөөрч, төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван эрх мэдэлд хуваадаг. Хууль тогтоох эрх мэдлийн үйл ажиллагаа хуулийн төслийг санаачлах, боловсруулах, хэлэлцэх, батлах, хэвлэн нийтлэх, дагаж мөрдүүлэх бүх үе шатандаа нээлттэй ил тод байдаг бол гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн гүйцэтгэл, хэрэгжилтийг хангах хүрээнд мөн ил тод, нээлттэй байдаг. Үүний жишгээр шүүх эрх мэдлийн үйл ажиллагаа (процесс)-г ил тод, нээлттэй болгох хүрээнд шүүх хэргийг ил таслан шийдвэрлэх зарчим хэдийнээ төлөвшсөн болно⁹⁵.

Түүнчлэн Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллага (OECD)-аас 2019 онд хийсэн “Хавтаст хэрэгтэй танилцах, нууц мэдээллийг хамгаалах” талаар гишүүн улсуудын дунд судалгаа хийж холбогдох зөвлөмжийг өгсөн байна.

Тус судалгаанд хавтаст хэрэгтэй танилцах, нууц мэдээллийг хамгаалах нь хууль сахиулах ажиллагааны хоёр тал юм гэж авч үзсэн. Хэргийн материалтай танилцах нь талууд, тэр дундаа зарим эрх мэдлийн хүрээнд гуравдагч этгээдүүдтэй холбоотой байгууллагын мэдэлд байгаа нотлох баримтыг шалгах эрх юм. Тайлбарласны дагуу хэргийн материалтай танилцах нь талуудын өмгөөллийн эрхийг хамгаалахад чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь мэтгэлцээнийг хэрэгжүүлэх тогтолцооноос хамааран агентлаг, шүүх ямар үндэслэлээр шийдвэрлүүлэхийг шалгах боломжийг олгодог. Нууц мэдээллийг хамгаалах нь хэргийн материалтай танилцах эрхийг хязгаарласан байдаг. Хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, өмгөөлөх эрхийг хамгаалахын тулд шаардлагагүй бол нууц мэдээллийг задруулахгүй байж болно. Ил болгох шаардлагатай бол нууц мэдээллийг нөхцөлтэйгээр хуваалцаж болно⁹⁶.


Энэхүү судалгааны хүрээнд хавтаст хэрэгтэй танилцах, нууц мэдээллийг хамгаалах хүрээнд Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллага (OECD)-аас дараах зөвлөмжийг өгсөн байна.

- Шүүхийн харьяалал нь талууд тус байгууллагын хавтаст хэрэгт байгаа нотлох баримттай танилцах боломжийг янз бүрээр баталгаажуулдаг. Зарим нь бараг бүхэл бүтэн хавтаст хэргийг хамарсан маш өргөн хандалтыг олгодог бол зарим нь зөвхөн тодорхой баримт бичигт хандах боломжийг олгодог. Оролцогчийг хамгаалах эрхийг хамгаалахын тулд талууд холбогдох бүх буруутгах, цагаатгах нотлох баримтыг олж авах боломжтой байх нь чухал юм. Аль мэдээллийг цагаатгах боломжтой болохыг тодорхойлох, талуудад зохих журмаар хандах эрх олгох бэрхшээлтэй байж болно. Талууд холбогдох бүх нотлох баримтыг цаг тухайд нь олж авах боломжтой байх нь зайлшгүй шаардлагатай бөгөөд ингэснээр тэд өөрсдийгөө зохих ёсоор хамгаалж чадна.

- Хавтаст хэргийн тодорхой баримт бичигтэй танилцах эрхийг бусад сонирхогч этгээд болон олон нийтэд олгож болно. Харьяаллын бүсүүд, ялангуяа олон нийтэд нэлээд хязгаарлагдмал хүртээмжтэй байдаг.

⁹⁵ Нээлттэй нийгэм форум, “Шүүхийн шийдвэрийн ил тод байдал Мониторингийн тайлан”, УБ, 2024, 12-13 дахь тал.

⁹⁶ OECD, “Working Party No. 3 on Co-operation and Enforcement Access to the case file and protection of confidential information – Background Note by the Secretariat”, 2019, [https://one.oecd.org/document/DAF/COMP/WP3\(2019\)6/en/pdf](https://one.oecd.org/document/DAF/COMP/WP3(2019)6/en/pdf), pp.4.



- Нууц мэдээллийг хамгаалах нь хавтаст хэрэгт хандах эрхийг хязгаарладаг. Харьяаллын дийлэнх нь нууц мэдээллийг хамгаалдаг ч "нууц мэдээлэл" гэсэн тодорхой тодорхойлолт нь харьяалал бүрт харилцан адилгүй байдаг. Арилжааны нууц мэдээлэл болон хувийн нууц мэдээллийг ихэвчлэн нууц гэж үздэг.

- Мэдээлэл нууц байна гэдэг нь зарчмын хувьд задруулахгүй гэсэн үг. Гэсэн хэдий ч илчлэх нь хэд хэдэн нөхцөл байдалд байж болно. Нэгдүгээрт, тэдний эрх, ашгийг хамгаалах эрхийг хамгаалахын тулд нууц мэдээллийг талуудтай хуваалцаж болно. Нууц мэдээлэл агуулсан баримт бичгийг агентлагуудад хуваалцах боломжийг олгодог хэд хэдэн механизм байдаг.

- Хоёрдугаарт, дотоод, гадаадын бусад байгууллагад нууц мэдээллийг задруулж болно. Зарим эрх мэдлийн хүрээнд дотоодын байгууллагуудад мэдээлэл өгөх талаар нэлээд нээлттэй хандлагыг баримталдаг. Зарим нь илүү хатуу байдаг. Гадаадын агентлагт мэдээлэл өгөх нь ерөнхийдөө мэдээллийг илгээсэн тал гарын үсэг зурсны дагуу хийгддэг.


- Эцэст нь, хувийн эрх зүйн шийдвэр гүйцэтгэх зорилгоор мэдээллийг задруулж болно. Нэхэмжлэгч нарт хавтаст хэрэгт байгаа мэдээлэлтэй танилцах боломжийг олгох нь хохирлыг барагдуулах үйл ажиллагааг дэмжихэд тустай. Гэсэн хэдий ч өршөөлийн болон төлбөр тооцооны материалыг задруулах нь талууд эдгээр механизмыг ашиглахад саад болж болзошгүй юм⁹⁷.

Дээрхээс дүгнэвэл, Нууц, аюулгүй байдалд хамаарах мэдээлэл, төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хувь хүний эмзэг мэдээлэл, хүн, хуулийн этгээд болон тэдгээрийн өмч, хөрөнгийг тодорхойлох мэдээллээс бусад мэдээлэл нь ил тод байх талаар нийтлэг жишиг тогтсон байна. Хавтаст хэрэгтэй танилцах, нууц мэдээллийг хамгаалах нь харилцан уялдаатай ойлголт ба нэг талаас нууцлах мэдээллийг оновчтой тодорхойлж, хязгаарлах нөгөө талаас талуудын нотлох баримт, баримт бичигтэй танилцах эрх, ашгийг хамгаалах ойлголт байхаар байна. Мөн түүнчлэн энэхүү зохицуулалтыг улс, орон болгон өөрийн шүүхийн харьяалал, хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд тохиромжтой байдлаар зохицуулдаг байна.

Хуулийн төсөлд төрийн болон албаны нууц мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэр, прокурорын яллах дүгнэлтийг прокурор, оролцогчид гардуулах, танилцуулах талаар, хүний хувийн мэдээлэл, эмзэг мэдээлэл агуулсан шүүх хуралдааны талаар нарийвчлан зохицуулсан хэдий ч талуудын нотлох баримт, баримт бичигтэй танилцах эрх, ашгийг хамгаалах талаар өргөнөөр хязгаарласан байна.

Тодруулбал, Төслийн 32.10 дугаар зүйлд 9 дэх хэсэгт төрийн нууцтай холбоотой хэргийн яллах дүгнэлтийг бүрэн бодитой танилцуулж, төрийн нууц мэдээлэл агуулсан хэсгийг хассан хувийг гардуулан өгөхөөр тусгасан нь яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн нотлох баримт, баримт бичигтэй танилцах эрх, ашгийг зөрчих боломжид хүргэж болох юм. Учир нь бүрэн бодитой танилцах нь тухайн талын нөхцөл байдлаас хамаарч өөр байж болох ба яллах дүгнэлтийг бүхэлд нь гардан аваагүйн улмаас түүний эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх магадлалтай. Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллагдагч ямар хэрэгт яллагдаж байгаага мэдэх эрхтэй. Иймд тус эрхүүдийг өргөнөөр ийнхүү хязгаарлахын оронд яллах дүгнэлттэй танилцах, гардан авах

⁹⁷ OECD, "Working Party No. 3 on Co-operation and Enforcement Access to the case file and protection of confidential information – Background Note by the Secretariat", 2019, [https://one.oecd.org/document/DAF/COMP/WP3\(2019\)6/en/pdf](https://one.oecd.org/document/DAF/COMP/WP3(2019)6/en/pdf), pp.30-31.



яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид нууц задруулахгүй байх үүргийг хүлээлгэх нь зүйтэй юм.

Мөн тус төслийн 36.13 дугаар зүйлийн 5,6 дахь хэсэгт төрийн нууц мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийн “Тодорхойлох”, “Удиртгал”, “Тогтоох” хэсэгт төрийн нууц агуулсан мэдээлэл агуулагдсан бол гардуулахгүйгээр, шүүхийн шийдвэрийг бүрэн бодитой танилцуулах арга хэмжээ авахаар зохицуулжээ. Энэ нь өмнө дурдсан талуудын нотлох баримт, баримт бичигтэй танилцах эрх, ашгийг зөрчих боломжид хүргэхээс гадна шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг өргөнөөр хязгаарлах нөхцөл байдал үүсгэх юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт зааснаар “...шүүхийн шийдвэрийг давж заалдах...” иргэний үндсэн эрхийг тусгасан ба үүнийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар баталгаажуулж 38.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, тэдгээрийн өмгөөлөгч шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэй.” гэж тусгасан байдаг. Иймд тус эрхүүдийг өргөнөөр хязгаарлахын оронд шүүхийн шийдвэртэй танилцах, гардан авах талуудад нууц задруулахгүй байх үүргийг хүлээлгэн давж заалдах эрхийг хангах талаар авч үзэх хэрэгтэй.

2. Шүүх хуралдааныг хаалттай явуулах зохицуулалтын өөрчлөлтийн талаар

Өмнө дурдагдсанаар тус нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хэргийн нотлох баримт, үйл явдал нь хүний эмзэг мэдээллээс бусад хувийн мэдээлэл болон байгууллагын нууц мэдээлэлд хамаарч байвал мэдээллийн эзэн буюу хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр шүүх хуралдааныг бүрэн, эсхүл түүний зарим ажиллагааг хаалттай явуулж болохоор зохицуулалтыг нэмжээ. Мэдээллийн эзэн зөвшөөрсөн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагаан дахь хүний эмзэг мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод байлгаж болно. Мөн Хаалттай шүүх хуралдааны явцад илэрхий болсон төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний хувийн мэдээллийг шүүгч, шүүх хуралдаанд оролцогч задруулж болохгүй талаар тусгажээ.

Одоогийн зохицуулалтыг авч үзвэл, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2019 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 56 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол улсын шүүхийн төрийн болон албаны нууцыг хамгаалах журам”-ын 9 дүгээр хэсэгт шүүх хуралдааныг хаалттай явуулах талаар тусгажээ.

9.1. Нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүхийн хэлэлцүүлэг, урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг холбогдох хуульд заасны дагуу бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хаалттай явуулна.

9.2. Төрийн нууцад хамаарах асуудал хэлэлцсэн хаалттай шүүхийн хэлэлцүүлэг, урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааны явцыг төрийн нууцтай танилцах эрх олгогдсон шүүх хуралдааны нарийн бичгийн дарга тэмдэглэл хөтөлж, шүүхийн серверт холбогдоогүй төхөөрөмжөөр дууны, эсхүл дуу-дүрсний бичлэг хийж баталгаажуулна.

9.3. Төрийн нууцад хамаарах асуудал хэлэлцэх шүүхийн хэлэлцүүлэг, урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдаанд хууль журмын дагуу төрийн нууцтай танилцах эрх олгогдсон буюу төрийн нууц задруулахгүй байх баталгаа гаргасан албан тушаалтан, хэргийн оролцогч, иргэнийг оролцуулах асуудлыг хуульд заасны дагуу шүүх шийдвэрлэнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.4 дүгээр зүйлд шүүх хуралдаан хаалттай явуулах процессын талаар нарийвчлан дараах байдлаар зохицуулсан байна.

34.4 дүгээр зүйл. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах

1. Шүүх хуралдааныг нээлттэй явуулна.
2. Шүүх хуралдааныг дараахь тохиолдолд бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулна:
 - 2.1. төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэх;
 - 2.2. өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэхэд түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан бол;
 - 2.3. арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай гэж үзвэл түүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх;
 - 2.4. хамгаалалтад байгаа гэрчийн мэдүүлгийг уншиж сонсох, эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад олж авсан нотлох баримтыг шинжлэн судлах.
3. Хаалттай явуулах шүүх хуралдаанд оролцуулах, байлцуулах хүнийг шүүх шийдвэрлэнэ.
4. Шүүх хуралдаанд мөрдөн шалгах ажиллагааг нууцаар явуулахтай холбоотой ил болгохыг хориглосон мэдээллийг танилцуулахдаа холбогдох хуулийг баримтална.
5. Шүүх эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсоно.
6. Өсвөр насны шүүгдэгч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг нээлттэй явуулж болно.


Дээрхээс дүгнэвэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.4 дүгээр зүйлд шүүх хуралдаан хаалттай явуулах зохицуулалтыг хуульчилсан байсныг тус нэмэлт, өөрчлөлтөөр 3.2 дугаар зүйлд давхардуулан хуульчилсан байна. Тухайлбал, шүүх хуралдаан хаалттай явуулах нөхцөл байдлыг хуульчилсан байсныг дахин тодорхойлж хүний эмзэг мэдээллээс бусад хувийн мэдээлэл болон байгууллагын нууц мэдээлэлд хамаарч байвал мэдээллийн эзэн буюу хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр хаалттай явуулахыг тодорхойлсон байна. Харин мэдээллийн эзэн зөвшөөрсөн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагаан дахь хүний эмзэг мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод байлгаж болох зохицуулалт болон хаалттай шүүх хуралдааны явцад илэрхий болсон төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний хувийн мэдээллийг шүүгч, шүүх хуралдаанд оролцогч задруулж болохгүй талаар зохицуулалт нь давхцаагүй хэдий ч 3.2 дугаар зүйлд бус 34.4 дүгээр зүйлд тусгагдах нь зохимжтой байна.

Үүнээс гадна шүүх хуралдааныг хаалттай явуулах дээрх үндэслэлүүдийг эргэн харах хэрэгтэй. Гадаадын улс, орнууд өөрийн эрх зүйн тогтолцоо, шүүхийн харьяаллаас хамааруулан онцлог зохицуулалттай байдаг. Зарим улс орныг авч үзье.

Австрали Улс

Австралид шүүх “нээлттэй шударга ёсыг” хэрэгжүүлэх ёстой гэсэн хуулийн үндсэн зарчмыг эртнээс баримталж ирсэн. Энэ нь шүүх ажиллагаа ерөнхийдөө олон нийтийн нүдэн дээр явагдах ёстой гэсэн үг юм. Энэхүү зарчим нь хууль дээдлэх ёсыг хамгаалж, шударга ёсыг тогтооход олон нийтийн итгэлийг төрүүлдэг гэдгээрээ ач холбогдолтой.

Гэхдээ шүүх хуралдааныг хаалттай явуулах тохиолдлууд байдаг. Энэ нь шүүх хуралдааны танхимд зөвхөн тухайн хэрэгт шууд хамааралтай хүмүүс буюу шүүгчийн урилгаар оролцох хүмүүс байна гэсэн үг. Одоогоор шүүх хуралдааны танхимд хэвлэл мэдээллийнхэн болон олон нийтийн төлөөлөл оролцох боломжгүй. Хаалттай шүүх хуралдаанууд нь бэлгийн хүчирхийлэл, үндэсний аюулгүй байдалд эрсдэлтэй хэрэг гэх мэт нууц мэдээлэл эсвэл хэрэгт холбогдсон хүмүүсийн хувийн мэдээлэлтэй холбоотойгоор хаалттай явагддаг.



1986 оны Эрүүгийн процессын тухай хуульд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гомдол гаргагчдад шүүхэд мэдүүлэг өгөх тусгай журмын зохицуулалтыг тусгасан байдаг. Ийм хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гомдол гаргагч нь мэдүүлэг өгөх, тэр дундаа тэдний нотлох баримтын бичлэг шүүх дээр хаалттай байх ёстой.

Шинэ Өмнөд Уэльст хаалттай шүүх хуралдааныг 2010 оны Шүүхийн хязгаарлалт болон хэвлэн нийтлэхгүй байх тухай хуулиар зохицуулдаг. Тус хуульд шүүх хуралдааныг хаалттай явуулах тохиолдлыг ихэвчлэн хүүхдийн шүүхэд хамааруулдаг. Энэ эь прокурорууд хүүхдэд ял оногдуулах асуудлыг шийдвэрлэх тусгай шүүх юм. 1987 оны Хүүхдийн (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай) хуулийн 15А бүлэгт мөн хүүхдийн нэрийг нийтлэх, дамжуулахыг хориглосон байдаг. Хууль ёсны төлөөлөгчид шүүх хуралдаан эхлэхээс өмнө шүүхийг хаалттай явуулах үндэслэл, хүсэлтийг шүүхэд гаргаж өгөх шаардлагатай⁹⁸.

Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулбал, нууц мэдээлэл, хувийн мэдээлэлтэй холбоотойгоор болон хүүхэд оролцсон шүүх хуралдааныг хаалттай явуулдгаараа ижил боловч гэр бүлийн хүчирхийллийн хэргийн шүүх хуралдааныг хаалттай явуулдгаараа өөр байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Хуульд заасны дагуу Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад шүүх хурал нээлттэй байдаг. Энэ нь үйл явц, шүүхийн шийдвэрт иргэд хяналт тавих боломжийг хангах зорилготой юм. "Шүүхийн нууц тогтолцоо"-оос аль болох зайлсхийх хэрэгтэй. Тийм ч учраас зарчмын хувьд сонирхсон хүн бүр, сэтгүүлчид хэлэлцүүлэгтэй танилцах боломжтой байх ёстой.

Үүний зэрэгцээ олон нийтэд шүүх хуралдааныг танилцуулах нь хувийн шинжтэй зүйлсийг гаргаж ирдэг тул холбогдох хүмүүст дарамт учруулах тохиолдол байдаг. Тийм ч учраас жишээлбэл, гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ихэнх нь нийтэд нээлттэй байдаггүй. Мөн өсвөр насны шүүгдэгчийн эсрэг (жишээ нь гэмт хэрэг үйлдэх үед 18 нас хүрээгүй хүмүүсийн эсрэг) эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ч хаалттайгаар явагддаг. Хуульд зааснаар дараах тохиолдлуудад шүүх хуралдаан хаалттай явагддаг байна.


§ 171a GVG – Байрлуулах

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллагдагчийг дангаар буюу ялаас гадна сэтгэцийн эмнэлэг, сэргээн засах төвд хэвтүүлэх тохиолдолд шүүх хуралдааныг хаалттайгаар явуулж болно. Эрүүгийн хуульд торгууль, хорих ялаас гадна сэтгэцийн эмгэг, донтолтын эмнэлэгт (албадан) байрлуулах зэрэг арга хэмжээнүүд байдаг. Эдгээр арга хэмжээг сэтгэцийн эмгэг, түүнчлэн мансууруулах бодис, эм, архины донтолтын үед харгалзан үздэг. Шүүгдэгчийн тухай хувийн зүйлийг байнга ярилцаж байх шаардлагатай байдаг тул ихэнхдээ хаалттайгаар шүүх хуралдааныг явуулдаг.

§ 171b GVG-ийн 1-р зүйл - Хувийн амьдралын хэсэг

Процедурт оролцсон хүн, гэрч, хууль бус үйлдлээс болж гэмтсэн хүний хувийн амьдралаас (Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь хэсэг) хэлэлцсэн тохиолдолд шүүх хуралдааныг хаалттай явуулж болно. Нийгмийн амьдралд хүн болгонд

⁹⁸ What is a Closed Court? Ashley Chung, <https://obriensolicitors.com.au/what-is-a-closed-court/>



тийм ч амархан түгээгдээд байдаггүй баримтуудыг багтаасан байх ёстой. Үүнд, юуны түрүүнд эрүүл мэндийн асуудал, хувийн шинж чанар, хандлага, бэлгийн дур хүсэл, гэр бүлийн харилцаа холбоо, улс төрийн үзэл бодол, шашин шүтлэг, үзэл суртлын хандлага зэрэг орно.

§ 171b GVG-ийн 2-р зүйл - Хүнд гэмт хэргийн насанд хүрээгүй гэрчүүд

Бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, хамгаалалтад байгаа хүмүүстэй зүй бус харьцсан, хувийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэрэгт 18 нас хүрээгүй гэрчийг сонссон тохиолдолд хаалттайгаар шүүх хуралдааныг явуулна. Онц хүнд гэмт хэрэг, тэр дундаа бэлгийн гэмт хэрэг гарсан тохиолдолд хүүхэд, залуучуудыг нээлттэй шүүх хуралдаанд хамруулж болохгүй.

§ 171b GVG-ийн 3-р зүйл - Эрх бүхий этгээдийн өргөдөл

1, 2-р зүйлд заасан шаардлагыг хангаж, хүсэлт гаргасан тохиолдолд шүүх хуралдааныг хаалттай зохион байгуулах ёстой. Хэрэв холбогдох хүн хүсэлт гаргавал шүүх дагаж мөрдөх ёстой.

§ 171b GVG-ийн 4-р зүйл – Эрх бүхий этгээдийн эсэргүүцэл

1 ба 2-т зааснаас ялгаатай нь хүсэлт гаргах эрхтэй хүмүүс хаалттай явуулахыг эсэргүүцсэн тохиолдолд шүүх хуралдаан нээлттэй явагдах ёстой.

§ 171b GVG-ийн 5-р зүйл – Маргаангүй байдал

1-4 дэх хэсэгт заасны дагуу гаргасан шийдвэр нь эцсийнх байна. Хуралдааныг хурдан явуулахын тулд шийдвэр эцсийнх бөгөөд давж заалдах эрхгүй байна. Гэхдээ энд шүүхийн шийдвэр харьцангуй явцуу хүрээнд байна.

Нэгдүгээрт, холбогдох ашиг сонирхлыг дэнсэлж үзсэний үндсэн дээр хаалттай явуулах үндэслэл байгаа эсэхийг тодорхойлох ёстой (1 ба 2-р зүйл).

Дараа нь тухайн хаалттай явуулах хүсэлт гаргасан уу, эсхүл хасахыг эсэргүүцсэн үү гэсэн асуултыг тавьж, үүнийг дагаж мөрдөх ёстой (3 ба 4-р зүйл).

Гагцхүү хаалттай явуулах үндэслэл байгаа боловч тухайн хүн аль нэг талаар тайлбар зайлшгүй шаардлагатай.


§ 172 GVG – Хаалттай явуулах нэмэлт шалтгаанууд

172-р зүйлд хасах нэмэлт үндэслэлийг оруулсан болно. Гэсэн хэдий ч, хасах шалтгаан нь асуудал байгаа тохиолдолд л ерөнхийдөө үндэслэлтэй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Жишээлбэл, төрийн ашиг сонирхолд заналхийлсэн тул хаалттай явуулсан бол ийм аюул занал учруулахаа больсон асуудлыг хэлэлцэж эхэлмэгц нээлттэй хийх ёстой.

§ 172 No 1 GVG – Төрийн ашиг сонирхол

Төрийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, ёс суртахуунд аюул заналхийлж байгаа тохиолдолд шүүх хуралдааныг хаалттай хийж болно. Цэргийн асуудал гэх мэт нууц мэдээлэлтэй холбоотой үед улсын ашиг сонирхол эрсдэлд ордог.

§ 172 No 1a GVG – Хувь хүний хувьд ноцтой аюул



Гэрч болон өөр хүний амь нас, бие махбодь, эрх чөлөөнд аюул учирсан бол шүүх хуралдааныг хаалттай явуулж болно. Энэ нь ялангуяа мэдүүлэг өгөх хүсэлтэй гэрчүүдийн эсрэг тусгайлан заналхийлсэн тохиолдолд бий болдог. Тухайлбал, хамсаатнуудын хэлмэгдүүлэлтээс айж мэдүүлэг өгөхийг хүсэхгүй байгаа тохиолдолд уг журам нь хамаарна.

§ 172 No 2 GVG – Эдийн засгийн нууц

Шүүх хуралдаанаар хэлэлцэх асуудал хамгаалагдахуйц давамгайлсан ашиг сонирхлыг зөрчих чухал бизнес, үйл ажиллагааны, шинэ бүтээл, татварын нууцыг хэлэлцэх тохиолдолд хаалттай явуулж болно. Хэрэв бизнес эрхлэгч борлуулалтын тоог зарлах, патент зарлах эсвэл ижил төстэй нууцыг задруулах шаардлагатай бол хаалттай хуралдаанд хийж болно.

§ 172 No3 GVG – Нууцлалд хамаарах хувийн нууц

Гэрч, шинжээчийн зөвшөөрөлгүй задруулсан нь шийтгэл ногдуулдаг хувийн нууцыг хэлэлцэж байгаа бол хаалттай хуралдаан хийнэ. Зөвхөн хуульч, эмч гэх мэт нууцлалыг хариуцсан хүмүүст хамаарах хувийн нууцыг л хамгаална.

§ 172 No 4 GVG - Цөөнхийн гэрч

Өсвөр насны гэрчийг оруулсан шүүх хуралдааныг ихэвчлэн хаалттай явуулна.

§ 173 GVG - Шүүхийн шийдвэрийг олон нийтэд зарлах

(1) Гэр бүлийн маргаантай холбоотой шүүхийн шийдвэр, эцсийн шийдвэрийг зарлах нь үргэлж нээлттэй байдаг.

(2) Шүүхийн тусгай захирамжаар 171b, 172 дугаар зүйлийн дагуу шийдвэрийн шалтгаан, тэдгээрийн зарим хэсгийг нээлттэй зарлахгүй байж болно. Бусад тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд гарсан шийдвэрийг үргэлж нээлттэй зарлах ёстой. Шүүхийн шийдвэрийн үндэслэлийг олон нийтэд ил тод зарласан бол нийтэд нээлттэй бус хэсгийг аль болох ашиг сонирхлыг хамгаалах үүднээс хуулбарлах ёстой⁹⁹.


Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулбал, сэтгэцийн эмнэлэг, сэргээн засах төвд хэвтүүлэх тохиолдолд, төрийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, ёс суртахуунд аюул заналхийлж байгаа тохиолдолд, бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн тохиолдолд, эдийн засгийн нууцтай холбоотой тохиолдолд, өсвөр насны гэрчийг оруулсан тохиолдолд гэх зэргээр шүүх хуралдааныг хаалттай явуулах нөхцөлийг өргөжүүлэн зохицуулснаас гадна процессын зохицуулалтыг нарийвчлан авч үзжээ.

Бүгд Найрамдах Солонгос Улс

Ерөнхий зарчмын хувьд шүүх хурлыг олон нийт, шүүгдэгчид нээлттэй явуулах шаардлагатай байдаг. Гэхдээ шүүх хуралдааныг хаалттай явуулах тохиолдолд үүсч болдог. Энэ нь Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтуудаас үндэстэй.

Үндсэн хуулийн 109 дүгээр зүйл.

⁹⁹ Der Ausschluss der Öffentlichkeit aus Gerichtsverhandlungen, https://www.anwalt.de/rec htstipps/der-ausschluss-der-oeffentlichkeit-aus-gerichtsverhandlungen_137107.html



Шүүх хуралдаан, шүүхийн шийдвэр нээлттэй байна. Харин үндэсний аюулгүй байдал, дэг журамд халдах, ёс суртахуунд халдах эрсдэлтэй тохиолдолд шүүх хуралдааныг хаалттай явуулж болно.

Үндсэн хуулийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

Яллагдагч хүндэтгэн үзэх шалтгаан байхгүй тохиолдолд нэн даруй шүүх хурлыг нээлттэй явуулах эрхтэй.

Шүүхийг нээлттэй явуулах талаар дээрх Үндсэн хуулийн зохицуулалт нь дараах агуулгыг илэрхийлж байна.

- Шүүхийн шийдвэрийг олон нийтэд зарлах ёстой;
- Харин тодорхой шалтгаантай бол шүүхийн шийдвэрээр хаалттай явуулна;
- Шүүхийг нээлттэй явуулах нь яллагдагчийн үндсэн эрх юм.

Мөн үүнээс гадна бие даасан хуулиудад шүүх хуралдааныг нээлттэй, хаалттай явуулах талаар дараах байдлаар тусгасан.

Шүүхийн зохион байгууллагын тухай хуулийн 57 дугаар зүйл (Шүүх хуралдааныг нийтэд мэдээлэх)

1. Шүүх хуралдаан, шүүхийн шийдвэр нь нээлттэй байна. Харин үндэсний аюулгүй байдал, амгалан тайван байдал, ёс суртахууныг алдагдуулах эрсдэлтэй тохиолдолд шүүх хурлыг шийдвэрээр хаалттай явуулна.

2. 1 дэх хэсэгт заасан шийдвэрт шалтгааныг дурдсан байна.

3. 1 дэх хэсэгт заасан шийдвэр гарсан ч шүүх бүрэлдэхүүний даргалагч үлдэхийг зөвшөөрч болно.

Цэргийн шүүхийн тухай хуулийн 67 дугаар зүйл (Нийтийн шүүх хурал)

1. Шүүх хуралдаан, шүүхийн шийдвэр нээлттэй байна. Харин нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах эрсдэлтэй, цэргийн нууцыг хамгаалах шаардлагатай үед зөвхөн цэргийн шүүхийн шийдвэрээр шүүх хуралдааныг хаалттай явуулж болно.

2. 1 дэх хэсэгт заасан шийдвэрт шалтгааныг дурдсан байна.

3. 1 дэх хэсэгт заасан шийдвэр гарсан ч шүүх бүрэлдэхүүний даргалагч үлдэхийг зөвшөөрч болно.

Үүний зэрэгцээ бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн шүүх хуралдаанд зориулсан тусгай журам байдаг.

Бэлгийн гэмт хэрэгт шийтгэлийн тухай тусгай хуулийн 31 дүгээр зүйл (Сонсголыг задруулахгүй байх)

1. Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн сонсголыг хохирогчийн хувийн нууцыг хамгаалах үүднээс шийдвэрээр олон нийтэд зарлахгүй байж болно.

2. Гэрчээр дуудагдсан бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчид болон тэдний ар гэрийнхэн нь хувийн нууцыг хамгаалах зэрэг шалтгаанаар гэрчийн байцаалтыг нууцлах хүсэлт гаргаж болно.

3. 2-т заасны дагуу хүсэлтийг хүлээн авсны дараа даргалагч гэрчийг байцаах арга, байршлыг шийдэж болно.

4. 1 ба 3 дахь хэсгийн хувьд Шүүхийн зохион байгуулалтын хууль болон Цэргийн шүүхийн тухай хуулийн холбогдох зохицуулалтыг хэрэглэнэ

Тус зохицуулалттай холбогдуулан БНСУ-ын Улсын дээд шүүх шийдвэр гаргасан.

Улсын дээд шүүхийн 2013 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 2511 дүгээр шийдвэр

1. Ил болгохыг хориглох үндэслэлгүй атлаа шүүх хуралдааны явцыг задруулахыг хориглосон шийдвэр гаргасан нь шүүх хуралдааныг нээлттэй явуулах эрхийг зөрчиж байна.

2. Иймд шүүгдэгчийн шүүх хуралдааныг нээлттэй явуулах эрхийг зөрчсөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гэрчийн мэдүүлгийг нотлох баримтаар хүлээн зөвшөөрөхгүй.

3. Шүүгдэгчийн шүүх хуралдааныг нээлттэй явуулах эрхийг зөрчсөн мэдүүлэг нь өмгөөлөгийн хөндлөнгийн эрхийг баталгаажуулсан хэдий ч хүлээн зөвшөөрөх боломжгүй.

4. Ил болгохыг хориглосон шийдвэр гараагүй гэх мэт шалтгаан тодорхойгүй байхад ч хуулийн заалт үйлчилнэ.

Дээрх зохицуулалтыг нэгтгэн үзвэл дараах байдалтай байна.

- Шүүхийг нээлттэй явуулах эрх нь яллагдагчийн Үндсэн хуулиар олгогдсон эрх юм.
- Шийдвэрийг болзолгүйгээр олон нийтэд зарлах ёстой бөгөөд шалтгаантай бол шүүхийн шийдвэрээр хурлыг хаалттай явуулж болно.
- Шүүх хуралдааны нууцыг хадгалах шийдвэр гаргахын тулд шалтгааныг тодруулах ёстой.
- Шүүх хуралдааныг нууцлах үндэслэлгүй ч шүүх хурлыг хаалттай явуулж байгаа нь шүүгдэгчийн шүүх хурлыг нээлттэй явуулах эрхийг зөрчинө.
- Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хувьд гэрчээр дуудагдсан хохирогч болон түүний ар гэрийнхэн гэрчийг нууцаар байцаах хүсэлт гаргаж байгаа эсэхийг шалгаж, хохирогчийн хувийн нууцыг хамгаалах үүднээс шүүх хуралдааныг хаалттай явуулах эсэхийг тогтоодог.
- Шүүх хуралдааныг хаалттай явуулсан ч даргалагч зохих хүмүүсийг шүүх хуралдааны танхимд оруулахыг зөвшөөрч болно¹⁰⁰.

Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулбал, зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгахаас гадна бусад хуулиар зохицуулсан байна. Үндэслэлийн тухайд аюулгүй байдал, амгалан тайван байдал, ёс суртахууныг алдагдуулах, цэргийн гэмт хэрэг, бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн зарим тохиолдолд шүүх хуралдааныг хаалттай явуулахаар тусгажээ.

Иймд, хуулийн төсөл болон одоогийн эрх зүйн зохицуулалтад шүүх хуралдааныг хаалттай явуулах талаар тусгасныг өргөжүүлж төрийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, ёс суртахууны эсрэг тохиолдлыг болон бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн хохирогч, гэрч, 18 нас хүрээгүй хохирогч, гэрч, өсвөр насны шүүгдэгчийг тусгах талаар анхаарч үзэх нь зүйтэй. Мөн байгууллагын нууц болон албаны нууцын талаар шүүх хуралдааныг хаалттай явуулах нь нийтлэг жишиг биш байна. Харин эдийн засаг, бизнесийн нууцын талаар анхаарч авч үздэг байна. Албаны нууц нь өмнө дурдсанаар байгууллага бүр өөрсдийн дур зоргоор аливаа мэдээллийг нууцлах байдал бий болгодог, тодорхойгүй байдлыг үүсгэдэг учраас хуулийн төсөл болон одоогийн эрх зүйн зохицуулалтаас хасах нь зүйтэй.


3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Энэхүү шалгах хэрэгслийг хэрэглэж хуулийн төслийн үр нөлөөг үнэлснээр хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоож, тэдгээрийг арилгаж, тухайн хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулна. Энэ хүрээнд хуулийн холбогдох зохицуулалтад дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн зүйл, заалт хуулийн төслийн болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн нэр нь Эрүүгийн хэрэг хянан тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай бөгөөд энэ нь тухайн зохицуулж буй харилцаандаа хамааралтай байна.

¹⁰⁰ 재판을-비공개로-진행할-수-있는-가?, <https://leepro127.tistory.com/entry/%EC%9E%AC%ED%8C%90%EC%9D%84-%EB%B9%84%EA%B3%B5%EA%B0%9C%EB%A1%9C-%EC%A7%84%ED%96%89%ED%95%A0-%EC%88%98-%EC%9E%88%EB%8A%94%EA%B0%80>



Судалгааны зорилгод хүрэх байдал, практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгон авсан сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголтод хамаарах зохицуулалтууд нь өөр хоорондоо зөрчилдөж байна.

Учир нь хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “баривчлагдсан” гэсний дараа “эсхүл гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэж нэмэхээр тусгасан нь гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнийг сэжигтэнд хамааруулж буй зохицуулалт юм. Гэтэл хуулийн төслийн бусад гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнтэй холбоотой зохицуулалтууд нь тухайн ойлголтыг сэжигтнээс ялгаатай мэт ойлгогдох байдлаар тусгагджээ. Үүнийг судалгааны зорилгод хүрэх байдал, практикт хэрэгжих байдал хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах зохицуулалт нь харилцан уялдаатай эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөтлөх баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байна.” гэж нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан. Мөн хуулийн төслийн 1.16 дугаар зүйлд “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах” зохицуулалтыг тухайлан оруулжээ. ЭХХШТХ-ийн 1-р бүлгийн нэр нь “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго, зарчим” гэсэн байх бөгөөд энэ бүлэгт дээрх байдлаар шинэ зүйл нэмж оруулсан нь тохиромжгүй байна. Учир нь 1.6-1.15 дугаар зүйл нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмуудыг агуулж байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах гэдэг нь процессын зарчим биш бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэл, бичигт мөн хамаарахгүй юм. Иймд 11.11 дүгээр зүйл буюу хавтаст хэргийн зохицуулалтад хамааруулан хуульчлах шаардлагатай.

Гадаадын эрх зүйн өндөр хөгжилтэй зарим улс, орнуудын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг цахимаар явуулах, цахим хавтаст хэргийн зохицуулалтыг авч үзвэл ихэвчлэн процессын хуулийн хавтаст хэрэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын хүрээнд тусгасан болохыг анхаарах нь зүйтэй. Тухайлбал, ХБНГУ-ын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”¹⁰¹, ХБНГУ-ын Хамбург мужийн “Хамбург мужийн шүүхүүд дэх цахим хавтаст хэргийн удирдлагын тухай журам”¹⁰², Бүгд Найрамдах Эстони Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”¹⁰³-д цахим хавтаст хэрэг болон түүний зохион байгуулалттай холбоотой зохицуулалтад үүнийг хамааруулан тусгажээ.

¹⁰¹ ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Strafprozeßordnung – StPO, 1987)

¹⁰² Elektronische Akte in der Justiz, 2024.02.28, <https://justiz.hamburg.de/e-justice/elektronische-akte-in-der-justiz-zuletzt-besucht> 2024.03.20.

¹⁰³ БНЭсУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Kriminaalmenetluse seadustik, 2003) <https://www.riigiteataja.ee/akt/104102013004>

ДӨРӨВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Тус судалгааны хүрээнд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ төслийн зохицуулалт, агуулга нь өөрчлөлтийн үзэл баримтлал, зорилгод нийцэж буй эсэх, зохион байгуулалтыг өөрчилж буй зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх, шинээр тусгагдсан зохицуулалтууд нь хүлээн зөвшөөрөгдсөн эсэх, хуулийн төсөл нь хууль зүйн техникийн хувьд алдаатай эсэхэд дүн шинжилгээ хийсэн бөгөөд дараах дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.


1.Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах, ялангуяа цахим хавтаст хэргийг бий болгох, цахим нотлох баримтын талаар зохицуулах нь одоогийн хэрэгцээ, шаардлагад нийцэхүйц байна. Өөрөөр хэлбэл орчин үед цахим хөгжил эрчимтэй явагдаж буй энэ үед эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох, хялбарчлах, хэмнэлттэй, үр дүнтэй байх ач холбогдлыг бий болгож байна. Хуулийн төслийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 1.16 дугаар зүйл, 11.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг болон бусад цахимжуулахтай холбоотой зохицуулалт нь тус хэрэгцээ, шаардлага, зорилгод нийцэж буй боловч цахим нотлох баримтыг хуулийн төсөлд тусгаж нарийвчлан зохицуулаагүйгээрээ нэмэлт, өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлага, зорилгод нийцэхгүй байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд цахим нотлох баримтын талаар нарийвчлан зохицуулах шаардлагатай.

Хуулийн төсөлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах талаар тусгасан нь зорилгод нийцэхээс гадна цахим хэлбэртэй байхаас гадна цаасан хэлбэртэй байхаар тусгасан нь зорилгод нийцэж байна. Учир нь 2020 онд батлагдсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу цаасан болон цахим суурьтай байх нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийн шаардлага юм. Түүнчлэн зохицуулалтын практик хэрэгжилт бий болох хүртэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийн найдвартай байдлыг хангах хөшүүрэг болохоор байна.

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэж ЭХХША-ны нэг субъектыг ялгамжтай байдлаар тусгаж хуульчлах нь хуулийн нэр томъёог нэг мөр ойлгон хэрэглэх, ойлгомжтой байдал, хууль хоорондын уялдаа холбоог хангахад сөргөөр нөлөөлөхөөр байна. Иймд одоо байгаа хуулийн зохицуулалт буюу сэжигтэнтэй холбоотой зохицуулалтаа засаж сайжруулах, эрх зүйн хийдлийг арилгахад чиглэсэн зохицуулалтуудыг хуулийн төсөлд тусгаж, сэжигтэнг тодорхойлон хуульчлах нь илүү оновчтой байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон хуулийн төсөлд “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн”-ий эрх, үүргийн талаар тусад нь зохицуулаагүй. Дээр дурдсанчлан хуулийн төслийн 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн сэжигтэнд хамаарч байгаа учир сэжигтний адил эрх эдлэхээр байна. Гэтэл хуулийн төслийн бусад зохицуулалтад сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголтыг өөр хоорондоо ялгаатай мэтээр тусгаснаас үзвэл гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн сэжигтний хуульд заасан эрхийг түүнтэй адил эдлэх эсэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрхэн явуулах нь ойлгомжгүй байна.



Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголт одоогийн ЭХХШТХ-д заасан сэжигтнээс илүү тухайн гэмт хэргийг үйлдсэн болох нь нотлогдож байгаа хүнийг тодорхойлсон байна. Нөгөөтээгүүр, “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэдгийг сэжигтнээс ялгамжтай байдлаар тусгасны ач холбогдол хуулийн төслөөс харагдахгүй байгааг дурдах нь зүйтэй.

- Хуулийн төсөлд шүүх хуралдааныг үндэслэлгүйгээр хойшлуулж байгаатай холбоотойгоор өмгөөлөгчид хариуцлага тооцох, шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулахгүй байх, прокурор шүүхээс тогтоосон хугацаанд даалгаврыг биелүүлэх боломжгүй бол дахин сунгах зэрэг зохицуулалтыг тусгасан нь хуулийн төслийн өөрчлөлтийн зорилго, үзэл баримтлалд нийцэж байна. Мөн түүнчлэн практик судалгааны үр дүнд тогтоосон асуудлыг шийдэхэд ач холбогдолтой тул зорилгодоо нийцсэн гэж үзэхээр байна.


2.Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Хуулийн төсөлд тусгагдсан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах талаар зохицуулалтыг дэлгэрүүлж нарийвчлан зохицуулах шаардлагатай. Гадаадын эрх зүйн өндөр хөгжилтэй зарим улс, орнуудын зохицуулалтыг авч үзвэл цахим баримт бичиг, хавтаст хэргийг цугт нь нарийвчлан зохицуулах жишиг тогтсон байна. ХБНГУ-ын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль” -д цахим хавтаст хэргийн удирдлага, түүнтэй холбоотой хуульд заасан арга хэмжээ авах бүрэн эрх, Прокурорын байгууллагууд болон шүүхүүдийн цахим харилцаа холбоо; хуульд заасан арга хэмжээ авах бүрэн эрх, прокурорын байгууллага, шүүхийн ашиглаж буй цахим баримт бичгийг бүрдүүлэх, дамжуулах; хуульд заасан арга хэмжээ авах эрх, Цахим хэлбэр; хуульд заасан арга хэмжээ авах эрх, цахим хавтаст хэрэг дэх хувийн мэдээллийг ашиглах, ХБНГУ-ын Хамбург мужийн “Хамбург мужийн шүүхүүд дэх цахим хавтаст хэргийн удирдлагын тухай журам” -д цахим хавтаст хэргийн хөтлөх журам, цахим хавтаст хэрэг үүсгэх, цаасан баримт бичгийг цахим хэлбэрт хувиргах, цахим хавтаст хэргийг дамжуулах, Бүгд Найрамдах Эстони Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль” -д цахим (дижитал) баримт бичгийг дамжуулах, цахим хавтаст хэргийг боловсруулах мэдээллийн систем, БНСУ-ын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хууль”-д "цахим хавтаст хэрэг", "цахимжуулсан хавтаст хэрэг" гэх нэр томъёог нарийвчлан тодорхойлсноос гадна эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим баримт бичгээр гүйцэтгэх, компьютержсэн мэдээлэл боловсруулах системийг ажиллуулах, цахим баримт бичгийг хүлээн авах, цахим баримт бичгийг бэлтгэх, цахим баримт бичгийг үзэх, хуулбарлах, цахим баримт бичгийг устгах зэрэг зохицуулалтыг тухайлан зохицуулсан байна.

Үүнээс гадна тус хуулийн төсөлд цахим нотлох баримтыг тодорхойлж, холбогдох зохицуулалтыг нарийвчлан тусгаагүй байна. Олон улсын гэрээ, конвенц, гадаадын эрх зүйн өндөр хөгжилтэй зарим улс, орнуудын зохицуулалтыг авч үзвэл цахим нотлох баримтыг тухайлан хуульчилж, нарийвчлан зохицуулсан жишиг бий болоод байна. Иймд тус хуулийн төсөлд цахим нотлох баримтыг тодорхойлон хуульчилж нарийвчлан зохицуулах хэрэгтэй.

3.Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- ЭХХШТХ-ийн 25.1 дүгээр зүйлд “Мэдүүлэг авах” зохицуулалтыг хуульчилсан бөгөөд төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэгт “Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнийг гэрчээр дуудан ирүүлэхийг хориглоно” гэж заасан нь хуулийн 25.1 дүгээр зүйлд хамаарахгүй байна. Иймд төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь заалтыг хамаарал бүхий ЭХХШТХ-ийн холбогдох зүйл, заалтад нэмж тусгах нь зүйтэй.



- Төслийн 2 дугаар зүйлд 7.3 дугаар зүйлийн “танилцах,” гэсний дараа “хувийг авах” гэж нэмэхээр тусгажээ. Гэвч ЭХХШТХ-ийн 7.3 дугаар зүйлийн аль хэсэгт заасан “танилцах” гэсний дараа “хувийг авах” гэж нэмэхийг орхигдуулан бичжээ. Иймд төслийн 2 дугаар зүйлд заасан 7.3 дугаар зүйлийн “танилцах” гэсний дараа “хувийг авах” гэснийг 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “танилцах” гэсний дараа “хувийг авах” гэж өөрчлөх.

- Төслийн 2 дугаар зүйлд 14.13 дугаар зүйлийн “прокурор” гэсний дараа “яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч” гэж нэмэхээр тусгажээ. Гэвч ЭХХШТХ-ийн 14.13 дугаар зүйл нь 12 хэсгээс бүрдэж байх бөгөөд энэхүү 12 хэсгийн аль хэсэг дэх “прокурор” гэсний дараа “яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч” гэж нэмэх нь ойлгомжгүй байна. Иймд хэсгийн дугаарыг ойлгомжтой байдлаар тусгах.

- Төслийн 2 дугаар зүйлд 34.1 дүгээр зүйлийн “болохгүй.” гэсний дараа “Шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй нь шүүх хуралдаан хойшлуулах үндэслэл болохгүй” гэж нэмэхээр тусгажээ. Гэвч төсөлд 34.1 дүгээр зүйлийн хэд дэх хэсэгт заасан “болохгүй.” гэсний дараа нэмж оруулахаар заагаагүй байна. Харин ЭХХШТХ-ийн 34.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “болохгүй.” гэх үг тусгагдсан байна. Иймд төслийн 34.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “болохгүй.” гэсний дараа “Шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй нь шүүх хуралдаан хойшлуулах үндэслэл болохгүй” гэж өөрчлөх.


- Төслийн 4 дүгээр зүйлд 5.1 дүгээр зүйлийн 2.10-2.15 дахь заалтын дугаарыг 2.12-2.16 гэж өөрчлөх талаар тусгажээ. Гэвч 2.10-2.15-д нийт 6 заалт хамаарч байх бөгөөд 2.12-2.16 гэж өөрчилснөөр нийт 5 зохицуулалтын дугаарыг өөрчлөхөөр тусгаж, нэг зохицуулалтын дугаарыг орхигдуулсан байна. Иймд төслийн 4 дүгээр зүйлд заасан 5.1 дүгээр зүйлийн “2.10-2.15 заалтын дугаарыг 2.12-2.16 гэж” гэсний орхигдуулсан дугаарыг оруулж “2.10-2.15 дахь заалтын дугаарыг “2.12-2.17” гэж өөрчлөх.

- Төслийн 4 дүгээр зүйлд заасан 32.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “тэдний өмгөөлөгчид” гэснийг “тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид” гэж өөрчлөх талаар тусгажээ. Гэвч ЭХХШТХ-ийн 32.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Мөрдөгч мөрдөн шалгах бүх ажиллагааг хийж дууссан, хэргийн бодит байдлыг бүрэн нотолж тогтоосон гэж үзвэл яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид хавтаст хэргийн материалтай танилцахыг мэдэгдэнэ.” гэж заасан. Өөрөөр хэлбэл, ЭХХШТХ-д оруулахаар тусгасан өөрчлөлт нь энэ хуулийн зохицуулалттай ижил байна. Иймд тус зохицуулалтыг хасах.

4.Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Практикт шүүхийн шийдвэрээр тухайн хэрэгт хураагдан ирсэн эд мөрийн баримтыг цаашид хадгалах эсэхийг хэрхэн шийдвэрлэснээс хамаарч нотлох баримтыг хадгалах эсхүл устгах арга хэмжээг авдаг. Цахим нотлох баримтын хувьд практикт ихэвчлэн CD дээр хуулбарлан хавтаст хэрэгт хавсаргадаг бөгөөд энэ нь тухайн хавтас хэргийг хадгалах хугацаатай ижил хугацаанд хадгалагдаж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын талаар зохицуулалтыг нэг мөр болгон хуульчилж дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын талаар тогтсон зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

Мөн хуулийн төслийн тухайд Хувийн мэдээллийг автоматаар боловсруулахтай холбоотой хувь хүнийг хамгаалах тухай Европын зөвлөлийн конвенцийн 5 дугаар зүйлийн е хэсэгт агуулгыг таних боломжтой хэлбэрээр хадгалагдсан өгөгдлийг тухайн өгөгдлийг хадгалах зорилгод шаардагдах хугацаанаас илүүгээр хадгалж болохгүй талаар зохицуулсан байгааг харгалзан бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний




бичлэгийн зорилгыг сайтар авч үзэх хэрэгтэй. Мөн БНСУ-д хэргийн төрлөөс хамааруулан баримт бичгийг жилээр, цаашлаад хөөн хэлэлцэх хугацааг дуусах хүртэл хадгалдаг болохыг харгалзан үзэх хэрэгтэй. Мөн түүнчлэн нотлох баримт, эд мөрийн баримтын хадгалалт, хамгаалалтын талаар нэгдсэн журам боловсруулан гаргах шаардлагатай болохыг анхаарах нь зүйтэй.

- Хуулийн төсөлд төрийн болон албаны нууц мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэр, прокурорын яллах дүгнэлтийг прокурор, оролцогчид гардуулах, танилцуулах талаар, хүний хувийн мэдээлэл, эмзэг мэдээлэл агуулсан шүүх хуралдааны талаар нарийвчлан зохицуулсан хэдий ч талуудын нотлох баримт, баримт бичигтэй танилцах эрх, ашгийг хамгаалах талаар өргөнөөр хязгаарласан байна. Тодруулбал, Төслийн 32.10 дугаар зүйлд 9 дэх хэсэгт төрийн нууцтай холбоотой хэргийн яллах дүгнэлтийг бүрэн бодитой танилцуулж, төрийн нууц мэдээлэл агуулсан хэсгийг хассан хувийг гардуулан өгөхөөр тусгасан нь яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн нотлох баримт, баримт бичигтэй танилцах эрх, ашгийг зөрчих боломжид хүргэж болох юм. Учир нь бүрэн бодитой танилцах нь тухайн талын нөхцөл байдлаас хамаарч өөр байж болох ба яллах дүгнэлтийг бүхэлд нь гардан аваагүйн улмаас түүний эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх магадлалтай. Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллагдагч ямар хэрэгт яллагдаж байгаага мэдэх эрхтэй. Иймд тус эрхүүдийг өргөнөөр ийнхүү хязгаарлахын оронд яллах дүгнэлттэй танилцах, гардан авах яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид нууц задруулахгүй байх үүргийг хүлээлгэх нь зүйтэй юм.

Мөн тус төслийн 36.13 дугаар зүйлийн 5,6 дахь хэсэгт төрийн нууц мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийн “Тодорхойлох”, “Удиртгал”, “Тогтоох” хэсэгт төрийн нууц агуулсан мэдээлэл агуулагдсан бол гардуулахгүйгээр, шүүхийн шийдвэрийг бүрэн бодитой танилцуулах арга хэмжээ авахаар зохицуулжээ. Энэ нь өмнө дурдсан талуудын нотлох баримт, баримт бичигтэй танилцах эрх, ашгийг зөрчих боломжид хүргэхээс гадна шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг өргөнөөр хязгаарлах нөхцөл байдал үүсгэх юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт зааснаар “...шүүхийн шийдвэрийг давж заалдах...” иргэний үндсэн эрхийг тусгасан ба үүнийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар баталгаажуулж 38.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, тэдгээрийн өмгөөлөгч шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэй.” гэж тусгасан байдаг. Иймд тус эрхүүдийг өргөнөөр хязгаарлахын оронд шүүхийн шийдвэртэй танилцах, гардан авах талуудад нууц задруулахгүй байх үүргийг хүлээлгэн давж заалдах эрхийг хангах талаар авч үзэх хэрэгтэй.

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.4 дүгээр зүйлд шүүх хуралдаан хаалттай явуулах зохицуулалтыг хуульчилсан байсныг тус нэмэлт, өөрчлөлтөөр 3.2 дугаар зүйлд давхардуулан хуульчилсан байна. Тухайлбал, шүүх хуралдаан хаалттай явуулах нөхцөл байдлыг хуульчилсан байсныг дахин тодорхойлж хүний эмзэг мэдээллээс бусад хувийн мэдээлэл болон байгууллагын нууц мэдээлэлд хамаарч байвал мэдээллийн эзэн буюу хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр хаалттай явуулахыг тодорхойлсон байна. Харин мэдээллийн эзэн зөвшөөрсөн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагаан дахь хүний эмзэг мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод байлгаж болох зохицуулалт болон хаалттай шүүх хуралдааны явцад илэрхий болсон төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний хувийн мэдээллийг шүүгч, шүүх хуралдаанд оролцогч задруулж болохгүй талаар зохицуулалт нь давхцаагүй хэдий ч 3.2 дугаар зүйлд бус 34.4 дүгээр зүйлд тусгагдах нь зохимжтой байна.



Гадаадын эрх зүйн өндөр хөгжилтэй зарим улс, орнуудын жишгийг авч үзвэл, сэтгэцийн эмнэлэг, сэргээн засах төвд хэвтүүлэх тохиолдолд, төрийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, ёс суртахуунд аюул заналхийлж байгаа тохиолдолд, бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн тохиолдолд, эдийн засгийн нууцтай холбоотой тохиолдолд, өсвөр насны гэрчийг оруулсан тохиолдолд гэх зэргээр шүүх хуралдааныг хаалттай явуулах нөхцөлийг өргөжүүлэн зохицуулснаас гадна процессын зохицуулалтыг нарийвчлан авч үзсэн нь сайн жишиг болж байна. Иймд хуулийн төсөлд тус үндэслэлүүдээс тусгах эсэхийг шийдвэрлэх шаардлагатай.

Мөн байгууллагын нууц болон албаны нууцын талаар шүүх хуралдааныг хаалттай явуулах нь нийтлэг жишиг биш байна. Харин эдийн засаг, бизнесийн нууцын талаар анхаарч авч үздэг байна. Албаны нууц нь өмнө дурдсанаар байгууллага бүр өөрсдийн дур зоргоор аливаа мэдээллийг нууцлах байдал бий болгодог, тодорхойгүй байдлыг үүсгэдэг учраас хуулийн төсөл болон одоогийн эрх зүйн зохицуулалтаас хасах нь зүйтэй.

5.Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “баривчлагдсан” гэсний дараа “эсхүл гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэж нэмэхээр тусгасан нь гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнийг сэжигтэнд хамааруулж буй зохицуулалт юм. Гэтэл хуулийн төслийн бусад гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнтэй холбоотой зохицуулалтууд нь тухайн ойлголтыг сэжигтнээс ялгаатай мэт ойлгогдох байдлаар тусгагджээ. Иймд тус зохицуулалтыг засварлах шаардлагатай.

- Хуулийн төслийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөтлөх баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байна.” гэж нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан. Мөн хуулийн төслийн 1.16 дугаар зүйлд “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах” зохицуулалтыг тухайлан оруулжээ. ЭХХШтХ-ийн 1-р бүлгийн нэр нь “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго, зарчим” гэсэн байх бөгөөд энэ бүлэгт дээрх байдлаар шинэ зүйл нэмж оруулсан нь тохиромжгүй байна. Учир нь 1.6-1.15 дугаар зүйл нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмуудыг агуулж байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах гэдэг нь процессын зарчим биш бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэл, бичигт мөн хамаарахгүй юм. Иймд 11.11 дүгээр зүйл буюу хавтаст хэргийн зохицуулалтад хамааруулан хуульчлах шаардлагатай. Гадаадын эрх зүйн өндөр хөгжилтэй зарим улс, орнуудын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг цахимаар явуулах, цахим хавтаст хэргийн зохицуулалтыг авч үзвэл ихэвчлэн процессын хуулийн хавтаст хэрэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын хүрээнд тусгасан болохыг анхаарах нь зүйтэй.



ТАВ. СУДАЛГААНЫ ЭХ СУРВАЛЖ


Хууль тогтоомж

Монгол хэлээр:

1. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992, №1;
2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2020, №29;
3. Төрийн болон албаны нууцын тухай хууль, 2016;
4. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, 2021;
5. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, 2021;
6. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №9;
7. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №8;
8. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2021, №5;
9. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №23;
10. Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
11. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
12. Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 5 сарын 18-ны өдрийн А/24 тушаалаар баталсан “Цахим үндэстэн” баримтлах чиглэл (2022-2027);
13. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 332 дугаар тогтоол;
14. 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол, Дугаар 31, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар;
15. 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн УДШ-ийн Ерөнхий шүүгч, ХЗДХ-ийн Сайд, УЕП-ын хамтарсан Дугаар А/18, 34, А/31 “Заавар батлах тухай”;
16. 2019 оны 12 сарын 5-ны өдрийн Дугаар 246, А/80 Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан захирамж, тушаал;
17. 2022 оны 1 сарын 6-ны өдрийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоол Дугаар 1 “Журам батлах тухай”
18. Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны 5 сарын 20-ны өдрийн А/69 дугаар тушаал;
19. Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2022 оны 4 сарын 15-ны өдөр дугаар А/42 тушаал
20. 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол, Дугаар 31, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар

Гадаад хэлээр:

1. Шүүх байгууллагын цахим үйл ажиллагааг дэмжих тухай хууль (Gesetz zur Förderung des elektronischen Rechtsverkehrs mit den Gerichten, 2013)
2. Gesetzentwurf der Bundesregierung BT-Drucksache 17/12634 vom 6. März 2013, S. 3 ff, Verfügbar um <https://dserver.bundestag.de/btd/17/126/1712634.pdf>

- 
3. ХБНГУ-ын Шүүхийн үйл ажиллагаанд цахим хавтаст хэргийг нэвтрүүлэх, цаашид цахим хууль зүйн үйл ажиллагааг дэмжих тухай хууль (Gesetz zur Einführung der elektronischen Akte in der Justiz und zur weiteren Förderung des elektronischen Rechtsverkehrs, 2017).
 4. Beschlussempfehlung und Bericht des Ausschusses für Recht und Verbraucherschutz (6. Ausschuss) zu dem Gesetzentwurf der Bundesregierung, Deutscher Bundestag, Drucksache 18/12203, Wahlperiode 28.04.2017. Verfügbar um <https://dserver.bundestag.de/btd/18/122/1812203.pdf>
 5. ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Strafprozeßordnung – StPO, 1987)
 6. БНЭсУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Kriminaalmenetluse seadustik, 2003) <https://www.riigiteataja.ee/akt/104102013004>
 7. Framework act on electronic documents and transactions of Korea, https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=27334&type=part&key=28
 8. Framework act on electronic documents and transactions of Korea, https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=27334&type=part&key=28
 9. Act on the Use of Electronic Documents in Criminal Judicial Procedures [Enforced into force on October 20, 2024] [Law No. 18485, enacted on October 19, 2021], [https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EC%82%AC%E C%82%AC%EB%B2%95%EC%A0%88%EC%B0%A8%EC%97%90%EC%84%9C %EC%9D%98%EC%A0%84%EC%9E%90%EB%AC%B8%EC%84%9C%EC%9D% B4%EC%9A%A9%EB%93%B1%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2 %95%EB%A5%A0/\(18485,20211019\)](https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EC%82%AC%E C%82%AC%EB%B2%95%EC%A0%88%EC%B0%A8%EC%97%90%EC%84%9C %EC%9D%98%EC%A0%84%EC%9E%90%EB%AC%B8%EC%84%9C%EC%9D% B4%EC%9A%A9%EB%93%B1%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2 %95%EB%A5%A0/(18485,20211019))
 10. Regulation (EU) 2023/1543 of the European Parliament and of the Council of 12 July 2023 on European Production Orders and European Preservation Orders for electronic evidence in criminal proceedings and for the execution of custodial sentences following criminal proceedings, https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv%3AOJ.L_.2023.191.01.0118.01.ENG
 11. Directive (EU) 2023/1544 of the European Parliament and of the Council of 12 July 2023 laying down harmonised rules on the designation of designated establishments and the appointment of legal representatives for the purpose of gathering electronic evidence in criminal proceedings, https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv%3AOJ.L_.2023.191.01.0181.01.ENG
 12. Details of Treaty No.185, <https://www.coe.int/en/web/conventions/full-list?module=treaty-detail&treaty-num=185>
 13. Convention on Cybercrime Budapest, 23.XI.2001, <https://rm.coe.int/1680081561>
 14. United Nations Convention against Transnational Organized Crime and the Protocols Thereto, <https://www.unodc.org/unodc/en/organized-crime/intro/UNTOC.html>
 15. Manual on the Effective Investigation and Documentation of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, https://www.ohchr.org/sites/default/files/documents/publications/2022-06-29/Istanbul-Protocol_Rev2_EN.pdf
 16. Convention for the Protection of Individuals with regard to Automatic Processing of Personal Data Strasbourg, 28.I.1981, <https://rm.coe.int/1680078b37>
 17. Convention for the Protection of Individuals with regard to Automatic Processing of Personal Data Strasbourg, 28.I.1981, <https://rm.coe.int/1680078b37>
 18. CRIMINAL PROCEDURE ACT OF KOREAN [Enforcement Date 09. Dec, 2021.] [Act No.17572, 08. Dec, 2020., Partial

Amendment], <https://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2§ion=lawNm&query=criminal+procedure&x=0&y=0#iBgcolor1>

19. Prosecutor's Office Preservation Rules Partially revised 2021-01-01 Ministry of Justice Ordinance No. 993 amendment, <http://www.yeslaw.com/lms/front/page/fulltext.html?pAct=view&pLawId=2408#:~:text=%E2%91%A0%20%EC%A7%84%EC%A0%95%EC%82%AC%EA%B1%B4%EA%B8%B0%EB%A1%9D%EC%9D%80,%EC%9D%80%203%EB%85%84%EA%B0%84%20%EB%B3%B4%EC%A1%B4%ED%95%9C%EB%8B%A4>

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол хэлээр:

1. 2023 оны 3 сарын 23-24-ний өдөр зохион байгуулагдсан “Монгол Улсын Шүүхийн цахимжуулалт” ОУБХ-д ЦХХХ-ны дэд сайд Ж.Эрхэмбаатарын хэлэлцүүлсэн “Монгол Улсын шүүхийн болон хуулийн байгууллагуудыг цахимжуулах мэдээлэл технологийн үүрэг” сэдэвт илтгэл
2. ГХУСЗ, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном, УБ, 2022, 2023, 86 дахь тал.
3. 2023 оны 3 сарын 23-24-ний өдөр зохион байгуулагдсан “Монгол Улсын Шүүхийн цахимжуулалт” ОУБХ-д Н.Отгончимэгийн хэлэлцүүлсэн “Шүүхийн санхүүжилтийн механизмыг шинэчлэх шаардлага” сэдэвт илтгэл
4. Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын төсөлд хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ /Хөндлөнгийн судалгаа/, УБ, 2023
5. Л.Галбаатар, Кибер гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх нь, УБ, 2015
6. ННФ, Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа /Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд/, УБ, 2022
7. Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (Кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа, УБ., 2019
8. Монгол Улсад үйлдэгдэж байгаа кибер гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, түүнтэй тэмцэх арга зам, үндсэн чиглэл /Суурь судалгааны тайлан/, УБ, 2015
9. Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (Кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа, УБ, 2019
10. Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын төсөлд хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ /Хөндлөнгийн судалгаа/, УБ, 2023
11. Нотолгооны өнөөгийн практик, арга зүй, техник хэрэгсэл, анхаарах асуудал /Судалгааны тайлан/, ННФ, УБ., 2021
12. Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хуулийн шүүмж, Цуврал 22, УБ, ННФ, 2018
13. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь өмгөөлөгчийн оролцооны эрх зүйн асуудал, ННФ, УБ, 2024
14. Б.Өнөрмаа, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “оролцогч биш” оролцогч буюу “сэжигтний” талаарх зохицуулалтын ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн /stop/ зохицуулалттай харьцуулах нь”, Хууль дээдлэх ёс сэтгүүл, УБ, 2019, №1, (71)

Гадаад хэлээр:

1. Manual on the Effective Investigation and Documentation of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment,

https://www.ohchr.org/sites/default/files/documents/publications/2022-06-29/Istanbul-Protocol_Rev2_EN.pdf

2. European Judicial Network, Fiches Belges on electronic evidence Germany. Available at <https://www.ejn-crimjust.europa.eu/ejnupload/DynamicPages/FB-EEGermany.pdf>
3. Эрик Хилгендорф, “Цахим нотлох баримт танилцуулга” сургалтын орчуулга, 2023.09.15
4. Eneli Lauritis, “Criminal procedure and digital evidence in Estonia”, Digital Evidence and Electronic Signature Law Review, 13 (2016)
5. Digital Evidence and the U.S. Criminal Justice System: Identifying Technology and Other Needs to More Effectively Acquire and Utilize Digital Evidence. Sean E. Goodison, Robert C. Davis, and Brian A. Jackson. <https://www.ojp.gov/pdffiles1/nij/grants/248770.pdf>

Цахим эх сурвалж

Монгол хэлээр:

1. Г.Даваадорж: Шүүхийн цахимжилтад хууль эрх зүйн орчин ус агаар мэт хэрэгтэй байна, https://www.judcouncil.mn/site/news_full/13818
2. Цахим орчин дахь гэмт хэргийн ул мөрийг баримтжуулж авах нь, <https://www.mnb.mn/i/92447>
3. М.Бямбасүрэн, Цахим баримт бичгийг нотлох баримтын хэмжээнд үнэлдэг байх шаардлагатай нийтлэл, 2024.01.29, <https://business.mn/2024/01/29/m-byambasuren-tsahim-barimt-bichgiig-notloh-barimtiin-hemjeend-uneldeg-baih-shaardlagatai/>
4. Ш.Мөнхжаргал, Л.Уянга, Б.Нямцэрэн нар, Нотлох баримт, түүнийг үнэлэхтэй холбоотой эрх зүйн эх сурвалжуудыг судалж бичсэн, асуудал дэвшүүлсэн өгүүлэл, <https://legaldata.mn/buteel/pdf?id=1761>
5. “Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”, “Хавтаст хэргийг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх журам” <http://old.supremecourt.mn/act/view/266>
6. Шинэ хуулиар сэжигтэн гэх ойлголт үгүй болно нийтлэл, 2015.05.06, <https://gogo.mn/r/qo8v7>

Гадаад хэлээр:

1. Beschlussempfehlung und Bericht des Rechtsausschusses zu dem Gesetzentwurf der Bundesregierung Drucksache 17/12634 – vom 12. Juni 2013, Verfügbar um <https://dserver.bundestag.de/btd/17/139/1713948.pdf>
2. Verordnung über die elektronische Aktenführung in der Hamburger Justiz (HmbEAktFVO, 2019) Verfügbar um <https://www.landesrecht-hamburg.de/bsha/document/jlr-JElektAktfVHAV9Anlage1/part/X>
3. Elektronische Akte in der Justiz, 2024.02.28, <https://justiz.hamburg.de/e-justice/elektronische-akte-in-der-justiz-zuletzt-besucht-2024.03.20>.
4. Factsheet E-Justice. Available at <https://e-estonia.com/wp-content/uploads/2020mar-facts-a4-v04-e-justice.pdf>
5. БНЭСУ-ын Шүүхийн мэдээлийн системийн, <https://www.rik.ee/en/international/court-information-system>
6. БНЭСУ-ын Шүүхийн олон нийттэй харилцах порталын вебийн <https://www.rik.ee/en/international/public-e-file>

- 
7. Electronic Filing in Criminal Actions and Proceedings: A REPORT TO THE GOVERNOR, LEGISLATURE AND CHIEF JUDGE, page 10
https://ww2.nycourts.gov/sites/default/files/document/files/2018-06/eFile_Criminal_Report%20April%2019.pdf
 8. Electronic Filing (CM/ECF), <https://www.uscourts.gov/court-records/electronic-filing-cmecf>
 9. Electronic Filing in Criminal Actions and Proceedings: A REPORT TO THE GOVERNOR, LEGISLATURE AND CHIEF JUDGE, page 8
https://ww2.nycourts.gov/sites/default/files/document/files/2018-06/eFile_Criminal_Report%20April%2019.pdf
 10. 미리 보는 형사전자소송, https://help.scourt.go.kr/nm/min_9/min_9_9/index.html
 11. E-evidence - cross-border access to electronic evidence Improving cross-border access to electronic evidence, https://commission.europa.eu/law/cross-border-cases/judicial-cooperation/types-judicial-cooperation/e-evidence-cross-border-access-electronic-evidence_en
 12. European Judicial Network, Fiches Belges on electronic evidence Estonia. Available at <https://www.ejn-crimjust.europa.eu/ejnupload/DynamicPages/EE%20electronic%20evidence%20fb.pdf>
 13. 형사절차상 digital evidence에 관한 연구 - 압수, 수색을 중심으로 - Digital Evidence in Criminal Procedure, pp.21, https://www.kicj.re.kr/boardDownload.es?bid=0001&list_no=9714&seq=1
 14. 형사절차상 digital evidence에 관한 연구 - 압수, 수색을 중심으로 - Digital Evidence in Criminal Procedure, pp.21, https://www.kicj.re.kr/boardDownload.es?bid=0001&list_no=9714&seq=1
 15. 전문법칙 관련 비디오테이프 등의 증거능력, <https://blog.naver.com/duckhee2979/220751969840>
 16. 성폭행피해아동의 진술녹화 비디오테이프의 증거능력, <https://www.lawtimes.co.kr/news/104776>
 17. 증거보전, <https://namu.wiki/w/%EC%A6%9D%EA%B1%B0%EB%B3%B4%EC%A0%84>
 18. What is a Closed Court? Ashley Chung, <https://obriensolicitors.com.au/what-is-a-closed-court/>
 19. Der Ausschluss der Öffentlichkeit aus Gerichtsverhandlungen, https://www.anwalt.de/rec htstipps/der-ausschluss-der-oeffentlichkeit-aus-gerichtsverhandlungen_137107.html
 20. 재판을-비공개로-진행할-수-있는가?, <https://leepro127.tistory.com/entry/%EC%9E%AC%ED%8C%90%EC%9D%84-%EB%B9%84%EA%B3%B5%EA%B0%9C%EB%A1%9C-%EC%A7%84%ED%96%89%ED%95%A0-%EC%88%98-%EC%9E%88%EB%8A%94%EA%B0%80>



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

“ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН”

/Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл/

ЗАХИАЛАГЧ: ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ



2024 оны X сар

Судалгааг хянасан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

Судалгааг удирдсан:

М.Түвшинжаргал

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн
нарийн бичгийн дарга, хууль зүйн ухааны
доктор

Судалгааг гүйцэтгэсэн:

М.Ганди

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хувийн эрх
зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан

Г.Болор-Эрдэнэ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хувийн эрх
зүйн секторын Эрдэм шинжилгээний ажилтан

Агуулга

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	4
НЭГ. УДИРТГАЛ	5
ХОЁР. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО	7
2.1. Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох	8
2.2. Хүний нөөцийг тодорхойлох	9
2.3. Гарах зардлыг урьдчилан тооцох	12
2.4. Үр дүнг тооцох	13
2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.....	14
2.5.1.Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;	14
2.5.2.Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;	15
2.5.3.Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;	15
2.5.4.Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;.....	15
2.5.5.Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх;	15
ГУРАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ	16

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Зардалд нөлөөлөх зүйл заалт	7
Хүснэгт 2. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь	8
Хүснэгт 3. Стандарт үйл ажиллагаа холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ	9
Хүснэгт 4. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал	11
Хүснэгт 5. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал.....	12
Хүснэгт 6. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардал.....	13
Хүснэгт 7. Нийт зардал	14

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

**/ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ/**

НЭГ. УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго 5-ын зорилт 5.1-т заасан эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд “5.1.9 Шүүх үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлж, үйл ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй болгоно” гэж; мөн зорилт 7.4-т заасан Хууль сахиулах салбарын эрх зүйн орчныг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжих, ажиллах нөхцөлийг сайжруулах, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлэх ажиллагааны хүрээнд “7.4.5. ... шүүхийн шийдвэр гүйцэтгэх, ... байгууллагуудын харилцан хамтын ажиллагааны шуурхай байдлыг хангана.” гэж тус тус засжээ.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 18 дугаар тогтоолын 1-д хүний эрхийг хангахтай холбоотой 14 асуудлыг судалж, холбогдох хуулийн төслийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн боловсруулж 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасныг хэрэгжүүлэхээр “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулжээ.

Хуулийн төслөөр Хүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл байгаа бол түүнийг гэрчээр дуудах, эсхүл түүнээс гэрчийн мэдүүлэг авахгүй байх, гэрчийн мэдүүлэг авах үед түүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрсэн бол гэрчийн мэдүүлэг авахыг даруй зогсоох зохицуулалтын талаар; Хүний халдашгүй байх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хүрээнд мөрдөн байцаалтыг өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр явуулахгүй байх, хэрвээ өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр мөрдөн байцаалт явуулж нотлох баримт цуглуулсан, хэрэг хүлээлгэсэн тохиолдолд тухайн мэдүүлэг, нотлох баримтыг үнэлэхгүй байх зохицуулалтын талаар; Шүүх хуралдаан хойшлох асуудлын талаар; Олон оролцогчтой хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тогтоохтой холбогдсон зохицуулалтын талаар; Хавтаст хэргийг цахимжуулах, цахим суурьтай нотлох баримтыг шүүх хуралдаанд шинжлэн судлах, цахим суурьтай нотлох баримтыг үнэлэх журмын талаар; Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүх, прокурорын шийдвэрийг оролцогчид танилцуулах, гардуулан өгөх журмын талаар; Шинээр нэгтгэсэн хэрэгт цагдан хоригдсон хугацааг тусад нь тоолох зохицуулалтын талаар; Өмгөөллийн тухай хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн эрх, үүргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмж тусгах талаар; Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авах болсон үндэслэлд хамаарах нотлох баримттай танилцах, таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлгийг талуудын мэтгэлцээний үндсэн дээр явуулах зохицуулалт; Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд яллах, өмгөөлөх талын эрх тэгш

мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх талаар; Мөрдөгч, прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан яллагдагч, шүүгдэгчийг цагаатгах, хэргийг хөнгөрүүлэх нөхцөл байдлыг нотлох чиг үүргээ хэрэгжүүлээгүй бол яллагдагч, шүүгдэгч энэ талаарх нотлох баримтыг шүүхэд гаргах эрхтэй байх талаар; Хүн ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхийг хангах хүрээнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан талаарх тогтоолыг гардуулан өгөх зохицуулалтын талаар; Шүүх, прокурор, мөрдөгч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан хүсэлтийг хангахаас татгалзаж байгаа үндэслэлийг тухайн шийдвэртээ тодорхой тусгах талаарх нарийн зохицуулалтуудыг тус тус зохицуулжээ.

Энэхүү судалгаагаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын тодорхой үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдох зардлыг тооцох, үйл ажиллагааны ачааллыг багасгаж, ногдох зардлыг бууруулах боломжит хувилбарыг боловсруулахыг зорилоо.

Тус хуульд иргэнд болон хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэх зохицуулалт тусгагдаагүй тул энэхүү зардлын тооцооны судалгааг зөвхөн төрийн байгууллагад үүсгэх зардлыг тооцож гүйцэтгэлээ.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцоолов.

ХОЁР. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцох бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- Байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
- Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
- Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Хууль тогтоомжийн тухай аргачлалын 4.4.6-д “Хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулан шийдвэр гаргахад төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоо хийхэд оруулахгүй.” гэж заасан ба хуулийн төслийн дараах зохицуулалт нь зардлыг тооцоход хамаарахгүй байна. Үүнд:

9/11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:

“7.Хавтаст хэргийг цахимжуулах, шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагуудын нэгдсэн системд холбох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд, төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох дараах зохицуулалтууд нь хамаарна. Үүнд:

Хүснэгт 1. Зардалд нөлөөлөх зүйл заалт

Хуулийн төслийн төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл заалт
1.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Шүүх хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах, баримт бичиг хүлээн авах, хүргэх ажиллагааг цахим платформ ашиглан цахимаар явуулж болно.	1.16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хавтаст хэрэг нь шүүхийн цахим платформын техникийн шаардлагад нийцсэн байна. 1/1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг: “3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөтлөх баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байна.” 8/11.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг: “2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хавтаст хэрэг нь

	мэдээллийн системийг ашиглан үүсгэх, боловсруулах, хадгалах, илгээх болон хүлээн авах боломжтой цахим хэлбэртэй байж болно.”
--	--

2.1. Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;
2. Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой агуулгыг хамааруулах.

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно.

Хүснэгт 2. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа ¹
Эрүүгийн хэргийн шүүх	1.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Шүүх хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах, баримт бичиг хүлээн авах, хүргэх ажиллагааг цахим платформ ашиглан цахимаар явуулж болно.	<p>-Хэргийн оролцогчтой цахимаар харилцахад тухайн этгээдийг таньж, баталгаажуулах боломжтой бусад цахим системд бүртгүүлэх;</p> <p>-Шүүх хуралдааны өмнө хэргийн оролцогчдыг бүртгэх;</p> <p>-Цахим платформын хэвийн тасралтгүй ажиллагааг урьдчилан шалгасан байх;</p> <p>-Өмгөөлөгчийн тайлбар, гомдол, хүсэлт зэрэг цахим баримт бичгийг хүлээн авах;</p> <p>-Мөрдөгч, прокуророос шүүхэд хүргүүлэх эрүүгийн хэрэг, баримт бичгийг албан тушаалтны цахим гарын үсгээр баталгаажуулан хүлээн авах;</p>

¹ Тус судалгааны стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо хуулийн төслийн холбогдох заалтуудаас авч үзсэн болно.

		<p>-Холбогдох бичиг баримтуудыг хэргийн талуудад илгээх;</p> <p>-Хэргийн талуудад хавтаст хэргийн материалтай танилцах боломжтойгоор байршуулах;</p> <p>-Цахим хавтаст хэргийн хуулбарлан авах боломжтойгоор байршуулах;</p> <p>-Программд нэвтэрсэн ажилтны хийсэн үйлдлийг хадгалж тайлан гаргадаг байх;</p> <p>-Бүртгэлтэй төхөөрөмжийн илгээсэн бүх мэдээллийг хүлээн авч бүрдүүлбэрийг шалгадаг байх.</p>
--	--	--

2.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистикт тоон мэдээллийг тооцсон болно.

Тухайлсан харилцааг зохицуулсан журам боловсруулж, батлах процесс нь нэг удаа гүйцэтгэгдэх тул тохиолдлын тоо нь хэмжигдэх боломжтой буюу стандарт үйл ажиллагаа бүрд 1 байна.

Хүснэгт 3. Стандарт үйл ажиллагаа холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Эрүүгийн хэргийн шүүх	Хэргийн оролцогчтой цахимаар харилцахад тухайн этгээдийг таньж, баталгаажуулах	960	53 ²	50880

² Монгол Улсын хэмжээнд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 30, Эрүүгийн хэргийн Давж заалдах шатны шүүх 22 болон Эрүүгийн хэргийн Улсын дээд шүүх 1 байгаа нь Эрүүгийн хэргийн шүүхийн тохиолдлын тоог нийтэд нь 53 байхаар шүүхийн шийдвэрийн цахим сангаас үндэслэн авч үзсэн.

боломжтой бусад цахим системд бүртгүүлэх;			
Шүүх хуралдааны өмнө хэргийн оролцогчдыг бүртгэх	30	53	1590
Цахим платформын хэвийн тасралтгүй ажиллагааг урьдчилан шалгасан байх;	60	53	3180
Өмгөөлөгчийн тайлбар, гомдол, хүсэлт зэрэг цахим баримт бичгийг хүлээн авах;	45	53	2385
Мөрдөгч, прокуророос шүүхэд хүргүүлэх эрүүгийн хэрэг, баримт бичгийг албан тушаалтны цахим гарын үсгээр баталгаажуулан хүлээн авах;	60	53	3180
Холбогдох бичиг баримтуудыг хэргийн талуудад илгээх;	30	53	1590
Хэргийн талуудад хавтаст хэргийн материалтай танилцах боломжтойгоор байршуулах;	180	53	9540
-Цахим хавтаст хэргийг хуулбарлан авах боломжтойгоор байршуулах;	180	53	9540

	Программд нэвтэрсэн ажилтны хийсэн үйлдлийг хадгалж тайлан гаргадаг байх;	480 ³	53	25440
	Бүртгэлтэй төхөөрөмжийн илгээсэн бүх мэдээллийг хүлээн авч бүрдүүлбэрийг шалгадаг байх.	100	53	5300
Нийт				112,625

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

- 1 жил = ажлын 200 өдөр
- 1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/
- 1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1600 ажлын цаг буюу (1600 x 60) 96.000 минут ажиллана.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 4. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
Эрүүгийн хэргийн шүүх	1.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Шүүх хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах, баримт бичиг хүлээн авах,	112.625	96.000	1.17

³ 480 минут буюу ажлын 8 цаг.

	хүргэх ажиллагааг цахим платформ ашиглан цахимаар явуулж болно.			
--	---	--	--	--

Эрүүгийн хэргийн шүүх шийдвэрийн төсөл боловсруулж, батлуулахад 112,625 минут буюу ажлын 20 өдөр зарцуулахаар байгаа нь уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн хэрэгцээ 1-с дээш буюу 1.17 байна. Энэ нь эрүүгийн хэргийн шүүх тус бүр дээр уг платформыг хариуцаж ажиллах мэргэжилтний хэрэгцээ үүсэж байгааг харуулж байна.

2.3. Гаргах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төсөлд улсаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалтны цалингийн хэмжээг үндэслэвэл Төрийн захиргааны байгууллагын нэг албан хаагчийн сарын дундаж цалин нь 1,365,400 төгрөг байна.⁴ Эндээс жилийн дундаж цалинг нь 16,384,800 төгрөг, түүнд оногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээг 1,884,252 төгрөг, нийт **18,269,052** төгрөг гэж тооцов.

Энэ зардлаа дээр тооцож гаргасан **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт 5. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал
------	----------------------------------	--	----------------------

⁴ Албан тушаалын зэрэглэлээр тогтоосон цалингийн хэмжээ (сард, төгрөгөөр)

ТҮ-1	1,703,000
ТҮ-2	1,621,000
ТҮ-3	1,544,000
ТҮ-4	1,471,000
ТҮ-5	1,400,000
ТҮ-6	1,334,000
ТҮ-7	1,271,000
ТҮ-8	1,210,000
ТҮ-9	1,100,000
ТҮ-10	1,000,000

Хэрэгжүүлэгч байгууллага	1	18,269,052	18,269,052
-----------------------------	---	------------	------------

2.4. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, хүний нөөцийн нэмэгдсэн ажлын ачаалалд ногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 6. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардал

Зардлын төрөл	Зардлын нэр	1 жилд зарцуулах зардал (төгрөгөөр)	Ажиллах хугацаанд зарцуулах зардал (төгрөгөөр)
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285	12,128
	Шуудан холбоо	167,881	16,788
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757	335,175
	Тавилга, эд хогшил	53,725	5372
Зардал	Түлш, халаалт	199,897	19,989
	Гэрэл, цахилгаан	937,251	93,725
	Цэвэр, бохир ус	51,947	5194
	Урсгал засвар	53,725	5372
	Газрын төлбөр	1411	141
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	356,555	35,655
	Тавилга, эд хогшил	100,000	10,000

Нэг албан хаагчид ногдох нийт зардал	5,395,434	539,543
---	------------------	----------------

Хүснэгт 7. Технологийн материаллаг зардал

Цахим мэдээллийн нэгдсэн платформыг худалдаж авах зардал	1,300,000,000 ⁵
---	----------------------------

Хуулийн төсөл хэрэгжих үед дээр дурдсанчлан ажлын 20 хоног шаардагдаж байх тул нэг албан хаагчид ногдох нэг жилийн материаллаг зардлыг бууруулж, 20 хоногт ногдох материаллаг зардал болон цахим платформ авах зардал нь нийтдээ **1,300,539,543** төгрөг гэж үзлээ.

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 8. Нийт зардал

Нэгж	Хүний нөөцийн зардал	Материаллаг зардал	Нийт
Эрүүгийн хэргийн шүүх	18,269,052	1,300,539,543	1,318,808,595

Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд Эрүүгийн хэргийн шүүхийн хүний нөөцийн цалингийн зардалд 18,269,052 нийт төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардал болон технологийн зардалд 1,300,539,543 төгрөг, нийт **1,318,808,595** төгрөгийн зардал үүсэхээр байна.

2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

2.5.1. Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;

Төрийн байгууллагын зардал тооцох хүрээнд, хуулийн төсөлд тусгасан чиг үүргийг тухайн төрийн байгууллага жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог “тохиолдлын тоо” гэж авч үздэг.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 1.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах, баримт бичиг хүлээн авах, хүргэх ажиллагааг цахим

⁵ Цахим платпормыг худалдаж авах зардалд Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн системд холбогдох дэд бүтцийн техник, тоног, төхөөрөмж, программ хангамж худалдан авах тендэрийн бичгээс үндэслэн жишиг болгон авч үзлээ. <https://user.tender.gov.mn/mn/invitation/detail/1679449857738>.

платформ ашиглан цахимаар явуулж болно.” гэж заасан нь Монгол Улсын хэмжээнд байгаа бүх эрүүгийн хэргийн шүүхүүд болон хэргийн оролцогчид, хамаарал бүхий этгээдүүд нь уг платформыг ашиглахаар тодорхойлсон байна. Уг судалгааны хүрээнд тохиолдлын тоог шүүхийн цахим санг үндэслэн нийт 53 шүүхээр авч үзсэн. Эрүүгийн хэргийн шүүх нь уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн хэрэгцээ 1-с дээш буюу 1.17 байгаа нь эрүүгийн хэргийн шүүх тус бүр дээр уг платформыг хариуцаж ажиллах мэргэжилтний хэрэгцээ үүсэж байна. Энэ нь тохиолдлын тоог багасгах боломжгүй юм.

2.5.2. Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;

Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 1.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах, баримт бичиг хүлээн авах, хүргэх ажиллагааг цахим платформ ашиглан цахимаар явуулж болно.” гэж заасан нь эрүүгийн хэргийн шүүх тус бүр дээр байнга давтагддаг шинжтэй тул мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломжгүй байна.

2.5.3. Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;

Шүүх хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах, баримт бичиг хүлээн авах, хүргэх үйл ажиллагаа нь тус бүр чиг үүрэг бүхий хэрэгжүүлэх шинжтэй тул мэдээллийн агуулгыг багасгах мэдээллийн агуулгыг хязгаарлалгүйгээр мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангах нь зүйтэй. Цахим мэдээллийн нэгдсэн платформыг худалдаж авахын оронд одоо байгаа хэрэгжүүлэгч байгууллагууд болох шүүх, прокурор, цагдаагийн мэдээллийн санг нэгтгэвэл төрд үүсэх зардлыг бууруулах боломжтой байна.

2.5.4. Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;

Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 1.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах, баримт бичиг хүлээн авах, хүргэх ажиллагааг цахим платформ ашиглан цахимаар явуулж болно” гэж тусгасан нь хавтаст хэргийг цахимжуулах нь цаасан суурьтай бичиг баримт, нотлох баримтыг боловсруулахад шаардагдах зардал, цаг хугацааг бууруулах ач холбогдол бүхий зохицуулалт учир мэдээллийг цахимаар хүргүүлэх хувилбарыг хангаж байна.

2.5.5. Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх;

Шүүх хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах, баримт бичиг хүлээн авах, хүргэх үйл ажиллагаа нь тус бүр чиг үүрэг бүхий хэрэгжүүлэх шинжтэй тул мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжгүй байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Хуулийн төсөлд зардлын тооцоо хийх нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох зорилготой байдаг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд төр, хуулийн этгээдэд учрах зардлыг урьдчилан тодорхойлох, цаашид ачааллыг аль болох багасгах санал боловсруулах зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд Шүүх хэргийн оролцогчтой харилцах, эргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах, баримт бичиг хүлээн авах, хүргэх ажиллагааг цахим платформ ашиглан цахимаар явуулж болно гэж заасан. Энэ нь эрүүгийн хэргийн хүний нөөцийн цалингийн зардалд 18,269,052 нийт төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардал болон технологийн зардалд 1,300,539,543 төгрөг, нийт **1,318,808,595** төгрөгийн зардал төрд үүсэхээр байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 1.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах, баримт бичиг хүлээн авах, хүргэх ажиллагааг цахим платформ ашиглан цахимаар явуулж болно.” гэж заасан нь Монгол Улсын хэмжээнд байгаа бүх эрүүгийн хэргийн шүүхүүд болон хэргийн оролцогчид, хамаарал бүхий этгээдүүд нь уг платформыг ашиглахаар тодорхойлсон байна. Уг судалгааны хүрээнд тохиолдлын тоог шүүхийн цахим санг үндэслэн нийт 53 шүүхээр авч үзсэн. Эрүүгийн хэргийн шүүх нь уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн хэрэгцээ 1-с дээш буюу 1.17 байгаа нь эрүүгийн хэргийн шүүх тус бүр дээр уг платформыг хариуцаж ажиллах мэргэжилтний хэрэгцээ үүсэж байгаа нь тохиолдлын тоог багасгах боломжгүйг харуулж байна. Мөн Шүүх хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах, баримт бичиг хүлээн авах, хүргэх ажиллагааг цахим платформ ашиглан цахимаар явуулж болно гэж тодорхойлсон ба уг үйлдлүүд нь эрүүгийн хэргийн шүүх тус бүр дээр байнга давтагддаг тул мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломжгүй юм. Түүнчлэн эрүүгийн хэргийн шүүхийн үйл ажиллагаа тус бүр нь чиг үүрэг бүхий хэрэгжүүлэх шинжтэй тул мэдээллийн агуулгыг хязгаарлалгүйгээр мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангах нь зүйтэй. Уг зохицуулалт нь хавтаст хэргийг цахимжуулах нь цаасан суурьтай бичиг баримт, нотлох баримтыг боловсруулахад шаардагдах зардал, цаг хугацааг бууруулах ач холбогдол бүхий зохицуулалт учир мэдээллийг цахимаар хүргүүлэх хувилбарыг хангаж байна. Эрүүгийн хэргийн шүүхийн шүүх хурлын холбогдох ажиллагаа нь тус бүр хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий шинжтэй тул мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжгүй байна.

Цахим мэдээллийн нэгдсэн платформыг худалдаж авахын оронд одоо байгаа хэрэгжүүлэгч байгууллагууд болох шүүх, прокурор, цагдаагийн мэдээллийн санг нэгтгэвэл төрд үүсэх зардлыг бууруулах боломжтой байна.



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
ХУУЛИЙН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ / Цахим
хавтаст хэрэг, цахим нотлох баримт, дууны,
дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт /**

2024

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

X сар

Улаанбаатар хот

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

Судалгааны багийн гишүүд:

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор (Ph.D.)

О.Энххүслэн

Хувийн эрх зүйн секторын Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M.)

Б.Ариунжаргал

Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын Эрдэм шинжилгээний ажилтан (LL.M.)

Т.Билгүүн

Хүний эрх, олон улсын эрх зүйн секторын Эрдэм шинжилгээний ажилтан

Х.Санчир

Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын Эрдэм шинжилгээний ажилтан

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	5
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ	6
УДИРТГАЛ	7
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	8
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь	8
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	10
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох	11
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох	15
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	15
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	15
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	16
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	18
Нэгдүгээр бүлэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэрэгтэй холбоотой хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ	18
1.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн ойлголт, шинж	18
1.2. Монгол Улс дахь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хавтаст хэргийн нөхцөл байдал, хэрэгцээ, шаардлага	19
1.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн харьцуулсан судалгаа	23
Хоёрдугаар бүлэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримттай холбоотой хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ	43
2.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтын ойлголт, шинж	43
2.2. Монгол Улс дахь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримтын нөхцөл байдал, хэрэгцээ, шаардлага	51
2.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтын харьцуулсан судалгаа	53
Гуравдугаар бүлэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалттай холбоотой зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ	73
3.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн ойлголт, шинж	73
3.2. Монгол Улс дахь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдал, сайжруулах хэрэгцээ, шаардлага	74

3.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын харьцуулсан судалгаа	80
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	88
ТАВ. СУДАЛГААНЫ ЭХ СУРВАЛЖ.....	93

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улсын
АТГ	Авлигатай Тэмцэх Газар
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНЭсУ	Бүгд Найрамдах Эстони Улс
ЕП	Европын Парламент
ЕХ	Европын Холбоо
ЗХШХШТХ	Захиргааны Хэрэг Шүүхэд Хянан Шийдвэрлэх тухай Хууль
ИХШХШТХ	Иргэний Хэрэг Шүүхэд Хянан Шийдвэрлэх тухай Хууль
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман улс
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ОУБХ	Олон Улсын Бага Хурал
УДШ	Улсын Дээд Шүүх
ХЗДХС	Хууль зүй, Дотоод хэргийн Сайд
ШССМХ	Шүүхийн Сургалт, Судалгаа Мэдээллийн Хүрээлэн
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий Газар
УИХ	Улсын Их Хурал
ЭХАШШ	Эрүүгийн Хэргийн Анхан Шатны Шүүх
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
CERT	Computer Emergency Response Team
CSIRT	Computer Security Incident Response Team
CSIRT	Electronic Case File
NYSCEF	New York State Courts Electronic Filing System

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт.....	12
Хүснэгт 2. Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт.....	13
Хүснэгт 3. БНСУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хуулийн зохицуулалт	37
Хүснэгт 4. ЗХШХШтХ болон ИХШХШтХ-ын цахим баримт, түүнийг үнэлэх.....	43
Хүснэгт 5. Цахим нотлох баримтын онцлог.....	44
Хүснэгт 6. Тоон нотлох баримтыг агуулж болох төхөөрөмж, хэрэгслүүд	48
Хүснэгт 7. БНСУ-ын Хэргийн бүртгэлийг хадгалах журам	85

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.7-д “...Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно...” гэж заажээ. Уг зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд, Улсын Их Хурал 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан. Үүнтэй холбогдуулан тодорхой асуудлыг судлан холбогдох хуулийн төслийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн боловсруулах талаар тусгасан “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 18 дугаар тогтоол гарсан.

Энэхүү тогтоолын 5 дахь хэсэгт “хавтаст хэргийг цахимжуулах, цахим суурьтай нотлох баримтыг шүүх хуралдаанд шинжлэн судлах, цахим суурьтай нотлох баримтыг үнэлэх журмыг боловсронгуй болгох”, 8 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах нөхцөл боломжийг бий болгох, 6-аас дээш сар хадгалах эрх зүйн орчныг бүрдүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь процессыг боловсронгуй болгох, хялбаршуулах, үр нөлөөг дээшлүүлэх, найдвартай байдлыг бүрдүүлэх улмаар хүний эрхийг хангах, хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зэрэг ач холбогдолтой.

Иймд дээр дурдсан асуудалд хамаарах Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх хэрэгцээ, шаардлага үүсч байна.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн. Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох;

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 оны 7 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлээд 7 жилийн хугацаа өнгөрч байгаа боловч тус хуулиар зохицуулж буй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой эрх зүйн хэм хэмжээний хийдэл бүхий асуудлууд өнөөдөр ч практикт байсаар байна. Энэ нь нийгэм хөгжин өөрчлөгдөхийн хэрээр нийгмийн харилцаанд зохицуулагдаж байгаагүй шинэ ойлголт, асуудлууд бий болсоор байдагтай холбоотой.

Манай улс сүүлийн жилүүдэд шүүхийн цахимжилттай холбоотой асуудалд нэлээд анхаарал хандуулах болсон бөгөөд нийгэм, цаг үеийн олон талт нөлөөлөлтэй шууд хамааралтай. Нөгөөтээгүүр, дан ганц шүүхийн цахимжилт төдийгүй нийгмийн бүхий л салбарт цахимжилт явуулах, цахим засаглалыг сайжруулах хэрэгцээ шаардлага бий болсоор байна.

Иймээс ч Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Цахим Монгол” арга хэмжээг авч хэрэгжүүлэх тусгасан бөгөөд үүнтэй холбогдуулан цахим багц хуулийг батлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 5 сарын 18-ны өдрийн А/24 тушаалаар “Цахим үндэстэн” баримтлах чиглэл (2022-2027)-ийг баталсан.

Өөрөөр хэлбэл, манай улс цахим засаглалыг хөгжүүлэх чиглэлд хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Нийтийн мэдээллийн ил байдлын тухай хууль, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийг батлан хэрэгжүүлж эхэлсэн бол бодлого, стратегийн хүрээнд Шинэ сэргэлтийн бодлого, Төрийн бүтээмжийн сэргэлт, “Цахим үндэстэн” дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна¹.

¹ 2023 оны 3 сарын 23-24-ний өдөр зохион байгуулагдсан “Монгол Улсын Шүүхийн цахимжуулалт” ОУБХ-д ЦХХХ-ны дэд сайд Ж.Эрхэмбаатарын хэлэлцүүлсэн “Монгол Улсын шүүхийн болон хуулийн байгууллагуудыг цахимжуулах мэдээлэл технологийн үүрэг” сэдэвт илтгэлээс.
https://docs.google.com/presentation/d/13pM_ibCxZi40sK3fBIKzffalucrgXh1X/edit#slide=id.p25

Түүнчлэн, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод төрийн үйл ажиллагааг үе шаттай бүрэн цахимжуулах зорилтыг тавьж, шүүхийн үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлж, үйл ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй болгох асуудлыг тусгасан. Мөн шүүхийн шинэчлэлийн хүрээнд баталсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.11-д “...шүүхийн Тамгын газрын үйл ажиллагаанд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого батлах, хэрэгжүүлэх...” гэж, 74 дүгээр зүйлийн 74.1.6-д “...шүүхийг дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангах нэгдсэн бодлого батлах, хэрэгжүүлэх...” гэж тус тус заасан бөгөөд дээрх зохицуулалтуудтай уялдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 332 дугаар тогтоолоор “Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого”-ыг баталсан.

Мөн Улсын ерөнхий прокурорын газраас Прокурорын байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөг Төрийн албаны тухай хууль, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн боловсруулсан бөгөөд энэхүү стратеги төлөвлөгөөнд дараах 5 зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байна. Үүнд:

- Олон нийтэд прокурорын байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар сурталчлан таниулж, эерэг хандлагыг нэмэгдүүлэх;
- Прокурорын үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангах;
- Прокурорын хяналтын ажлын чанар, үр нөлөөг сайжруулж, боловсронгуй болгох;
- Хамт олны дунд эерэг хандлагыг төлөвшүүлж, удирдлагын манлайллыг сайжруулах;
- Цахим шинэчлэлийг хэрэгжүүлэх замаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх.

Энэхүү зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд прокурорын байгууллага үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн дэвшил, инноваци нэвтрүүлэх, ажлын үр нөлөө, бүтээмжийг нэмэгдүүлэх, их өгөгдлийг бодлогын шийдвэр гаргахад ашиглах, зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, статистикийн үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах зэрэг арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэн ажиллаж байна².

Дээрхээс дүгнэвэл, шүүх эрх мэдлийн байгууллагуудын цахимжилттай холбоотой асуудлууд хууль, эрх зүйн хүрээнд тусгалаа олж бодлогын баримт бичгүүдэд тодорхой байдлаар зохицуулагджээ. Мөн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд ч тухайн агуулга, зохицуулалт зохих ёсоор тусжээ.

Харин ЭХХШТХ-ийн 11.11 дүгээр зүйлд заасан Эрүүгийн хавтаст хэрэгтэй холбоотой зохицуулалтад 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар “...Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байж болно. Цаасан баримтыг шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагын ажилтан хөрвүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулна...” гэж, мөн 1.16 дугаар

² ГХУСЗ, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном, УБ, 2022, 2023, 86 дахь тал.

зүйлд “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах” зохицуулалтыг шинээр нэмсэн нь цахим хавтаст хэрэг, цахимжуулсан хавтаст хэрэг, цахим нотлох баримт зэрэг цахимтай холбоотой зарим асуудлыг ЭХХШТХ-д хуульчлах урьдач нөхцөл болсон гэж үзэж болох юм.

Гэвч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтад цахим хавтаст хэрэг, цахим нотлох баримт болон түүний хадгалалттай холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусаагүй байна. Иймд тус судалгааны хүрээнд дээрх асуудлыг судалж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зөвлөмжийг өгөх юм.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Энэ нь үнэлгээ хийх болсон шалтгаанууд (өмнө тодорхойлсон)-тай харилцан уялдаа, хамааралтайгаар хийгдэх ажиллагаа бөгөөд тодорхойлогдсон эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг илрүүлнэ.

Үнэлгээний хүрээг тогтооходоо үнэлгээ хийх ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, хүний нөөц, цаг хугацаа, гарах зардлыг заавал харгалзан үзэх хэрэгтэй. Хуулийг бүхэлд нь үнэлэх ажиллагааны зардал ихэвчлэн хэт өндөр гардаг тул зөвхөн тухайн хуулийн зорилго, үнэлгээний шалгуурт хамгийн ихээр нөлөөлж болохуйц хуулийн зохицуулалтыг зөв сонгох шаардлагатай.

Дээр дурдагдсан үнэлгээ хийх шалтгаанд тулгуурлан 2017 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах агуулга бүхий зохицуулалтуудад хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийхээр тогтлоо.

Үнэлгээний хүрээ

Нэгдүгээр бүлэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэрэгтэй холбоотой хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

- 1.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн ойлголт, шинж
- 1.2. Монгол Улс дахь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хавтаст хэргийн нөхцөл байдал, хэрэгцээ, шаардлага
- 1.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн харьцуулсан судалгаа
 - Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
 - Бүгд Найрамдах Эстони Улс
 - Америкийн Нэгдсэн Улс
 - Бүгд Найрамдах Солонгос Улс

Хоёрдугаар бүлэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримттай холбоотой хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

- 2.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтын ойлголт, шинж
- 2.2. Монгол Улс дахь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримтын нөхцөл байдал, хэрэгцээ, шаардлага

- 2.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтын харьцуулсан судалгаа

- Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
- Бүгд Найрамдах Эстони Улс
- Америкийн Нэгдсэн Улс
- Бүгд Найрамдах Солонгос Улс

Гуравдугаар бүлэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалттай холбоотой зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

3.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн ойлголт, шинж

3.2. Монгол Улс дахь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдал, сайжруулах хэрэгцээ, шаардлага

3.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын харьцуулсан судалгаа

- Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
- Бүгд Найрамдах Эстони Улс
- Америкийн Нэгдсэн Улс
- Бүгд Найрамдах Солонгос Улс

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах гурван шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал;
3. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал;

I. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Тухайн хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд төлөвлөсөн зорилгодоо хүрсэн эсэх байдлыг тогтооно. Үндсэн болон дагалдах зорилгыг тодорхойлно.

2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлд зааснаар “...гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд оршино.” гэж зорилгыг тодорхойлжээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах зохицуулалтуудыг тухайн шалгуур үзүүлэлтийн түвшинд судлахаар болов.

Хүснэгт 1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт

№	2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт	Тус зохицуулалтыг сонгосон үндэслэл
1.	<p>11.11 дүгээр зүйл. Эрүүгийн хэргийн хавтаст хэрэг</p> <p>1. Хавтаст хэрэг нь хэрэгт тусгасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэр, баримт бичиг, хэрэгт хавсаргасан бусад баримт бичиг, зүйлээс бүрдэнэ.</p> <p>2. Мөрдөгч, прокурор, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь оролцогч, бусад оролцогчоос гаргасан хүсэлт, гомдол, мэдээлэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэр, бусад баримт бичиг, эд зүйлийг тэмдэглэл үйлдэж, эсхүл төрийн албан хэрэг хөтлөх журмын дагуу бүртгэж, хавтаст хэрэгт тусгаж, хавсаргана.</p> <p>3. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний баталсан болон бичсэн баримт бичгийг хавтаст хэрэгт шууд тусгана.</p> <p>4. Овор хэмжээ, бусад шалтгааны улмаас хавтаст хэрэгт тусгах боломжгүй эд зүйл, баримт бичгийг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тэмдэглэлд тусгана.</p> <p>5. Хавтаст хэрэг нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад мөрдөгчид, энэ хуульд заасан үндэслэлээр шилжүүлсэн, эсхүл татаж хянаж байгаа бол прокурорт, шүүхийн шатанд тухайн шүүхэд байна.</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хавтас хэргийг цахимжуулаагүйн улмаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа нь цаг үеэсээ хоцорч, бусад эрх зүйн зохицуулалт, бодлогын баримт бичигт нийцэхгүй байна. Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хавтаст хэргийг цахим болгосноор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай, тасралтгүй, найдвартай, ил тод байх байдал хангагдана.</p>

II. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Шинэчлэн найруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

Энэ шалгуур үзүүлэлтээр ихэвчлэн тухайн хуулийг хэрэгжүүлэгч этгээдээс болон байгууллагаас уг зохицуулалт практикт хэрэгжиж чадаж байгаа эсэхийг тогтооход түлхүү ашигладаг. Мөн хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон амьдралд гарч байгаа эерэг болон сөрөг ямар үр дагаврууд байгааг тодорхойлох бөгөөд хуулийн зохицуулалтын ойлгомжтой байдал, түүнийг хэрэгжүүлэх боломж бололцоо практикт байгаа эсэхийг тооцох нь чухал юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах зохицуулалтуудыг тухайн шалгуур үзүүлэлтийн түвшинд судлахаар болов.

Хүснэгт 2. Практикт нийцэж байгаа байдал шалеуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт

№	2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт	Тус зохицуулалтыг сонгосон үндэслэл
1.	<p>16.14 дүгээр зүйл.Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх</p> <p>1.Энэ хуульд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах замаар нотлох баримт цуглуулж, хэрэгт цугларсан эд мөрийн баримт, баримтат мэдээллийг мөрдөн шалгах ажиллагааны болон шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгаж бэхжүүлнэ.</p> <p>2.Нотлох баримт бэхжүүлэхдээ тэмдэглэл үйлдэхийн зэрэгцээ мэдээллийг тусгасан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх, гэрэл зураг авах, гар зураг үйлдэх, ул мөрнөөс хэв, хээ буулгаж авах зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчимд нийцэх бусад аргыг хэрэглэнэ.</p> <p>3.Мөрдөгч нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхдээ тэдгээрийг устах, гэмтэх, үрэгдэхээс хамгаалах арга хэмжээг авна.</p> <p>4.Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхдээ иргэний амь нас, эрүүл мэндэд аюултай, эсвэл тэдний нэр төрийг гутаан доромжлох, хүнлэг бус, хэрцгий харьцах, айлган сүрдүүлэх, мэдүүлэг, тайлбар, дүгнэлт гаргуулахаар тулган шаардах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэхийг хориглоно.</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах нөхцөл боломжийг сайжруулах шаардлага үүсч байна.</p>

III. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Иргэд, хуулийн этгээдээс хуулийг хэрхэн хүлээн авч буй байдал болон хуулийг хэрэгжүүлж байна уу? гэдгийг тодорхойлно. Хуулийн үр нөлөөг шууд хүртэж байгаа этгээдээс авах нь зохимжтой. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах зохицуулалтуудыг тухайн шалгуур үзүүлэлтийн түвшинд судлахаар болов.

№	2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт	Тус зохицуулалтыг сонгосон үндэслэл
1.	<p>16.1 дүгээр зүйл.Нотлох баримт</p> <p>1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ.</p> <p>2.Баримтат мэдээлэл нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, эд мөрийн баримт, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, мөрдөгчийн магадлагаа, энэ хуульд заасны дагуу бэхжүүлсэн кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, эрх бүхий байгууллагын цахим мэдээллийн сангаас цахим гарын үсгээр баталгаажуулж авсан лавлагаа, тодорхойлолт, ул мөрөөс авсан хэв, мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл, хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гэмт хэргийн</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь нотлох баримтын төрөлд цахим нотлох баримтын төрлийг хуульчилж түүнтэй холбоотой процессыг зохицуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулан шуурхай, тасралтгүй,</p>

<p>талаархи гомдол, мэдээлэл болон энэ хуульд заасан бусад баримтаар тогтоогдоно.</p> <p>3.Прокурор, мөрдөгч, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, өргөдлийг шалгах, эрүүгийн хэргээс бусад зөрчил, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын явцад хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн болон энэ хуулийн Дөчин хоёрдугаар бүлэгт заасан журмаар гадаад улсаас ирүүлсэн баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцож болно.</p> <p>4.Мөрдөгч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу нотлох баримт цуглуулж, шалгаж, бэхжүүлнэ.</p> <p>5.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцох нь тэдгээрийг шалгах зорилгоор мөрдөн шалгах ажиллагаа явуулахыг хязгаарлах үндэслэл болохгүй.</p> <p>6.Нотлох баримтыг хууль бус арга, хэрэгслээр цуглуулж, бэхжүүлэхийг хориглоно.</p> <p>7.Энэ хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж авсан баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцохгүй.</p> <p>8.Шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдаанаар шинжлэн судалсан нотлох баримт шүүхийн шийдвэрийн үндэслэл болно.</p> <p>9.Хавтаст хэрэгт авагдаагүй нотлох баримт шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.</p> <p>10.Хохирогч, яллагдагч тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс гаргаж өгсөн эд зүйл, баримт бичиг, гомдол, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурор авч хавтаст хэрэгт тусгаж хавсаргана.</p> <p>11.Энэ хуульд заасны дагуу оролцогчоос прокурор, мөрдөгчид гаргаж өгсөн эд зүйл, баримт бичиг, гомдол, мэдээлэл, бусад баримтыг олж авсан эх сурвалжийг зааж хэлээгүй бол дангаараа нотлох баримт болохгүй.</p> <p>12.Өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх, өмгөөлөх үйл ажиллагаатай холбоотой харилцааны баримтыг нотлох баримтаар тооцохгүй.</p> <p>13.Шүүх, прокурор, мөрдөгч тухайн хэрэгт хамааралтай энэ хуульд заасны дагуу цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай эсэхийг бүхэлд нь үнэлнэ.</p> <p>14.Нотлох баримтыг шинжлэн судлах явцад хэрэгт ач холбогдолтой, хамааралтай эсэхэд эргэлзэх үндэслэл байвал тухайн нотлох баримтыг шүүх, прокурорын шийдвэрийн үндэслэл болгохгүй.</p> <p>15.Хавтаст хэрэгт тусгагдсан нотлох баримтыг шүүх хуралдаанаар шинжлэн судалж аль нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болохыг шүүх шийдвэрлэнэ.</p>	<p>найдвартай, ил тод байх байдлыг хангана.</p>
---	---

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
- Тохиолдол судлах.

Судалгааны явцад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дээрх зүйл, заалтад хамаарах агуулга тус бүр дээр байх ёстой болон одоо байгаа, хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших, хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших, тохиолдол судлах харьцуулах хэлбэрийг аль тохирохыг ашиглана. Мөн гадаад улсуудын эрх зүйн зохицуулалт болон туршлагыг харьцуулан судална.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

“Шалгуур үзүүлэлтийг томъёолох” гэдэг нь сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавьдаг бөгөөд үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалтад “зорилтод хүрсэн түвшин ямар байна вэ?”, “практикт хэрхэн нийцэж байна вэ?”, “хүлээн зөвшөөрөгдөх үү?” гэсэн асуултын хүрээнд гүйцэтгэв.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдөх байдал, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, энэхүү сэдвээр бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл уншиж судлах, түүхчилсэн судалгаа хийх, харьцуулсан судалгаа хийх, судалгааны тайлан унших, харьцуулалт хийх, холбогдох байгууллагаас судалгааг гаргуулах зэрэг аргыг ашиглана.

Мэдээлэл цуглуулах арга:

- Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах;
- Холбогдох субъектээс судалгаа авах аргыг сонгон хэрэгжүүллээ;

Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, холбогдох сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайланг цуглуулж үнэлгээ хийхэд ашиглав.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, харьцуулсан судалгааны аргад тулгуурлаж энэхүү судалгааг гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлүүд, илтгэл, өгүүлэл, судалгааны тайланг ашигласан болно.

Сурах бичиг, гарын авлага, судалгааны тайлан:

- 2023 оны 3 сарын 23-24-ний өдөр зохион байгуулагдсан “Монгол Улсын Шүүхийн цахимжуулалт” ОУБХ;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2022, 2023 он;
- Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын төсөлд хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ /Хөндлөнгийн судалгаа/, 2023 он;
- Л.Галбаатар, Кибер гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх нь, 2015 он;
- Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа /Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд/, ННФ, 2022 он;
- Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (Кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа, Уб., 2019 он;
- Монгол Улсад үйлдэгдэж байгаа кибер гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, түүнтэй тэмцэх арга зам, үндсэн чиглэл /Суурь судалгааны тайлан/, 2015 он;
- М.Бямбасүрэн, Цахим баримт бичгийг нотлох баримтын хэмжээнд үнэлдэг байх шаардлагатай нийтлэл, 2024.01.29;
- Нотолгооны өнөөгийн практик, арга зүй, техник хэрэгсэл, анхаарах асуудал /Судалгааны тайлан/, ННФ, Уб., 2021 он гэх мэт.

Хууль, эрх зүйн акт:

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992, №1;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2020, №29;
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №9;
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №8;
- Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2021, №5;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №23;

- Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 5 сарын 18-ны өдрийн А/24 тушаалаар баталсан “Цахим үндэстэн” баримтлах чиглэл (2022-2027);
- Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 332 дугаар тогтоол;
- 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол, Дугаар 31, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар;
- 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн УДШ-ийн Ерөнхий шүүгч, ХЗДХ-ийн Сайд, УЕП-ын хамтарсан Дугаар А/18, 34, А/31 “Заавар батлах тухай”;
- 2019 оны 12 сарын 5-ны өдрийн Дугаар 246, А/80 Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан захирамж, тушаал;
- 2022 оны 1 сарын 6-ны өдрийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоол Дугаар 1 “Журам батлах тухай”
- Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны 5 сарын 20-ны өдрийн А/69 дугаар тушаал;
- Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2022 оны 4 сарын 15-ны өдөр дугаар А/42 тушаал гэх мэт.

Олон улсын гэрээ, конвенци:

- Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтыг бий болгох, хадгалах журам (EU) 2023/154;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт цуглуулах үүрэг бүхий байгууллагыг үүсгэн байгуулах, түүний хууль ёсны төлөөлөгчдийг томилох зохицуулалтыг ижилтгэх удирдамж (EU) 2023/154;
- Кибер гэмт хэргийн тухай Будапештийн конвенц (ETS No. 185);
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц ба түүнд заасан протоколууд (55/255)
- Истанбулын протокол (Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг гутаан харьцах, шийтгэхийг үр дүнтэй мөрдөн шалгах, баримтжуулах гарын авлага)
- Хувийн мэдээллийг автоматаар боловсруулахтай холбоотой хувь хүнийг хамгаалах тухай Европын зөвлөлийн конвенц гэх мэт.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл, заалтуудыг сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу дараах байдлаар үнэлгээг хийсэн.

Нэгдүгээр бүлэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэрэгтэй холбоотой хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

Судалгааны нэгдүгээр бүлгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн талаар нарийвчлан авч үзэх ба Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шинээр зохицуулж хуульчлах шаардлага бий эсэхийг судална. Мөн түүнчлэн ийнхүү хуульчлахдаа гадаадын зарим улс, орнуудаас нутагшуулах сайн жишиг бүхий зохицуулалтыг тодорхойлох болно.

1.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн ойлголт, шинж

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт эрүүгийн хэргийн хавтаст хэргийг хэрэгт тусгасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэр, баримт бичиг, хэрэгт хавсаргасан бусад баримт бичиг, зүйлээс бүрдэнэ гэж тодорхойлсон. Мөрдөгч, прокурор, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь оролцогч, бусад оролцогчоос гаргасан хүсэлт, гомдол, мэдээлэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэр, бусад баримт бичиг, эд зүйлийг тэмдэглэл үйлдэж, эсхүл төрийн албан хэрэг хөтлөх журмын дагуу бүртгэж, хавтаст хэрэгт тусгаж, хавсаргана. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний баталсан болон бичсэн баримт бичгийг хавтаст хэрэгт шууд тусгана. Овор хэмжээ, бусад шалтгааны улмаас хавтаст хэрэгт тусгах боломжгүй эд зүйл, баримт бичгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тэмдэглэлд тусгана. Хавтаст хэрэг нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад мөрдөгчид, энэ хуульд заасан үндэслэлээр шилжүүлсэн, эсхүл татаж хянаж байгаа бол прокурорт, шүүхийн шатанд тухайн шүүхэд байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар "...Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байж болно. Цаасан баримтыг шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагын ажилтан хөрвүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулна..." гэх зохицуулалтыг нэмж тусгаснаас бусдаар хавтаст хэрэгтэй холбоотой зохицуулалтад цахим хавтаст хэргийн талаар авч үзээгүй байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахим баримт буюу хавтаст хэрэг гэдэгт эрүүгийн хэрэгт хамааралтай цахим баримт бичиг, тухайлбал дижитал файл, цахим шуудан, мессеж, зураг болон бусад хэлбэрийн цахим өгөгдлийг хамааруулан ойлгодог. Хууль эрх зүйн процессыг цахимжуулах эрүүгийн хэрэг бүртгэлт, шүүх хуралдаанд цахим баримт бичиг ашиглах жишиг ихээр дэлгэрч байгаа энэ үед цахим хавтаст хэрэг нь ихээхэн ач холбогдолтой юм. Эдгээр цахим баримт бичиг нь нотлох баримт, гэрчийн мэдүүлэг, хууль ёсны бусад мэдүүлэг байхаас гадна тухайн хэрэгт хамааралтай бусад материалыг агуулж

болно. Цахим баримт бичиг нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны уламжлалт цаасан баримт бичигтэй ижил дүрэм, журамд захирагддаг бөгөөд энэ нь хүлээн зөвшөөрөгдөх байдал, үнэн зөв, хамааралтай байх ёстой. Энэ тухай дараа дараагийн хэсгүүдэд нарийвчлан авч үзэх болно.

1.2. Монгол Улс дахь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хавтаст хэргийн нөхцөл байдал, хэрэгцээ, шаардлага

Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал болон дэлхий нийтээрээ цахим шилжилтэд шилжиж буй өнөө үед харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшил нь хөгжлийн хурдасгуур, цахим үндэстнийг цогцлоон хөгжүүлэх гол хүчин зүйл болж байна³. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 3-т “...Шүүх улсын төсвөөс санхүүжинэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана...” гэж, мөн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжихээр заасан. Ингэхдээ 2021-2030 он төрийн албаны хувьд төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх үе гэж тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, Монгол Улс ойрын жилүүдэд төрийн алба, мөн түүний нэг төрөл болох шүүхийн албаны үр дүн, үр нөлөөг дээшлүүлэхийг зорьж байна. Төрийн үйлчилгээг ийнхүү үр дүн, үр нөлөөгөөр (output/outcome) хэмжиж дээшлүүлэх нь New public management буюу нийтийн албаны шинэ менежментийн ухаанаас улбаатай гэж үзэх бөгөөд энэ нь бизнесийн салбарын удирдлагын “багаар ихийг хийх” (do more with less) -тэй холбоотой зарим арга зүйг төрийн буюу нийтийн албанд нэвтрүүлж үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэжээ⁴. Энэ хүрээнд шүүхийн цахимжилтын асуудал нэн тэргүүнд хөндөгдөж байна.

Түүнчлэн, шүүхийн цахимжилт нь дан ганц шүүхийн асуудал биш шүүх эрх мэдлийн бүхий л байгууллага, цагдаа, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, улсын бүртгэлийн газар гэх мэт олон талын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох интеграци учир хууль, эрх зүйн орчинд ач холбогдол өгөх ёстой. Тодруулбал, иргэн, эрүү, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх процессын хуулиудад цахимаар мэдүүлэх, цахим нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, үнэлэх, цахим хавтаст хэрэг үүсгэх, цахимаар мэтгэлцэх эрх зүйн орчныг бүрдүүлж өгөх хэрэгцээ шаардлага тулгараад байна⁵.

Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн хэрэг, цагдан хорих гэх мэт асуудлыг цахимжуулах боломжтой. Гадаад орнуудын туршлагаас харахад процессын хуулиудад ерөнхий зохицуулалтыг тусгаж, нарийвчилсан зохицуулалтыг журам батлан хэрэгжүүлдэг туршлага нийтлэг байна. Манай улс хуулиндаа цахимаар мэдүүлэх, цахим

³ Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 5 сарын 18-ны өдрийн А/24 тушаалаар баталсан “Цахим үндэстэн” баримтлах чиглэл (2022-2027)

⁴ 2023 оны 3 сарын 23-24-ний өдөр зохион байгуулагдсан “Монгол Улсын Шүүхийн цахимжуулалт” ОУБХ-д Н.Отгончимэгийн хэлэлцүүлсэн “Шүүхийн санхүүжилтийн механизмыг шинэчлэх шаардлага” сэдэвт илтгэлээс. <https://docs.google.com/document/d/10Dj6LDSgTdrjOyp8UkrRIZ0z3Bq-DyvcaqLBSJSrEAW/edit>

⁵ Г.Даваадорж: Шүүхийн цахимжилтад хууль эрх зүйн орчин ус агаар мэт хэрэгтэй байна, https://www.judcouncil.mn/site/news_full/13818

хавтаст хэрэгтэй холбоотой ерөнхий зохицуулалтыг тусгах нь цаашдын шүүх болон бусад хуулийн байгууллагын цахимжилтад эергээр нөлөөлөх боломжтой⁶.

Улсын Их Хурлын Байнгын хороо 2015 онд “Шүүх хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн цахим нэгдсэн сүлжээ бүрдүүлэх тухай” 23 дугаар тогтоол гарсан. Энэ тогтоолыг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн яам, шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон ХБНГУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хамтран хэрэгжүүлсэн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах” төслөөс шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудыг нэгдсэн сүлжээнд холбосон⁷.

2020-2021 онд “Ковид-19” цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд шүүхээс хэрэг, нэхэмжлэл, гомдлыг цахимаар хүлээн авах, хэргийн оролцогчдыг цахимаар шүүх хуралдаанд оруулах, зарим нотлох баримтыг төрийн эрх бүхий байгууллагуудаас авах, солилцох зэргээр үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг цахимд шилжүүлэн, шүүн таслах ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулж байсан⁸.

Өөрөөр хэлбэл, Коронавирус цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор шүүх эрх мэдлийн байгууллагын хүрээнд үүссэн шүүхийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, шүүхийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх, шүүхийн байранд аюулгүй байдлыг хангах, хамгаалах, удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ шүүхийн зарим үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн. Энэ нь шүүхийн ачаалал, цаг хугацаа, хөрөнгө санхүү, хүний нөөц, шүүх хурлын танхим зэрэг олон асуудлыг бууруулахад эерэг нөлөөлөл үзүүлж байсан тиймээс ч цаашид шүүхийн цахимжилтийн эрчимжүүлэх хэрэгцээ шаардлага байгааг практикт ажиллаж буй шүүх, прокурор, өмгөөлөгч, хууль сахиулах байгууллагын төлөөллүүд олон удаагийн хурал, сургалт, хэлэлцүүлгийн явцад хөндсөөр байна.

Энэ талаар сүүлийн жилүүдэд шүүхийн цахимжилт, цахим нотлох баримттай холбоотой олон улсын бага хурал, хэлэлцүүлэг, сургалтууд цөөнгүй зохион байгуулагдаж байгаагаас харж болох юм. Тухайлбал, 2022 оны 3 сарын 28, 29-ний өдрүүдэд АНУ-ын Элчин Сайдын яамны Нууц албанаас УЕПГ, АТГ, Цагдаагийн байгууллагын алба хаагчдад “Цахим нотлох баримт, криптовалюта” сэдэвт мэргэшүүлэх сургалт, 2023 оны 5 сарын 15-18-ны өдрүүдэд УЕПГ, АНУ-ын Хууль зүйн яамны Прокурорын хөгжил, туслалцаа, сургалтын газрын хамтын ажиллагааны хүрээнд “Дижитал нотлох баримт болон Зэрлэг ан амьтдыг худалдаалах, Мөнгө угаах гэмт хэргийг шалгаж шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт сургалт, 2023 оны 9 сарын 16-ны өдөр УДШ-ийн дэргэдэх ШССМХ-гээс Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн шүүгч нарт “Цахим нотлох баримт” сэдэвт сургалт, 2023 оны 3 сарын 2-ны өдөр “Шүүх эрх мэдлийн байгууллагуудын цахимжилт ба шинэчлэлт” сэдэвт хэлэлцүүлэг, 2023 оны 9 сарын 3-16-ны өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотод зохион байгуулагдсан “Мөнгө угаах гэмт хэрэг ба цахим нотлох баримт” сэдэвт сургалт, 2023 оны 3 сарын 23-24-ний өдрүүдэд “Монгол Улсын шүүхийн цахимжуулалт” ОУБХ, 2024 оны 3 сарын 25-28-ны өдрүүдэд Монголын Хуульчдын холбоо, АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран хэрэгжүүлж буй “US speaker” хөтөлбөрийн

⁶ Мөн тэнд.

⁷ Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын төсөлд хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ /Хөндлөнгийн судалгаа/, УБ, 2023, 86-87 дахь тал.

⁸ Мөн тэнд, 87 дахь тал.

хүрээнд “Шүүхийн цахимжилт ба тулгамдсан асуудал” сэдэвт хэлэлцүүлэг тус тус зохион байгуулагдсан байна.

Үүнээс 2023 оны 3 сарын 23-24-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Монгол Улсын шүүхийн цахимжуулалт” ОУБХ-д хэлэлцүүлсэн зарим илтгэлүүдээс онцлох зүйлийг дурдвал:

Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар “Монгол Улсын Шүүх эрх мэдлийн байгууллага болон бусад холбогдох байгууллагуудын цахимжуулалт, уялдаа холбоог хангах нь” сэдэвт илтгэлдээ “...*Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай буюу цахим хэлбэрээр хүргэх нөхцөлийг бүрдүүлж, цахим гэрээ, хэлцлийн хууль, эрх зүйн орчныг сайжруулан цахим орчинд хийгдсэн гэрээ, хэлцлийг шүүхэд нотлох баримтаар тооцох, шүүхийн зарим үйл ажиллагааг цахимжуулж, баялаг бүтээгч, хувийн хэвшлийг дэмжих хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хууль ёсыг бэхжүүлнэ...*” гэжээ.⁹

Мөн тус олон улсын бага хурлын үеэр шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын төлөөллүүд цахимжилттай холбоотойгоор санал, дүгнэлтээ танилцуулснаас дурдвал:

Шигтгээ 1.

Цахимжилттай холбоотойгоор шинэ, шинэ нэр томъёо хэрэглэгдэх болсон. Тухайн нэр томъёог анхнаас нь зөв тодорхойлж, нэр мөр ойлгох нь маш чухал. Нөгөөтээгүүр, цахимжих үйл явц нь цахим гарын үсгийн хэрэглээтэй нягт уялдаа холбоотой бөгөөд манай улсын хувьд цахим багц хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан цахим гарын үсгийн хэрэглээ эрс нэмэгдэж байна.

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч Г.Даваадорж

Шигтгээ 2.

Хавтаст хэргийг цахимжуулах нь маш чухал хэрэгжүүлэх шаардлагатай ажлын нэг болоод байна. Хэрэв цахим хавтаст хэрэгтэй байсан бол шүүхийн нотлох баримт шинжлэн судлан үе шатанд гэхэд дан ганц прокурор хавтаст хэргийн ... хуудас гээд тухайн судалж буй нотлох баримтыг ганцаар уншиж танилцуулахгүйгээр тухайн шүүх хуралдааны танхимд сууж буй хүн бүрд нээлттэй, үнэн зөв байх боломжийг бүрдүүлнэ. Нөгөөтээгүүр, хэрэг маргаан олон жил шалгагдан үргэлжилж байгаа тохиолдолд цаасан суурьтай баримт дэс дараалалгүйгээр үдэгдэж хавсрагддаг. Цахим хавтаст хэрэгт бол тухайн нотлох баримтыг төрөлжүүлэх, шүүгч, прокурор өмгөөлөгчдийн хувьд ч тухайн хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтуудын уялдаа холбоотой байдлыг шалгах, танилцахад хялбар болно.

Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга, УЕП-ын туслах прокурор О.Мөнхбаатар

Шигтгээ 3.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах ажлыг эхлүүлээд байна. Тухайлбал, 2023 оны 3 сарын 20-ны өдрөөс эхлээд ЧД-ийн Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Замын цагдаагийн хэлтэстэй хамтраад 100 орчим эрх бүхий албан тушаалтанд эрх олгож шинэ программыг үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашиглаж эхлээд байна.

ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Статистик мэдээллийн хэлтсийн дарга, Цагдаагийн дэд хурандаа Д.Жанчивдорж

⁹ Г.Даваадорж: Шүүхийн цахимжилтад хууль эрх зүйн орчин ус агаар мэт хэрэгтэй байна, https://www.judcouncil.mn/site/news_full/12923

2024 оны 3 сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан “Шүүхийн цахимжилт ба тулгамдсан асуудал” сэдэвт хэлэлцүүлэгт ЦХХХ-ны сайд Н.Учрал хэлсэн үгэндээ “...Цахим шилжилт нь зөвхөн технологийн асуудал биш юм. Холбогдох харилцааг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм журам буюу процесс, ажиллуулж чаддаг, ашиглаж чаддаг хэрэглэгч, тохиромжтой технологийн шийдэл нийлж байж цахим шилжилт амжилттай хэрэгжинэ. Тиймээс өнөөдөр манай улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй 109 хуульд цахим шилжилтийг тусгасан нэмэлт, өөрчлөлтийг боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлэн батлуулж, энэ жилийн 3 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөж эхлээд байна. 109 хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр шийдсэн гол өөрчлөлтүүдийн нэг нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд цаасан болон цахим эх хувийг адил тэнцүү, аль түрүүлж үүссэн хэлбэрийг нь эх нотлох баримтаар тооцох зохицуулалтыг тусгасан. Энэ өөрчлөлт нь шүүхийн цахим шилжилтэд маш том дэмжлэг, суурь нөхцөлийг нь хангаж өгч байна. Тухайлбал шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргахдаа цахим хэлбэрээр, “e-Mongolia”-аар, киоскоор дамжуулан гаргаж болно. Үүнийг хэвлэхгүй, цахим хэлбэрээр нь ХУР-аар дамжуулан шүүхийн системд илгээх, бусад нотлох баримт, лавлагаа тодорхойлолтыг албаны цахим шуудан, лавлагаа системээс мөн цахим хэлбэрээр нь бүрдүүлэн авч цахим хавтаст хэрэг бүрдүүлэх боломжтой. Цаашид хэрэг хянан шийдвэрлэх процессын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа юм...” талаар дурджээ.

Мөн ЧД-ийн ЭХАШШ-ийн шүүгч Л.Галбадар “Эрүүгийн шүүхийн цахимжилт, тулгамдсан асуудал” сэдэвт илтгэлдээ “...Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлдээ цахимжих боломжгүй. Зарим цахимжих боломжгүй ажиллагаа байгаа харин шүүхийн зөвшөөрөл, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэрэг, зөрчлийн хэргийн хүрээнд цахимжилт хийгдэх бүрэн боломжтой. Үүний тулд Цагдаагийн байгууллага зөрчил, гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл ирэхэд тухайн гомдол, мэдээллийн дагуу хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа сонголттойгоор буюу цахимаар эсвэл уламжлалт цаасан суурьтайгаар нотлох баримт бүрдүүлэх боломжийг хуульд тусгаж өгөх нь зүйтэй. Монголын хөрөнгө, хохирол үнэлэгчдийн холбоо цахимаар хохирлынхоо үнэлгээг гаргаад тоон гарын үсгээр баталгаажуулан явуулж болдог болсон гэсэн ч одоогийн байдлаар үүнийг шууд хэвлээд хавтаст хэрэгт хийх боломжгүй. Хэрэв цахим хавтаст хэрэгтэй байсан бол шууд татаад хавтаст хэрэгт хавсаргах боломжтой. Иймээс хэдийгээр нэг талдаа цахимаар нотлох баримт цуглуулах боломж байгаа боловч одоогийн практикт заавал цаасан хэлбэрт буулгаж, нотлох баримтаа бүрдүүлж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим суурьтай нотлох баримт, цахим хавтаст хэрэг бүрдүүлэх зохицуулалтыг тусгаж өгөх шаардлагатай. Энэ нь хуульдаа тусгаагдаж байж практикт хэрэгжих боломж нь бүрдэнэ. Түүнээс хууль заагаагүй эх сурвалж нотлох баримт болохгүй, нотолгооны чанараа алдана. Үүнийг анхаарах зайлшгүй шаардлагатай. Түүнчлэн, шүүх хуралдааны цахимаар явуулах асуудлыг журмаар бус хуульдаа тусгаж өгөх хэрэгтэй...” гэжээ.

Дээрх хурал, хэлэлцүүлгийн үр дүнгээс харахад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас мөрдөгч нотлох баримт цуглуулж, хавтаст хэрэг бүрдүүлдэгээрээ ялгаатай болохын хувьд шүүхийн цахимжилт нь цагдаагийн байгууллага, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цахимжилт өөр хоорондоо шууд харилцан хамааралтай байна.

Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн ач холбогдол, хэрэгцээ, шаардлага нөхцөл байдлын талаар холбогдох мэргэжилтэн, судлаач дараах мэдээллийг өгсөн юм.

Шигтгээ 4.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахимжилтын нөхцөл байдлыг авч үзвэл одоогоор хавтаст хэргийг цахим байдлаар аривлаж буй үйл ажиллагаа хамаарч байна. Мөн түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 18 төрлийн баримт бичгийг шүүхээс цахимаар (Үүнд e-mongolia системээс авч болох иргэний үнэмлэхний лавлагаа, төрсний бүртгэлийн лавлагаа гэх мэт) шүүхийн тамгын газраар дамжуулан авч байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хавтаст хэргийг цахимаар бүрдүүлэх нь тухайн үйл ажиллагааны ил тод байдал, хэргийг талуудад танилцуулах ач холбогдолтой.

Нийгэмд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хавтаст хэрэг, баримт бичгийг ашиглах хэрэгцээ, шаардлага бий болоод байгаа. Тухайн харилцааг хуульчлахаас илүү нийгмийн харилцаанд цахим үйл ажиллагаа ихээр бий болоод байгааг хүлээн зөвшөөрөх ёстой. Тухайлбал, одоогийн байдлаар хүмүүсийн цахим хэрэглээ ихэсч эмнэлэгт цаг авахаас эхлүүлээд хэрэглээний зээлийг хүртэл цахимаар авахаар болсон. Ковид-19 цар тахлын үед цахим хэрэглээ хурдацтай нэмэгдэж ихэнх үйл ажиллагааг цахимаар явуулах практик суусан. Үүнээс гадна цахим багц хууль батлагдсан нь энэ төрлийн харилцааг зохицуулах шаардлагатайг харуулж байна.

Гэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хавтаст хэргийг цахимжуулах тал дээр хэд хэдэн хүндрэлтэй асуудлууд бий болж болох юм. Тодруулбал, хавтаст хэргийг цахимжуулсны дараа мэргэжлийн оролцогч болон энгийн оролцогчдыг тусад нь ялгаж авч үзэх; хэрэгжүүлэгч байгууллагуудын цахим системийн хоорондын уялдаа холбоог хангах, аюулгүй байдлыг хангах, программ хангамжийг сайжруулах, хадгалах багтаамж (storage)-ийг нэмэгдүүлэх гэх мэт. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулахдаа нэгэнт бий болоод байгаа нэгдсэн платформууд болох e-mongolia систем, ХУР систем, Дан системийг ашиглах шаардлагатай.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гишүүн Н.Баасанжавтай хийсэн ярилцлагын хэсгээс...

Түүнчлэн, цахим нотлох баримт, цахимжуулсан нотлох баримт, цахим хавтаст хэргийн асуудал нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлэх буюу гомдол, мэдээлэл хүлээн авахаас эхлэн цахим эсвэл цаасан суурьтай хавтаст хэрэг бүрдүүлэх сонгох боломжийг хуульд тусгах, хэргийн оролцогч, өмгөөлөгч, прокуророос шүүхэд хандаж буй гомдол, хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх журмыг хуульд тусгах, зарим төрлийн /зөрчил, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэрэг/ хэрэгт цахим хавтаст хэрэг үүсгэх боломжийг сонголттойгоор хуульчлах гэх мэт асуудлыг цахимжилтын хүрээнд нэн тэргүүнд шийдвэрлэж, хэрэгжүүлэх боломжтой.

1.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн харьцуулсан судалгаа

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн харьцуулсан судалгааг хийхдээ шүүх, хууль, эрх зүйн үйл ажиллагааг цахимжуулах талаар дэвшил гаргасан, эрх зүйн тогтолцооны хувьд жишиг болгож судалдаг дараах улсуудыг судалсан юм.

1.3.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын сайн туршлага

ХБНГУ-ийн жишиг

ХБНГУ-ын хувьд анхлан “Шүүх байгууллагын цахим үйл ажиллагааг дэмжих тухай хууль”-ийг¹⁰ Холбооны засгийн газрын санаачилгаар “*Орчин үеийн техник, технологийн*

¹⁰ Шүүх байгууллагын цахим үйл ажиллагааг дэмжих тухай хууль (Gesetz zur Förderung des elektronischen Rechtsverkehrs mit den Gerichten, 2013)

дэвшлийг ашиглан цахим хууль зүйн үйл ажиллагааг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд таниулан сурталчлах, шүүх эрх мэдлийн байгууллагын цахимаар үйл ажиллагаа явуулахад учирч буй хүндрэлийг бууруулах, харилцааны шинэ сувагтай харьцах хэрэглэгчдийн итгэлийг бэхжүүлэхэд чиглэсэн хууль эрх зүйн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх...”¹¹ зорилгоор боловсруулж, Бундестагаас 2013 оны 10 дугаар сарын 10-ны өдөр батлан гаргасан бөгөөд ХБНГУ-ын холбооны засгийн газраас уг хуулийг дагаж мөрдөх зардал нь улсын төсөвт дарамт учруулахгүй буюу шүүхийн үйл ажиллагаа цахимжсанаар шуудангаар (шуудан, факсын хураамж) болон цаасаар харилцах, үйл ажиллагаа явуулахтай харьцуулахад хэмнэлттэй, зардал буурна гэж үзсэн байна.¹²

Уг хуулийн дагуу,

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (ZPO);
- Гэр бүлийн шүүхийн тухай хууль (FamFG);
- Хөдөлмөрийн шүүхийн тухай хууль (ArbGG);
- Нийгмийн шүүхийн тухай хууль (SGG);
- Захиргааны хэргийн шүүхийн хууль (VwGO);
- Санхүүгийн шүүхийн тухай хууль (FGO)

зэрэг нийт ХБНГУ-ын 23 хууль тогтоомжид өөрчлөлт орж дээрх салбар эрх зүйн шүүх байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулах буюу хуульч, эрх бүхий байгууллагууд шүүхүүдтэй харилцахдаа цахим хэлбэрээр харилцах, шүүхийн үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичгийг цахимаар дамжуулах арга, хэрэгслийг тодорхойлох зэрэг асуудлын эрх зүйн үндсийг тавьсан боловч уг хуулийн үйлчлэх хүрээнд үндсэн хуулийн болон ЭХХШТХ багтаагүй байна.

Ийнхүү олонх салбар эрх зүйн шүүх байгууллагын үйл ажиллагаанд цахим хэлбэрийг нэвтрүүлэх ажил үе шаттайгаар хэрэгжиж 2017 оны 7 дугаар сарын 12-ний өдөр Бундестагаас нэмэлтээр “Шүүхийн үйл ажиллагаанд цахим хавтаст хэргийг нэвтрүүлэх, цаашид цахим хууль зүйн үйл ажиллагааг дэмжих тухай хууль”-ийг¹³ нэмэлтээр баталж 2018 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон байна. Уг хуулийн төслийг боловсруулсан ажлын хэсгийн зөвлөмж, тайланд уг хуулийг баталан гаргах замаар холбогдох салбар эрх зүйн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хавтаст хэргийн удирдлагыг нэвтрүүлэх нэмэлт өөрчлөлтийг хийх болсон шалтгаан буюу тулгамдаж буй асуудал, түүний шийдлийг дараах байдлаар тусгасан байна.

¹¹ Beschlussempfehlung und Bericht des Rechtsausschusses zu dem Gesetzentwurf der Bundesregierung Drucksache 17/12634 – vom 12. Juni 2013, Verfügbar um <https://dserver.bundestag.de/btd/17/139/1713948.pdf>

¹² Gesetzentwurf der Bundesregierung BT-Drucksache 17/12634 vom 6. März 2013, S. 3 ff, Verfügbar um <https://dserver.bundestag.de/btd/17/126/1712634.pdf>

¹³ ХБНГУ-ын Шүүхийн үйл ажиллагаанд цахим хавтаст хэргийг нэвтрүүлэх, цаашид цахим хууль зүйн үйл ажиллагааг дэмжих тухай хууль (Gesetz zur Einführung der elektronischen Akte in der Justiz und zur weiteren Förderung des elektronischen Rechtsverkehrs, 2017).

2017 оны 4-р сарын 28-ны ХБНГУ-ын засгийн газрын хуулийн төслийн талаарх хууль зүйн болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах хорооны (6-р хороо) тогтоолын зөвлөмж, тайлан /18/9416/ ¹⁴

Асуудал

Шүүхийн байгууллагын эрхлэн явуулдаг ихэнх хянан шийдвэрлэх ажиллагаа нь олон жилийн турш цахим хэлбэрийн сонголттой байсаар ирсэн бөгөөд 2013 оны 10-р сарын 10-ны өдрийн “Шүүх байгууллагын цахим үйл ажиллагааг дэмжих тухай хууль”-иар цахим хууль зүйн үйл ажиллагааны зохицуулалтыг үндсээр нь шинэчилж, шүүх байгууллагуудын эрхлэн явуулдаг ихэнх хянан шийдвэрлэх ажиллагаа нь олон жилийн турш цахим хэлбэрийн сонголттой байсаар ирсэн. Харин эрүүгийн хавтаст хэрэг өнөөг хүртэл цаасан хэлбэрээр байгаа боловч тэдгээрт агуулагдаж буй баримт бичгийн дийлэнх нь цахим мэдээлэл боловсруулалтыг ашиглан үүсгэгдсэн байх бөгөөд өдөр ирэх тусам цахимаар дамжуулагдах зэргээр цахимжсаар байна. Энэ нь одоогийн эрх зүйн зохицуулалтаар эцсийн үр дүн нь цаасан баримт бичиг боловч шүүх хавтаст хэргийг хөтлөн явуулах үйл ажиллагаагаа цахимаар явуулах бүрэн боломжтой болсон гэсэн үг юм.

Холбооны засгийн газар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ч мөн техник технологийн дэвшлийг тусгах, эрүүгийн эрх зүйн тогтолцоог шинэчлэх зорилготой медиа сувгийг өөрчлөх урьдчилсан нөхцөл болгон цахим хавтаст хэргийг нэвтрүүлэх эрх зүйн үндсийг бий болгохоор зорьж байна. Уг ажлын хүрээнд эрүүгийн хэргийн цахим хавтаст хэрэг, үйл ажиллагааны зохицуулалтыг бусад харьяалах эрх зүйн салбартай нэгэн адил буюу 2013 онд бий болгосон эрх зүйн зохицуулалттай нийцүүлэхээр төлөвлөж байна. Мөн хууль зүйн мэргэжлийн хэрэглэгчийн давхар сувгаар дамжилгүйгээр цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны порталд шууд хандан хавтаст хэрэгтэй танилцах, ашиглах үүргийг өргөжүүлэх үүднээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд ч холбогдох нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай байна.

Шийдэл

Хуулийн төслийг нэмэлт, өөрчлөлтөөр батлах тухай. Тодруулбал, Хорооноос цахим хавтаст хэргийн удирдлагыг зөвхөн Эрүүгийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд төдийгүй бусад процессийн хууль тогтоомжид (11-23-р зүйл) тусгаж өгөхийг зөвлөж байна. Энэ нь шүүхийн байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь цахимжуулах ажлыг дуусгах сүүлийн хугацаа нь 2026 он юм. Нэмж дурдахад баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэх журмыг бүх процедурын зохицуулалтад стандартчилж, үйлчилгээнд тавигдах шаардлагын талаар хялбаршуулсан байх ёстой (StPO – Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн §32e(3); ZPO – Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §§ 169, 298a(2); VwGO – Захиргааны хэргийн шүүхийн тухай хуулийн § 55b(6) хэсгийн тус тус үзнэ үү). Шүүх, прокурорууд хавтаст хэрэгт хандах эрх олгоход илүү уян хатан хандах боломжийг олгохын тулд хавтаст хэрэгт хандах журамд өөрчлөлт оруулах шаардлагатай (StPO-E-ийн 32f хэсэг, 299-р зүйлийн (3) дахь хэсэг, VwGO-ийн 100-р зүйлийн (2) дахь хэсгийг үзнэ үү). Эцэст нь тус хорооноос Шүүхийн Үндсэн хуулийн хуульд заасан харьяаллын төвлөрөлтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шилжүүлэхийг зөвшөөрөх тухай тодорхой заалт оруулахыг зөвлөж байна (28 дугаар зүйл).

(Хэсэгчлэн авав)

¹⁴ Beschlussempfehlung und Bericht des Ausschusses für Recht und Verbraucherschutz (6. Ausschuss) zu dem Gesetzentwurf der Bundesregierung, Deutscher Bundestag, Drucksache 18/12203, Wahlperiode 28.04.2017. Verfügbar um <https://dserver.bundestag.de/btd/18/122/1812203.pdf>

Уг хуулийн холбогдох хэсгийн дагуу ХБНГУ-ын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт орсон байна. Тухайлбал тус хуулийн 1, 2 дугаар зүйлийн дагуу тус тус ЭХХШТХ-ийн 1-р бүлгийн “Хавтаст хэргийн удирдлага (менежмент) ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь харилцаа холбоо” гэсэн 4-р дэд бүлэгт “Цахим хавтаст хэргийн удирдлага (менежмент), түүнтэй холбоотой хуульд заасан арга хэмжээ авах бүрэн эрх” гэсэн 32 дугаар зүйлийг 32a, 32b, 32c, 32d, 32f, 32e гэсэн 6 дэд зүйлийн хамтаар; 8-р бүлэгт “Цахим хавтаст хэрэг дэх хувийн мэдээллийг хамгаалах; цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувийн мэдээллийг ашиглах” гэсэн 4 зүйл (496, 497, 498, 499-р зүйл) бүхий 4-р дэд бүлгийг тус тус нэмсэн байна. Ийнхүү шүүх, прокурорын байгууллагын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны материалыг цахим хэлбэрээр ашиглах, хадгалах, дамжуулах журам, тэдгээрийн эрх зүйн үндсийг ЭХХША-ны хууль тогтоомжид баталгаажуулсан байна.

ХБНГУ-ын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль” дахь цахим хавтаст хэргийн зохицуулалтын агуулга (гарчиг)¹⁵

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Дэд бүлэг 4. Хавтаст хэргийн удирдлага ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь харилцаа холбоо

- *32-р зүйл Цахим хавтаст хэргийн удирдлага, түүнтэй холбоотой хуульд заасан арга хэмжээ авах бүрэн эрх*
- *Зүйл 32a Прокурорын байгууллагууд болон шүүхүүдийн цахим харилцаа холбоо; хуульд заасан арга хэмжээ авах бүрэн эрх*
- *Зүйл 32b Прокурорын байгууллага, шүүхийн ашиглаж буй цахим баримт бичгийг бүрдүүлэх, дамжуулах; хуульд заасан арга хэмжээ авах эрх*
- *Зүйл 32c Цахим хэлбэр; хуульд заасан арга хэмжээ авах эрх*
- *Зүйл 32d Цахим дамжуулалтын үүрэг*
- *Зүйл 32e Хавтаст хэргийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор баримт бичгийг хувиргах (хөрвүүлэх)*
- *Зүйл 32f Хавтаст хэргийн шалгалт (Танилцах буюу хандах эрх); хуульд заасан арга хэмжээ авах эрх*

НАЙМДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН ХАМГААЛАЛТ БА ХЭРЭГЛЭЭ

Дэд бүлэг 4. Цахим хавтаст хэрэг дэх хувийн мэдээллийг хамгаалах; цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувийн мэдээллийг ашиглах

- *496-р хэсэг Цахим хавтаст хэрэг дэх хувийн мэдээллийг ашиглах*
- *497-р хэсэг Мэдээллийг (өгөөдлийг) түүний хянах этгээдийн нэрийн өмнөөс боловсруулах*
- *498-р хэсэг Цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувь хүний мэдээллийг ашиглах*
- *499-р хэсэг Хавтаст хэргийн цахим хуулбарыг устгах*

*Тухайн зохицуулалтуудын орчуулгыг дэлгэрүүлэн Хавсралт хэсэгт оруулсан болно

¹⁵ ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Strafprozeßordnung – StPO, 1987)

ХБНГУ-ын Хамбург мужийн туршлага

Дээр дурдсанчлан Холбооны Бундестагаас 2017 оны 7 дугаар сарын 12-ний өдөр баталсан “Шүүхийн үйл ажиллагаанд цахим хавтаст хэргийг нэвтрүүлэх, цаашид цахим хууль зүйн үйл ажиллагааг дэмжих тухай хууль”-иар холбооны ЭХХШТХ-д эрүүгийн хавтаст хэргийг цахимаар хөтлөх хууль зүйн зохицуулалтын үндсийг тавьснаас гадна муж улсын засгийн газруудад *цахим хавтаст хэргийг хадгалах хугацаа, түүнчлэн цахим хавтаст хэрэг үүсгэх, удирдах, хадгалахад хамаарах зохион байгуулалт, техникийн тогтолцооны нөхцөл, журам зэргийг батлан гаргах муж улсын хэмжээнд мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, үүнтэй холбоотой зарим бүрэн эрхийг холбогдох муж улсын яамдад шилжүүлэх* бүрэн эрхийг олгосон байна. Мөн муж улс бүр цахим хавтаст хэрэгтэй холбоотой холбогдох эрх зүйн зохицуулалт, дүрэм, журмыг батлах, дагаж мөрдөх ажлыг холбооны улсын хэмжээнд 2026 оны 1-р сарын 1-ний өдөр гэхэд зохион байгуулж дуусгахаар дээрх хуульд зохицуулсан.

Дээрх зохицуулалтын дагуу ХБНГУ-ын муж улс бүр уг ажлыг өөр хоорондоо харилцан адилгүйгээр хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа олон жишээ байна (Хамбург, Баден-Вюртемберг, Байерн г.м). Эдгээр мужуудаас энд ХБНГУ-ын Хамбург мужийн туршлагыг энд дурдаж болно.

Хамбург мужийн засгийн газраас (парламент) 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр “Хамбург мужийн шүүхүүд дэх цахим хавтаст хэргийн удирдлагын тухай журам”-ыг батлан гаргасан байна¹⁶. Уг журмаар цахим хавтаст хэргийн удирдлагын талаар илүү нарийн зохицуулалтыг хийсэн бөгөөд тухайлбал,

- Эрүүгийн хэрэг болон зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль (StPO, OWiG);
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (ZPO);
- Гэр бүлийн маргаан болон маргаангүй харьяал бүхий нэхэмжлэл хянан шийдвэрлэх тухай хууль (FamFG);
- Хөдөлмөрийн шүүхэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль (ArbGG);
- Нийгмийн шүүхийн тухай хууль (SGG);
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (VwGO);
- Санхүүгийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (FGO) зэрэг хуулиудтай холбоотой цахим хавтаст хэргийн удирдлага болон гомдол, нэхэмжлэлийг цахимаар гаргах журмыг нарийвчлан зохицуулсан байна.

Ийнхүү Хамбург мужид 2019 оноос цахим хавтаст хэргийн удирдлагыг шүүхийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн, хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаандаа ашиглаж нэвтрүүлэх ажил амжилттай явагдаж байна. Үүнийг “Хамбург мужийн шүүхүүд дэх цахим хавтаст хэргийн удирдлагын тухай журам”-ын хавсралт 1 дүгээр хавсралт дахь уг журам үйлчлэх мужийн шүүх болон прокурорын байгууллагуудын жагсаалтаас харж болох бөгөөд

¹⁶Verordnung über die elektronische Aktenführung in der Hamburger Justiz (HmbEAktFVO, 2019) Verfügbar um <https://www.landesrecht-hamburg.de/bsha/document/jlr-JElektAktfVHAV9Anlage1/partX>

тус мужийн цахим хавтаст хэргийн удирдлагатай холбоотой журам, зохицуулалт улам бүр нарийвчилсан болж шинэчлэгдсээр байна¹⁷.

ХБНГУ-ын Хамбург мужийн “Хамбург мужийн шүүхүүд дэх цахим хавтаст хэргийн удирдлагын тухай журам”-ын агуулга (гарчиг)¹⁸

§ 1. Цахим хавтаст хэргийн хөтлөх журам

§ 2. Цахим хавтаст хэрэг үүсгэх

§ 3. Цаасан баримт бичгийг цахим хэлбэрт хувиргах

§ 4. Цахим хавтаст хэргийг дамжуулах

§ 5. Орлуулах арга хэмжээ

§ 6. Хүртээмжтэй байдал

Хавсралт 1 - Журам үйлчлэх шүүх, прокурорын байгууллагуудын жагсаалт

Хавсралт 2 - Журам үйлчлэх Хамбург мужийн дээд шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаа, үйлчилж эхлэх хугацаа

Хавсралт 3 - Цахим хэлбэрт шилжүүлэх цаасан хэлбэрээр байгаа үндсэн хавтаст хэрэг/бүртгэлийн хавтаст хэргийн жагсаалт

Хавсралт 4 - Цаасан хэлбэрээр үүсгэсэн хавтаст хэргийг цахим үргэлжлэлийг 1-р хэсгийн 1-р зүйлийн 4-р зүйлийн 1-р зүйлийн дагуу захиалах журам, хугацаа

Дээрхээс дүгнэвэл, ХБНГУ-ын хувьд олон тооны хууль тогтоомжид өөрчлөлт оруулж шүүх байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулах буюу хуульч, эрх бүхий байгууллагууд шүүхүүдтэй харилцахдаа цахим хэлбэрээр харилцах, шүүхийн үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичгийг цахимаар дамжуулах арга, хэрэгслийг тодорхойлох зэрэг асуудлын эрх зүйн үндсийг тавьсан боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд төдийлэн өөрчлөлт ороогүй байсан. Улмаар 2017 оны 7 дугаар сарын 12-ний өдөр Бундестагаас нэмэлтээр “Шүүхийн үйл ажиллагаанд цахим хавтаст хэргийг нэвтрүүлэх, цаашид цахим хууль зүйн үйл ажиллагааг дэмжих тухай хууль”-д нэмэлт оруулж үүний дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар цахим хавтаст хэргийн зохицуулалт бий болсон байна. Энэхүү зохицуулалтад цахим хавтаст хэргийн удирдлага, түүнтэй холбоотой хуульд заасан арга хэмжээ авах бүрэн эрх, прокурорын байгууллагууд болон шүүхүүдийн цахим харилцаа холбоо, прокурорын байгууллага, шүүхийн ашиглаж буй цахим баримт бичгийг бүрдүүлэх, дамжуулах; хуульд заасан арга хэмжээ авах эрх, цахим хавтаст хэрэг дэх хувийн мэдээллийг ашиглах, мэдээллийг түүний хянах этгээдийн нэрийн өмнөөс боловсруулах, цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувь хүний мэдээллийг ашиглах гэх мэт боловсронгуй, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, үйл ажиллагааг үр дүнтэй болгоход чиглэсэн олон нарийвчилсан зохицуулалт орсон нь сайн жишиг болж байна. Мөн түүнчлэн холбооны хэмжээнд бус мужийн хэмжээнд нарийвчилсан, боловсронгуй зохицуулалтууд бий болсон байна. Тухайлбал, Хамбург мужийн засгийн газраас 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан “Хамбург мужийн шүүхүүд дэх цахим хавтаст хэргийн удирдлагын тухай журам”.

¹⁷ Elektronische Akte in der Justiz, 2024.02.28, <https://justiz.hamburg.de/e-justice/elektronische-akte-in-der-justiz> zuletzt besucht 2024.03.20.

¹⁸ Мөн тэнд.

Монгол Улсын хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим хавтаст хэргийн талаар тусгахдаа ХБНГУ-тай адилаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн зохицуулалтыг сүүлд нь зохицуулж байгаа тул ХБНГУ-ын сайн жишгийг баримтлах нь зүйтэй байна. Тодруулбал, цахим хавтаст хэргийн удирдлага, түүнтэй холбоотой хуульд заасан арга хэмжээ, прокурорын байгууллагууд болон шүүхүүдийн цахим харилцаа холбоо, прокурорын байгууллага, шүүхийн ашиглаж буй цахим баримт бичгийг бүрдүүлэх, дамжуулах; хуульд заасан арга хэмжээ, цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувь хүний мэдээллийг ашиглах гэх мэт боловсронгуй зохицуулалтын агуулга, зарчмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн тусгах шаардлагатай.

1.3.2. Бүгд Найрамдах Эстони Улсын сайн туршлага

Эстони улсын хувьд бусад улс орнуудтай харьцуулхад шүүхийн байгууллагын үйл ажиллагаа харьцангуй эрт буюу 2009 оноос нэвтэрч эхэлсэн бөгөөд шүүхийн үйл ажиллагааг дижитал болгосноор улс орны эдийн засаг, төрийн үйлчилгээний чанар, хөдөлмөрийн зах зээл, бизнесийн өсөлт зэргийг нэмэгдүүлнэ хэмээн үзсэн байна. Сүүлийн 15 жилийн хугацаанд Эстони улс шүүхийн тогтолцоог дижитал болгоход ихээхэн хүчин чармайлт гаргасан бөгөөд шүүхийн удирдлага, үйл ажиллагаа, шүүх болон бусад талуудын харилцаа холбоонд мэдээлэл, харилцаа холбооны хамгийн сүүлийн үеийн технологийг нэвтрүүлсэн орны нэг юм¹⁹.

Эстони улсын шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагын цахимжуулалт

Эстони улс шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааныхаа хурдаараа Европт хоёр дугаарт ордог. Эстони улсын цахимжуулсан шүүхийн систем нь цахим хавтаст хэргийн төв мэдээллийн систем (e-File), шүүхийн мэдээллийн систем (KIS), иргэд болон бусад талуудад зориулсан олон нийтийн портал гэсэн үндсэн гурван хэсгээс бүрддэг.

Цахим хавтаст хэргийн систем буюу e-File нь Эстонийн шүүхийн системийн хамгийн чухал нь юм. Энэхүү төв мэдээллийн систем нь шүүхийн мэдээллийн систем болох KIS2, цагдаа, хорих байгууллага, прокурор, эрүүгийн хавтаст хэргийн удирдлагын мэдээллийн системийг датагаар хангадаг. Мэдээллийг нэг л удаа оруулдаг тул цахим хавтаст хэрэг (e-File) нь цаг хугацаа, мөнгө хэмнэдэг бөгөөд талуудын хоорондын бүх харилцаа цахим хэлбэрээр явагддаг.

Эстонийн **шүүхийн мэдээллийн систем KIS2²⁰** нь шүүхийн бүхий л хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдах цогц шийдэл юм. Энэхүү цогц шийдлийг Хууль зүйн яам Эстонийн шүүхүүдэд хариуцан хэрэгжүүлсэн бөгөөд 2014 оноос эхлэн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.

¹⁹ Factsheet E-Justice. Available at <https://e-estonia.com/wp-content/uploads/2020mar-facts-a4-v04-e-justice.pdf>

²⁰ БНЭСУ-ын Шүүхийн мэдээллийн системийн, <https://www.rik.ee/en/international/court-information-system>

Эстонийн шүүхүүдэд тулгарч байсан хамгийн том хүндрэл бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чухал баримт бичгүүдийг талуудад хүргэх явдал байсан. Энэхүү асуудлыг шүүхийн **олон нийттэй харилцах портал e-File**²¹ шийдэж, шүүхэд виртуал хэлбэрээр олон нийттэй харилцах боломжийг олгосон. Энэхүү портал дээр тал бүрийн хэрэг үүсгэж, аливаа баримт бичигт хандаж, илгээх боломжтой. Анхны нэхэмжлэлийг 24/7 нийтийн порталаар дамжуулан гаргаж болно. Ажлын урсгалын хөдөлгүүр нь хуваарилагдсан шүүгчид шаардлагатай өгөгдлийг порталаар дамжуулан хүргэдэг.

Эстонийн шүүхүүд дэх мэдээлэл, харилцаа холбооны технологийн (ICT) түүх

- 2002 он – Шүүхийн шийдвэрүүд болон статистик тоо баримт нийтлэх зорилгоор анхны шүүхийн цахим мэдлээллийн систем KOLA нэвтрүүлэв.
- 2006 он – Баримт бичгийн удирдлагыг хэрэгжүүлэх, автоматжуулсан мэдэгдэл, урилга зэргийг илгээх үндсэн чиг үүрэг бүхий 1-р үеийн цогц шүүхийн мэдээллийн систем KIS-г хэрэглээнд нэвтрүүлэв.
- 2009 он – анхны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талууд (цагдаа, прокурор, хуульч, өмгөөлөгч, иргэд г.м) хороондоо харилцах боломж бүхий олон нийттэй харилцах порталыг хэрэглээнд нэвтрүүлэв.
- 2013-2014 он – 2-р үеийн шүүхийн мэдээлэл KIS2 системийг хэрэглээнд нэвтрүүлэв.
- 2015 он – Цаасгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэв.
- 2017 он – Торгуулийг автоматаар хураадаг болов.

Эстони улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дахь цахим хавтаст хэргийн зохицуулалт

Өмнөх хэсэгт дурдсанчлан Эстони улс нь шүүхийн үйл ажиллагаа буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаа бүрэн цахимжуулсан бөгөөд ЭХХША-нд хавтаст хэргийн E-File системийг нэвтрүүлсэн байна. Эстони улсын ЭХХШТХ-даа Цахим хавтаст хэргийн систем E-file-н (210-р зүйл) талаар болон бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе дэх цахим хавтаст хэргийн системийг ашиглах зохицуулалтын тус тус хийсэн байна.

БНЭсУ-ын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль” дахь цахим хавтаст хэргийн (E-File) зохицуулалт²²

§ 149. Гэрэл зураг

(3) Дижитал гэрэл зургийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аливаа шийдвэрт тусгаж, эсхүл хавсралт болгон танилцуулж, компьютерийн файл хэлбэрээр цахим хавтаст хэргийн системд (E-File) хадгална. Дижитал гэрэл зураг нь видео бичлэгээс авсан дан зураг (скрийн шот) байж болно.

[RT I 2008, 28, 180 - 2008.07.15 хүчин төгөлдөр болсон]

§ 156¹. Шүүх хуралдааны бичлэг, тэмдэглэлийг шалгах

²¹ БНЭсУ-ын Шүүхийн олон нийттэй харилцах порталын вебийн <https://www.rik.ee/en/international/public-e-file>

²² БНЭсУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Kriminaalmenetluse seadustik, 2003) <https://www.riigiteataja.ee/akt/104102013004>

(4) Шүүх хуралдааны дууны (аудио) бичлэгийн хуулбарыг шүүхийн байгууллага холбогдох хүсэлтийг гаргаснаас хойш гурав хоногийн дотор дижитал мэдээллийн хэрэгслээр гаргах буюу цахим хэрэгслээр илгээнэ. Шүүх хуралдааны аудио бичлэгийг цахим хавтаст хэргийн системээр (E-File) прокурорт нээлттэй болгож байна.

§ 156². Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг шүүх хуралдаанд бэлэн болгох

(1) Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх баримт бичгийг шүүх хуралдааны оролцогчдод хэрхэн хүргэж байгаагаас үл хамааран E-File систем дэх шүүх хуралдаанд оролцогчдод нэн даруй нээлттэй болгоно.

§ 160¹. Хавтаст хэрэг

(5) Шүүхийн хэргийг дижитал хэлбэрээр хөтөлж байгаа бол цаасан баримтыг сканнердаж, холбогдох журмын дагуу цахим файлын системд хадгална. E-File систем нь баримт бичгийн хадгалагдсан хугацаа, түүнийг хадгалж буй хүний мэдээллийг автоматаар бүртгэнэ. Цахим файлын системд хадгалагдсан баримт бичиг цаасан баримтыг орлоно.

§ 160². Цахим (дижитал) баримт бичгийг дамжуулах

(1) Энэ хуульд өөрөөр заагаагүй бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахим (дижитал) хүсэлт, давж заалдах болон бусад баримт бичгийг шууд буюу цахим хавтаст хэргийн системээр (E-File) дамжуулна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллага нь шууд илгээсэн цахим баримт бичгийг (дижитал) цахим хавтаст хэргийн системд (E-File) оруулна.

[RT I 2008, 28, 180 - 2008.07.15 хүчин төгөлдөр болсон]

(2) Цахим (дижитал) баримт бичгийг эрүүгийн хавтаст хэрэгт хавсаргахын тулд баримт бичгийг хэвлэж, хавтаст хэрэгт оруулна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллага нь хэвлэсэн баримт бичгийн үнэн зөв, тоон баримт бичигтэй тохирч байгааг өөрийн гарын үсгээр баталгаажуулж, цахим хавтаст хэргийн системд (E-File) тухайн баримт бичгийн таних дугаарыг нэмж оруулна.

[RT I 2008, 28, 180 - 2008.07.15 хүчин төгөлдөр болсон]

§ 165. Бичгээр зарлан дуудах хуудас хүргэх журам

(4) Хэрэв зарлан дуудах хуудсыг цахим хавтаст хэргийн системээр (E-File) дамжуулан авах боломжтой бол дуудагдсан этгээдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичигт заасан цахим шуудангийн хаягаар нь зарлан дуудах хуудас байгаа тухай мэдэгдэнэ. Ийнхүү шүүхийн зарлан дуудаж байгаа мэдэгдэлд цахим хавтаст хэргийн (E-File) систем дэх тоон (дижитал) зарлан дуудах хуудасны лавлагааг хавсаргах бөгөөд түүнд хандах хугацаа нь зарлан дуудах хуудас илгээсэн өдрөөс хойш гурав хоног байна. Илгээгч болон түүнийг илгээсэн цагийг E-File системээр тодорхойлох боломжтой бол зарлан дуудах хуудасны хамт тоон гарын үсэг оруулахгүй. Хүлээн авагч нь баримт бичгийг нээлгүйгээр мэдээллийн системд нээсэн буюу мэдээллийн системд хүлээн авснаа баталгаажуулсан бол цахим файлын системээр дамжуулан авах боломжтой зарлан дуудах хуудсыг хүргүүлсэн гэж үзнэ. Мэдээллийн систем дэх баримт бичгийг хүлээн авагч идэвхжүүлсэн. Хэрэв зарлан дуудах хуудсыг илгээсэн өдрөөс хойш гурав хоногийн дотор цахим хавтаст хэргийн системээр хүлээн аваагүй бол зарлан дуудах хуудсыг шуудангаар илгээх, эсхүл зарлан дуудагдаж буй этгээдэд өөр нь гардуулна.

[ТХГН-ийн I, 2013.03.22, 9 - хүчин төгөлдөр болох 2013.04.01]

(5) Гарын үсгийн эсрэг зарлан дуудах хуудас гардуулах тухай мэдэгдэл, шуудангийн үйлчилгээ үзүүлэгчээс гаргасан хүргэлтийн мэдэгдэл, зарлан дуудах хуудас олгох тухай цахим шуудангийн хэвлэмэл материал, зарлан дуудах хуудсыг хүлээн авсныг баталгаажуулсан цахим шуудангийн хэвлэмэл материалууд зэргийг хавтаст хэрэгт хавсаргана. E-File системээр дамжуулан зарлан дуудах хуудас хүлээн авсан бол хүлээн авсан тухай баримтыг цахим хавтаст хэргийн системд бүртгэж, хэвлэмэл хэлбэрээр хавтаст хэрэгт тусгахгүй.

[RT I, 2011.02.23, 1 - 2011.09.01 хүчин төгөлдөр болсон]

(6) Хууль зүйн сайд нь шүүх хуралдааны явцад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг цахим хавтаст хэргээр (E-File) дамжуулан хүргэхэд илүү тодорхой шаардлагыг журмаар тогтоож болно.

[ТХГН-ийн I, 2013.03.22, 9 - хүчин төгөлдөр болох 2013.04.01]

§ 210. Цахим хавтаст хэргийг боловсруулах мэдээллийн систем (E-File)

(1) Цахим хавтаст хэргийг боловсруулах мэдээллийн систем (цаашид энд E-File гэнэ) нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээлэл, хувийн увийн мэдээллийг боловсруулахад зориулагдсан төрийн мэдээллийн системд хамаарах мэдээллийн сан бөгөөд дараахь зорилготой.

- 1) Мөрдөн шөлгөх байгууллага, прокурор, шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа, түүнчлэн эхлээгүй эрүүгийн хэргийн талаархи тоймыг өгөх;
- 2) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гүйцэтгэгдсэн ажиллагааны мэдээллийг тусгах;
- 3) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллагуудын үйл ажиллагааг зохион байгуулах боломжийг олгох;
- 4) эрүүгийн бодлогын талаар шийдвэр гаргахад шаардлагатай гэмт хэрэгтэй холбоотой статистик мэдээллийг цуглуулах;
- 5) өгөгдөл, баримт бичгийг цахим хэлбэрээр дамжуулах боломжийг бүрдүүлэх.

(2) Мэдээллийн санд дараах мэдээллийг оруулна.

- 1) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй эрүүгийн хэрэг, эхлээгүй, дуусгавар болсон эрүүгийн хэргийн талаархи мэдээлэл;
 - 2) эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гүйцэтгэгдсэн ажиллагааны талаарх мэдээлэл;
 - 3) энэ хуульд заасан тохиолдолд цахим (дижитал) баримт бичиг;
 - 4) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллага, хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид, ял шийтгүүлсэн этгээд, шинжээч, гэрчийн талаарх мэдээлэл;
- [RT I, 2011.02.23, 1 - 2011.09.01 хүчин төгөлдөр болсон]

5) Шийдвэрүүд.

(3) Цахим хавтаст хэргийн системийг бий болгох, түүний ажиллагааны журмыг батлах ажлыг Бүгд Найрамдах Улсын Засгийн газар гүйцэтгэнэ.

(4) Цахим хавтаст хэргийн системийн ерөнхий процессор (боловсруулагч) нь Хууль зүйн яам юм. E-File системийн эрх бүхий процессор нь Хууль зүйн сайдын томилсон хүн байна.

(5) Хууль зүйн сайдын зүгээс E-File системийн үйл ажиллагааны зохион байгуулалтын журмыг батлан гаргаж болно.

(6) Хууль зүйн яам E-File системийн мэдээлэлд үндэслэн жил бүрийн 3-р сарын 1-ний дотор өмнөх оны гэмт хэргийн тайланг нийтэлнэ.

(7) Гэмт хэргийн статистик мэдээллийг Хууль зүйн яам нийтэлнэ.

(8) Гэмт хэргийн статистик мэдээг нийтлэх журмыг Бүгд Найрамдах Улсын Засгийн газар тогтооно.

[RT I 2008, 28, 180 - 2008.07.15 хүчин төгөлдөр болсон]

Дээрхээс дүгнэвэл, Бүгд Найрамдах Эстони Улс нь цахим хавтаст хэргийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд чухалчилж авч үздэг болох нь тодорхойлогдож байна. Тус улс нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульдаа энэ тухай хуульчилж гэрэл зураг, шүүх хуралдааны бичлэг, тэмдэглэлийг шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг шүүх хуралдаанд бэлэн болгох, цахим хавтаст хэргийн

ерөнхий зохицуулалт, цахим баримт бичгийг дамжуулах, бичгээр зарлан дуудах хуудас хүргэх журам, цахим хавтаст хэргийг боловсруулах мэдээллийн системийн талаар нарийвчлан авч үзсэн нь сайн жишиг болохоор байна. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим хавтаст хэргийн зохицуулалтыг тусгахдаа тус улсын жишгийг харгалзан үзэх нь зүйтэй.

1.3.4. Америкийн Нэгдсэн Улсын сайн туршлага

New York-д e filing(цахим хавтас хэрэг, бүртгэл) нь анх 1999 онд хязгаарлагдмал тооны газруудад жижиг ангиллын хэрэгт хэрэглэх эрхтэй болсон. 1999 онд цахим хэлбэрээр хэрэг ирүүлээгүй. 13 жилийн дараа Хууль тогтоох байгууллага цахим мэдүүлгийг ашиглах зөвшөөрлийг аажмаар өргөжүүлснээр ихээхэн ахиц дэвшил гарсан. Нью-Йорк мужын шүүхийн цахим мэдүүлгийн системийн бүртгэлтэй 21,000 гаруй хэрэглэгчийн 350,000 орчим хэрэгт 1,3 сая гаруй баримт бичгийг Нью-Йоркийн шүүхэд цахим хэлбэрээр (“NYSCEF”) өгсөн байна.

Нью-Йоркт үүсгэн байгуулагдсанаасаа хойш цахим хавтаст хэрэг нь найдвартай, үр ашигтай, тохиромжтой, аюулгүй болох нь батлагдсан. NYSCEF хөтөлбөр нь шүүхийн байр руу явах шаардлагагүйгээр шүүхийн баримт бичгийг бараг л агшин зуур, хүссэн үедээ, хаанаас ч гаргаж өгөх боломжийг олгодог. Өмгөөлөгч нар өдөр, шөнийн аль ч цагт, интернэт холболттой аль ч газраас онлайнгаар хэргийн материалаа үзэх боломжтой. Цахим мэдүүлэг нь баримт бичгийг хадгалах, сэргээх, хуулбарлах зардлыг эрс багасгах, эсрэг талуудад бичиг баримт өгөх ачаа, зардлыг ихээхэн хэмжээгээр арилгах, баримт бичгийг бүрдүүлэх, авахын тулд шүүхийн байранд очиход зарцуулах үнэ цэнэтэй алдагдсан цагийг арилгах боломжтой юм. Цахим мэдүүлэг нь шүүхийн оролцогчид, өмгөөлөгчид, шүүхүүд болон дүүргийн бичиг хэргийн ажилтнуудад ихээхэн хэмжээний зардлыг хэмнэх мөн бүх нийтийн цахим мэдүүлэг нь Нью-Йоркийн шүүхэд зарга мэдүүлж буй хувь хүмүүс, аж ахуйн нэгжүүд, муж, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын зардлыг хэдэн зуун сая доллараар бууруулах боломжтой гэж тооцоолж байна. Мөн цахим мэдүүлэг нь хууль зүйн тогтолцооноос илүү ногоон, байгаль орчинд ээлтэй хандлагыг тусгаж, жил бүр олон мянган тонн цаасны хэрэглээг арилгах юм.

Холбооны шүүхэд цахим хавтаст нь Нью Йоркоос илүү хурдацтай явагдаж байна. АНУ-ын дүүргийн шүүхүүдэд 2002 онд, давж заалдах шатны шүүхүүдэд 2005 онд хэрэгжиж эхэлсэн. Холбооны шүүхэд цахим мэдүүлэг гаргах нь заавал байх ёстой бөгөөд холбооны шүүхийн үйл ажиллагаа болон холбооны хуулийн практикт үндсэн бөгөөд хүлээн зөвшөөрөгдсөн бүрэлдэхүүн хэсэг болсон. ECF системийг иргэний болон эрүүгийн хэргийн бүх дүүргийн шүүх, улсын хэмжээнд дампуурлын шүүх, бүх бүс нутгийн давж заалдах шатны шүүх, Холбооны нэхэмжлэлийн шүүх, Олон улсын худалдааны шүүхэд ашиглаж байна. Холбооны шүүхэд сар бүр зургаан сая гаруй баримт бичгийг цахим хэлбэрээр илгээдэг бөгөөд 500,000 гаруй өмгөөлөгч цахим мэдүүлгийн системийг ашигладаг.

Улсын хэмжээнд улсын шүүхэд цахим мэдүүлэг гаргах нь жишиг болж байна. Одоогоор 41 мужид зөвшөөрөгдсөн бөгөөд үлдсэн ихэнх мужид хэрэгжих төлөвтэй байна. АНУ-ын мужын анхан шатны шүүхүүдийн ихэнх нь орон нутгийн удирдлагатай байдаг тул эдгээр шүүхэд цахим мэдүүлгийг хэрэгжүүлэх нь муж тус бүрээр явагддаг бөгөөд ихэвчлэн

туршилтын хөтөлбөрүүдэд зориулсан шүүхийн дүрэм мөн хуулиар тогтоосон зөвшөөрөл дагалддаг²³.

Case Management/Electronic Case Files Хэргийн менежмент/Цахим хэргийн файлууд (CM/ECF) нь нэхэмжлэл, хүсэлт, өргөдөл зэрэг хэргийн баримт бичгийг шүүхэд онлайнаар илгээх боломжийг олгодог холбооны шүүхийн систем юм. CM/ECF-ийг өмгөөлөгчид, АНУ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч, дампуурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч нар ихэвчлэн ашигладаг. Зарим шүүхүүд дампуурлын нэхэмжлэгч болон нэхэмжлэлийн шаардлагыг хангаж буй хүмүүст CM/ECF ашиглан мэдүүлэг гаргахыг зөвшөөрдөг²⁴.

NYSCEF хөтөлбөр нь өмгөөлөгчид болон өөрийгөө төлөөлж буй заргалдагч тал шүүхийн байр руу явах шаардлагагүйгээр өдрийн аль ч цагт, аль ч газраас шүүхийн баримт бичгийг бүрдүүлж, үйлчлэх боломжийг олгодог. Мөн NYSCEF нь интернетэд холбогдсон өмгөөлөгчдөд хавтаст хэргийг хүссэн үедээ хаанаас ч үзэх боломжийг олгодог. NYSCEF нь тусгай техник хангамж, програм хангамж шаарддаггүй. Харин цахим мэдүүлэг гаргахад шаардлагатай тоног төхөөрөмж нь : компьютер, үндсэн (software) программ хангамж (вэб хөтөч болон Adobe гэх мэт PDF/A уншигч/ бичигч), интернет холболт, сканнер. Баримт бичгийг бүрдүүлэхийн тулд өмгөөлөгч эсвэл өөрийгөө төлөөлж буй шүүхийн оролцогч нь хэрэглэгчийн ID, нууц үг авах ёстой бөгөөд энэ нь онлайнаар хийгддэг энгийн процесс юм. Ганц хэрэглэгчийн ID болон нууц үг нь Нью-Йоркт бүртгэлтэй өмгөөлөгчид аль ч муж, шүүх, цахим мэдүүлэг өгөх эрх бүхий хэрэгт цахим мэдүүлэг гаргах боломжийг олгодог. NYSCEF-ийн иргэний хэргийн хавтаст хэрэгт байгаа нууцлалгүй, битүүмжлэлгүй баримт бичгүүдийг онлайн зочноор үзэхийн тулд хэрэглэгчийн ID болон нууц үг шаардлагагүй байдаг (олон нийт гэр бүлийн болон эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд цахимаар бүрдүүлсэн баримт бичигт хандах боломжгүй). Шүүхийн ердийн хураамжаас гадна NYSCEF-ийг ашиглахад ямар ч төлбөр байдаггүй байна.

NYSCEF нь хэрэглэгчдэд ээлтэй ба цахимаар мэдүүлэх баримт бичгүүдийг эхлээд баримт бичгийг боловсруулсны дараа PDF/A формат руу программ хангамжийн хөрвүүлэлт эсвэл сканнераар дамжуулан хөрвүүлдэг бөгөөд энэ нь өнөөгийн ихэнх өмгөөлөгчдийн мэддэг энгийн процесс юм. Цахим файл үүсгэгч нь хэрэглэгчийн ID болон нууц үгээр NYSCEF-д нэвтэрч , дэлгэцэн дээрх зааврыг дагаж баримтыг NYSCEF систем рүү оруулна. Баримт бичгийг дамжуулсны дараа NYSCEF нь цахим файл илгээгч болон хэргийн бусад цахим мэдүүлэг гаргагч талуудад хүлээн авсан тухай имэйл мэдэгдлийг автоматаар үүсгэдэг. Шинээр бүрдүүлсэн баримт бичгийн аюулгүй холбоосыг агуулсан эдгээр мэдэгдэл нь тухайн баримт бичгийн оролцогч хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээг бүрдүүлдэг. Цахим хэлбэрээр эхэлсэн тохиолдолд ч гэсэн цаасан хэлбэрээр биечлэн ирүүлэх ёстой баримт бичгээс бусад тохиолдолд талууд эсрэг талуудад бичиг баримт өгөх ачааллаас чөлөөлөгддөг - NYSCEF нь энэ үүргийг автоматаар гүйцэтгэж, бүртгэдэг.²⁵

²³ Electronic Filing in Criminal Actions and Proceedings: A REPORT TO THE GOVERNOR, LEGISLATURE AND CHIEF JUDGE, page 10

https://ww2.nycourts.gov/sites/default/files/document/files/2018-06/eFile_Criminal_Report%20April%2019.pdf

²⁴ Electronic Filing (CM/ECF), <https://www.uscourts.gov/court-records/electronic-filing-cmecf>

²⁵ Electronic Filing in Criminal Actions and Proceedings: A REPORT TO THE GOVERNOR, LEGISLATURE AND CHIEF JUDGE, page 8

https://ww2.nycourts.gov/sites/default/files/document/files/2018-06/eFile_Criminal_Report%20April%2019.pdf

Дээрхээс дүгнэвэл, АНУ-ын хэмжээнд шүүхэд цахим мэдүүлэг гаргах, цахим хавтаст хэрэг бүрдүүлэх нь жишиг болж байна. Одоогоор 41 мужид зөвшөөрөгдсөн бөгөөд үлдсэн ихэнх мужид хэрэгжих төлөвтэй байна. Тус шинэчлэлт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хөнгөвчилж, хэргийн оролцогч, өмгөөлөгчдөд бий болох саад бэрхшээлийг арилгах үр дүнтэй өөрчлөлт болсон байна. Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн боловсруулалтыг техник технологи талаас нь боловсронгуй болгосон ба үүнийг ашиглахад ямар нэг төлбөр хураамж авдаггүй нь сайн жишиг болж байна.

1.3.5. Бүгд Найрамдах Солонгос Улсын сайн туршлага

Бүгд Найрамдах Солонгос Улсад цахим хавтаст хэрэг нь эрүүгийн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүрэлдэхүүнд хамаардаг. Эрүүгийн хэргийн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэдэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг цахим баримт хэлбэрээр бэлтгэх, ирүүлэх, удирдах, үйлчлэх, үзэх, хадгалах зэрэг үйл ажиллагааг хамаардаг. Эрүүгийн хэргийн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь цаасан баримтаас илүү цахим баримт дээр суурилдаг тул талууд баримт бичгийг цахим хэлбэрээр бүрдүүлж, хүлээн авч, шүүх нь цаасан хэрэг хөтлөлтийн оронд цахим бүртгэл үүсгэж, удирддаг.

2010 онд патентын маргаанаас эхлэн иргэний хэрэг, захиргааны хэрэг, ахуйн хэрэг, дампуурлын хэрэг зэрэг эрүүгийн хэргээс бусад шүүхийн ихэнх ажиллагаанд цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем хэрэгжиж эхэлсэн байна. Гэвч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хараахан нэвтрээгүй байгаа нь олон чирэгдэл учруулж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэвтрүүлэх шаардлагатай гэдэг дээр нэгдсэн байр суурь бий болж байгаатай байгаатай холбогдуулан 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн БНСУ-ын парламентын чуулганы нэгдсэн хуралдаанаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хуулийг баталсан. Улмаар үүний дагуу 2024 оны 10-р сарын 20-ны өдрөөс эхлэн бүрэн хэмжээний эрүүгийн цахим шүүх хуралдааныг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Эрүүгийн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэвтрүүлэхийн ач холбогдол:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх.

Цахим эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэвтрүүлснээр шүүх хуралдааны оролцогчид цаг хугацаа, газар нутгаас үл хамааран эрүүгийн хэргийн талаарх мэдээллийг хялбархан авах боломжтой болно. Эрүүгийн хэргийн талаарх мэдээллийг ил тод, системтэй, эргэлт буцалтгүй удирддаг тул эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа илүү ил тод, шударга явагдах боломжтой.

- Шүүгчдийн үндсэн эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахим хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цахим бүртгэлээр хэрэг бүртгэлтийг шуурхай үзэж, удирдаж, хэргийн гол асуудлуудыг түргэн шуурхай тодорхойлох боломжтой болж, улмаар шүүгдэгчийн шүүх хурлыг шударгаар, шуурхай шийдвэрлүүлэх, шүүх хуралдаанд оролцогч талуудын эрх ашгийг дээшлүүлэх, өмгөөлөх эрх, хохирогчийн үйл ажиллагаанд оролцох эрх зэрэг багтана. Үндсэн эрхийг илүү өндөр түвшинд баталгаажуулсан.

- Цаасан бүртгэлийн хязгаарлалтыг даван туулах хурдан бөгөөд үр дүнтэй журам

Цахим эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд шүүхийн гишүүд болон шүүгдэгч, өмгөөлөгч, прокурор хэрэгтэй зэрэгцэн танилцах боломжтой болж, шүүх хуралдааныг илүү нарийвчилсан байдлаар явуулах боломжтой болсон. Цахим хэрэг бүртгэлийг удирдан, цахим баримт бичгийг хүргэснээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа илүү хурдан, үр дүнтэй явагдаж, цаасан хэрэг үүсгэх, хүргэх, хадгалахад шаардагдах хугацаа, зардлыг бууруулах боломжтой²⁶.

2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хуулийн зорилго нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт бичгийг ашиглах, удирдах үндсэн зарчим, журмыг тогтоосноор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай, ил тод байдлыг нэмэгдүүлэх, иргэдийн эрх ашгийг хамгаалах юм. Тус хуулийн 2 дугаар зүйлд “Цахим хавтаст хэрэг” болон “Цахимжуулсан хавтаст” хэргийг дараах байдлаар тодорхойлсон.

Цахим хавтаст хэрэг - Цахим баримт болон цахим гүйлгээний суурь хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу мэдээлэл боловсруулах системээр цахим хэлбэрээр бэлтгэсэн, дамжуулсан, хүлээн авсан, хадгалсан мэдээлэл²⁷

Цахимжуулсан хавтаст хэрэг - Цаасан баримт болон бусад хэлбэрээр цахим байдлаар бэлтгээгүй баримт, эсхүл зураг, гэрэл зураг, дуу, дүрсний өгөгдөл гэх мэт /цаашид “дигитал баримт бичиг” гэх/-ийг цахим хэлбэрт шилжүүлж, компьютержсэн мэдээлэл болгон боловсруулах. Энэ нь системд бүртгэгдсэн цахим баримт бичигт хамаарна²⁸.

2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хуульд дараах үйл ажиллагааг тусгасан²⁹.

²⁶ 미리 보는 형사전자소송, https://help.scourt.go.kr/nm/min_9/min_9_9/index.html

²⁷ Framework act on electronic documents and transactions of Korea, https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=27334&type=part&key=28

²⁸ Act on the Use of Electronic Documents in Criminal Judicial Procedures [Enforced into force on October 20, 2024] [Law No. 18485, enacted on October 19, 2021], [https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EC%82%AC%EC%82%AC%EB%B2%95%EC%A0%88%EC%B0%A8%EC%97%90%EC%84%9C%EC%9D%98%EC%A0%84%EC%9E%90%EB%AC%B8%EC%84%9C%EC%9D%B4%EC%9A%A9%EB%93%B1%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2%95%EB%A5%A0/\(18485,20211019\)](https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EC%82%AC%EC%82%AC%EB%B2%95%EC%A0%88%EC%B0%A8%EC%97%90%EC%84%9C%EC%9D%98%EC%A0%84%EC%9E%90%EB%AC%B8%EC%84%9C%EC%9D%B4%EC%9A%A9%EB%93%B1%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2%95%EB%A5%A0/(18485,20211019))

²⁹ Act on the Use of Electronic Documents in Criminal Judicial Procedures [Enforced into force on October 20, 2024] [Law No. 18485, enacted on October 19, 2021], [https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EC%82%AC%EC%82%AC%EB%B2%95%EC%A0%88%EC%B0%A8%EC%97%90%EC%84%9C%EC%9D%98%EC%A0%84%EC%9E%90%EB%AC%B8%EC%84%9C%EC%9D%B4%EC%9A%A9%EB%93%B1%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2%95%EB%A5%A0/\(18485,20211019\)](https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EC%82%AC%EC%82%AC%EB%B2%95%EC%A0%88%EC%B0%A8%EC%97%90%EC%84%9C%EC%9D%98%EC%A0%84%EC%9E%90%EB%AC%B8%EC%84%9C%EC%9D%B4%EC%9A%A9%EB%93%B1%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2%95%EB%A5%A0/(18485,20211019))

Хүснэгт 3. БНСУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хуулийн зохицуулалт

Зүйл заалт, агуулга	Зохицуулалтын агуулга
<p>5 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим баримт бичгээр гүйцэтгэх</p>	<ul style="list-style-type: none"> - Сэжигтэн, шүүгдэгч, хохирогч, гомдол гаргагч, мэдээлэгч, өмгөөлөгч болон Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн журамд заасан бусад этгээд 7 дугаар зүйлд заасны дагуу хэрэглэгчээр бүртгүүлсэн бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарна. Баримт бичиг, зураг, гэрэл зураг, аудио, дүрс бичлэгийн материалыг Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасны дагуу мэдээлэл боловсруулах цахим системээр дамжуулан цахим баримт бичиг хэлбэрээр гаргаж болно. - Шаардлагыг хангасан цахим баримт бичгийг энэ хуульд заасны дагуу бэлтгэж, ирүүлсэн, хүргүүлсэн, хадгалсан бол тухайн баримт бичгийг бэлтгэсэн, ирүүлсэн, хүргүүлсэн, хадгалсанд тооцно. - Энэ хуулийн дагуу цахимжуулсан, бүртгүүлсэн баримт бичиг нь дижитал хэлбэрт шилжих баримт бичигтэй адил байна. - Энэхүү хуульд заасны дагуу компьютержсэн мэдээлэл боловсруулах системээр цахим баримт бичиг хэлбэрээр хэвлэсэн баримт бичгийг цахим баримт бичигтэй адилтгана. - 3 дугаар зүйлийн дэд хэсэг бүрт баримт бичгийн хуулбарыг олгох, хүргүүлэх, хадгалах гэх мэтээр заасан тохиолдолд мэдээллийн компьютержсэн системээр цахим баримт хэлбэрээр хэвлэсэн баримт бичиг нь баримт бичгийн эх хувь байх ёстой.
<p>6 дугаар зүйл. Компьютержсэн мэдээлэл боловсруулах системийг ажиллуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага бүрийн дарга мэдээлэл боловсруулах компьютержүүлсэн системийг суурилуулж ажиллуулна. - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллагууд цахим баримт бичгийн ашиглалт, менежментийн стандартыг бий болгохын тулд бие биетэйгээ хамтран ажиллах ёстой. - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага нь энэхүү хуулийг хэрэглэх буюу компьютержсэн мэдээлэл боловсруулах системийг ажиллуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настан гэх мэт хүмүүст эрхээ бүрэн эдлэх боломжийг хангахыг хичээнэ.
<p>7 дугаар зүйл. Хэрэглэгчийн бүртгэл</p>	<ul style="list-style-type: none"> - Мэдээлэл боловсруулах компьютержүүлсэн системийг ашиглахыг хүссэн хүн бүр (эрүүгийн шүүх хянан шийдвэрлэх байгууллагад харьяалагддаг төрийн албан тушаалтнуудаас бусад) Ерөнхийлөгчийн зарлиг болон Улсын дээд шүүхийн дүрмийн дагуу хэрэглэгчээр бүртгүүлэх ёстой. - (1)-д заасны дагуу хэрэглэгчээр бүртгүүлсэн (цаашид “хэрэглэгчийн бүртгэл” гэх) хүн /цаашид “бүртгүүлсэн хэрэглэгч” гэх/ Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн тогтоолоор тогтоосон хэрэглэгчийн бүртгэлээ цуцалж болно. - Дараах шалтгааны аль нэг нь байвал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх албаны дарга Ерөнхийлөгчийн зарлиг болон Улсын дээд шүүхийн дүрэмд заасан бүртгэлтэй хэрэглэгчийн компьютержсэн мэдээлэл боловсруулах системийг ашиглахыг түдгэлзүүлэх, хэрэглэгчийн бүртгэлийг цуцалж болно. <ol style="list-style-type: none"> 1. Бүртгүүлсэн хэрэглэгчийн биеийн байцаалт танигдаагүй үед; 2. Хэрэглэгчийн бүртгэлд бүртгүүлэх, хэрэглэгчийн мэдээллийг өөрчлөхдөө мэдээлэл боловсруулах компьютержсэн системд худал мэдээлэл оруулсан бол; 3. Мэдээлэл боловсруулах компьютержсэн системийг ашиглан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад саад учруулах, тухайлбал, бүртгэлтэй бусад хэрэглэгчийн мэдээллийг компьютержүүлсэн мэдээлэл боловсруулах системийг ашиглахад саад учруулсан, бусад бүртгэлтэй хэрэглэгчийн мэдээллийг хулгайлсан тохиолдолд;

	<p>4. Санаатай болон илт хайхрамжгүй байдлаас болж мэдээлэл боловсруулах компьютержсэн системд гэмтэл гарсан тохиолдолд;</p> <p>5. Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн журамд заасан 1-4 дэх хэсэгт заасан бусад шалтгаан байгаа тохиолдолд;</p>
8 дугаар зүйл. Цахим гарын үсэг	<ul style="list-style-type: none"> - Эрүүгийн байцаан шийтгэх байгууллагад цахим баримт бичгийг ирүүлэхийг хүссэн хүн цахим баримт бичигт цахим гарын үсэг (гарын үсэг зурсан хүний жинхэнэ нэрийг баталгаажуулах боломжтой, цаашид энэ хэсэгт мөн адил хамаарна) байрлуулах ёстой. Харин цахим гарын үсгийг ашиглах боломжгүй, ирүүлсэн этгээдийн биеийн байцаалтыг баталгаажуулсан, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасан тохиолдолд цахим гарын үсэг ашиглахыг хориглоно. - Шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар шүүхийн шийдвэр, тэмдэглэл зэргийг цахим баримт бичигт бэлтгэхдээ Улсын дээд шүүхийн журамд заасан шүүхийн цахим гарын үсэгт гарын үсэг зурна. Энэ тохиолдолд 3 дугаар зүйлд заасан хуульд заасны дагуу мэдэгдэл гаргаж байгаа этгээдийн гарын үсэг шаардлагатай бол цахим хэлбэрээр гарын үсэг зурна. - Шүүхээс бусад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд харьяалагддаг төрийн албан тушаалтнууд цахим баримт бичигт шийдвэр, тэмдэглэл, тайлан гаргахдаа Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу захиргааны цахим гарын үсэг зурах ёстой. Энэ тохиолдолд 3 дугаар зүйлд заасан хуульд заасны дагуу мэдэгдэл гаргаж байгаа этгээдийн гарын үсэг шаардлагатай бол цахим хэлбэрээр гарын үсэг зурна. - Хэрэв 1-3 дахь хэсэгт заасны дагуу цахим гарын үсэг, шүүхийн цахим гарын үсэг, захиргааны цахим гарын үсэг хийгдсэн бол гарын үсэг, нэрийн тамга нь хуулийн дагуу хийгдсэн гэж үзнэ. - Хэрэв 1-ээс 3 дахь хэсэгт заасны дагуу ирүүлсэн буюу бэлтгэсэн цахим баримт бичигт хуудасны тоог заасан бол 3 дугаар зүйлийн дэд зүйл бүрийн дагуу хууль тогтоомжийн дагуу тамга дарсан гэж үзнэ.
9 дүгээр зүйл. Цахим баримт бичгийг хүлээн авах	<ul style="list-style-type: none"> - Цахим баримт бичгийг компьютержсэн мэдээлэл боловсруулах системд цахим хэлбэрээр бүртгэсэн тохиолдолд хүлээн авсанд тооцогдоно. - Компьютержсэн мэдээлэл боловсруулах системээр ирүүлсэн цахим баримт бичгийг хүлээн авах журам, аргыг Ерөнхийлөгчийн зарлигаар буюу Улсын дээд шүүхийн дүрмээр тогтооно. Энэ тохиолдолд ирүүлсэн цахим баримт бичгийн хувийн шинж чанарыг хадгалах техникийн арга хэмжээний тухай асуудлыг агуулгад оруулах ёстой. - 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу цахим баримт бичгийг ирүүлсэн бүртгэлтэй хэрэглэгч нь хүлээн авсан цахим баримт бичгийг баталгаажуулах хүсэлт гаргавал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн журамд заасан баталгаажуулах боломжийг олгох ёстой. - Хэрэв 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу ирүүлсэн цахим баримт бичгийн агуулга нь хүлээн авсан цахим баримт бичгийн агуулгатай таарахгүй бол бүртгэлтэй хэрэглэгч Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасны дагуу холбогдох байгууллагад засвар оруулах хүсэлт гаргаж болно. - Хүлээн авсан цахим баримт бичгийг хуурамчаар үйлдсэн эсвэл өөрчилсөн эсэхийг шалгах шаардлагатай бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага нь 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу цахим баримт бичгийг ирүүлсэн бүртгэлтэй хэрэглэгчээс эх хувийг нь гаргаж өгөхийг хүсч болно.
10 дугаар зүйл. Цахим баримт бичгийг бэлтгэх	<ul style="list-style-type: none"> - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны байгууллагад харьяалагддаг төрийн албан тушаалтнууд шүүх хуралдааны тэмдэглэл, яллах дүгнэлт, шилжүүлсэн шийдвэр, сэжигтэн байцаалтын бүртгэл зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичгүүдийг бүрдүүлэхдээ цахим баримт бичиг болгон бэлтгэдэг. Гэхдээ

	<p>дараах тохиолдлуудын аль нэг нь Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасан үндэслэл байвал энэ нь хамаарахгүй.</p> <ol style="list-style-type: none"> 1. Компьютержсэн мэдээлэл боловсруулах системд асуудал гарсан тохиолдолд; 2. Цахим баримт бичгийг бэлтгэхэд ихээхэн хүндрэлтэй буюу зохисгүй тохиолдолд. <p>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллагад харьяалагддаг төрийн албан тушаалтан сэжигтний байцаалтын тэмдэглэлийг (1) дэх заалт бүрийн текстийн дагуу цахим баримт бичиг болгон бэлтгэсэн бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан сэжигтэн байцаалтын тэмдэглэлийг бүрдүүлэх журам, аргачлалыг Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу хэрэгжүүлэх ёстой.</p>
<p>11. дүгээр зүйл. Дижитал баримт бичгийг бэлтгэх</p>	<p>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд харьяалагдах төрийн албан тушаалтан дижитал баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээлэл боловсруулан цахим системд бүртгүүлнэ. Харин цахимжуулах баримт бичгийг дижитал хэлбэрт шилжүүлэхэд ихээхэн хүндрэлтэй, тохиромжгүй үед Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн журамд заасны дагуу хөрвүүлэх, бүртгэхийг хориглоно.</p> <p>- Цахим хэлбэрт шилжүүлэх баримт бичгийг дижитал хэлбэрт шилжүүлэх, мэдээлэл боловсруулах цахим системд бүртгэх журам, аргыг Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрмээр тогтооно. Энэ тохиолдолд дижитал хэлбэрт оруулах баримт бичгийн онцлог байдлыг хадгалах техникийн арга хэмжээний тухай асуудлыг агуулгад оруулах ёстой.</p>
<p>12 дугаар зүйл. Дижитал хэлбэрт шилжүүлсэн баримт бичгийг хадгалах</p>	<p>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага нь 11 дүгээр зүйлд заасны дагуу цахим хэлбэрт шилжүүлж, бүртгүүлсэн баримт бичгийг Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн журамд заасан хугацаа хүртэл хадгална.</p> <p>- 1 дэх хэсгийг үл харгалзан цахим хэлбэрт шилжүүлэх баримт бичгийг ирүүлсэн этгээдээс хүсэлт гаргавал байгууллага цахим хэлбэрт шилжүүлэх баримт бичгийг буцааж болно.</p> <p>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага нь 2 дахь хэсэгт заасны дагуу цахимжуулах баримт бичгийг ирүүлсэн этгээдэд буцааж өгөхдөө цахим хэлбэрт шилжүүлэх баримт бичиг болон цахимжуулах баримт бичгийг мөн адил баталгаажуулах боломжийг олгоно.</p>
<p>13 дугаар зүйл. Цахим баримт бичиг тараах</p>	<p>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бэлтгэсэн цахим баримт бичгийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад байгууллагад илгээхдээ компьютержсэн мэдээлэл боловсруулах системээр дамжуулан явуулах ёстой.</p> <p>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллагаас өөр байгууллагад шилжүүлэх тохиолдолд цахим баримт бичгийг мэдээлэл боловсруулах компьютержуулсан системээр хэвлэж, бичгийн баримтыг илгээдэг. Харин цахим баримт бичгийг цахим баримт бичгийг илгээх, хүлээн авах системээр тоноглогдсон байгууллагын хувьд Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасан байгууллагад шилжүүлэх, дамжуулахдаа цахим баримт бичгийг цахим хэлбэрээр илгээж болно.</p> <p>2 дахь хэсгийн үндсэн бичвэрт заасны дагуу цахим баримт бичгийг хэвлэх журам, аргыг Ерөнхийлөгчийн зарлигаар буюу Дээд шүүхийн дүрмээр тогтооно. Энэ тохиолдолд цахим баримт бичгийн үнэмлэхийг хадгалах техникийн арга хэмжээний тухай асуудлыг агуулгад оруулах ёстой.</p>
<p>14 дүгээр зүйл. Цахим үйлчилгээ эсвэл мэдэгдэл</p>	<p>Үйлчилгээ, мэдэгдэл хүлээн авах этгээд нь дор дурдсан зүйлсийн аль нэгэнд хамаарах бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага мэдээлэл боловсруулах цахим системээр дамжуулан үйлчилгээ, мэдэгдлийг цахим хэлбэрээр хийж болно.</p> <ol style="list-style-type: none"> 1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллагын хувьд

	<p>2. Хэрэв та эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллагад харьяалагддаг төрийн албан тушаалтан бол</p> <p>3. Цахим хүргэлт, мэдэгдлийг зөвшөөрсөн бүртгэлтэй хэрэглэгч, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасан этгээд бол.</p> <p>- (1)-д заасны дагуу үйлчилгээ, мэдэгдлийг эрүүгийн байцаан шийтгэх байгууллага цахим баримт бичгийг мэдээлэл боловсруулах цахим системд бүртгэж, тухайн баримт бичгийг гардуулах буюу мэдэгдэх этгээдэд цахимаар мэдэгдэнэ.</p>
15 дугаар зүйл. Хэвлэсэн цахим баримтыг хүргүүлэх	<p>- Дараах тохиолдлын аль нэгэнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу цахим баримт бичгийг компьютержсэн мэдээлэл боловсруулах системээр дамжуулан илгээнэ.</p> <p>- (1)-д заасны дагуу цахим баримт бичгийг хэвлэх журам, аргыг Ерөнхийлөгчийн зарлигаар эсвэл Дээд шүүхийн дүрмээр тогтооно. Энэ тохиолдолд цахим баримт бичгийн танилтыг хадгалах техникийн арга хэмжээний тухай асуудлыг агуулгад оруулах ёстой.</p>
16 дугаар зүйл. Цахим баримт бичгийг үзэх, хуулбарлах гэх мэт	<p>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 35, 55, 59-2, 59-3, 174, 185, 200-4, 262 дугаар зүйлийн 2, 266-3 дугаар зүйл, 266-4 дүгээр зүйл, 266-11 дүгээр зүйл, 294-4 дүгээр зүйлд заасныг үл харгалзан энэ хуулийн дагуу бэлтгэсэн цахим баримт бичгийг үзэх, хуулбарлахдаа интернет, эсвэл компьютержсэн мэдээлэл боловсруулах системийг ашиглах ба цахим хэлбэрээр үзэх, хуулах, дамжуулах замаар хийж болно.</p> <p>- 1-р хэсгийг үл харгалзан, бүртгэлтэй хэрэглэгчээс өөр хүн цахим баримтыг үзэх, хуулбарлах хүсэлт гаргасан тохиолдолд компьютержсэн мэдээлэл боловсруулах системээр дамжуулан баримт бичгийг хэвлэн гаргаж болно.</p> <p>- (1)-д заасны дагуу цахим баримт бичгийг үзэх, хуулбарлах, дамжуулах журам, аргыг Ерөнхийлөгчийн зарлигаар эсвэл Дээд шүүхийн дүрмээр тогтооно. Энэ тохиолдолд цахим баримт бичгийн танилтыг хадгалах техникийн арга хэмжээний тухай асуудлыг агуулгад оруулах ёстой.</p> <p>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 266-3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүгдэгч (шүүгдэгч байсан этгээдийг оролцуулан), өмгөөлөгч (өмгөөлөгч байсан этгээдийг оролцуулан) баримт бичгийг үзэх, хуулбарлах, дамжуулах боломжтой. Цахим баримт бичгийг зориулалтын бус зорилгоор интернет эсвэл компьютержсэн мэдээлэл боловсруулах системээр дамжуулан өөр этгээдэд дамжуулах, олгох (цахим баримт бичгийг хэвлэх, бичгээр олгох гэх мэт) холбогдох хэрэг болон холбогдох хэргийн шүүх хуралдаанд бэлтгэх тухай танилцуулахыг хориглоно (цахим баримт бичгийг хэвлэх, бичгээр танилцуулах, харилцаа холбооны хэрэгслээр хангах гэх мэт).</p>
17 дугаар зүйл. Зөвшөөрлийг гүйцэтгэх тусгай заалтууд	<p>Дараахь батлан даалт, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ, зөвшөөрөл, хүсэлт зэргийг /цаашид “зөвшөөрөл” гэх/ цахим хэлбэрээр олгосон бол прокурор, шүүхийн цагдаагийн ажилтан: Улсын дээд шүүхийн журамд заасны дагуу; баталгаа гэх мэтийг цахим баримт бичгийг танилцуулах, дамжуулах замаар гүйцэтгэж болно.</p> <p>1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 73, 113, 200-2, 201, 215 дугаар зүйлд заасны дагуу баталгаа гаргах.</p> <p>2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 172, 221-3 дугаар зүйлд заасан үнэлгээний цагдан хорих байр</p> <p>3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 173 дугаар зүйл, 221-4 дүгээр зүйлд зааснаар зөвшөөрлийн бичиг.</p> <p>4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 473 дугаар зүйлд заасан гүйцэтгэх хуудас</p> <p>5. Жинхэнэ нэрийн санхүүгийн гүйлгээ, нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу баталгаа.</p>

	<p>6. Харилцаа холбооны нууцыг хамгаалах тухай хуулийн 6, 8 дугаар зүйлд заасны дагуу харилцаа холбоог хязгаарлах арга хэмжээ авах зөвшөөрөл</p> <p>7. Харилцаа холбооны нууцыг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу харилцаа холбоог баталгаажуулах мэдээлэл өгөх хүсэлт</p> <p>8. Харилцаа холбооны нууцыг хамгаалах тухай хуулийн 13-2 дугаар зүйлд заасны дагуу харилцаа холбоог баталгаажуулах мэдээлэл өгөх хүсэлт</p> <p>- (1)-д заасны дагуу цахим баримт бичиг хэлбэрээр гаргасан хүсэлт гэх мэтийг гүйцэтгэхэд ихээхэн хүндрэлтэй, зохисгүй тохиолдолд цахим баримт бичиг хэлбэрээр олгосон хүсэлт гэх мэтийг компьютерийн цахим хэрэгслээр хэвлэсэн бичгээр үйлдэж болно.</p> <p>- Мэдээлэл боловсруулах компьютержсэн системээр 2 дахь хэсэгт заасны дагуу цахим баримт хэлбэрээр олгох батлан даалт зэргийг хэвлэх журам, аргыг Улсын дээд шүүхийн журмаар тогтооно. Энэ тохиолдолд агуулга нь цахим баримт бичгийн хувийн шинж чанарыг хадгалах, олон хуулбарыг шүүгчийн гаргасан зориулалтаас өөрөөр гаргахаас урьдчилан сэргийлэх техникийн арга хэмжээг агуулсан байх ёстой.</p>
<p>18 дугаар зүйл. Нотлох баримтыг шалгах тусгай заалтууд</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 292, 292-3 дугаар зүйлийг үл харгалзан эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд цахим баримт бичгийн нотлох баримтыг шалгах ажиллагааг дараах байдлаар хийж болно.</p> <p>1. Захидал, бусад тэмдэгт, зураг, гэрэл зураг гэх мэтийн нотлох баримтыг судлах: Холбогдох цахим баримт бичгийг дэлгэц, дэлгэц гэх мэтээр үзэх арга.</p> <p>2. Аудио, дүрс бичлэгийн мэдээллийг нотлох баримт шалгах: Холбогдох цахим баримт бичгийн аудиог сонсох, дүрс бичлэгийг тоглуулах арга</p>
<p>19 дүгээр зүйл. Шүүх хуралдааны гүйцэтгэлийг удирдах аргын талаархи тусгай заалтууд</p>	<p>- Шүүхийн шийдвэр, шүүх хуралдааны тэмдэглэлийг цахим баримтаар бүрдүүлсэн бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 461 дүгээр зүйлийн үндсэн бичгийг үл харгалзан прокурор шүүх хуралдааны гүйцэтгэлийг цахим баримтаар удирдана.</p> <p>- (1)-ээс үл хамааран шүүхийн гүйцэтгэлийг цахим баримтаар удирдан чиглүүлэхэд хүндрэлтэй байгаа бол шүүхийн гүйцэтгэлийг цахим баримт бичигт бэлтгэсэн бичгээр гаргасан шүүхийн шийдвэрээр, эсхүл компьютерийн төхөөрөмжөөр хэвлэсэн шүүхийн протоколоор дамжуулан шийдвэрлэнэ.</p> <p>- 2 дахь хэсэгт заасны дагуу цахим баримт бичгийг хэвлэх журам, аргыг Ерөнхийлөгчийн зарлигаар буюу Дээд шүүхийн дүрмээр тогтооно. Энэ тохиолдолд цахим баримт бичгийн үнэмлэхийг хадгалах техникийн арга хэмжээний тухай асуудлыг агуулгад оруулах ёстой.</p>
<p>20 дугаар зүйл. Цахим баримт бичгийг устгах</p>	<p>- Мэдээлэл боловсруулах компьютержсэн системээр бий болсон цахим баримт бичгийг дараах ангиллын дагуу тогтоосон хугацаанд устгана.</p> <p>1. Ял оногдуулсан шүүх хуралдааныг баталгаажуулсан хэрэг: Шийтгэх хөөн хэлэлцэх хугацаа дууссан бол; Харин цагдан хорих, хөнгөн торгох ял оногдуулсан бол шийдвэр гарсан өдрөөс хойш гурван жил өнгөрсний дараа;</p> <p>2. Цагаатгах, ялаас чөлөөлөх, яллах дүгнэлт үйлдүүлэхийг хэрэгсэхгүй болгох, хорих ялыг хойшлуулах тогтоол батлагдсан тохиолдолд: Яллах хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа</p> <p>3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 245 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2-т зааснаар яллагдагчаар татаагүй, шилжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн хэргүүд: Хөөн хэлэлцэх хугацаа дууссан тохиолдолд.</p> <p>- 1 дэх хэсгийг үл харгалзан Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасан хэргүүд, тухайлбал, дотоод, олон улсын ноцтой хэрэг, хамсаатнуудыг мөрдөн шалгах шаардлагатай тохиолдолд цахим баримт бичгийг Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн журмын дагуу байнга хадгалж болно. Эсвэл 1 дэх хэсэгт заасны дагуу устгах хугацаа хойшлогдож болно.</p>

Дээрхээс дүгнэвэл, БНСУ-ын тухайд 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн БНСУ-ын парламентын чуулганы нэгдсэн хуралдаанаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хуулийг баталж нарийвчилсан хуулиар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хавтаст хэргийг зохицуулж байгаа нь сайн жишиг бүхий боловсронгуй зохицуулалт болж байна. Тус хуульд "цахим хавтаст хэрэг", "цахимжуулсан хавтаст хэрэг" гэх нэр томъёог нарийвчлан тодорхойлсноос гадна эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим баримт бичгээр гүйцэтгэх, компьютержсэн мэдээлэл боловсруулах системийг ажиллуулах, цахим баримт бичгийг хүлээн авах, цахим баримт бичгийг бэлтгэх, цахим баримт бичгийг үзэх, хуулбарлах, цахим баримт бичгийг устгах гэх мэт зохицуулалтыг тусгасан байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим хавтаст хэргийн зохицуулалтыг тусгахдаа дээрх зохицуулалтын агуулгыг тусгах талаар авч үзэх хэрэгтэй.

Хоёрдугаар бүлэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримттай холбоотой хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

Судалгааны хоёрдугаар бүлгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн талаар нарийвчлан авч үзэх ба Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд үүнийг шинээр зохицуулж хуульчлах шаардлага бий эсэхийг судална. Мөн түүнчлэн ийнхүү хуульчлахдаа гадаадын зарим улс, орнуудаас нутагшуулах сайн жишиг бүхий зохицуулалтыг болон олон улсын гэрээ, конвенцийн зохицуулалтыг тодорхойлох болно.

2.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтын ойлголт, шинж

ЭХХШТХ-ийн 16.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ...” гэж тодорхойлсон байдаг.

Энэхүү тодорхойлолтоос үзвэл, манай улсын ЭХХШТХ-д нотлох баримтыг ерөнхий байдлаар тодорхойлж өгсөн бөгөөд цахим нотлох баримтын талаар хуульд тусгайлан заагаагүй байна. Харин ЗХШХШТХ, ИХШХШТХ-д “цахим баримт” гэсэн нэр томъёог хуульчилсан.

Хүснэгт 4. ЗХШХШТХ болон ИХШХШТХ-ын цахим баримт, түүнийг үнэлэх

	ЗХШХШТХ	ИХШХШТХ
Цахим баримт	31.2.Нотлох баримт нь хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл, цахим баримт, эд мөрийн баримт, эсхүл баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, ул мөрнөөс буулгаж авсан хэв, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл зэрэг нотолгооны хэрэгслээр тогтоогдоно.	37.2.Хэргийн нотлох баримт нь зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл ба цахим баримт, эд мөрийн баримт, эсхүл баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, кино ба гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэг, ул мөрнөөс буулгаж авсан хэв, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл зэрэг нотолгооны хэрэгслээр тогтоогдоно.
Цахим баримт бичгийг үнэлэх	38.7.Шүүх цахим баримт бичгийг үнэлэхдээ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 38 дугаар зүйлд ³⁰ заасныг баримтална.	44.5.Шүүх цахим баримт бичгийг үнэлэхдээ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасныг баримтална.

³⁰ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 38 дугаар зүйлд Баримт бичгийн албан ёсны хүчинтэй байдлыг талаар тусгасан бөгөөд 38.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол цаасан болон цахим баримт бичиг нь хууль тогтоомж болон стандартаар тогтоосон баримт бичгийн бүрдлээр баталгаажна” гэж, 38.2-т “Цахим баримт бичиг нь цаасан баримт бичигтэй адил хүчинтэй байх бөгөөд зөрсөн тохиолдолд анх баталгаажсан баримт бичгийн хэлбэр (цаашид “баримт бичгийн эх хувь” гэх)-ийг баримтална” гэж, 38.3-т “Баримт бичгийн эх хувийг цаасан, эсхүл цахим баримт бичгийн хэлбэрт хуулбарласан тохиолдолд цаасан, эсхүл цахим баримт бичигт “хуулбар хувь” гэсэн тэмдэглэгээ хийнэ” гэж тус тус заажээ.

Өөрөөр хэлбэл, манай улсад иргэн, захиргааны хэрэгт цахим баримтыг нотолгооны хэрэгсэлд хамааруулан авч үзэхээр хуульд тодорхойлон заасан нь цахим нотлох баримтыг цаасан суурьтай нотлох баримттай ижил түвшинд үнэлэх боломжийг бүрдүүлсэн гэж дүгнэж болохоор байгаа юм. Хэдийгээр одоогоор практикт цахим нотлох баримтын үр нөлөө цаасан суурьтай нотлох баримттай харьцуулахад бага байгаа боловч хуульд тусгагдсан учир цаашид цахим нотлох баримт цаасан суурьтай нотлох баримттай адил үнэлэгдэх боломж бүрдэж эхэлсэн гэж үзэж болох юм.

Цахим нотлох баримт нь өргөн утгаараа “...тухайн хэрэгт ач холбогдол бүхий хуульд заасан арга, хэрэгслээр олж авсан цахим төхөөрөмж, хэрэгсэлд хадгалагдаж буй цахим баримт, мэдээллийг...” илэрхийлнэ. Харин явцуу утгаараа “зөрчил хэрхэн болсныг компьютер ашиглан батлах, эсвэл няцаах, тухайн зөрчил нь санаатайгаар үйлдэгдсэн, эсвэл хэрэгт холбогдолгүй болохыг батлах хадгалагдаж эсвэл дамжуулж буй аливаа өгөгдлийг” хэлнэ³¹.

Хүснэгт 5. Цахим нотлох баримтын онцлог³²

Онцлог	Тайлбар
Хэврэг	Компьютерын сүлжээгээр боловсруулсан зарим цахим өгөгдөл маш хэврэг учир амархан устаж өөрчлөгддөг. Үүнийг цахим нотлох баримт цуглуулах үед онцгой анхаарах нь зүйтэй. Өгөгдөл зөвхөн RAM сүлжээний санах ойд хадгалагдах тул урьдчилан сэргийлэх техникийн тусгай арга хэмжээ аваагүй тохиолдолд сүлжээ гэмтэх буюу унтрах аюултай. Сүлжээний санах ойд хадгалагдсан мэдээлэл мөрдөн шалгах үйл ажиллагаанд чухал. Энэхүү нотлох баримтыг цуглуулах технологи нь уламжлалт нотлох баримт цуглуулах ажиллагаанаас ялгаатай.
Хувиргахад амархан	Цахим өгөгдлийг хувиргах буюу өөрчлөхөд амархан. Компьютерын шинжилгээний үндсэн суурь зарчмын нэг нь цахим нотлох баримтын бүрэн бүтэн байдлыг хадгалах явдал юм. Компьютерын өгөгдлийг бүрэн бүтэн хадгалах арга хэрэглэх, зохих бичиг баримт бүрдүүлэх нь мөрдөн байцаагчийн хувьд нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх талаар хуульд заасан журмыг баримтлаагүй буюу зөрчсөн гэх асуудлаар сэжигтний зүгээс гомдол гаргахаас зайлсхийхэд чухал.
Тархан байршсан хадгалалт	Өргөн зурвасын хүртээмж, серверт зайнаас хадгалах боломж нь мэдээлэл хадгалах арга замд нөлөөлдөг. Өмнө нь мөрдөн байцаагчдын хувьд сэжигтний орон байранд төвлөрч компьютерийн өгөгдлийг хайж болдог байсан бол одоо цагт тэдний хувьд тоон мэдээллийг хилийн чанадад, шаардлагатай бол сэжигтэй мэдээллийг зөвхөн алсаас хандаж хадгалж болно гэдгийг анхаарах шаардлагатай.
Техникийн дэвшлийн хурд	Техникийн дэвшил хурдацтай урагшилж байгаа нь криминалистикийн шинжилгээнд шинэ сорилтыг бий болгож байна. Ийм хөгжил нь нотлох баримт цуглуулах үүрэгтэй хүмүүсийг сургах, түүнчлэн одоогийн криминалистикийн шинжилгээний багаж, хэрэгслийг шинэчлэхийг шаардана. Үйлдлийн систем болон бусад программ хангамжийн бүтээгдэхүүнүүдийн шинэ хувилбарууд мөрдөн шалгах үйл ажиллагаатай холбоотой янз бүрийн мэдээлэл, өгөгдөл бий болгодог болсон.

Мэдээлэл (дохио) боловсруулж буй аргад нь үндэслэн цахим нотлох баримтыг “аналоги” болон “дижитал (тоон)” баримт гэж 2 ангилдаг. Аналоги төхөөрөмж гэдэгт хар

³¹ Л.Галбаатар, Кибер гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх нь, УБ, 2015, 26 дахь тал.

³² ННФ, Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа /Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд/, УБ, 2022, 53-54 дэх тал.

цагаан зураг, хальсан дээр буулгасан гэрэл зураг, видео-кассет, дуу хураагуурт хураасан бичлэг зэрэг нотлох баримтыг анхдагч шинжийг түлхүү агуулсан, хадгалалтын онцгой нөхцөл шаардах баримтуудыг ойлгох бөгөөд эдгээрийн хэрэглээ өнөөдрийн байдлаар буурсан. Харин дижитал нотлох баримтад “бит” бүр нь 1 эсвэл 0 гэсэн хоёртын хэлбэрээр илэрхийлэгдэж буй баримт мэдээллүүд болох компьютер, гар утас, мессеж, мессенжер зэрэг хадгалагдаж, дамжуулагдаж буй мэдээлэл, зурвасуудыг хамааруулдаг. Аналог эсвэл дижитал гэдгээс үл хамаарч цахим нотлох баримт нь хүний хувийн мэдээллийг шууд агуулж байдаг тул “Мэдээлэлд нэвтрэх үйл ажиллагаа нь тухайн мэдээллийг хайж олох зорилгодоо нийцсэн байх” зарчим баримтлах шаардлагатай. Уг зарчмын дагуу мөрдөн шалгах ажиллагаанд нэг талаас “хувийн халдашгүй байдлыг хангах” буюу хүний хувийн мэдээллийг, тэр дундаа эмзэг мэдээллийг хамгаалах, нөгөө талаас “нийгмийн аюулгүй байдлыг хангах” буюу гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, үндэсний аюулгүй байдлыг хангах гэсэн хоёр ашиг сонирхлыг нэгдмэл байдлаар авч үзэж, харилцан тэнцвэртэй байдлыг хангах ёстой.³³

Цахим нотлох баримт нь кибер гэмт хэрэг төдийгүй уламжлалт гэмт хэргийг мөрдөн шалгахад чухал ач холбогдолтой нотлох баримт юм. Тухайн нотлох баримтад хандах эрхийн зохицуулалт улс орон бүрд харилцан адилгүй боловч хүний хувийн халдашгүй байдалд халдах болон түүнийг хамгаалах үйл ажиллагааны түвшинд үндэслэн цахим нотлох баримтыг дараах гурван төрөлд ангилна. Үүнд:³⁴

1. Хэрэглэгчийн мэдээлэл (Subscriber information) – Тодорхой үйлчилгээ авч буй хэрэглэгчийг тодорхойлоход ач холбогдолтой мэдээллүүд. Хэрэглэгч бүртгүүлэх болон түүнд тодорхой үйлчилгээ үзүүлэх үед цуглуулсан мэдээллүүд байна. Тухайлбал, нэр, гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар гэх мэт. Эдгээр мэдээлэл гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд нэн тэргүүнд шаардлагатай мэдээллүүд байх тул хуульд зааснаар мэдээлэлд шууд хандаж, хууль сахиулах эрх бүхий ажилтны бүрэн эрхэд хадгалагдана.

2. Хандалт /хөдөлгөөн буюу шилжүүлгийн өгөгдөл (traffic/Access and Transactional data) – хэрэглэгч хоорондын харилцсан мэдээлэл, холбоос, IP хаяг, газар зүйн байршлын мэдээлэл, тодорхой үйлчилгээнд авсан хугацаа, огнооны талаарх мэдээллүүд. Хууль, эрх зүйн зохицуулалтаас хамаарч зарим улс оронд үйлчилгээ эхлүүлэх, зогсоохтой холбоотой мэдээлэл мөн хамаардаг. Тухайн мэдээлэлд нэвтрэх, мэдээлэл цуглуулахад прокурорын зөвшөөрөлтэй байхыг шаардана.

3. Контентын өгөгдөл (Content data) – Контент болон цахим шуудан, мессеж, зурган мэдээллүүд. Эдгээр мэдээлэлд нэвтрэх эрхийг зөвхөн шүүгч захирамжийн дагуу олгодог.

Цахим нотлох баримтад дуу, бичлэг, зураг болон дижитал, эсвэл аналог форматтай мета өгөгдөл зэргийг хамааруулсан бөгөөд дараах эх сурвалжаас үүсэж болохоор тодорхойлсон. Үүнд:

³³ ННФ, Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа /Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд/, УБ, 2022, 50 дахь тал.

³⁴ Мөн тэнд, 51-52 дахь тал.

- Байгууллагын үүсгэсэн эсвэл хадгалсан мультимедиа (ярилцлага, хяналтын камерын болон машины камерын бичлэг, хувцсанд зүүсэн камер, хэргийн газрын бичлэг гэх мэт);

- Гуравдагч этгээдээс ирүүлсэн болон олж авсан мультимедиа (олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, видео бичлэгийн төхөөрөмжөөр хийгдсэн бичлэг, гар утас, дрон, CCTV камерын бичлэг, зүйлсийн интернэт (Internet of Things¹²⁰) гэх мэт).

Манай улсад цахим нотлох баримт болон эд мөрийн баримтын хооронд эрх зүйн ялгаа байхгүй, цахим нотлох баримтыг эд мөрийн баримттай ижил хууль зүйн хүчин төгөлдөр гэдгийг тодотгон заагаагүй.³⁵ Иймд ЭХХШТХ-д цахим нотлох баримт, түүний төрөл тодорхойлж хуульчлах шаардлагатай. Үүний зэрэгцээ цахим нотлох баримтыг эд мөрийн баримтын нэг хэсэг болгон зохицуулах нь олон талын тустай.³⁶

Цахим нотлох баримтыг цуглуулах, гаргуулан авах нь кибер гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүхээр хянан хэлэлцэх үйл явцын нэг чухал хэсэг байдаг. Мөн цахим нотлох баримт нь дээрэм, хулгай, авлига, өмч хөрөнгө ашиглах гэх мэт уламжлалт хэргүүд болон зохион байгуулалттай гэмт хэргүүдэд нотолгооны өндөр ач холбогдолтой болж байна. Уламжлалт гэмт хэргүүдэд утасны ярианы бичлэг, цахим шуудан, захидлууд, чат, IP холболтын бүртгэл, SMS мэдээлэл, гар утасны дуудлага, хаягийн бүртгэл, компьютерын файлууд олон нотлох баримт гаргаж өгөх эх сурвалж болж хувирсан.³⁷

Тоон (цифр) нотлох баримт буюу цахим нотлох баримт гэж гэмт хэргийн тал бүрийн нөхцөл байдлыг тогтоохын тулд шүүхэд нотлох баримт болгон ашиглаж буй цифр хэлбэрээр хадгалсан, дамжуулсан аливаа мэдээлэл юм. Ихэнх улсын хуулинд цахим тоон нотлох баримт гэдгийг “цахим хэлбэрээр хадгалж, эсхүл дамжуулж буй нотолгооны ач холбогдолтой аливаа мэдээлэл, түүний дотор компьютерын нотлох баримт, цифр аудио, видео, гар утас, цифр факсын мэдээллүүд” хэмээн тодорхойлсон байна.³⁸

Тоон нотлох баримтуудын үндсэн шинж нь ДНК, хурууны хээний мөртэй нэгэн адил янз бүрийн хэлбэрээр нуугдмал байдаг, ямар ч улсын хил хязгаараас үл хамаарсан, маш эмзэг, амархан өөрчилж болдог, хурдан өөрчлөгддөг, устгагддаг, цаг хугацаанд ихээхэн мэдрэмтгий байдагт оршино. Энэ шалтгааны улмаас энэ төрлийн нотлох баримтыг илрүүлэх, цуглуулах, хадгалах, баримтжуулах, судлахад онцгой дэгийг баримтлах шаардлагатай.³⁹

Тоон нотлох баримттай ажиллах үед дараах зарчмыг чанд баримтлах ёстой:

- Тоон нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, аюулгүй байдлыг хангах, хадгалах, зөөвөрлөх үйл явц уг нотлох баримтыг өөрчлөхгүй байх;
- Тоон нотлох баримтыг шинжилж буй этгээд тусгайлан сургалтад хамрагдсан, зохих мэдлэг, чадвар, туршлагатай байх;

³⁵ Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (Кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа, УБ., 2019, 17 дахь тал.

³⁶ Мөн тэнд.

³⁷ Мөн тэнд, 33 дахь тал.

³⁸ Мөн тэнд, 77 дахь тал. Дам эшлэв.

³⁹ Мөн тэнд, 77 дахь тал.

- Тоон нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, аюулгүй байдлыг нь хангах, хадгалах, зөөвөрлөх үйл явцыг заавал баримтжуулсан, зохих ёсоор хадгалсан, дараа нь үзэх боломжтой байх.⁴⁰

⁴⁰ Мөн тэнд.

Хүснэгт 6. Тоон нотлох баримтыг агуулж болох төхөөрөмж, хэрэгслүүд⁴¹

№	Тоон төхөөрөмж	Хадгалагдаж байж болох нотлох баримт
1	Суурин компьютерийн процессор их бие, зөөврийн компьютер	Төхөөрөмж өөрөө хулгай, хуурамчаар үйлдэх гэх мэт хэргийн нотлох баримт байж болно. Төхөөрөмж дотроо гэмт хэргийн нотолгоо болох төрөл бүрийн өгөгдөл, мэдээлэл, түүний дотор шууд харах боломжгүй устгасан мэдээлэл бүхий эд ангиуд агуулна. Компьютерын цифр-тоон шинжилгээ ашиглан өгөгдлийн дүрийг (image) хуулж, гаргаж авч, шинжилдэг. Мөрдөгч туршлага мэдлэгтэй бол дүрийг хуулан авах боломжтой.
2	Ажиллаж буй компьютер, серверийн дэлгэц, таблет, зөөврийн төхөөрөмж, гар утасны дэлгэц	Ажиллаж буй системийн дэлгэц дээр харагдаж буй бүх файл, зураг, график нотлох баримт байх боломжтой. Эдгээрийг видео, фото зураг хэлбэрээр бэхжүүлж баримтжуулдаг.
3	Ухаалаг карт, донгл, токен, крипто токен, биометр сканнер болон бусад	Төхөөрөмж өөрөө болон түүнд агуулагдаж буй таних, баталгаажуулах мэдээлэл, хандалтын эрх, түвшин, тохируулга, зөвшөөрлийн мэдээллүүд
4	Хариулдаг машинууд	Төхөөрөмж дуут мэдээлэл, мэдээллийг үлдээсэн хугацааны талаар мэдээллийг хадгалан үлдэж болно. Холбогдсон сүүлийн дугаар, утасны дугаарууд, бичлэг, мэдээлэл гэх мэт мэдээлэл агуулж болно.
5	Тоон камерууд	Эдгээр төхөөрөмжөөс зураг, видео, дуу авиаг гаргаж авах, сольдог юмуу байнгын санах ойн мэдээллийг авах, цаг хугацааны мэдээлэл олж авах боломжтой.
6	Тоон гар төхөөрөмж, зохион байгуулагч, тэмдэглэлийн дэвтэр, гар утас, дэлгэцэн төхөөрөмж гэх мэт	Хаягийн тэмдэглэл, хуанли, хуваарь, уулзалт, баримт бичгүүд, цахим захидал, утасны дугаарууд, мессеж, мэдээллүүд, нууц үгнүүд гэх мэт маш олон мэдээллийг эдгээр төхөөрөмжөөс олж авч болно.
7	Хатуу болон SSD дискүүд	Энэ төхөөрөмж өөрөө болон түүнд агуулагдаж буй бүх мэдээлэл өгөгдөл
8	Сүлжээний төрөл бүрийн картууд	Төхөөрөмж өөрөө болон MAC (Media access control) хаягуудыг авна.
9	Чиглүүлэгч-рутер, холбогч-свитч, хаб болон модемууд	Төхөөрөмжүүд өөрөө болон тэдгээрт агуулагдаж буй тохируулгын файлууд, IP хаягууд
10	Серверүүд	Серверийн бүх бүртгэлийн файлууд, түүнд байх хандалтын мэдээллүүд, солилцсон мэдээлэл, ажиллаж буй систем дэх захидал, оруулсан, гаргасан, өөрчилсөн, устгасан, хадгалсан, боловсруулсан гэх мэт бүх мэдээлэл, хандсан интернэт хаягууд, татсан мэдээллүүд гэх мэт.
11	Сүлжээний кабел, холбогч толгой	Сүлжээний кабел нь түүнд холбогдсон төхөөрөмжүүдийг мөшгөн бүртгэх, баталгаажуулах боломжийг олгоно. Холбогч толгойг шинжилснээр ямар төрлийн төхөөрөмжүүд холбогддогийг илрүүлнэ.
12	Принтер	Принтерт сүүлийн хэвлэсэн зүйлсийн ул мөр, мэдээлэл, тоо, мөн сүүлийн үеийн загварууд нь ашиглалтын бүртгэл, цаг хугацааг хадгалан үлддэг. Сүлжээний принтер бол сүлжээний талаар зарим мэдээллийг хадгална. Түүнчлэн, сүүлд ашигласан хүмүүсийн гарын хээний мөрийг авч болно.

⁴¹ Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (Кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа, УБ., 2019, 77 дахь тал.

13	Зөөврийн тээгч, санах ой бүхий төхөөрөмж	Бүх төрлийн флаш диск, зөөврийн диск, шинэ үеийн гар утас, камер, дэлгэцэн таблет төхөөрөмжүүдийн санах ойд нотлох баримтын ач холбогдолтой олон файл хадгалагдаж болно.
14	Сканнер	Энэ төхөөрөмж өөрөө болон түүний санах ойд үйлдсэн хууль бус үйлдлийн талаарх бүртгэлийн мэдээлэл
15	Телефон болон гар утас	Орчин үеийн ихэнх телефон утас дуудлагын түүх, нэр, бичгэн болон дуут мессеж, бичлэг, утасны дугаар, нууц үг болон дуудлага хийгчийн мэдээллийг хадгалсан байж болно.
16	Хувилагч	Хувилагчууд хувилсан баримт бичгийн ул мөрийг биетээр болон цахим хэлбэрээр хадгалж үлдсэн байж болно. Түүнчлэн, хэрэглэгч, хувилсан цаг хугацааны бүртгэлийг агуулдаг.
17	Диск уншигч, бичигч	Эдгээр төхөөрөмжид нотлох баримтын ач холбогдолтой файл, бүртгэл, огнооны мэдээлэл үлдэж болно.
18	Карт уншигчид	Картны соронзон тууз, чипний дараах мэдээллүүд карт уншигчид үлдэж болно. 1. Картны хугацаа 2. Хэрэглэгчийн нэр, хаяг 3. Картны дугаар
19	Цифр технологитой цагууд	Сүүлийн үеийн цифр-тоон цагууд хаяг, тэмдэглэл, ажлын хуваарь, утасны дугаар, цахим шуудан, замын маршрут, байршлын тухай мэдээлэл хадгалдаг.
20	Факсын машин	Факсын аппарат нь зарим баримт бичиг, бүртгэл, тухайлбал, холбогдсон утасны дугаарууд, илгээсэн, хүлээн авсан бүртгэл, хэвлэгч картриж хор агуулдаг. Картриж хороос сүүлийн хэвлэсэн зүйлсийн ул мөрийг гаргаж авч болно.
21	GPS байршил тодорхойлогч систем	Аялсан маршрут очдог газруудын байршил, замын цэгүүд, тэдгээрийн нэр гэх мэт олон мэдээлэл гарган авч болно.
22	Компьютерын гар, хулгана	Эдгээрээс хурууны хээ авч болохоос гадна ямар товчлуурыг илүү их дардаг, нууц үгээ хэрхэн оруулдаг зэргийг мэдэх боломжтой.

Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт халдлагыг шинжлэх ухааны тодорхой салбарын тусгай мэдлэг, тусгай техник хэрэгсэл, тусгай арга, арга зүйг ашиглан шинжлэн судалж гаргасан баттай дүгнэлтийг үндэслэн болж өнгөрсөн үйл явдлын бодит үнэнийг тогтоохоос өөрөөр уламжлалт аргаар мөрдөн шалгаж шийдвэрлэх ямар ч боломжгүй болсон. Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт халдлага бүр орон зай, цаг хугацааны хувьд ямар ч хязгаарлалтгүй төдийгүй үйлдэгч болон хохирогч, хохирлын шинж, онцлог, зорилго, сэдэл, үйлдэлдээ хэрэглэсэн арга, технологи шаардах болсонтой холбоотой.⁴²

Дэлхийн бусад улс орнуудад ч эрүүгийн болон кибер гэмт хэргийн чиглэлээр шуурхай хамтран ажиллах механизм бий болгох нь маш чухал болохыг тэмдэглэж байна. Зарим улс хууль хамгаалах байгууллагуудын хооронд албан бус хамтын ажиллагааны механизмыг хөгжүүлэхийг санал болгож байгаа бол зарим нь хоёр талын болон олон талын, бүс нутгийн гэрээ байгуулах замаар албан ёсны сувгуудыг хөгжүүлэхийг санал болгож байна. Түүнчлэн, CERT / Computer Emergency Response Team /, CSIRT / Computer Security Incident Response Team /-ийн шугамаар нотлох баримтыг даруй гаргуулж авах хамтын ажиллагааг санал болгож байна.⁴³

⁴² Монгол Улсад үйлдэгдэж байгаа кибер гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, түүнтэй тэмцэх арга зам, үндсэн чиглэл /Суурь судалгааны тайлан/, УБ, 2015, 88 дахь тал.

⁴³ Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (Кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа, УБ, 2019, 7 дахь тал.

Тоон (цифр) нотлох баримт нь кибер гэмт этгээдийн гэм бурууг нотлоход ашиглаж буй тоон хэлбэртэй төрөл бүрийн хэрэгслийг хэлдэг. Энэ нь хадгалж болдог болон түргэн хугацаанд устдаг өгөгдлүүд, компьютерийн файл, дамжуулалт, үйлдлийн бүртгэл файлууд, журнал, мета өгөгдлүүд болон сүлжээний өгөгдлүүд хэлбэртэй байж болно.

Шүүхийн тоон шинжилгээний явцад ихэнхдээ тогтвортой бус, хялбархан өөрчлөгддөг, нотлох баримтын ач холбогдолтой мэдээллийг сэргээх ажиллагаа хийгддэг. Шүүхийн тоон шинжилгээний аргад эх өгөгдөлд өөрчлөлт орохоос сэргийлэх зорилгоор хадгалагдаж байгаа болон устгасан мэдээллийн хувийг “битийг битэд”, “бичлэгийг блоклох” зарчмын дагуу үүсгэх арга ордог. Дэлхийн ихэнх улсад шүүхийн тоон шинжилгээний чадамжийг бий болгосон байхад Монгол улсад энэ нь эхлэл төдий байна. Монгол улсын нэгэн адил хөгжиж буй улсуудад шүүхийн тоон шинжээчид хүрэлцээгүй, шинжилгээ хийх хэрэгсэл, төхөөрөмж, тусгай программ хангамж дутагдалтай байна. Түүнчлэн, сэжигтнүүд шифрлэлтийг түлхүү ашигладаг болсон учир задлах түлхүүрийг олох хэрэгслүүд шаардлагатай болж байна. Ихэнх улсад тоон нотлох баримтын шинжилгээг цагдаагийн байгууллага гүйцэтгэж байна. Прокурорууд цахим нотлох баримтыг судлах, ойлгох шаардлагатай. Гэтэл прокурорын байгууллагад энэ чиглэлийн чадамж, чадвартай хүний нөөц байхгүй байна.⁴⁴

Кибер гэмт хэргийн нөхцөл байдлыг нотлох буюу гэмт хэргийн ул мөрийг баримтжуулах нь тоон шинжилгээтэй (digital forensic) салшгүй холбоотой. Тоон шинжилгээ нь цахим нотлох баримт цуглуулах, шалгах, үнэлэхтэй холбоотой хийгдэж буй ажиллагаа буюу шүүхийн шинжилгээний нэг тусгай төрөл юм. Ийм тусгай шинжилгээг тоон шинжилгээ буюу компьютерын шинжилгээ гэсэн хоёр ойлголтоор илэрхийлдэг. Тоон шинжилгээ (digital forensic) гэдэг нь аливаа тоон тоног төхөөрөмжтэй хамааралтай материал дээр үндэслэн төрөл бүрийн тусгай арга механизм, техникийг ашиглан дүн шинжилгээ хийх замаар баримт бүрдүүлэх шинжилгээ судалгааны нэг төрөл юм. Харин компьютерын шинжилгээ нь тоон шинжилгээний нэг төрөл бөгөөд компьютер болон хадгалах төхөөрөмжид хадгалагдсан өгөгдөл дээр үндэслэн төрөл бүрийн тусгай арга механизм, техникийг ашиглан дүн шинжилгээ хийх замаар баримт бүрдүүлэх, дүгнэлт гаргах ажиллагаа юм.⁴⁵

Манай улсын ЭХХШТХ-ийн 16.1 дүгээр зүйлийн 6-д “Нотлох баримтыг хууль бус арга, хэрэгслээр цуглуулж, бэхжүүлэхийг хориглоно” гэж, мөн хуулийн 16.11, 16.12 дугаар зүйлд нотлох баримтаар тооцохгүй байх тохиолдлуудыг хуульчилсан. Шүүхэд ирүүлж буй файлын төрөл нь эх төхөөрөмж дээр бичигдсэн байдлаас өөр байх нь мультимедиа нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх эсэхэд эргэлзээ төрүүлж, маргаан үүсгэдэг.⁴⁶

Монгол Улсын хувьд ЭХХШТХ-ийн 16.1 дүгээр зүйлийн 4-т “Мөрдөгч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу нотлох баримт цуглуулж, шалгаж, бэхжүүлнэ” гэж заасны дагуу мөрдөгч нотлох баримтыг бэхжүүлэх ажиллагааг гүйцэтгэдэг.

⁴⁴ Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (Кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа, УБ, 2019, 16 дахь тал.

⁴⁵ Цахим орчин дахь гэмт хэргийн ул мөрийг баримтжуулж авах нь, <https://www.mnb.mn/i/92447>

⁴⁶ ННФ, Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа /Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд/, УБ, 2022, 68 дахь тал.

2.2. Монгол Улс дахь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримтын нөхцөл байдал, хэрэгцээ, шаардлага

Ковид 19 цар тахлын нөлөөгөөр цахим харилцаа холбоо, цахимжилт нийгмийн олон талт харилцаанд томоохон нөлөө үзүүлсэн. Ийнхүү цахим харилцаа холбоо өргөжин тэлэхийн хэрээр Монгол Улсад төдийгүй олон улсын хэмжээнд шинэ төрлийн гэмт хэргүүд бүртгэгдэж, цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн тоо өсөх, зарим гэмт хэргийг урьд тогтсон уламжлалт хандлагаар авч үзэх боломжгүй байдлаар хувьсан өөрчлөгдөж агуулга, хэлбэр, хор уршиг, хохирлын хэмжээ нэмэгдэж байна. Иймээс ч тухайн гэмт хэргийг илрүүлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж, хэргийн бодит байдлыг тогтооход цахим нотлох баримт чухал ач холбогдолтой болоод байна.

Тухайлбал, 2022 онд Прокурорын байгууллага Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэгт заасан Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хамаарах нийт 751 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьж ажилласан бөгөөд Эрүүгийн хуулийн 26.1 дүгээр зүйлд заасан Кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан 750 хэрэг, мөн хуулийн 26.3 дугаар зүйлд заасан Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан 1 хэрэг байна. Энэхүү 751 хэргийн 2 хэргийг хэрэгсэхгүй болгож, 37 хэргийг шүүхэд шилжүүлж, 202 хэргийг нэгтгэн, 71 хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэжээ.

Энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд цахим нотлох баримт чухал үүрэгтэй боловч цахим суурьтай нотлох баримтыг бэхжүүлэх, цуглуулах, хадгалах, шинжлэн судлах зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цаасан суурьтай нотлох баримттай ижил түвшинд үнэлэхгүй байх, цахим нотлох баримтыг заавал цаасан суурьтай нотлох баримт болгох, цаасан хэлбэрт буулгаж хавтаст хэрэгт хавсаргах зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна.

Гэтэл кибер гэмт хэрэг үйлдэж буй орон зай, тухайн хэрэгт ашиглаж буй төхөөрөмж, хэрэгсэл, халдлагын зүйлээс шалтгаалж, зөвхөн уламжлалт нотлох баримт (бичгэн болон эд мөрийн баримт)-уудад тулгуурлан тухайн үйл явдал болсныг нотлох, эсвэл үгүйсгэх боломжгүй тул цахим нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах ажиллагаа чухал байр суурь эзэлдэг. Хэрэгт ач холбогдол бүхий цахим, аналог, дижитал (тоон) баримтуудыг хамтад нь “цахим баримт” гэж нэрлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нийтлэг байдлаар хэрэглэж байна.

Цахимаар мэдүүлэх, цахим хавтаст хэрэг үүсгэх, цахим нотлох баримт, нотлох баримтыг цахим хэлбэрт оруулснаар цаасан суурьтай бичиг баримт бүрдүүлэх шаардлагагүй болж, байгаль орчинд эергээр нөлөөлнө. Мөн цахимаар шүүхэд мэдүүлэх, цахим хавтаст хэрэг үүсгэх зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулснаар шүүхийн хүртээмж илүү нэмэгдэж, хэрэг маргаан хянан шийдвэрлүүлж буй этгээдийн хувьд цаг хугацаа, зардал хэмнэгдэж, шүүхэд итгэх иргэдийн итгэл нэмэгдэн шүүх эрх мэдэл улам бэхжих юм.⁴⁷

Түүнчлэн, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээр цаасан суурьтай баримт бичиг шаардахгүй байх үндэслэл бий болно. Ингэснээр иргэд заавал өөрийн биеэр очиж, хэн нэгэн албан тушаалтны хаалга үүдийг сахиж, цаас бүрдүүлэх шаардлагагүй болно.

⁴⁷ Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын төсөлд хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ /Хөндлөнгийн судалгаа/, УБ, 2023, 47 дахь тал.

Нөгөөтээгүүр, цахим баримт бичгийг нотлох баримт бичгийн хэмжээнд хүлээн зөвшөөрдөг болох юм. Практикт төрийн байгууллагын үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэхэд цахим баримт бичгийг нотлох баримтын хэмжээнд үнэлдэггүй, цаасан баримт бичгийг л нотлох баримтын хэмжээнд хүлээн зөвшөөрдөг.⁴⁸

Шигтгээ 5.

Цахим нотлох баримтын одоогийн практикийн хувьд ИХШХШТХ-ийн жишгээр буюу баримт бичгийн эх хувь нь цахим бол шүүх түүнийг нотлох баримтад тооцож байна. Гэвч цахим нотлох баримтыг үнэлэхэд шүүхэд тулгарч буй гол асуудал түүнийг үнэлэх, үнэн зөвийг нь тогтооход төвөгтэй, цаг хугацаа шаарддаг, зарим тохиолдолд нарийн мэргэжлийн мэдлэг, технологи шаардлагатай байдаг. Иймд шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь цахим нотлох баримтын үнэлэх чадавхийг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм.

Цахим нотлох баримтын тал дээр одоо хэрэгжиж байгаа туршлага гэвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай улсын мэдээллийн санд буй 18 төрлийн мэдээллийг шүүх нь тамгын газрын даргаар дамжуулан шууд авч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглаж байгааг дурдаж болно. Гэхдээ ийнхүү төрд цахимаар байгаа мэдээллийг шүүх шууд хандан авах практикийг цаашид эрүүгийн болон зарим тохиолдолд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илүү ашиглах, нэвтрүүлэх шаардлагатай бөгөөд учир нь ийнхүү нотлох баримтыг шүүх өөрөө цуглуулах нь иргэний эрх зүйн мэтгэлцэх зарчимтай харшлах магадлалтай юм.

Мөн энэ тал дээр бас нэг анхаарах чухал асуудал бол цахим буюу дижитал архивыг бий болгох, үйл ажиллагааг нь зохион байгуулах, ажиллах журмыг боловсруулах асуудал юм.

Ер нь ЭХХШТХ-д цахим нотлох баримтын хэлбэрийн шаардлага болон хэрхэн үнэлэх журам, цахим хавтаст хэргийн тодорхойлолт, түүнийг хөтлөх журам зэрэг нарийвчилсан зохицуулалтыг шууд хуульчлан тусгахын оронд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримтыг үнэлэх, хавтаст хэргийн цахимаар хөтлөж болох тухай ерөнхий зохицуулалтыг хийж цахим нотлох баримт, түүнийг баталгаажуулах, үнэлэх, цахим хавтаст хэргийг хөтлөх зэрэг ажлыг аргачлалаар хангах ажлыг зохион байгуулах боломж бий. Нэгэнт байгуулагдсан ШЕЗ гэх мэт институцид даалгах нь илүү оновчтой шийдэл байж болох юм.

Гэхдээ ийнхүү ажлыг зохион байгуулахдаа ХБНГУ зэрэг улсын жишгийн дагуу, хавтаст хэргийг цахимаар хөтлөх, нотлох баримтыг цахимаар авах, цахим хэлбэрт байгаа хавтаст хэрэгт хэргийн оролцогчид хандах, шүүх хуралдаанд эдгээр цахим баримтыг танилцуулах, үнэлэх зэрэг ажлыг аль болох хэрэгийн оролцогчид шууд хандаж ойлгох, ашиглахад хялбар хэлбэр бүхий технологийг ашиглах нь зүйтэй.

Мөн шүүхийн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар нэвтрүүлэх хэрэгтэй. Жишээлбэл, бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг шийдэх, таслан сэргийлэх арга хэмжээ авах, шүүгч ээлжээр ажиллах ажлыг цахимаар явуулахаар бол тодорхой хугацаа зааж, уг хугацааны хүрээнд уг ажлыг зохион байгуулна гээд тэр хугацаанд нь мэргэжлийн оролцогчдын тоон гарын үсгийг ашиглаж сурах боломжийг бүрдүүлэх гэх мэт.

Ийнхүү шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим болгож буй гол үндсэн зорилго нь шүүхийн ажиллагааг хурдан шуурхай болгож, иргэдийн шударгаар шүүлгэх эрхийг хангах, ил тод байдлыг хангах бөгөөд хэрэгцээ шаарлагын хувьд өнөө үед нотлох баримт цахим байх, түүнийг үнэлэх, хавтаст хэргийг цахимаар хөтлөх зэрэг нь боломжтой, зарим тохиолдолд зайлшгүй цахим хэрэглээнд тохирсон зохицуулалт байх тул нийгмийн энэ хөгжлийг дагасан зохицуулалт хийх шаардлагатай.

Цахим хавтаст хэрэг, нотлох баримтыг хадгалах, архивлах ажлын хувьд тэдгээрийг хэрхэн хадгалах технолги (scanner), хадгалалтын хугацаанд тохирсон хэлбэр (pdf) зэргийг анхаарч үзэх мөн зарим төрлийн гэмт хэрэгтэй холбоотой хэргийн материал, хавтаст хэрэг зэргийг цаасаар байх эсэх гэх мэт зохицуулалтыг ч анхаарах шаардлагатай.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гишүүн Н.Баасанжавтай хийсэн ярилцлагын хэсгээс...

⁴⁸ М.Бямбасүрэн, Цахим баримт бичгийг нотлох баримтын хэмжээнд үнэлдэг байх шаардлагатай нийтлэл, 2024.01.29, <https://business.mn/2024/01/29/m-byambasuren-tсахим-barimt-bichgiig-notloh-barimtiin-hemjeend-uneldeg-baih-shaardlagatai/>

Цахим нотлох баримт, цахим хавтаст хэрэг, цахимжуулсан хавтаст хэрэг гэх мэт цахимжуулалттай холбоотой асуудлыг шийдвэрлэхийн тулд юун түрүүнд эрх зүйн орчин, дата бааз, хадгалах сервер, технологийн шийдэл, бүрдүүлэх нь чухал.

Тухайлбал, цахим хавтаст хэрэг үүсгэснээр маш их хэмжээний дата буюу өгөгдөл бий болно. Иймд шүүхийн их өгөгдлийн сан буюу Big data-г үүсгэх нь чухал. Их өгөгдөл бол компьютерын шинжлэх ухаан, статистик хоёртой салшгүй холбоотой бөгөөд мэдээллүүдийг нэгтгэж, хооронд нь холбож, богино хугацааны давтамжтайгаар, олон үзүүлэлтээр боловсруулах, нарийвчлан задлах зэргээр маш хурдтай, цаг хугацааны алдагдалгүй, байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглах, иргэд олон нийтэд мэдээлэх, оновчтой бодлого шийдвэр гаргахад зориулагдсан технологийн \hadoop зэрэг\ шийдэл юм.⁴⁹

2.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтын харьцуулсан судалгаа

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтын талаар харьцуулсан судалгааг хийхдээ өмнө нь авч үзсэн шүүх, хууль, эрх зүйн үйл ажиллагааг цахимжуулах талаар дэвшил гаргасан, эрх зүйн тогтолцооны хувьд жишиг болгож судалдаг дараах улсуудыг судаллаа. Мөн олон улсын гэрээ, конвенцийн зохицуулалтыг нэмж судлан харьцуулсан юм.

2.3.1. Олон улсын гэрээ, конвенцийн зохицуулалт

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримт, хавтаст хэрэг, түүний хадгалалтын талаар дараах олон улсын гэрээ, конвенцүүд хүчин төгөлдөр үйлчилж байна.

- Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтыг бий болгох, хадгалах журам (EU) 2023/154;

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт цуглуулах үүрэг бүхий байгууллагыг үүсгэн байгуулах, түүний хууль ёсны төлөөлөгчдийг томилох зохицуулалтыг ижилтгэх удирдамж (EU) 2023/154;

- Кибер гэмт хэргийн тухай Будапештийн конвенц (ETS No. 185);

- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц ба түүнд заасан протоколууд (55/255)

- Истанбулын протокол (Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг гутаан харьцах, шийтгэхийг үр дүнтэй мөрдөн шалгах, баримтжуулах гарын авлага)

- Хувийн мэдээллийг автоматаар боловсруулахтай холбоотой хувь хүнийг хамгаалах тухай Европын зөвлөлийн конвенц гэх мэт.

1. “Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь цахим нотлох

⁴⁹ Г.Даваадорж: Шүүхийн цахимжилтад хууль эрх зүйн орчин ус агаар мэт хэрэгтэй байна, https://www.judcouncil.mn/site/news_full/13818

баримтыг бий болгох, хадгалах журам”⁵⁰ болон “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт цуглуулах үүрэг бүхий байгууллагыг үүсгэн байгуулах, түүний хууль ёсны төлөөлөгчдийг томилох зохицуулалтыг ижилтгэх удирдамж”⁵¹-ийн гол зорилго нь цахим нотлох баримтын тогтворгүй шинж чанар, хадгалагдсан өгөгдлийн (дата) "байршлын алдагдлаас" үүссэн асуудлуудыг тусгайлан шийдвэрлэхийн тулд одоо байгаа олон улсын хамтын ажиллагаа, эрх зүйн харилцан туслалцааны хэрэгслүүдээс илүү хурдан, илүү үр дүнтэй механизмыг бий болгох явдал юм. Уг журамд гишүүн улсын эрх бүхий байгууллага эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Европын нотлох баримт бий болгох захиалга эсвэл хадгалалтын захиалга гаргаж, үүгээрээ Холбооны нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлж буй болон өөр гишүүн улсад байгуулагдсан үйлчилгээ үзүүлэгчээс (шууд), эсхүл ийм байгууллага байгуулаагүй бол өөр гишүүн улсын хууль ёсны төлөөлөгчөөр төлөөлүүлэн мэдээллийн байршлаас үл хамааран цахим нотлох баримтыг захиалж авах, бүрдүүлж болох юм.

Цахим нотлох баримтыг олж авах буюу түүнд хандах эрхийг олж авах эрх бүхий байгууллагын хувьд төвөгтэй, урт удаан процесс бөгөөд учир нь уг цахим өгөгдөл, түүнд хандах эрх нь ихэвчлэн өөр улсад байдаг. Онлайн үйлчилгээ үзүүлэгчид Европын холбооны доторх болон гаднах хэд хэдэн улс оронд байрлах серверүүд дээр хэрэглэгчдийн мэдээллийг хадгалдаг бөгөөд энэ нь цахим нотлох баримт, түүнд хандах эрхийг шүүх олж авах ажлыг илүү удаа төвөгтэй болгодог. Европын холбооны гишүүн орнууд даяар явагдаж буй нийт ЭХХША-ны 50 хувь гадаад дахь цахим нотлох баримтын авах, түүнд хандах зөвшөөрлийг хүссэн хүсэлт гадаад орнуудад гаргасан байдаг.

Дээрх шалтгаануудыг үндэслэн 2018 оны 4-р сард Европын Зөвлөл болон Зөвлөлийн уриалгын дагуу Европын Комисс эрх баригчдад мэдээллийн байршлаас үл хамааран цахим нотлох баримтад хандахад хялбар, хурдан болгох шинэ зохицуулалтыг бий болгохыг санал болгосон байна. Ийнхүү ЕХ-ны хувьд таван жил үргэлжилсэн хэлэлцээний эцэст Европын Зөвлөл болон Европын парламент (ЕП) Европын холбооны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт цуглуулах шинэ тогтолцоог нэвтрүүлэх хууль тогтоомжийн актууд болох дээрх зохицуулалтыг баталжээ⁵².

“Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтыг бий болгох, хадгалах журам”⁵³-ын 3 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт “цахим нотлох баримт”-ыг Европын нотлох баримтын захиалгын гэрчилгээ (ЕРОС) эсвэл Европын хадгалалтын

⁵⁰ Regulation (EU) 2023/1543 of the European Parliament and of the Council of 12 July 2023 on European Production Orders and European Preservation Orders for electronic evidence in criminal proceedings and for the execution of custodial sentences following criminal proceedings, <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv%3AOJ.L.2023.191.01.0118.01.ENG>

⁵¹ Directive (EU) 2023/1544 of the European Parliament and of the Council of 12 July 2023 laying down harmonised rules on the designation of designated establishments and the appointment of legal representatives for the purpose of gathering electronic evidence in criminal proceedings, <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv%3AOJ.L.2023.191.01.0181.01.ENG>

⁵² E-evidence - cross-border access to electronic evidence Improving cross-border access to electronic evidence, https://commission.europa.eu/law/cross-border-cases/judicial-cooperation/types-judicial-cooperation/e-evidence-cross-border-access-electronic-evidence_en

⁵³ Regulation (EU) 2023/1543 of the European Parliament and of the Council of 12 July 2023 on European Production Orders and European Preservation Orders for electronic evidence in criminal proceedings and for the execution of custodial sentences following criminal proceedings, <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv%3AOJ.L.2023.191.01.0118.01.ENG>

захиалгын гэрчилгээг хүлээн авах үед үйлчилгээ үзүүлэгчээс эсвэл түүний өмнөөс цахим хэлбэрээр хадгалсан захиалагчийн өгөгдөл, шилжүүлгийн өгөгдөл эсвэл контентын өгөгдөл байхаар томъёологджээ. Мөн үүнтэй холбогдуулан дараах харилцааг зохицуулжээ.

I БҮЛЭГ. ЗОХИЦУУЛАХ АСУУДАЛ, ХАМРАХ ХҮРЭЭ БА НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 1- р зүйл. Зохицуулах асуудал
- 2- р зүйл. Хамрах хүрээ
- 3- р зүйл. Нэр томъёоны тодорхойлолт

II БҮЛЭГ. ЕВРОПЫН ЦАХИМ НОТЛОХ БАРИМТ БИЙ БОЛГОХ БОЛОН ХАДГАЛАХ ЗАХИАЛГА, ГЭРЧИЛГЭЭ

- 4- р зүйл. Эрх бүхий байгууллага
- 5- р зүйл. Цахим нотлох баримт бий болгох захиалга хийх нөхцөл /журам/
- 6- р зүйл. Цахим нотлох баримт хадгалах захиалга хийх нөхцөл /журам/
- 7- р зүйл. Европын цахим нотлох баримт бий болгох, хадгалах захиалга гаргах хаяг
- 8- р зүйл. Хууль сахиулах байгууллагад мэдэгдэх
- 9- р зүйл. Европын цахим нотлох баримт бий болгох, хадгалах захиалгын гэрчилгээ
- 10- р зүйл. Цахим нотлох баримт бий болгох захиалгыг гүйцэтгэх
- 11- р зүйл.
- 12- р зүйл. Европын цахим нотлох баримт бий болгох захиалгаас татгалзах үндэслэл
- 13- р зүйл. Хэрэглэгчийн мэдээлэл ба нууцлал
- 14- р зүйл. Зардлын нөхөн төлбөр

III БҮЛЭГ. ТОРГУУЛЬ БА АЛБАДАН ГҮЙЦЭТГЭЛ

- 15- р зүйл. Торгууль
- 16- р зүйл. Албадан гүйцэтгүүлэх процесс

IV БҮЛЭГ. ЗӨРЧИЛДӨӨНИЙ ХЭМ ХЭМЖЭЭ БА АРГА ХЭМЖЭЭ

- 17- р зүйл. Зөрчилдөөнтэй үүрэг үүссэн тохиолдолд хянан шалгах процесс
- 18- р зүйл. Үр дүн бүхий арга хэмжээ

V БҮЛЭГ. ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ ТОГТОЛЦОО

- 19- р зүйл. Эрх бүхий байгууллага, үйлчилгээ үзүүлэгч болон эрх бүхий байгууллагуудын хооронд дижитал харилцаа холбоо, мэдээлэл солилцох аюулгүй байдлыг хангах
- 20- р зүйл. Цахим баримт бичгийн эрх зүйн үр нөлөө
- 21- р зүйл. Цахим гарын үсэг ба тамга
- 22- р зүйл. Лавлагаа хэрэгжүүлэх програм хангамж
- 23- р зүйл. Төвлөрлийг бууруулах IT системийн зардал
- 24- р зүйл. Шилжилтийн үе
- 25- р зүйл. Актыг хэрэгжүүлэх

2. Кибер гэмт хэргийн тухай Будапештийн конвенц нь интернэт болон бусад компьютерийн сүлжээгээр үйлдэгдсэн гэмт хэргийн тухай, ялангуяа зохиогчийн эрхийг зөрчих, компьютертэй холбоотой луйвар, хүүхдийн садар самууныг сурталчлах, сүлжээний аюулгүй байдлыг зөрчих зэрэг гэмт хэргийн тухай олон улсын анхны гэрээ юм. Энэ нь мөн компьютерийн сүлжээг хайх, саатуулах зэрэг хэд хэдэн зохицуулалт, процедурыг агуулдаг. Оршил хэсэгт тусгагдсан гол зорилго нь нийгмийг цахим гэмт хэргээс хамгаалах, ялангуяа зохих хууль тогтоомжийг баталж, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн эрүүгийн нийтлэг бодлогыг хэрэгжүүлэх явдал юм⁵⁴. Тус конвенцын 14, 35 дугаар зүйлд оролцогч тал бүр эрүүгийн гэмт хэргийн нотлох баримтыг цахим хэлбэрээр цуглуулахыг үүрэг болгосон ба 23, 25 дугаар зүйлд зааснаар цахим нотлох баримтын талаар өргөн

⁵⁴ Details of Treaty No.185, <https://www.coe.int/en/web/conventions/full-list?module=treaty-detail&treaty-num=185>

хүрээнд хамтран ажиллана. Мөн түүнчлэн 46 дугаар зүйлд нотлох баримтыг цахим хэлбэрээр цуглуулах чиглэлээр талууд хамтарч ажиллахаар тусгажээ⁵⁵.

3. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн 20, 29 дүгээр зүйлд үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд цахим тандалт, мөрдөх ажиллагааг хэрэгжүүлж орчин үеийн арга барил хэрэглэхийг талуудад үүрэг болгожээ⁵⁶.

4. Истанбулын протокол (Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг гутаан харьцах, шийтгэхийг үр дүнтэй мөрдөн шалгах, баримтжуулах гарын авлага)-ын 232 дугаар зүйлд дараах зохицуулалтыг мөн тусгажээ.

- Мөрдөгч цахим төхөөрөмж дээр хадгалагдаж, хүлээн авсан эсвэл дамжуулсан аливаа нотлох мэдээллийг баталгаажуулахыг эрэлхийлэх ёстой. Ялангуяа компьютер, гар утас зэрэг электрон төхөөрөмжүүдийг хураан авах, нээлттэй эх сурвалжийн мэдээллийг интернетээр үзэх замаар цахим нотлох баримтыг олж авч болно. Хэрэв хураан авсан цахим хэрэгслээс дижитал нотлох баримтыг олж авбал эдгээр төхөөрөмжийг эд мөрийн баримт болгон хадгалах шаардлагатай бөгөөд мэдээллийг гаргаж авсан дижитал шинжээч шүүхэд ашиглах боломжтой тайлан эсвэл нотлох баримтыг бэлтгэх ёстой. Дижитал нотолгоонд дараахь зүйлс орно: (а) эрүүл мэндийн цахим бүртгэл; (б) хаалттай камераар бичигдсэн видео; (в) дижитал камер, ухаалаг утас зэрэг хөдөлгөөнт хэрэгслээр авсан зөрчил, бие махбодид гэмтэл учруулсан газар гэх мэтийг агуулсан зураг, видео; (г) олон нийтийн мэдээллийн хэрэгслээр байршуулсан зураг, видео болон бусад мэдээлэл; (д) санах ойн карт, USB хөтөч, CD-ROM гэх мэт компьютерийн хатуу диск болон бусад дагалдах төхөөрөмжид хадгалагдсан мэдээлэл; (е) имэйл, текст болон шуурхай мессеж; (ж) агаарын болон сансрын хиймэл дагуулаас авсан зураг, тухайлбал, нууц саатуулах төв эсвэл зөрчлийн бусад газар; (ж) гар утас эсвэл олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хадгалагдсан байршлын мэдээлэл; ба (и) мета өгөгдөл, өөрөөр хэлбэл файлын талаарх мэдээлэл (жишээ нь дижитал гэрэл зураг авсан цаг хугацаа, байршил гэх мэт). Дижитал нотлох баримтын жинхэнэ байдал нь түүнийг нотлох баримт болгон ашиглахад чухал ач холбогдолтой юм. Тиймээс түүний жинхэнэ эсэхийг дижитал шүүх эмнэлгийн хүлээн зөвшөөрөгдсөн арга техникийг ашиглан шалгах хэрэгтэй⁵⁷.

5. Хувийн мэдээллийг автоматаар боловсруулахтай холбоотой хувь хүнийг хамгаалах тухай Европын зөвлөлийн конвенцийн зорилго нь оролцогч улс бүрийн нутаг дэвсгэрийн харьяалал, оршин суугаа газраас үл хамааран хүний хувийн халдашгүй байх эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх ("өгөгдлийн хамгаалалт"), ялангуяа хувийн нууцыг хамгаалах эрхийг хангахад оршино. Тус конвенцийн 5 дугаар зүйлийн е хэсэгт агуулгыг таних боломжтой хэлбэрээр хадгалагдсан өгөгдлийг тухайн өгөгдлийг хадгалах зорилгод шаардагдах хугацаанаас илүүгээр хадгалж болохгүй талаар мөн зохицуулжээ⁵⁸.

⁵⁵ Convention on Cybercrime Budapest, 23.XI.2001, <https://rm.coe.int/1680081561>

⁵⁶ United Nations Convention against Transnational Organized Crime and the Protocols Thereto, <https://www.unodc.org/unodc/en/organized-crime/intro/UNTOC.html>

⁵⁷ Manual on the Effective Investigation and Documentation of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, https://www.ohchr.org/sites/default/files/documents/publications/2022-06-29/Istanbul-Protocol_Rev2_EN.pdf

⁵⁸ Convention for the Protection of Individuals with regard to Automatic Processing of Personal Data Strasbourg, 28.I.1981, <https://rm.coe.int/1680078b37>

2.3.2. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын сайн туршлага

Цахим нотлох баримт гэдэг нь тодорхой эрүүгийн мөрдөн байцаалтад хамаарах тоон (дигитал) хэлбэрээр хадгалагдсан эсвэл дамжуулсан бүх мэдээллийг хэлэх бөгөөд цахим нотлох баримтыг дигитал өгөгдөл хаана хадгалагдаж байгаа зөөвөрлөгчийг хайх, хураах, үйлчилгээ үзүүлэгчийн оролцоотойгоор дигитал өгөгдөл (захиалагчийн мэдээлэл, хөдөлгөөний мэдээлэл, агуулгын өгөгдөл) цуглуулах замаар олж авдаг.⁵⁹

ХБНГУ-ын хувьд эрүүгийн процессын эрх зүй буюу ЭХХШТХ-даа цахим нотлох баримтыг тусгайлан тодорхойлж, зохицуулаагүй байна. Харин нотлох баримтын хувьд дараах нотлох баримтуудыг ЭХХША-нд хатуу (Strengbeweis) нотлох баримтаар тооцон үнэлнэ гэж заасан байдаг. Эдгээрт

- Шинжээчийн дүгнэлт (§§ ЭХХШТХ-ийн 72);
- Шүүхийн хяналт, шалгалт хийсэн баримт бичиг (§ ЭХХШТХ-ийн 86);
- Баримтат нотлох баримт (§ ЭХХШТХ-ийн 249);
- Гэрч (§§ ЭХХШТХ-ийн 48) зэрэг нотлох баримтын төрлүүд тус тус багтана.

Эдгээрээс “Унших замаар нотлох баримтыг баримтжуулах; хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед уншиж танилцуулсан нотлох баримт” гэсэн ЭХХШТХ-ийн 249-р зүйлийн (1)-т “...Цахим баримт бичгийг уншиж танилцах боломжтой бол баримт бичиг гэж үзнэ.”⁶⁰ гэж заасан байна.

Дээрхээс үзэхэд ХБНГУ-ын ЭХХШТХ-д цахим нотлох баримтыг тусгайлан тодорхойлж зохицуулаагүй ч ЭХХША-нд цахим нотлох баримтыг ашиглах, үнэлэхийг хориглосон аливаа хязгаарлалт байхгүй буюу хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд ЭХХША-нд ашиглах боломжтой байна. Өөрөөр хэлбэл Герман улсын ЭХХША-ны нотлох баримтад хэлбэрийн шаардлага тавьдаггүй буюу цахим нотлох баримтыг хэлбэрийн хувьд тусгайлан авч үзэх, эсхүл хязгаарласан хязгаарлалт байхгүй.

ХБНГУ-ын нэгдэн орсон цахим нотлох баримт, түүнийг цуглуулах, олж авах асуудалд хамаарах олон улсын хууль тогтоомж, гэрээ, конвенц.

- “Цахим (Кибер) гэмт хэргийн тухай” 2001 оны Будапештын конвенц;
- Эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны Европын журам (EU 2014);
- Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих ял эдлүүлэх ажиллагааны цахим нотлох баримтыг бий болгох, хадгалах журам (EU) 2023/1543;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт цуглуулах үүрэг бүхий байгууллагыг үүсгэн байгуулах, түүний хууль ёсны төлөөлөгчдийг томилох зохицуулалтыг ижилтгэх удирдамж (EU) 2023/1544 .

Цахим нотлох баримтыг ЭХХША-нд үнэнийг тогтоох зорилгоор Үндсэн хуулийн шаардлагыг хүрээнд ашиглах нь (ХБНГУ-ын практик туршлага)

⁵⁹ European Judicial Network, Fiches Belges on electronic evidence Germany. Available at. <https://www.ejn-crimjust.europa.eu/ejnupload/DynamicPages/FB-EEGermany.pdf>

⁶⁰ European Judicial Network, Fiches Belges on electronic evidence Germany. Available at. <https://www.ejn-crimjust.europa.eu/ejnupload/DynamicPages/FB-EEGermany.pdf>

Дээр дурдсанчлан ХБНГУ-д цахим нотлох баримтыг ЭХХША-нд үнэнийг тогтоох зорилгоор ашиглах боломжтой боловч ийнхүү ашиглахдаа хуульд заасан аливаа хязгаарлалтын хүрээнд буюу хуулийн шаардлагад нийцүүлэн ашиглах шаардлагатай юм. Ийнхүү нотлох баримтыг ЭХХША-нд үндсэн хуулийн шаардлагад нийцүүлэн ашиглах техник буюу ХБНГУ-ын практик туршлагыг энд танилцуулъя.⁶¹

Цахим нотлох баримтыг ЭХХША-нд Германы шүүхүүд цуглуулах, олж авах, үнэлэхдээ дараах шинжилгээний үндсэн бүтцийг (үе шатыг) ашигладаг. Үүнд:

- Үндсэн эрхийн нөхцөл байдал;
- Нотлох баримт бүрдүүлэх;
- Үнэлэх;
- Шүүх хуралдаанд оруулан танилцуулах.

Үндсэн эрхийн анхдагч нөхцөл (түүний хязгаарлаж болох нөхцөлүүд):

- /Зайнаас харилцахад/ харилцаа холбооны нууц, Германы Үндсэн Хуулийн 10 /GG/ *Зөвхөн дамжуулах явцад хамаарах бөгөөд үндсэн эрхийг хязгаарлаж болно.*

- Хүний нэр төр /хүн байх үнэ цэнэ, хүний эрхэмсэг оршихуй/ Германы Үндсэн Хуулийн 1 /GG/

Хувь хүний мөн чанарын үндсэн цөм хэсгийг хамгаалалтдаа авсан, хязгаарлах боломжгүй.

- Хувийн мэдээллийг хэрхэхээ өөрөө тодорхойлох эрх, Германы Үндсэн Хуулийн 2-р зүйлийн 1 дэх хэсэг +1-р зүйлийн 1 дэх хэсэг

хувийн мэдээллээ хамгаалах; хязгаарлах боломжтой.

- Мэдээллийн технологийн систем дэх халдашгүй байх эрх, Германы Үндсэн Хуулийн 2-р зүйлийн 1 дэх хэсэг .+1-р зүйлийн 1 дэх хэсэг

Компьютер зэрэгт зөвшөөрөлгүй нэвтрэхээс хамгаалах, хязгаарлаж болно.

Хуулиар зохицуулсан мэдээлэл цуглуулах боломжтой тусгай тохиолдлууд (нотлох баримт цуглуулах):

- Утасны яриаг хянах, бичиж авах, Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §100a
- Кодыг тайлан и-мэйлийг нууцаар үзэх ажиллагаа , Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §100a
- Цахим холбоо харилцааны холболтын өгөгдөлд нэвтрэх, Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §100g

⁶¹ Уг ХБНГУ-ын практикийг ХБНГУ-ын Бавари мужийн Цахим хувьслын судалгааны хүрээлэнгийн захирал, тус мужийн Хиймэл оюун ухааны зөвлөлийн гишүүн, Вюрцбург хотын Юлиус-Максимилианс Их Сургуулийн доктор, профессор Эрик Хилгендорфын Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Ханнс-Зайделийн сантай хамтран “Цахим нотлох баримт” уулзалт, хэлэлцүүлгийн үеэр хийсэн танилцуулгаас авсан болно.

Эрик Хилгендорф, “Цахим нотлох баримт танилцуулга” сургалтын орчуулга, 2023.09.15.

- Гар утасны мэдээллийг байршлыг тодорхойлох, Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §100i
- Хяналтын программд нууцаар нэвтрэх, Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §100b

Хуулийн шаардлага:

- Тодорхой заасан хүнд гэмт хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд ашиглах
- Шүүгчийн захирамж гарсан байх.

Уламжлалт хандалтын аргууд:

- Эд юмсыг хураах, нэгжлэг хийх (Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §§ 94, 102): компьютер, гар утас зэрэгт мөн хэрэглэнэ.
- Хууль сахиулах байгууллагын хүсэлтийн дагуу цахим /сүлжээний/ үйлчилгээ эрхлэгч эсвэл үүлэн операторуудаас сэжигтний мэдээллийг авах, Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §103

Хуулийн шаардлага:

- Эдгээр ажиллагаа нь далд бус, ил хэлбэрээр явагддаг учраас хөнгөн шаардлага тавигддаг.

Хувийн нууцыг хамгаалах

- Харилцаа холбооны хэрэгслийг хянах ажиглах болон хадгалагдсан өгөгдлийг нууцаар хайхад хүний хувийн амьдралын хүрээний үндсэн цөм хэсэгт хамаарах мэдээлэл/өгөгдлийг ашиглаж үл болно.
 - Өдрийн тэмдэглэлийн хэсэг
 - Эрүүгийн хуульд хамааралгүй сэдвээр эхнэр, нөхөртэйгөө ярилцах
 - Ажиглалтад буй этгээд нь эмч, хуульч гэх мэт тодорхой мэргэжлийн бүлгийн гишүүдтэй харилцсан яриа
- Өөрөө өөрийгөө буруутгах нөхцөл байдлыг дэлгэхгүй байх эрх ("nemo tenetur se ipsum accusare") нь гар утасны өгөгдлийг нотлох баримтаар үнэлэх үед хамгаалагдаж байна уу? Гар утас нь хэрэглэгчийн өөрийн "хадгалагдсан санах ой" юм.

Нотлох баримтыг үнэлэх:

- Үндсэн асуудал: цуглуулсан мэдээллийн жин хэт их
- Дагах асуудлууд:
 - Хэн үнэлэх вэ?
 - Тусгай албаныхан уу?
 - тэдгээрийн хэлтэс үү? Хууль ёсны зарчмын улмаас үүсэх ачаалал, Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §160.1, 163.
- Хэрхэн үнэлэх вэ?
 - тус бүрнээ шалгалт хийх, дээж авах, автомат хянах ажиллагаа, KI
- Мэдээллийг хэнд нээлттэй байлгах вэ?
 - Шүүх

- Хууль зүйн туслалцаа үзүүлэгч: ямар хэлбэрээр? процесст оролцох “зэвсэг” тэгш байх тухай асуудал
- Мэдээллийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрхэн оруулж ирэх вэ?

Тусгай асуудал I: Өгөгдлийн шинжилгээнд хиймэл оюун ухааныг ашиглах

- Жишээ нь хүүхдийн садар самууныг сурталчлах болон бусад сэтгэлзүйн хувьд дарамттай мэдээллүүд
- Одоогоор Германы ЭХХШтХ-ийн /StPO/-д зохицуулалт байхгүй

Тусгай асуудал II: Батлан хамгаалах эрх

- Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §147.1: Өмгөөлөгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн материалтай танилцах, "албан журмаар хадгалагдаж буй нотлох баримттай танилцах" эрхтэй.
- Хэргийн материалтай танилцах эрхийн хүрээнд Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр -BVerfGE 63, 65-с.
- Хууль зүйн туслалцаа үзүүлэгчийн чадлаас хир давсан ойлголт вэ?
- Өмгөөлөгч хиймэл оюун ухаантай байх, түүнд олгох ёстой юу?
- Хиймэл оюун ухаан үйлдвэрлэгчдийн бизнесийн нууц яах вэ?
- Холбооны Үндсэн хуулийн шүүхийн /BVerfG/-ийн 2020 оны 11-р сарын 12-ны өдрийн шийдвэр, AZ 2 BvR 1616/18, NZV 2021, 41: Яллагдагч нь замын хөдөлгөөнд хурдны хязгаарыг хэтрүүлж байгааг нотлох зорилготой хяналтын камер ашиглах нөхцөлд түүнд камер хэрхэн ажилладаг талаар шаардлагатай бүх мэдээллийг өгөх ёстой.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зүйл болгох (Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зүйл болгох):

- Нотлох баримтын уламжлалт хэлбэрүүд: үзлэг, гэрч, баримт бичиг, шинжээч
- Эдгээр нотлох баримтын хэлбэрүүд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нээлтэй байдал, ил тод байдал, түүнийг хянах боломжийг баталгаажуулах зорилготой
- Цахим нотлох баримтыг уламжлалт нотлох баримтын адилаар шалгах:
 - Хэвлэх
 - Графикт оруулах
 - Шинжээчдийн дүгнэлт •
 - Хиймэл оюун ухаанаар үүсгэсэн өгөгдөлтэй ажиллах? Ийм мэдээллийг шалгах боломжтой юу?

2.3.3. Бүгд Найрамдах Эстони Улсын сайн туршлага

Эстони улсын ЭХХША-нд цахим (дижитал) нотлох баримт улам бүр нэмэгдэж байгаа боловч одоогийн хууль тогтоомжид ийм нотлох баримтыг олж авах, цуглуулах асуудлыг тодорхой журамлаагүй тул уламжлалт нотлох баримтыг цуглуулах, мөрдөн шалгах тухай заалтууд нь цахим нотлох баримтын үндэс зохицуулалт хэвээр байна.⁶² Цахим нотлох баримт гэдгийг цахим хэлбэрээр (компьютерын өгөгдөл) байгаа нотлох ач холбогдолтой мэдээлэл гэж үзнэ.⁶³

Эстони улсын ЭХХШТХ-ийн Нотолгоо гэсэн 3-р бүлэгт ЭХХША-ний нотлох баримтын зохицуулалтыг тусгасан байдаг бөгөөд “Нотлох баримт” гэсэн 63 -р зүйлд *“Нотлох баримт гэж сэжигтэн, яллагдагч, хохирогчийн мэдүүлэг, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, шинжээчийн дүгнэлтийн талаар тайлбар гаргасны дагуу шинжээчийн өгсөн мэдүүлэг, эд мөрийн баримт, мөрдөн байцаалтын ажиллагааны тайлан, шүүх хуралдааны тэмдэглэл, тайлан, тандалтын үйл ажиллагаа, бусад баримт бичиг, гэрэл зураг, кино эсвэл бусад мэдээллийн бичлэг.”*⁶⁴ Гэж тодорхойлсон байна. Ерөнхийдөө, уг 63 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан нотлох баримтын төрлийг (хатуу нотлох баримт гэж нэрлэдэг) нотлох үндэслэлээр ЭХХША-нд ашиглаж болно.

Мөн уг 63 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт ороогүй нотлох баримтыг хэргийн үндсэн үйл баримтыг тогтоох зорилгоор бус ЭХХША-тай холбоотой баримтуудыг нотлох зорилгоор ашиглаж болно. 62 дугаар зүйлд заасан нотлох баримтаар ашиглах үндэслэлд дараах үндэслэлүүд хамаарна.

1. гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа, газар, арга хэлбэр, гэмт хэрэгтэй холбоотой бусад баримт;
2. Гэмт хэргийн зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг (элемент);
3. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруутай эсэх;
4. гэмт хэрэг үйлдсэн этгээд болон тухайн этгээдийн хариуцлагад нөлөөлж буй бусад нөхцөл байдлын талаарх мэдээлэл.

Энэхүү нотлох баримтын систем нь хүлээн зөвшөөрөгдөх янз бүрийн нотлох баримтууд болон нотлох баримтын янз бүрийн эх сурвалжуудын хооронд тодорхой ялгааг харуулж байгааг Эстонийн Дээд шүүх тогтоосон⁶⁵.

Эстонийн хууль тогтоох байгууллага ЭХХША-ны явцад нотлох баримтын зөвшөөрөгдөх хэлбэрийг тодорхойлсон. Дээрх заалт (63(1)) нь Эстонийн ЭХХШТХ-ийн нотлох баримтын төрлийг тодорхойлсон цорын ганц заалт юм. Нотолгооны зүйл болон нотлох баримтаар авах ерөнхий нөхцөлд тусад нь тодорхойлолт эсхүл тусгай журам тогтоогоогүй болно. Үүнтэй холбоотой дараах заалтууд ЭХХШТХ-д байдаг. Үүнд:

⁶² Eneli Lauritis, “Criminal procedure and digital evidence in Estonia”, Digital Evidence and Electronic Signature Law Review, 13 (2016), P.113

⁶³European Judicial Network, Fiches Belges on electronic evidence Estonia. Available at <https://www.ejn-crimjust.europa.eu/ejnupload/DynamicPages/EE%20electronic%20evidence%20fb.pdf>

⁶⁴ БНЭсУ-ийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Kriminaalmenetluse seadustik, 2003)

⁶⁵ Eneli Lauritis, “Criminal procedure and digital evidence in Estonia”, Digital Evidence and Electronic Signature Law Review, 13 (2016), P.113

64-р зүйл. ЭХХША-нд нотлох баримтаар тогтоох (хэрэгт авах) ерөнхий нөхцөл⁶⁶

- (1) Нотлох баримтыг авахад оролцсон хүмүүсийн нэр төр, алдар хүндэд харшлахгүй, амь нас, эрүүл мэндэд нь аюул учруулахгүй, үндэслэлгүй эд хөрөнгийн хохирол учруулахгүй байхаар нотлох баримтыг авна. Хүнийг эрүүдэн шүүх, түүний эсрэг бусад хэлбэрээр хүчирхийлэх, ой санамжид нь нөлөөлөх, хүний нэр төрийг гутаан доромжлох зэргээр нотлох баримтыг авч болохгүй.
- (2) Эрэн сурвалжлах, биет үзлэг хийх, харьцуулсан дээж авах явцад хүний хувцсыг тайлах шаардлагатай бол эрүүл мэндийн мэргэжилтэн, шүүх эмнэлгийн эмчээс бусад мөрдөн байцаах байгууллагын албан тушаалтан, прокурор, процесс ажиллагаанд оролцогчид тухайн хүнтэй ижил хүйсийн хүн байна.
- (3) Нотлох баримт авах явцад техникийн хэрэгсэл ашигласан бол энэ тухай ЭХХША-нд оролцогчдод урьдчилан мэдэгдэж, техникийн хэрэгслийг ашиглах зорилгыг тайлбарлана.
- (4) [Хүчингүй болсон - 2011.02.23-ны өдрийн 1 дүгээр тогтоол, 2011.09.01-ний өдөр хүчин төгөлдөр болсон.]
- (5) Шаардлагатай бол энэ хуулийн § 214-д заасны дагуу шүүхийн өмнөх ажиллагаатай холбоотой мэдээллийг задруулахыг хориглохыг процессын ажиллагаанд оролцогчдод анхааруулна.
- (6) Нууцаар ажиглах ажиглалтын үйл ажиллагаагаар нотлох баримт авах асуудлыг энэ хуулийн 31 дүгээр бүлгээр зохицуулна.

Эндээс үзэхэд Эстонийн ЭХХШТХ-д заасан нотлох баримтын төрлийг ерөнхийд нь тодорхойлсон тул энэхүү заалтыг үндэслэн цахим хэлбэрийн нотлох баримтыг ЭХХША-нд ашиглах боломжтой гэсэн үг юм.⁶⁷ Үүний зэрэгцээ, Эстонийн хууль эрх зүйн орчинд цахим (дижитал) нотлох баримтын талаар тусгай журам, тодорхой заалтууд зайлшгүй шаардлагатай байгаа тухай хэлэлцүүлэг хэсэг хугацаанд явагдсан байна. Жишээлбэл, Эстонийн Хууль зүйн асуудал хариуцсан канцлер цахим харилцааны өргөн хэрэглээ, цахим мэдээллийн хэрэгсэлд агуулагдаж буй мэдээллийг задруулснаас үүдэлтэй үндсэн эрхийн зөрчлийн цар хүрээг харгалзан үзэж, уг зөрчигдөж буй үндсэн эрх, эрх чөлөөг илүү сайн хамгаалах чадвартай илүү нарийн зохицуулалт (шаардлагатай процедурын хамгаалалтыг дагалдсан) хийхийг санал болгож байв.⁶⁸ Эстонийн Хуульчдын холбооны зүгээс мөн нэгжлэг хийх явцад хураан авсан цахим мэдээлэл нь олон эрүүгийн хэрэгт нотлох баримт болж, ийм нотлох баримтын ач холбогдол улам бүр нэмэгдсээр байгааг олж тогтоосон бөгөөд Хуульчдын холбооноос цахим (дижитал) нотлох баримтыг олж авах, түүнийг ЭХХША-нд ашиглах асуудлыг уламжлалт нотлох баримтаас тусад нь зохицуулах нь зүйтэй гэж үзсэн байна. Учир нь уламжлалт нотлох баримттай холбоотой заалтуудыг цахим (дижитал) нотлох баримт дээр ашиглах нь ЭХХША-н дахь хүний эрх, түүнчлэн ийм нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх, найдвартай байдал, баталгаажуулалт зэрэгтэй бүрэн нийцэхгүй юм⁶⁹ гэж үзсэн байна.

⁶⁶ БНЭсУ-ийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Kriminaalmenetluse seadustik, 2003)

⁶⁷ Эстонийн Дээд шүүх гар утасны зурвас болон цахим шуудангийн захидал харилцааны аль алиныг нь нотлох баримт болгон хүлээн зөвшөөрдөг боловч хувийн ярианы бичлэгийг ЭХХШТХ-ийн 63 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдээллийн бичлэг гэж үнэлдэг.

⁶⁸ Eneli Lauritis, "Criminal procedure and digital evidence in Estonia", Digital Evidence and Electronic Signature Law Review, 13 (2016)

⁶⁹ Мөн тэнд.

Эстонид Цахим (дигитал) нотлох баримтыг ЭХХШтХ дээр үндэслэн мөрдөн шалгах ажиллагааны процесс эсвэл нууцаар явуулсан сэжигтнийг ажиглах процесс ажиллагааны тусламжтайгаар олж авдаг ч цахим нотлох баримтыг уламжлалт нотлох баримтыг олж, цуглуулах процедурын дарааллын дагуу олж авч, цуглуулж, хэрэгт авдаг⁷⁰ хэвээр байна.

БНЭсУ-ын нэгдэн орсон цахим нотлох баримт, түүнийг цуглуулах, олж авах асуудалд хамаарах олон улсын хууль тогтоомж, гэрээ, конвенц.

- “Цахим (Кибер) гэмт хэргийн тухай” 2001 оны Будапештын конвенц;
- Эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны Европын журам (EU 2014);
- Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих ял эдлүүлэх ажиллагааны цахим нотлох баримтыг бий болгох, хадгалах журам (EU) 2023/1543;

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт цуглуулах үүрэг бүхий байгууллагыг үүсгэн байгуулах, түүний хууль ёсны төлөөлөгчдийг томилох зохицуулалтыг ижилтгэх удирдамж (EU) 2023/1544 .

2.3.4. Америкийн Нэгдсэн Улсын сайн туршлага

Цахим нотлох баримт нь бусад нотлох баримтуудтай үзэл баримтлалын хувьд ижил байдаг—энэ нь гэмт хэргийн учир шалтгааны холбоог тогтоохын тулд хүмүүс, үйл явдлыг цаг хугацаа, орон зайд байрлуулахыг оролдсон мэдээлэл юм. Гэсэн хэдий ч цахим нотлох баримт нь биет нотлох баримттай харьцуулахад илүү өргөн цар хүрээтэй, илүү хувийн хүрээнд эмзэг, уян хатан, хөдөлгөөнт шинж чанартай, өөр бэлтгэл, багаж хэрэгсэл шаарддаг.

Цахим нотлох баримт нь "цахим төхөөрөмж дээр хадгалагдаж, хүлээн авсан эсвэл дамжуулсан мөрдөн байцаалтын явцад үнэ цэнтэй мэдээлэл, өгөгдөл юм" (National Institute of Justice [NIJ], 2008) . Ийм нотлох баримтууд үндсэн компьютер, телефон утасны систем гэх мэт хязгаарлагдмал хэлбэрээр олон арван жилийн турш оршин тогтнож байсан ч хувийн электрон төхөөрөмжүүд хурдацтай тархах тусам цахим нотлох баримтыг боловсруулахын ач холбогдол нэмэгдсээр байна. 21-р зууныг зөөврийн хөгжим тоглуулагч, гар утас, компьютерын төхөөрөмжүүдийн дэвшил тодорхойлсон. АНУ-ын Дээд шүүх саяхан гар утас нь ганц харилцаа холбооны хэрэгсэл биш, харин утас, календарь, өдрийн тэмдэглэл, цахим шуудангийн системийн үүрэг гүйцэтгэдэг микрокомпьютер юм гэж тайлбарласан; цахим нотлох баримт нь уламжлалт биет бүртгэл, нотлох баримтаас хэрхэн ялгаатай болохыг ойлгоход орчин үеийн технологи гурван шинж чанарыг бий болгодог: (1) Цахим нотлох баримт нь илүү өргөн хүрээг хамардаг, (2) биет болон хувийн нууц мэдээллийг хоёуланд нь авч үздэг, (3) хууль сахиулах байгууллагын нотлох баримт цуглуулах ердийн чиг үүргээс гадна эрүүгийн эрх зүйн харилцан уялдаатай асуудлуудыг хамардаг.

⁷⁰ Мөн тэнд.

Цахим нотлох баримтын төрлүүд

Интернет

Хууль сахиулах байгууллагын мөрдөн байцаалтад ашигладаг зарим дижитал нотлох баримтууд нь харилцаа холбооны вэбсайтууд, ялангуяа мессежний самбар, чат өрөөнүүдээс гаралтай. Эдгээр төрлийн сайтууд нь одоогийн мөрдөн байцаалтын мэдээллийн эх сурвалж байсаар байгаа ч бусад интернэт болон интернетэд холбогдсон технологиуд тархаж байгаа нь нотлох баримтын олон эх сурвалжийн тоонд багтаж байна гэсэн үг. Мессежний самбар болон чат өрөөнүүд нь хэрэглэгчдэд архив эсвэл тухайн цаг үеийн харилцаа холбоог уншиж, хариулах боломжийг олгодог. Эдгээр эх сурвалжийг ашиглахад хэд хэдэн бэрхшээл тулгардаг. Ийм сайтуудын байршил, хаяг нь олон нийтэд үргэлж мэдэгддэггүй, учир нь сайтуудыг олохын тулд анхан шатны мэдээлэл цуглуулах ажил эсвэл онлайн хайлт хийх шаардлагатай байдаг. Уншигчид чат харилцааг ойлгох, оролцогчдыг танихаас сэргийлэхийн тулд хэрэглэгчид нэрээ нууцлах, кодлогдсон эсвэл шифрлэгдсэн харилцаа холбоог ашигладаг. Интернэтийн дэлхий даяарх мөн чанар нь үүнийг улам хүндрүүлдэг, учир нь амжилттай танигдсан ч тухайн хүн нь мөрдөн байцаагчийн эрх мэдлээс гадуур байж болох юм. Мөрдөн байцаалтын явцад ашигладаг өөр нэг гол эх сурвалж бол файл хуваалцах сүлжээ юм. Эдгээр сүлжээнүүд нь зураг, видео зэрэг өгөгдлийн файлуудыг дамжуулахын тулд хэрэглэгчдийг холбодог. Хууль сахиулах байгууллагын мөрдөн шалгах ажиллагаа, хуулийн арга хэмжээ, ялангуяа зохиогчийн эрхийн зөрчил болон бусад хууль бус материал солилцохтой холбогдуулан олон тооны файл хуваалцах сүлжээг хаасан эсвэл шинэчилсэн байдаг. Хэрэглэгчдийг хянах боломжтой бөгөөд татаж авсан файлуудыг ихэвчлэн тодорхой IP хаягтай нь холбож болдог. Жишээлбэл, хөгжмийн зохиогчийн эрхийн хэрэг нь зохиогчийн эрхийг хуулиар зөрчсөн, ямар хэрэглэгчид оролцсон гэхээсээ илүү тодорхой хөгжмийн файлтай холбоотой байж болно. Гэсэн хэдий ч шилжүүлгийн агуулга нь хүүхдийн садар самууныг мөрдөн шалгах гэх мэт хэрэгт хамааралтай байж болно.

Компьютер

Хувийн компьютер дээр олон тооны цахим нотлох баримтууд байдаг. Эдгээр зүйлсийн ихэнхийг гар аргаар эсвэл logical аргаар гаргаж авч болно. Зарим нотлох баримтууд нь интернетээс олж авсан мэдээлэлтэй давхцаж байгаа ч Интернетээс бус биет төхөөрөмжөөс олж болох хэд хэдэн нэртэй эх сурвалжууд байдаг.

Интернэтээр аялж байхад программууд нь ихэвчлэн түр зуурын интернет файл, (cookie) күүки болон хайлтын түүхийг хадгалдаг. Эдгээрийг хэрэглэгчийн веб түүхийг тодорхойлохын тулд мөрдөн байцаалтын явцад ашиглаж болно. Түр зуурын файлууд болон күүкиг ихэвчлэн вэбсайтууд өөрсдөө хэрэглэгчдийг хянах, мэдээлэл хадгалахад ашигладаг байна.

Имэйл болон бусад мессежийг биет компьютер дээрээс олж болно. Хэдийгээр Google болон Microsoft-ын эсрэг сүүлийн үеийн хэргүүдээс харахад ихэнх цахим шуудан нь интернэт серверүүд дээр хадгалагддаг боловч зарим харилцаа холбооны программ хангамж нь өмнөх мессежнүүдийг компьютерын хатуу диск рүү архивладаг.

Зөөврийн электрон хэрэгсэл

Одоогийн байдлаар гар утас гэх мэт зөөврийн электроник хэрэгслээс цахим нотлох баримт гаргаж авах нь эксперт, судлаачдын анхаарлын төвд байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд ийм төхөөрөмжүүдийн хэрэглээ ба нөлөө нь эрс нэмэгдэж, электрон болон биет

эх сурвалжийн өмнөх хослолоос илүү хувийн мэдээллийг агуулсан жижиг электрон төхөөрөмжүүдийг нийлүүлэхэд хүргэсэн.

Цахим нотлох баримтын салбарт гар утас зонхилох сонирхлыг татаж байгаа нь гайхах зүйл биш юм. Эдгээр төхөөрөмжүүд нь орчин үеийн нийгэмд бараг хаа сайгүй байгаа бөгөөд 21-р зуунд үзүүлэлтийн хувьд хувьсгал хийж, хууль эрх зүйн шинэ сорилтуудыг дагуулж байгаа тул АНУ-ын Дээд шүүх саяхан хэргийн газарт ихэнх гар утсыг нэгжиж шалгахад зөвшөөрөл шаардлагатай гэж шийдвэрлэсэн. Салбарын судалгаанаас үзэхэд АНУ-ын утасгүй сүлжээний захиалгын тоо одоогийн байдлаар нийт хүн амаас давж байна (336 сая хүн амтай, 313 сая хүн); Энэ захиалгын тооцоо нь арван жилийн өмнө байсан 159 сая байснаас хоёр дахин их байна (Утасгүй сүлжээний салбарын жилийн судалгаа, 2014). Ерөнхий шүүгч Жон Робертс Райлигийн шийдвэрт гар утас нь хүмүүсийн олон тооны чухал хэрэгцээг хангадаг "микрокомпьютер" юм гэж дурдсан. Нэг шалтгаан нь хэргийн газарт гар утсыг нэгжиж шалгахад хууль сахиулах байгууллага нь зөвшөөрөлтэй байх ёстой гэж шүүх шийдвэрлэсэн -цаас эсвэл бусад зөөврийн зүйлээс ялгаатай нь гар утасны мэдээлэл нь дэвтэр, өдрийн тэмдэглэл, хувийн компьютер гэх мэт зөөврийн бус том эд зүйлстэй адилхан байж болно. Гар утаснууд нь зураг авах, байршил тогтоох систем (GPS), имэйл болон бусад баримт бичгүүдээс ялгаатай текст мессеж илгээх зэрэг онцлогтой. Мөн гар утас нь ихэвчлэн утасны жагсаалт, дуудлага хийсэн болон хүлээн авсан бүртгэл, дуудлагын үргэлжлэх хугацаа зэргийг багтаасан байдаг.

Цахим нотлох баримттай холбоотой хууль эрх зүйн асуудлууд

Технологийн байнгын өөрчлөлтийн үед хуулийн байгууллагууд цахим нотлох баримттай холбоотой асуудлуудыг шийдвэрлэхийн тулд цаг үетэй нийцсэн бодлогын төслийг боловсруулах ёстой. Бодлого тогтоохын тулд хууль сахиулах байгууллага нь шүүх, прокурор зэрэг талуудтай хамтран хэрэг бүртгэл мөн хүлээн зөвшөөрөгдөх эсэх нь хууль ёсны шаардлага хангаж байгаа эсэхийг тодорхойлох ёстой. Нотлох баримт нь хэргийн дараа зохисгүй олж авсан гэж үзвэл эрүүгийн эрх зүйн тогтолцоонд төдийлөн ач холбогдолгүй. Хууль сахиулах байгууллага мөн хамтарч буй байгууллагууд нь цахим нотлох баримтад нийцсэн хүлээлт тавих хэрэгтэй ба цахим бус нотлох баримтын процесс бодлого нь ялгаатай байдаг.

Үзлэг нэгжлэг хийх

АНУ-ын Дөрөв дэх нэмэлт өөрчлөлт нь төрийн эрх баригчдын үндэслэлгүй нэгжлэг, хураан авахаас хамгаалдаг. Шүүх нь цахим төхөөрөмж, цахим мэдээллийн өвөрмөц шинж чанарыг судалж Дөрөвдүгээр нэмэлт өөрчлөлт нь цахим мэдээлэлд хэрхэн үйлчлэх талаар тайлбарлахаар зорьж байна. Дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлт үйлчилж байгаа тохиолдолд хууль сахиулах албан хаагч нь нэгжлэг хийхийн тулд зохих шүүхээс нэгжлэг хийх зөвшөөрөл авах ёстой боловч зарим үл хамаарах зүйлс байдаг. Зөвшөөрөлгүй нэгжлэгийг зохих этгээдийн зөвшөөрлөөр хийж болох ч хойшлуулшгүй нөхцөл байдал эсвэл нотлох баримт устах аюултай үед нь цахим хадгалах төхөөрөмжийг хязгаартайгаар үзлэг нэгжлэг хийх шалтгаан болдог. Хууль сахиулах ажилтнуудыг хамгаалах, нотлох баримт устахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай үед баривчлах ажиллагааны хүрээнд хязгаартай нэгжлэг хийж болно.

Хянан шалгагчид ил тод харагдах нотлох баримтууд нь үзлэг нэгжлэг хийхэд зөвшөөрөл авах шаардлагаас үл хамаарч болдог (Horton v California, 1990). Гэсэн хэдий ч цахим хэлбэрээр хадгалагдсан мэдээллийн хувьд энэ зарчмыг хэрэгжүүлэх нь илүү

төвөгтэй болдог. Мерфи, Эсворти нар (2012) цахим нотлох баримт цуглуулах үйл явцыг хоёр үе шаттай үйл явц гэж үзэхийг зөвлөдөг. Эхний шат бол зөвшөөрөлд хамаарч төхөөрөмж эсвэл төхөөрөмжид байгаа мэдээллийг хураан авах явдал юм. Мерфи, Эсворти нарын хэлснээр, эхний хураан авалт нь хэт өргөн хүрээтэй бөгөөд нэгжлэг хийх зөвшөөрөлд хамраагүй олон мэдээллийг агуулж болохыг шүүх зөвшөөрсөн. Тиймээс хууль сахиулахын албан хаагчид нэгжих зөвшөөрлийн хүрээнд хураан авсан мэдээллийг шалгаж ялгаж авах хоёр дахь үе шат байх ёстой. Үүний тулд хураан авсан төхөөрөмжүүд дээрх файлуудыг шалгах шаардлагатай: Ийм шалгалтын явцад нэгжлэг хийх зөвшөөрлөөс гадуур гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагааны нэмэлт нотлох баримтууд илэрч болно.

АНУ-д Конгресс Дөрөвдүгээр нэмэлт өөрчлөлтийн шаардлага болон эрүүгийн мөрдөн байцаалтын хэрэгцээг тэнцвэржүүлэхийн тулд олон хууль баталсан. АНУ-ын хуулийн дөрвөн хэсэг нь цахим нотлох баримтад онцгой хамаатай: Wiretap Act (18 U.S.C. §2510 et seq.); the Pen Registers and Trap and Trace Device Statute (18 U.S.C. §3121 et seq.); Цахим харилцааны нууцлалын тухай хууль (ECPA) (18 U.S.C. §2701 гэх мэт); болон Нууцлалыг хамгаалах тухай хууль (PPA) (42 U.S.C. §2000aa ба бусад).

The Wiretap Act нь утсаар, амаар эсвэл цахим харилцаанд оролцогч талуудыг харилцаа холбоог гаднын этгээд чагнахаас хамгаалдаг. Уг үйлдэл нь аман харилцаа холбоо, утасны дуут болон текст мессеж, эсвэл шууд мессеж, цахим шуудан гэх мэт компьютероор үүсгэсэн мессежийг чагнах зориулалттай төхөөрөмжид хамаарна. Үндэслэлтэй бол шүүхээс хууль сахиулах байгууллагад хөндлөнгөөс оролцохыг зөвшөөрсөн захирамж гаргаж болдог. Шүүхийн захирамжгүйгээр харилцаа холбоог чагнах засгийн газрын оролдлого нь иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээлгэж, нотлох баримтыг таслан зогсооход хүргэдэг.

The Pen Registers and Trap and Trace Device Statute нь утас, интернэт холболттой холбоотой мета өгөгдөл цуглуулахыг хязгаарладаг. Харилцааны агуулгыг зохицуулдаг The Wiretap Act-с ялгаатай нь The Pen Registers and Trap and Trace Device Statute нь имэйл хаяг, залгасан утасны дугаар эсвэл хүлээн авсан дуудлагын утасны дугаар зэрэг мэдээллийг хамардаг. Хэрэв хуульд үл хамаарах зүйл байхгүй бол хууль сахиулах ажилтнууд харилцааны холбооны мета өгөгдлийг хайхаасаа өмнө шүүхийн захирамж авах ёстой.

Цахим харилцааны нууцлалын тухай хууль (ECPA) нь сүлжээ нийлүүлэгчийн хадгалсан бүртгэл, файлуудтай холбоотой заалтыг агуулдаг. Энэ нь интернэт сүлжээ нийлүүлэгчийн (ISP) хадгалсан имэйл болон бусад захиалагчийн мэдээллийг хууль ёсны зөвшөөрөлгүйгээр задруулахаас хамгаалдаг. Хадгалсан мэдээлэлд хандахын тулд хууль сахиулах байгууллагаас шаардагдах зөвшөөрлийн төрөл нь хайж буй мэдээллийн нууцлалаас хамааран шүүхэд дуудах хуудаснаас авхуулаад үзлэг нэгжлэг хийх зөвшөөрөл хүртэл байдаг. Уг хууль нь сэжигтний хувийн компьютерт хадгалагдсан харилцаа холбоотой мэдээлэлд хамаарахгүй. Боловсронгүй болж хууль нь хэт өргөн хүрээний иргэний зарлан дуудах хуудас нь интернэт сүлжээ нийлүүлэгч ISP-ийг хэрэглэгчийн хувийн мэдээллийг өгөхийг албадахад хангалтгүй байж магадгүй гэж үзэж байна (Мэрфи ба Эсворти, 2012). Гэсэн хэдий ч Цахим харилцааны нууцлалын тухай хууль нь гуравдагч этгээдийн сервер дээр 180 хоногоос дээш хугацаагаар хадгалагдсан материалыг орхигдуулсан гэж үздэг тул хууль сахиулах байгууллагын ажилтнууд зөвхөн мөрдөн байцаалтад хамааралтай болохыг нотолсон бичгээр мэдэгдэл өгөхөд л хангалттай. Өнөөдөр хэрэглэгчид гуравдагч этгээдийн сервер дээр имэйлээ тодорхойгүй хугацаагаар хадгалах магадлалтай бөгөөд энэ нь хууль сахиулах байгууллагад асар их давуу тал болж өгдөг, учир нь өөр тохиолдолд хэрэглэгчийн

хувийн төхөөрөмжөөс ижил мэдээлэл авахад зөвшөөрөл авах шаардлагатай ба 180 хоногийн дүрмийг хасах талаар нэлээд маргаантай байдаг байна.

PPA нь зохиогчийн бүтээсэн бүтээгдэхүүн (онлайн мэдээллийн товхимол, блог гэх мэт), мөн тухайн бүтээгдэхүүнийг бүтээхэд ашигласан материалыг хамгаалдаг. PPA-д хамаарах материалууд нь нэгжлэг хийх зөвшөөрөлд хамаарахгүй. Гэсэн хэдий ч, материал нь гэмт хэрэг үйлдэхтэй холбоотой эсвэл хураан авах нь амь нас аврах, бие махбодод ноцтой гэмтэл учруулахаас сэргийлэх тохиолдолд үл хамаарах юм.

Баримтжуулах

Цахим нотлох баримтыг баримтжуулах нь гэрчлэх, баримт бичгийн бүртгэлийн хоёр асуудлыг багтаадаг. Баталгаажуулалт нь нотлох баримт нь түүнийг санал болгогчийн үзэж байгаа зүйл мөн болохыг тогтоох үйл явц юм. Нотлох баримт гаргаж буй тал нь тухайн зүйл жинхэнэ гэдгийг нотлох шаардлагатай. Цахим нотлох баримтыг баталгаажуулах гол асуудал бол цахим баримтын зохиогчийн хэн болохыг тогтоох явдал юм. Жишээлбэл, хариуцагчаас хохирогчид бичсэн цахим шуудан нь хариуцагч өөрөө бичсэн гэдгийг нотлох баримтыг прокурор нотлох шаардлагатай. Олон мужийн шүүхээс баталсан Холбооны нотлох баримтын дүрэмд компьютер, гар утас хураан авсан хууль сахиулах албан хаагч гэх мэт мэдлэгтэй гэрчийн мэдүүлгээр нотлох баримтыг тогтоохыг зөвшөөрдөг бөгөөд файлуудыг хаанаас авсан болохыг гэрчлэх боломжтой юм. И-мэйл нь хариуцагчийн мэддэг байсан мэдээлэл эсвэл мессежийг илгээсэн төхөөрөмжид анх хандсан хүн нь хариуцагч байсан тухай гэрчлэх гэх мэт янз бүрийн арга хэрэгслээр дамжуулан баталгаажуулж болно. Баталгаажуулах үйл явцын нэг хэсэг болгон баримт бичгийн бүртгэл нь цахим нотлох баримтыг анхны хэлбэрээр нь хадгалж баталгаажуулдаг. Энэ нь нотлох баримтыг хэзээ цуглуулсан, хаанаас цуглуулсан (төхөөрөмжийн төрөл, таних тэмдэг, өмчлөгч гэх мэт), төхөөрөмжийг хэн эзэмшиж байсан, хэн түүнд хандах эрхтэй болохыг баримтжуулах боломжтой болно. Энэ нь нотлох баримтыг хэрхэн цуглуулсан (жишээ нь ямар арга хэрэгсэл, процедур ашигласан) зэргийг багтаана. Эцэст нь, баримт бичгийн бүртгэл нь нотлох баримт хэрхэн хадгалагдсан, хэн нотлох баримттай харьцсан, хэн нэвтэрч байсан талаар баримтжуулсан байдаг⁷¹.

Дээрхээс дүгнэвэл АНУ-д цахим нотлох баримтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах нь түгээмэл болох нь харагдаж байна. Мөн “цахим нотлох баримт” гэдгийг тодорхойлж өгснөөс гадна үзлэг нэгжлэг хийх, баримтжуулах үйл ажиллагааг Wiretap Act (18 U.S.C. §2510 et seq.); the Pen Registers and Trap and Trace Device Statute (18 U.S.C. §3121 et seq.); Цахим харилцааны нууцлалын тухай хууль (ECPA) (18 U.S.C. §2701 гэх мэт); болон Нууцлалыг хамгаалах тухай хууль (PPA) (42 U.S.C. §2000aa ба бусад) гэх хуулиудаар нарийвчлан зохицуулсан нь боловсронгуй зохицуулалт болжээ. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим нотлох баримтыг тусгахдаа дээрх боловсронгуй зохицуулалтыг жишиг болгон авч үзэх нь зүйтэй.

⁷¹ Digital Evidence and the U.S. Criminal Justice System: Identifying Technology and Other Needs to More Effectively Acquire and Utilize Digital Evidence. Sean E. Goodison, Robert C. Davis, and Brian A. Jackson. <https://www.ojp.gov/pdffiles1/nij/grants/248770.pdf>

2.3.5. Бүгд Найрамдах Солонгос Улсын сайн туршлага

Одоогийн байдлаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим нотлох баримт болон түүнийг хураан авах, нэгжлэг хийх талаар ямар ч зохицуулалтыг тусгаагүй байна⁷².

Мөн цахим мэдээлэл гэдэг нь компьютер гэх мэт мэдээлэл боловсруулах системээр боловсруулагдсан мэдээллийг хэлдэг бөгөөд үүнийг цахим нотлох баримт гэж нэрлэдэг. Цахим мэдээлэл нь компьютерийн диск гэх мэт мэдээллийн хадгалах хэрэгсэлд хадгалагддаг. Цахим мэдээлэл нь биет бус боловч мэдээлэл хадгалах хэрэгсэл нь биет юм. Компьютер нь аж ахуйн нэгжийн болон хувь хүмүүсийн үйл ажиллагааны чухал хэрэгсэл болсон тул цахим мэдээллийг хадгалах, хайх хэрэгцээ улам бүр өргөжиж байна.

Цахим нотлох баримт гэдэг нэр томъёо нь гэмт хэрэг үйлдсэнийг нотлох эсвэл гэмт хэрэг болон түүний хохирогч, гэмт хэрэг болон түүнийг үйлдэгч хоёрын хооронд холбоо тогтоох боломжтой аливаа цахим өгөгдлийг агуулсан ойлголт юм. Цахим нотлох баримт нь үндсэндээ баримт бичиг, зураг, аудио, видео зэрэг мэдээллийн хэлбэрүүд ба нэмж дурдахад энэ нь хэл, тоонуудын өвөрмөц хослол хэлбэрээр компьютер дээр хуулбарлагддаг. Заримдаа цахим нотлох баримт нь соронзон орон, электрон импульсээс бүрдэх тул биет бус, бодитой бус нотлох баримт болох тохиолдол байдаг. Үүнийг тусгай багаж, тусгай техник ашиглан цуглуулж, шинжилж болдог. Үүнийг илрүүлэх, цуглуулах, ашиглах байдлын хувьд мэргэжлийн мэдлэг, тусгай багаж хэрэгсэл шаарддагийг эс тооцвол эд мөрийн баримтаас нэг их ялгагдахгүй. Харин эд мөрийн баримт нь гэмт хэрэгтэн устгасан тохиолдолд нөхөн сэргээх боломжгүй тохиолдол байдаг бол цахим нотлох баримтын хувьд нотлох баримтыг устгасан ч нотлох баримтын зарим хэсэг буюу хуулбар нь үлддэг.

Өнөөдрийн байдлаар олон янз илэрч буй кибер гэмт хэрэг нь түүнд тохирсон цахим нотлох баримтын янз бүрийн хэлбэрийг бий болгож байна. Жишээлбэл, кибер мөшгигчид хохирогчдоо бэлгийн дарамт үзүүлэхийн тулд цахим шуудан ашигладаг, компьютерийн хакерууд нэвтэрсэн ул мөрийг бүртгэлийн файлд үлдээдэг, хүүхдийн садар самууныг сонирхогчид компьютер дээрээ хүүхдийн садар самууныг харуулсан дижитал видео файлуудыг хадгалдаг. Тэдгээр нь амархан танигдахгүй янз бүрийн хэлбэрээр байдаг. Цахим нотлох баримтыг хэд хэдэн шалгуурт үндэслэн дараах байдлаар ангилдаг. Нэгдүгээрт, хүний оролцоотой боловсруулалтын процесс байсан эсэхээс хамаараад компьютероор хувиргасан нотлох баримт, компьютерийн тусламжтай бий болсон нотлох баримт гэж бий. Эхнийх нь компьютер ажиллаж эхлэх үед өгөгдөл оруулах гэх мэт хүний оролцоогүйгээр тодорхой программыг хэвийн ажиллуулж, бие даан гүйцэтгэсэн ажлыг бүртгэдэг компьютерээр үүсгэгдсэн нотлох баримт гэж хэлж болно. Тухайлбал, онгоцонд суурилуулсан хар хайрцганд нислэгийн бүртгэл автоматаар бүртгэгддэг бол хүний гараар өгөгдөл оруулах, командыг гүйцэтгэх явцад компьютерийн боловсруулалт хийх замаар өгөгдөл бүрдүүлдэг тохиолдол байдаг. Тодруулбал компьютерээр залилангийн гэмт хэрэг хийх үеийн нотолгоо үүнд хамаарна. Үүнийг компьютерт хадгалагдсан нотлох баримт, компьютерийн симуляци гэж хуваагддаг. Компьютерт хадгалагдсан нотлох баримт гэдэг нь хүний гараар дамжуулан компьютерт хадгалагдаж, төрийн байгууллага эсвэл компаниудад ашиглагдаж буй өгөгдлийг хэлнэ. Жишээлбэл нягтлан бодох бүртгэлийн төрөл бүрийн

⁷² 형사절차상 digital evidence에 관한 연구 - 압수, 수색을 중심으로 - Digital Evidence in Criminal Procedure, pp.21, https://www.kicj.re.kr/boardDownload.es?bid=0001&list_no=9714&seq=1

программууд эсвэл статистикийн программууд гэх мэт. Компьютерийн симуляци гэдэг нь зам тээврийн осол, онгоцны ослын үед хоёр талын зам, хурд зэрэг виртуал өгөгдлийг оруулах замаар компьютерийн программын үр дүнд бий болсон өгөгдлийг хэлнэ. Энэ нь голчлон тодорхой нөхцлөөр боловсруулагдах үр дүнг шүүх хуралдаанд нотлох баримт болгон ашиглах нотлох баримт болгон гаргаж ирсэн тохиолдлуудад хамаарна. Гэсэн хэдий ч компьютерийн симуляцийн хувьд загварчлалд ашигласан шинжлэх ухааны зарчмуудын үнэн зөв, зохистой байдлыг хүлээн зөвшөөрсөн ч загварчлал нь өөрөө өөр алдаа гаргавал эсэргүүцэлтэй тулгарах болно. Үүнийг хязгаарлах ёстой. Учир нь шинжээч шүүх хуралдаанд дүгнэлтээ хэлж, ийм симуляцийг өөрийн дүгнэлтийг батлах үндэслэл болгон ашиглахад нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй. Нэгдүгээрт, компьютерээр үүсгэсэн нотлох баримтууд нь хүний амнаас гарсан нотлох баримт биш тул хүний амаар ярьсан нотлох баримт болохгүй, мөн бичлэг өөрөө найдвартай өндөр зэрэгтэй тул тухайн хэрэгт хамааралтай, үнэн зөв эсэх асуудлыг хөнддөггүй. Асуудлыг даван туулсан тохиолдолд үүнийг нотлох баримт болгон ашиглаж болно гэж хэлж болох ч компьютерийн тусламжтай нотлох баримтыг мэдээлэл оруулагч эсвэл өгөгдөл нийлүүлэгчийн мэдэгдэл гэж хүлээн зөвшөөрч, дуу ярианы нотлох баримт гэж ангилдаг.

Цахим нотлох баримтын байгаа хэлбэрээс хамааран төрлийг дараах байдлаар ангилж болно. Өөрөөр хэлбэл, соронзон хальс, соронзон дискэнд хадгалагдсан цахим бичлэг, цахим бичлэгийг тодорхой цахим мэдээлэл боловсруулах төхөөрөмж, түүний тусламжтайгаар гаргаж, үүсгэсэн тохиолдол гэж хувааж болно. Энэ нь бичгийн нотлох баримт ба нотлох баримтыг ялгах тухай онолоос санаа авсан дүгнэлт бөгөөд нотлох баримтыг судлах арга гэж хэлж болно. Энэ ангиллын арга нь эцсийн дүндээ цахим нотлох баримтыг баримтжуулж чадах эсэхээс хамаарна гэж хэлж болно. Эхнийх нь баримтжуулах боломжгүй төдийгүй харагдахуйц, уншигдахуйц хэлбэрээр үзүүлэхэд хэцүү бөгөөд тодорхой биет хэлбэрт хувиргах боломжгүй өгөгдөл юм. Сүүлийнх нь тодорхой агуулгатай, харагдахуйц, унших боломжтой баримт бичиг, зураг хэлбэрээр гаргаж болох, баримтжуулж болох, тиймээс шалгах шаардлагатай нотлох баримт бичигтэй дүйцэх мэдээллийн төрөл юм.

Эцэст нь цахим нотлох баримтыг хадгалсан эсэхээс нь хамааруулан төрөл болгон ангилж болно. Нарийн утгаараа цахим нотлох баримтыг хувийн компьютерээс сүлжээний сервер эсвэл интернетийн виртуал санах ойд хадгалах, мэдээлэл, харилцаа холбооны сүлжээгээр дамжуулж болно. Эхний тохиолдолд дижитал нотлох баримт хаана хадгалагдаж байгааг олж тогтоовол гэмт хэргийн нотлох баримт болгон нэгжлэг хийж хурааж авдаг бол сүүлийн тохиолдолд мэдээлэл, харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн талаар мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг⁷³.

Цахим мэдээлэл хадгалах хэрэгсэлд хадгалагдаж буй цахим мэдээлэл нь асар том хэмжээтэй бөгөөд эрүүгийн хариуцлагатай холбоотой цахим мэдээллээс гадна компанийн худалдааны нууц, хувийн нууц зэрэг эрүүгийн хариуцлагатай холбоогүй контентыг хадгалах шинж чанартай байдаг. Иймд цахим мэдээллийг хураан авах, нэгжихдээ бусад албадлагаас илүү болгоомжтой байж тухайн субъектийн үндсэн эрхийг зөрчихгүй байх шаардлагатай.

Хураан авч буй зүйл нь компьютерийн диск болон түүнтэй адилтгах бусад мэдээлэл хадгалах хэрэгсэл бол хадгалагдаж буй мэдээллийн хамрах хүрээг тодорхойлж, хэвлэж,

⁷³ 형사절차상 digital evidence에 관한 연구 - 압수, 수색을 중심으로 - Digital Evidence in Criminal Procedure, pp.26-29, https://www.kicj.re.kr/boardDownload.es?bid=0001&list_no=9714&seq=1

эсхүл хуулбарлан ирүүлэх ёстой. Харин мэдээлэл хадгалах зөөвөрлөгч зэргийг хязгаарлагдмал хүрээнд хэвлэх, хуулбарлах боломжгүй буюу хураах зорилгодоо хүрэхэд ихээхэн хүндрэлтэй гэж үзвэл хурааж авч болно (БНСУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 3, 219 дүгээр зүйл).

Энэ мэтчилэн мөрдөн байцаах байгууллага цахим мэдээллийг хураан авч, нэгжлэг хийх нь зарчмын хувьд 1) зөвхөн нотолгоо гаргах үндэслэл болсон гэмт хэрэгт холбогдсон хэсгийг хэвлэмэл баримт болгон цуглуулах, 2) Газар дээрх нөхцөл байдал, их хэмжээний цахим мэдээллийн улмаас холбогдох мэдээллийг олж авахад удаан хугацаа шаардагдах, мэргэжлийн боловсон хүчин техникийн арга хэмжээ авах шаардлагатай зэрэг онцгой тохиолдолд холбогдох файлыг мөрдөн байцаах газрын зөөвөрлөдөг хадгалах хэрэгсэлд хуулбарлах 3) мэдээлэл хадгалах хэрэгслийг шууд хураан авах, 4) мэдээлэл хадгалах хэрэгсэлд агуулагдах бүх цахим файлыг цаасан хуулбар, дүрс бичлэг гэх мэт хэлбэрээр хураах байдлаар ангилж болно. Энэ тухай эрэн сурвалжлах зөвшөөрөлд заасан байх ёстой.

Мэдээлэл хадгалах хэрэгслээс хууль ёсны дагуу олж авсан хуулбарыг хайж олох, сэжиглэгдсэн баримттай холбоотой цахим мэдээллийг баримт болгон гаргах, файл болгон хуулбарлах зэрэг үйл явц нь мөн зөвшөөрлийн дагуу хураан авах, нэгжлэг хийх ажиллагааны нэг хэсэг гэж тооцогддог. Тиймээс ийм тохиолдолд баримт бичгийг хэвлэх, хуулбарлах объект, тухайлбал мэдээлэл хадгалах хэрэгслийн байршилд хураан авах, нэгжлэг хийх зэрэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 114, 215 дугаар зүйл болон Үндсэн хуулийн 12 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэгд заасны дагуу сэжиглэгдсэн хэсгүүдээр хязгаарлагдах ёстой. Энэ нь процедурын зарчмууд ба пропорциональ байдлын үүднээс энэ нь зүй ёсны хэрэг юм. Иймд мэдээлэл хадгалах хэрэгсэлд хадгалагдаж байгаа цахим мэдээллийг, эсхүл мөрдөн байцаах газрын албанд авч явсан хуулбарыг дур мэдэн баримт болгон хэвлэх, эсхүл хэрэгт авагдсан баримтад хамааралгүйгээр хуулбарлан файл болгон хуулж байгаа үйлдэл нь зарчмын хувьд хууль бус хураан авах ажиллагаа юм.

Түүнчлэн дээрх цуврал ажиллагаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 219, 121 дүгээр зүйлд заасан эрэн сурвалжлагдаж байгаа болон хураагдсан цахим мэдээллийг эзэмшигч этгээд, тэдгээрийн өмгөөлөгчийг оролцуулах боломжийг хангах, хамааралгүй цахим мэдээллийг дур зоргоороо давхардуулахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохих арга хэмжээг авч байна. Хэрэв ийм арга хэмжээ аваагүй бол сэжигтэн этгээд, эсхүл уг хэргийн мөн чанар, агуулгыг харгалзан хурааж авсан зүйлийн эзэмшигч этгээдийн процессын баталгааг хангах зорилгыг ноцтой зөрчсөн гэж үзэж болно.

Мөрдөн шалгах байгууллага, шүүх нь мэдээлэл хадгалах хэрэгслийг хураан авах замаар тодорхой мэдээлэл хүлээн авсан тохиолдолд тухайн мэдээллийн субъект болох, холбогдох баримтыг мэдээллээр таньж болох этгээдэд нэн даруй мэдэгдэх ёстой (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 219 дүгээр зүйлийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг)⁷⁴.

Дээрхээс дүгнэвэл, БНСУ-ын тухайд цахим нотлох баримтыг ангилан тодорхойлдог нь сайн жишиг бүхий зохицуулалт байх ба Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нотлох баримттай холбоотой нийтлэг зохицуулалтуудад цахим нотлох баримтыг хамааруулж уялдуулан хуулийг хэрэглэдэг сайн туршлагатай байна. Иймд Эрүүгийн хэрэг

⁷⁴ 출처 : 법률저널(<http://www.lec.co.kr>)

хянан шийдвэрлэх тухай хуульд цахим нотлох баримтын талаар тусгахдаа түүний ангилал болон хууль хэрэглээний талаар сайн жишгийг авч үзэх нь зүйтэй.

Гуравдугаар бүлэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалттай холбоотой зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

Судалгааны гуравдугаар бүлгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын талаар нарийвчлан авч үзэх ба Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд үүнийг шинээр зохицуулж хуульчлах шаардлага бий эсэхийг судлана. Мөн түүнчлэн ийнхүү хуульчлахдаа гадаадын зарим улс, орнуудаас нутагшуулах сайн жишиг бүхий зохицуулалтыг тодорхойлох болно.

3.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн ойлголт, шинж

ЭХХШТХ-ийн үзэл баримтлал, шинэ төрлийн нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх аргуудын талаар нэгдсэн ойлголт байхгүй, шинэлэг зохицуулалтуудыг төдийлөн ашиглахгүй, уламжлалт хуучин арга, тактикаар нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх нь давамгайл байна.⁷⁵

Судалгаанаас үзэхэд мөрдөгчид нотлох баримтыг бэхжүүлэхэд дуу-дүрсний бичлэг, гэрэл зургийн аппаратыг түгээмэл ашигладаг. Нотлох баримтын шаардлага хангах дуу-дүрсний бичлэг хийх төхөөрөмж, гэрэл зургийн аппаратыг олон мөрдөгч дундаа ашигладгаас шалтгаалж гол төлөв өөрийн гар утсаар орлуулж байна. Энэ нь нотлох баримт устах, алдагдах эрсдэл дагуулахын зэрэгцээ, нотлох баримтын шаардлага хангах эсэхэд эргэлзээ төрүүлдэг. Дараагийн түгээмэл хэрэглэдэг техник хэрэгсэл нь суурин компьютер, принтер бөгөөд эдгээр нь нотлох баримт бэхжүүлэх техник хэрэгсэл мөн боловч тэмдэглэл үйлдэхэд л голчлон ашигладаг. Цөөн тохиолдолд байршлыг нарийвчлан тогтоох GPS ашиглаж байна. Дийлэнх мөрдөгч эдгээрээс өөр техник хэрэгсэл ашигладаггүй гэсэн нь техник хэрэгслийн ололт дэвшлийг өргөнөөр ашиглаж чадахгүй байгааг харуулж байна.⁷⁶

ЭХХШТХ-д нотлох баримт цуглуулах, бэхжүүлэхэд техник хэрэгсэл өргөн ашиглах, өмгөөлөгчийн зүгээс баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгах, үнэлэхтэй холбоотой олон шинэлэг зохицуулалт орсон боловч эрүүгийн процессын явцад эдгээр зохицуулалт төдийлөн ашиглагдахгүй, практик хэрэглээ нь үр дүн муутай байна.⁷⁷

2019 оны 4 сарын 1-ний өдрийн Архивын ерөнхий газрын даргын дугаар А/51 тушаал “Кино, гэрэл зураг, дуу авианы баримтын архивын цахим баримт хадгалалтын журам батлах тухай”,

Нотлох баримт, түүнийг үнэлэх нь шүүн таслах ажиллагааны амин сүнс болсон асуудлын нэг юм. Үүний хамгийн тод жишээ бол “нотлогдоогүй бол гэм буруугүй” гэсэн эрх зүйн суурь зарчим юм. Тиймээс ч Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т –“гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн

⁷⁵ННФ, Нотолгооны өнөөгийн практик, арга зүй, техник хэрэгсэл, анхаарах асуудал /Судалгааны тайлан/, УБ, 2021, 70 дахь тал.

⁷⁶ Мөн тэнд, 62 дахь тал.

⁷⁷ Мөн тэнд, 53 дахь тал.

гэм буруутайд тооцож үл болно” гэж заасан. Эрүүгийн процессын онолд нотлох баримтыг хэлбэрийн хувьд мэдүүлгэн, биет, бичмэл, буулгасан, вертуаль гэж ангилан үздэг.⁷⁸

Цахим нотлох баримт нь зөвхөн цахим төхөөрөмж, системээр гаргасан баримт бичгээр хязгаарлагдахгүй. Цаасан бичиг баримт, гэрэл зураг, дүрс бичлэгийг цахим нотлох баримт гэж үзэхээс гадна эд мөрийн баримтыг хүртэл цахим хэлбэрт шилжүүлж, хууль хяналтын байгууллагаас баталгаажуулан нотлох баримт болгон байршуулах боломжтой.⁷⁹

3.2. Монгол Улс дахь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдал, сайжруулах хэрэгцээ, шаардлага

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цахим нотлох баримт, түүнийг цуглуулах, бэхжүүлэх, шинжлэх судлах, үнэлэхтэй холбоотой холбогдох байгууллагуудаас гаргасан эрх зүйн акт, журмыг судлан үзвэл:

1. 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 31 дүгээр тогтоол, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбарт:

Хуульд нэрлэн зааснаас бусад бичмэл болон цахим баримт, бусад эд зүйл нь хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих байдал, эсхүл гэм бурууг үгүйсгэхэд ач холбогдолтой тохиолдолд эд мөрийн баримт гэж үзэх бөгөөд зөвхөн нотлох ажиллагаанд ашиглаж, гэм буруутай эсэхийг эцэслэн шийдвэрлэсний дараа хууль ёсны өмчлөгч, эзэмшигчид нь буцаан өгөх, гүйлгээнд хориглосон болон цаашид ашиглах боломжгүй эд зүйлийг устгах буюу зохих байгууллагад шилжүүлэх, бичмэл эд мөрийн баримтыг хэрэгт хавсарган үлдээх зэргээр шийдвэрлэдэг онцлогтой. Хуульд "... бичмэл болон цахим баримт ..." гэж ерөнхий агуулгаар тусгагдсанаас тус бүрийн онцлог, нотлох баримтын бие даасан төрөл болох баримт бичгээс ялгагдах шинжийг тодорхойлох шаардлага үүсч байна.

Цахим төхөөрөмжид үүсгэсэн, боловсруулсан, хадгалсан, өөрчилсөн, илгээсэн, дамжуулсан, хүлээн авсан бүх хэлбэрийн мэдээлэл нь гэмт хэрэг үйлдэхэд, эсхүл гэмт хэрэгт бэлтгэх, завдахад ашигласан, гэмт хэргийн ул мөр үлдсэн, агуулсан тохиолдолд эд мөрийн баримт болно.

Цахим баримт нь биет бус, олон байршилд хадгалах, олон хэрэглэгч зэрэг нэвтрэх боломжтой, тогтвортой бус түргэн хугацаанд хувирч өөрчлөгдөх, устах эрсдэлтэй, технологийн хурдацтай хөгжил мөрдөн шалгах ажиллагаанд нөлөөлдөг зэрэг онцлог шинж чанартай эд мөрийн баримтын төрөл юм. Энэ төрлийн баримтыг хайх, олж илрүүлэх, бэхжүүлэх, хадгалах, зөөвөрлөх, шалгах ажиллагаанд цахим мэдээллийн бүрэн бүтэн, найдвартай байдал нь нотлох баримтаар үнэлэхэд чухал ач холбогдолтой.

Цахим төхөөрөмжид агуулагдаж буй мэдээлэл нь түүний онцлог шинж чанараас шалтгаалан эх хувийг тогтооход бэршээлтэй, цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, зөөвөрлөх явцад амархан өөрчлөгдөх, устах эрсдэлтэй тул энэ төрлийн эд мөрийн баримтыг илрүүлэх,

⁷⁸ Ш.Мөнхжаргал, Л.Уянга, Б.Нямцэрэн нар, Нотлох баримт, түүнийг үнэлэхтэй холбоотой эрх зүйн эх сурвалжуудыг судалж бичсэн, асуудал дэвшүүлсэн өгүүлэл, <https://legaldata.mn/buteel/pdf?id=1761>

⁷⁹ U.S. Embassy - Ulaanbaatar, Mongolia

бэхжүүлэхдээ хуулийн 9.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тусгай мэдлэг, туршлага бүхий хүнийг мэргэжилтнээр оролцуулбал зохино.

Мэргэжлийн байгууллага, ур чадвар бүхий мэргэжилтнийг цахим баримтыг эрж хайх, олж илрүүлэх, бэхжүүлэх ажиллагаанд оролцуулсан бол тэдний хийсэн үйлдэл, үйл ажиллагаа бүрийг нэг бүрчлэн тэмдэглэлд тусгана. Цахим төхөөрөмжөөс өөрчлөгдсөн, устгасан мэдээллийг нарийн мэргэшсэн шинжээчийн тусламжтайгаар сэргээсэн тохиолдолд нотлох баримтад тооцогдоно⁸⁰ гэж тусгажээ.

2. Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны 5 сарын 20-ны өдрийн А/69 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүгийн хэрэгт хөрөнгө, орлого, эд мөрийн баримт, эд зүйлийг хураан авах, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, шийдвэрлэх журам”

Тус журмын 7 дугаар зүйлд “Онцлог эд мөрийн баримтыг хураан авах, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, шийдвэрлэх” ажиллагааг тусгайлан тусгасан бөгөөд тус журмын 7.2.9. “цахим төхөөрөмж” гэж суурин болон гар утас, гэрэл зургийн аппарат, дүрс бичлэгийн камер, таблет, сканнер, факсын машин, хэвлэгч, хувилагч, бусад төхөөрөмжийг, 7.2.10. “мэдээлэл хадгалах хэрэгсэл” гэж хард диск, флаш диск, санах ой бүхий картууд, CD, DVD болон бусад хэрэгслийг гэж тус тус тодорхойлжээ. Мөн энэхүү журмын 7.12-д цахим баримтын талаар дараах байдлаар тусгажээ.

7.12.1. цахим баримтыг мэргэжилтний тусламжтайгаар тусгай техник хэрэгсэл, программ ашиглан хуулбарлан авч, энэ тухай тэмдэглэл үйлдэж, үйл явцыг гэрэл зураг, дуу дүрсний бичлэгээр бэхжүүлнэ. Шаардлагатай тохиолдолд цахим төхөөрөмж , мэдээлэл хадгалах хэрэгслийг хураан авна.

7.12.2. мэдээллийг хуулбарлахдаа хөндлөнгийн хоёроос доошгүй гэрчийг байлцуулан засварлаж өөрчлөх боломжгүйгээр код үүсгэн “hash” /хэшлэх-тусгай программ ашиглах/, тэмдэглэж хөтөлж, түүнд байлцсан хүмүүсээр гарын үсэг зуруулна.

7.12.3. цахим төхөөрөмж, мэдээлэл хадгалах хэрэгслийг хураан авахад ул мөр үлдсэн, интернэт холболтын модем, кабель шугам, бусад төхөөрөмжтэй холбогдсон эсэхийг шалгана.

7.12.4. шаардлагатай бол модем, свитч рүтер зэрэг сүлжээний төхөөрөмжийг хураан авч, тэмдэглэл үйлдэнэ.

7.12.5. тэмдэглэлд цахим төхөөрөмжийг хураан авах үед асаалттай ажиллагаатай байсан эсэх, тухайн үед хэн, хэрхэн ашиглаж байсан талаарх мэдээллийг тусгана.

7.12.6. компьютер, цахим төхөөрөмжид хадгалагдаж байгаа бүх төрлийн мэдээлэл нь устах, гэмтэх эрсдэлтэй тул үзлэг хийхээс өмнө төхөөрөмжид байгаа мэдээллийг үзэх, агуулгыг хайх, асаах, унтраах зэргээр дур мэдэн оролдохыг хориглоно.

7.12.7. компьютер, цахим төхөөрөмжийн дэлгэц дээрх мэдээлэл өгөгдлийг устгаж байгаа шинж тэмдэг илэрсэн тохиолдолд шууд унтраана.

7.12.8. хэргийн газраас нууц үг бүхий цаас, программ, техник хангамжийн гарын авлага, компьютероос хэвлэсэн бичвэр болон график материалыг хураан авна.

7.12.9. цахим төхөөрөмж, гар утасны нууц үгийг эд зүйлээ хураалгаж буй этгээд буюу өмчлөгч, эзэмшигчээр бичүүлж, эд зүйлийн хамт уут, саванд битүүмжилнэ.

7.12.10. цахим эд мөрийн баримтыг зөвхөн цаасан уут, хайрцаг зэрэг саванд хийж, тээвэрлэх явцад доргилтоос хамгаална.

7.12.11. савлахын өмнө шошго тавьж, хоорондоо холбогдсон төхөөрөмжүүдийн холболтуудыг дараа нь угсарч ажиллуулах зорилгоор ойлгомжтой хэлбэрээр хаяглаж, үйл явцыг гэрэл зураг, дуу дүрсний бичлэгээр бэхжүүлнэ.

⁸⁰ 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол, Дугаар 31, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар

7.12.12. цахим баримтыг соронзон орон бүхий цахилгаан үүсгэх боломжтой аливаа төхөөрөмж материалаас хол, аюулгүй байдлын хамгаалалттай, температурын хяналт бүхий орчин, чийгшилгүй газарт зориулалтын хамгаалалтын уут эсхүл хайрцагт хадгална.

7.12.13. цахим мэдээлэл хадгалах хэрэгслийн мэдээлэл устгах, гэмтэхээс сэрэмжилж цахилгаан үүсгүүр, радио дамжуулагч зэрэг соронзон орны орчин үүсгэх, ердийн дулаанаас хэт өндөр температур, чийгшил, тоосжилт, доргилт ихтэй газарт хадгалахыг хориглоно.

Монгол Улсын хувьд цахим нотлох баримт хураан авах, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах үйл ажиллагааны дараалал, аргачлалыг журамлахдаа цахим баримт хадгалагдаж буй төхөөрөмж бүрд ялгаатай байдлаар бус, нийтлэг байдлаар журамласан.⁸¹

3. 2019 оны 12 сарын 5-ны өдрийн Дугаар 246, А/80 Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан захирамж, тушаалын⁸² нэгдүгээр хавсралтаар “Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”, хоёрдугаар хавсралтаар “Хавтаст хэргийг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх журам”-ыг тус тус шинэчлэн баталсан.

Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журмын 3.5-д “...Эд мөрийн баримт болон мэдээллийн техник, технологийн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл /бүх төрлийн CD, зөөврийн хатуу диск, хатуу диск, флаш.../ зэргийг хүлээн авахдаа хавтаст хэргийн онцлогоос шалтгаалан тухайн тоног төхөөрөмж нь хэвийн ажиллаж байгаа эсэх, гэмтэлтэй эсэх, серийн дугаар тохирч буй эсэхийг шалгана...” гэж заажээ.

4. Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2022 оны 4 сарын 15-ны өдөр дугаар А/42 тушаалын нэгдүгээр хавсралтаар “Эрүүгийн хэргийн тусгай, салбар архивт баримт хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх, хадгалах, ашиглуулах журам”, хоёрдугаар хавсралтаар “Архивт хөтлөгдөх тоо бүртгэлийн баримт бичиг, мэдээний жагсаалт, загвар”-ыг тус тус баталжээ.

Эрүүгийн хэргийн тусгай, салбар архивт баримт хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх, хадгалах, ашиглуулах журамд:

3.8 дугаар зүйл. Цахим хэлбэрт шилжүүлэх

1.Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим мэдээллийн сан үүсгэх аргачлалыг Улсын ерөнхий прокурорын тушаалаар батална;

2.Баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, тоо бүртгэл, эрэлт хайлт, ашиглалтын үйл ажиллагааг хөнгөн шуурхай болгох, эх баримтыг ашиглалтаас чөлөөлөх зорилгоор баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим мэдээллийн сан үүсгэнэ;

3.Баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажилтантай нууц хадгалалтын гэрээ байгуулна.

3.9 дүгээр зүйл. Баримтыг цахим хэлбэрт шилжүүлэхдээ

1.Баримтын мэдээллийг алдагдуулахгүй, бодит байдлыг өөрчлөхгүй байх;

2.Баримтыг гэмтээхгүй байх;

3.Баримтын онцлог шинжийг хэвээр хадгалах;

⁸¹ ННФ, Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа /Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд/, УБ, 2022, 62 дахь тал.

⁸² “Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”, “Хавтаст хэргийг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх журам” <http://old.supremecourt.mn/act/view/266>

4.Мэдээлэл тээгчийн шинж чанарыг муутгахгүй байх;

5.Баримтын үндсэн дарааллыг алдагдуулахгүй;

6.Ажлын явцад баримтын бүрэн бүтэн байдлыг цахим хэлбэрт шилжүүлж байгаа ажилтан хариуцна.

3.10 дугаар зүйл. Бусад

1.Цахим баримтыг хөмрөг үүсгэгч байгууллагын хөмрөгт хамааруулж, цаасан суурьтай баримтаас тусад нь хадгална;

2.Цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын мэдээг хариуцсан ажилтан сар бүрийн 05-ны дотор гаргаж, тусгай архивт ирүүлнэ;

3.Мэдээг удаа дараа буруу ирүүлсэн, хугацаа хожимдуулсан, алдаатай, худал ташаа ирүүлсэн, мэдээг огт ирүүлээгүй, зохих журмын дагуу серверт байршуулаагүй ажилтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцуулах албан бичгийг байгууллагын удирдлагад хүргүүлнэ;

4.Байгууллагын удирдлага нь цахим мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас хамгаалах, мэдээлэл алдагдахаас сэргийлэх зорилгоор техник хэрэгслийн найдвартай байдал, сүлжээ, серверийн аюулгүй байдлыг хангах, хорт код вирусээс хамгаалах арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллана.

4.4 дүгээр зүйл. Хадгалалт

2.Цахим мэдээлэл хадгалах хэрэгслийн мэдээлэл устах, гэмтэхээс сэрэмжилж цахилгаан үүсгүүр, радио дамжуулагч зэрэг соронзон орны орчин үүсгэх, ердийн дулаанаас хэт өндөр температур, чийгшил, тоосжилт, доргилт ихтэй газарт хадгалахыг хориглоно.

4.6 дугаар зүйл. Баримтын шинж чанарыг тодорхойлох

6.Тусгай тээгчтэй болон цахим баримтын хадгалалтын байдалд 2 жил тутам нягтлан шалгалт хийж, шаардлагатай тохиолдолд цахим баримтын файлыг ашиглагдаж буй форматад хөрвүүлж, хадгалалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх, солих арга хэмжээ авна;

7.Цахим баримтыг зориулалтын хадгалах төхөөрөмж, бүх төрлийн сервер, компьютер, зөөврийн болон бусад тоон технологийн шийдэл ашиглан тээгчээс хамгийн багадаа гурван өөр тээгчид хуулбарлан хадгална.

5. 2022 оны 1 сарын 6-ны өдрийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоол Дугаар 1 “Журам батлах тухай”

Энэхүү “Шүүхийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлд цахим баримтыг хадгалах талаар тусгасан. Тухайлбал,

Журмын 6.3-т “...Цахим баримтыг тодорхой хугацааны давтамжтайгаар сервер болон тусгай тээгч /CD, DVD, Flash, Portable hard disk/-д хадгална...” гэж, 7.1-д “Цахим баримтын агуулгыг эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг, баримт удирдлагын баримт бичгүүд гэсэн төрлөөр төрөлжүүлэн системд мэдээллийг оруулна”, 7.2-т “Системд оруулсан мэдээлэл болон хавсаргасан цахим файл нь тухайн баримтыг хайхад саадгүй илэрч байхаар зөв тодорхойлж, томъёологдсон байна”, 7.3-т “Цахим баримтаар архивын үйлчилгээ үзүүлэхэд системийг ашиглана. Тусгай архиваас системийг суурилуулах бөгөөд уг систем, программ хангамж дээр ажиллахад шаардлагатай мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгнө” гэж тус тус заажээ.

Дээрх тайлбар, журмуудаас харвал цаашид цахим нотлох баримтыг ЭХХШТХ-д тодорхойлон заах шаардлагатай байна. Энэ нь тухайн нэр томъёог өөр өөрөөр тодорхойлон хэрэглэхээс сэргийлэх, нэр томъёог нэг мөр ойлгон хэрэглэхэд чухал ач холбогдолтой.

Түүнчлэн, шүүхийн цахимжилттай холбогдуулан цахим нотлох баримт, цахим хавтаст хэрэг, цахимжуулсан хавтаст хэрэг зэрэг шинэ шинэ нэр томъёо, ойлголт,

ухагдахуун гарч ирж байгаатай холбогдуулан анхнаасаа тухайн нэр томъёог оновчтой зөв тодорхойлж, нэг мөр ойлгон хэрэглэх шаардлага бий болж байгааг дурдах нь зүйтэй.

6. 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн УДШ-ийн Ерөнхий шүүгч, ХЗДХ-ийн Сайд, УЕП-ын хамтарсан Дугаар А/18, 34, А/31 “Заавар батлах тухай”

Тус тушаалаар “Эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох баримтыг архивт хадгалах заавар”-ыг нэгдүгээр, “Эрүүгийн хэргийн төв болон салбар архивт хадгалагдаж байгаа баримтыг хадгалах хугацааны заавар”-ыг хоёрдугаар хавсралтаар баталсан.

Эрүүгийн хэргийн төв болон салбар архивт хадгалагдаж байгаа баримтыг хадгалах хугацааны зааварт:

Хоёр. Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн баримтын хадгалах хугацаа

2.1. Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн баримтыг дор дурдсан хугацаагаар хадгална.

2.1.1. хорихоос өөр төрлийн үндсэн болон нэмэгдэл ялын тухай баримтыг ялыг эдэлж дууссан өдрөөс хойш 10 жил;

2.1.2. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг 1 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг 1 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон эрүүгийн гэмт хэргийн баримтыг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 12 жил;

2.1.3. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 1 жилээс дээш, дээд хэмжээг 8 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг 1 жилээс дээш хугацаагаар тогтоосон эрүүгийн гэмт хэргийн баримтыг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 16 жил;

2.1.4. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 5 жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг 15 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон эрүүгийн хэргийн баримтыг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 жил;

2.1.5. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 12 жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг 20 жил хүртэл тогтоосон ба бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй эрүүгийн гэмт хэргийн баримтыг байнга;

2.1.6. Эрүүгийн хуульд бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг, хүний амь нас хохирсонтой холбоотой, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээдэд холбогдох, нууцад хамаарах баримт, Төв болон салбар архивын ББНШАЗК-ын хурлын шийдвэрээр байнга хадгалахаар шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн баримт, баримт бичгийг байнга;

2.2. 1961, 1986 оны Эрүүгийн хуулиар шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн баримтын хадгалах хугацааг тухайн хэргийг шийдвэрлэсэн хуулийн зохих зүйл, хэсэгт заасан ялын дээд хэмжээг 2002 оны Эрүүгийн хуулийн гэмт хэргийн ангилалд хамааруулан тооцож, хадгалах хугацааг нь тогтооно.

2.3. Шүүхээс хэрэгсэхгүй болгосон, цагаатгасан, өршөөж шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн баримтын хадгалах хугацааг энэ зүйлийн 1.1.1-1.1.5 дахь заалтад заасан хугацаагаар хадгална.

2.4. Шүүхээр шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн баримтыг дор дурдсан хугацаагаар хадгална.

2.4.1. хүнд холбогдох хэргийн баримтыг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 жил;

2.4.2. хуулийн этгээдэд холбогдох хэргийн баримтыг байнга;

Гурав. Прокуророос шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн баримт материалыг хадгалах хугацаа

3.1. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн материал – шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 жил;

3.2. Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан болон хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэргийн баримт;

3.2.1. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг 1 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг 1 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэргийн баримтыг – шийдвэр хуулийн хүчинэ төгөлдөр болсон өдрөөс хойш 3 жил;

3.2.2. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 1 жилээс дээш, дээд хэмжээг 8 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг 1 жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэргийн баримтыг – шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 жил;

3.2.3. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 5 жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг 15 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэргийн баримтыг – шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 12 жил;

3.2.4. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 12 жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг 20 жил хүртэл тогтоосон ба бүх насаар нь хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийн баримтыг – шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 20 жил;

3.2.5. Эрүүгийн хуульд бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг болон хүний амь нас хохирсон бүх хэргийн баримт, материал, баримт бичиг – байнга.

3.2.6. Улс төрд нөлөө бүхий хүн, төрийн өндөр албан тушаалтан, дипломат дархан эрх ямба эдэлж байгаа хүн, шүүгч, прокурор болон авлигатай тэмцэх, хил хамгаалах, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах албан тушаалтанд холбогдох хэргийн баримт – байнга.

Практикт шүүхийн шийдвэрээр тухайн хэрэгт хураагдан ирсэн эд мөрийн баримтыг цаашид хадгалах эсэхийг хэрхэн шийдвэрлэснээс хамаарч нотлох баримтыг хадгалах эсхүл устгах арга хэмжээг авдаг. Цахим нотлох баримтын хувьд практикт ихэвчлэн CD дээр хуулбарлан хавтаст хэрэгт хавсаргадаг бөгөөд энэ нь тухайн хавтас хэргийг хадгалах хугацаатай ижил хугацаанд хадгалагдаж байна.

Энэ талаар буюу дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалтын талаар холбогдох мэргэжилтэн, судлаач дараах мэдээллийг өгсөн юм.

Шигтгээ 6.

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хувьд 100% хийгдэж чаддаггүй. Одоогийн байдлаар тус дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуустал хадгалдаг бөгөөд зарим нь богино хугацаанд устгагдах тохиолдол байдаг. Нөхцөл байдлын тухайд дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийг хадгалах сервер, багтаамжийн хүрэлцээ муу байдаг нь асуудал үүсгэж байна. Түүнчлэн бичлэгийн чанар муу байгаа нь хэрэгжүүлж буй зорилготойгоо нийцэхгүй байна.

Шүүхийн цахимжилтын сайн жишгийг авч үзвэл шүүх хуралдаан нь боловсронгуй тоног, төхөөрөмжөөр тоноглогдсон, сайтар бичлэг хийх дуу, дүрсний төхөөрөмжтэй, түүнийг хадгалах багтаамжтай байх нь зүйтэй. Дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн найдвартай байдал нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гишүүн Н.Баасанжавтай хийсэн ярилцлагын хэсгээс...

3.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын харьцуулсан судалгаа

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтын талаар харьцуулсан судалгааг хийхдээ өмнө нь авч үзсэн шүүх, хууль, эрх зүйн үйл ажиллагааг цахимжуулах талаар дэвшил гаргасан, эрх зүйн тогтолцооны хувьд жишиг болгож судалдаг дараах улсуудыг судаллаа.

3.3.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын сайн туршлага

Ерөнхий зохицуулалт

ХБНГУ-ын ЭХХШТХ-ийн “Хэргээ хүлээсний дараа буюу эсэргүүцсэн тохиолдолд шүүгчийн тэмдэглэлээс уншиж танилцуулах” гэсэн 254-р зүйлийн (1) -т “*Шүүгдэгчийн мэдүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэл, дуу дүрсний бичлэгт тусгагдсан мэдүүлгийг хэргээ хүлээсэн тухай нотлох баримт авах зорилгоор уншиж, сонсгож болно*” мөн “Баримт бичгийг унших замаар баримтат нотлох баримт бүрдүүлэх; баримт бичгийн найруулгыг анхаарч үзэх” гэсэн 249-р зүйлийн (1) хэсэгт “*Баримт бичгийг агуулгынх нь талаар нотлох баримт авах зорилгоор үндсэн шүүх хуралдаанд уншина. Цахим баримт бичгийг уншиж танилцах боломжтой баримт бичиг гэж үзнэ.*” гэж тус тус зааснаас үзэхэд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг нь ЭХХША-нд авах, үнэлэх буюу үнэнийг тогтоох зорилгоор ашиглах боломжтой цахим (дижитал) нотлох баримт буюу цахим баримт бичгийн нэг төрөл юм.

Нарийвчилсан зохицуулалт

ХБНГУ-ын ЭХХШТХ-ийн 1-р бүлгийн “Хавтаст хэргийн удирдлага (менежмент) ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь харилцаа холбоо” гэсэн 4-р дэд бүлэгт “*Хавтаст хэргийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор баримт бичгийг хувиргах (хөрвүүлэх)*” гэсэн 32е зүйлд цахим баримт бичгийг хэрхэн цахим хавтаст хэрэгт хавсаргах, цахим байдалд хөрвүүлэх болон хадгалалтын хугацаа зэргийг зохицуулсан байна. Уг дэлгэрэнгүй зохицуулалтыг доор танилцуулъя.

Хэсэг 32е

Хавтаст хэргийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор баримт бичгийг хувиргах (хөрвүүлэх)⁸³

- (1) Тухайн хавтаст хэргийг хадгалж буй хэлбэртэй (эх баримт бичигтэй) баримт бичиг нь тохирохгүй байвал тохирох хэлбэрт тус баримт бичгийг хөрвүүлж болно. Нотлох баримт болгон баталгаажуулсан эх баримт бичгийг зохих шаардлагатай хэлбэрт шилжүүлж болно.
- (2) Баримт бичгийг хөрвүүлэхдээ хөрвүүлсэн баримт бичиг нь харагдах байдал болон агуулгын хувьд эх баримт бичгийн агуулгатай тохирох байдлыг хангахуйц хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглана.
- (3) Цахим бус эх баримт бичгийг цахим баримт бичиг болгон хөрвүүлэхдээ хөрвүүлэхэд ямар процедур ашигласан, энэ нь эх баримт бичигтэй харагдах байдал болон агуулгатай тохирч

⁸³ БНЭсУ-ийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Kriminaalmenetluse seadustik, 2003)

байгаа зэргийг нотлох баримтыг хавсаргана. Прокурорын байгууллага болон шүүхэд хэрэглэгдэж байсан, хариуцах үүрэг бүхий этгээдийн гарын үсэг зурсан баримт бичгийг хөрвүүлэх тохиолдолд хөрвүүлэлтийг нотлох баримт нь прокурорын газар, шүүхийн бүртгэлийн ажилтны мэргэшсэн цахим гарын үсэгтэй байх ёстой. Мэргэшсэн цахим гарын үсэг бүхий эсхүл дамжуулах аюулгүй аргаар ирүүлсэн цахим эх баримт бичгийг уг баримт бичигт хийсэн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг шалгасан шалгалтын дүнгийн хавтаст хэрэгт бичилт хийн оруулна.

- (4) Үргэлжилж буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтаар хадгалагдаагүй эх баримт бичгийг хөрвүүлснээс хойш дор хаяж зургаан сар хадгална. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссан, эсхүл хугацаа хэтэрсэн тохиолдолд нотлох баримтаар хадгалагдаагүй эх баримт бичгийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссанаас хойшхи хуанлийн хоёр дахь жилийг дуустал хадгалах боломжтой.
- (5) Нотлох баримтаар хадгалагдаагүй эх баримт бичгийг баталгаатай нотлох баримтад хамаарах нөхцөлөөр шалгаж болно. Хавтаст хэргийг шалгах эрх бүхий этгээд нь энэ төрлийн шалгалтыг хийх бүрэн эрхтэй.

Дээрхээс дүгнэвэл, ХБНГУ-ын тухайд дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийг цахим нотлох баримтад хамааруулан зохицуулж, хадгалалт, хамгаалалтын асуудлыг ерөнхий журмаар зохицуулдаг байна. Нарийвчилсан журмын тухайд нотлох баримтаар авагдаагүй эх баримт бичгийг хадгалах журмыг нарийвчлан зохицуулжээ.

3.3.2. Бүгд Найрамдах Эстони Улсын сайн туршлага

Ерөнхий зохицуулалт

Эстонийн ЭХХШТХ-ийн “Кино ба дуу, дүрсний бичлэг” гэсэн 150-р зүйлийн (1)-д “Мөрдөн шалгах ажиллагаа болон бусад процесс ажиллагаа, эсхүл түүний тодорхой хэсгийг камержуулж, дууны, дүрсний бичлэг хийж болно. Мөрдөн шалгах ажиллагаа болон бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэхээс өмнө энэ тухай гэрч, ЭХХША-нд оролцогчид мэдэгдэнэ.” Гэсэн бол (4)-р зүйлд “Дууны, дүрсний бичлэгийг эрүүгийн хавтаст хэрэгт хавсаргана. Дууны болон дүрсний бичлэгт өөрчлөлт оруулахыг хориглоно.” Гэж зохицуулсан байна.

Дээр дурдсанчлан Эстони улсын ЭХХША-нд хавтаст хэргийг цахим хавтаст хэргийн системээр цахимаар хөтлөх (ЭХХШТХ-ийн 160¹ (5), 210-р зүйл) бөгөөд 150-р зүйлийн (4)-т зааснаас үзэхэд ЭХХША-ны явцад бэхжүүлж авсан дуу, дүрсний бичлэг, киног цахим хавтаст хэрэгт цахим хэлбэрээр хавсаргах бололтой гэвч энэ талаар нарийвчлан зохицуулсан зохицуулалт одоогоор алга байх бөгөөд 160¹-р зүйлийн (6),(7)-д шүүхийн хавтаст хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлэх хугацаа, цахим хэрэг хөтлөлт, түүнд хандах, цахим баримт бичгийн хадгалалт түүнд тавигдах техник шаардлага, цахим хавтаст хэргийг архивлах журам зэрэг нарийвчилсан зохицуулалтыг Хууль зүйн сайдын гаргасан журмаар тогтооно гэж заасан боловч одоогоор тус төрлийн журам батлагдаагүй байна.

Нарийвчилсан зохицуулалт, хугацаа

Эстонийн ЭХХШТХ-ийн 124-р зүйлд “Биет эд мөрийн баримт гэж эрүүгийн гэмт хэргийн объект болсон зүйл, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан эд зүйл, эрүүгийн гэмт хэргийн нотлох баримт бүхий зүйл, гэмт хэргийн нотлох баримтын ул мөр бүхий сэтгэгдэл, хэвлэмэл, эрүүгийн гэмт хэрэг, эсхүл нотлох баримттай холбоотой үйл баримтыг тогтооход ашиглаж болох эрүүгийн үйлдэлтэй холбоотой бусад чухал

объектыг хэлнэ.” Гэж тодорхойлсон бөгөөд уг биет эд мөрийн баримтыг хадгалах журмыг уг хуулийн 125-р зүйлд зохицуулсан байна. Гэвч ЭХХШТХ-ийн 63-р зүйлд “нотлох баримт”-ыг тодорхойлохдоо биет нотлох баримт буюу биет эд мөрийн баримтад, дууны, дүрсний болон дуу-дүрсний бичлэгийг багтаалгүй тусад нь тоочин бичсэн байх тул ЭХХШТХ-ийн 125-р зүйлд зохицуулсан “Эд мөрийн баримтыг хадгалах журам” нь дууны, дүрсний болон дуу-дүрсний бичлэгт хамаарах эсэх нь эргэлзээтэй байна.

Хэрэв 125-р зүйлд зохицуулсан “Эд мөрийн баримтыг хадгалах журам” нь дууны, дүрсний болон дуу-дүрсний бичлэгт ижил хамаарах бол 125-р зүйлийн (1)-т заасны дагуу эд мөрийн баримтыг “*ЭХХША явуулж буй байгууллагын эд мөрийн баримтын хадгалах газар, эсхүл шүүх эмнэлгийн байгууллагын эзэмшил, хамгаалалтад байгаа бусад байранд*” хадгалах бөгөөд хадгалах хугацааны хувьд 6 сар байх бөгөөд прокурор, мөрдөн байцаах байгууллагын хүсэлтээр энэ хэсгийн (4) дэд хэсэгт заасан зургаан сарын хугацааг нэг жил хүртэл хугацаагаар сунгаж болно (ЭХХШТХ-ийн 124-р зүйлийн (4), (5)) гэж тус тус заасан байна.

Нууц мөрдөн шалгах ажиллагааны үед олж авсан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалт

БНЭСУ-ын ЭХХШТХ-ийн “Нууц мөрдөн шалгах ажиллагааны хавтаст хэргийг хадгалах, хөтлөх” гэсэн 126¹¹ – р зүйлийн (1)-т заасны дагуу нууц мөрдөн шалгах ажиллагааны явцад олж авсан аливаа мэдээллийг нууц мөрдөн шалгах ажиллагааны хавтаст хэрэгт хадгалах бөгөөд уг зүйлийн (2)-т ийнхүү “...*хадгалах, хөтлөх журмыг Дотоод хэргийн сайдын санал болгосноор Бүгд Найрамдах Улсын Засгийн газар тогтооно*” гэж заасан байна. Уг хуулийн зохицуулалтын дагуу Эстони улсын Засгийн газраас 2013 оны 03 дугаар сарын 01-ний өдөр баталсан №3 “Мөрдөн шалгах ажиллагааны хавтаст хэргийг хөтлөх, хадгалах журам”⁸⁴-ын 7-р зүйлийн (5) дахь хэсэгт “*Нууц мөрдөн шалгах ажиллагааны явцад авсан гэрэл зураг, кино, дуу авианы болон дүрс бичлэг, бусад мэдээллийг эсхүл түүний зарим хэсгийг болон хавтаст хэргийг нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын нууц мэдээллийг боловсруулах цахим системд эсхүл нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын энэ зорилгоор тусгайлан тохируулсан өрөөнд хадгална*” гэж заасан байна.

Дээрхээс үзэхэд Эстони улсад ЭХХША-ны явцад бэхжүүлж авсан болон цахим хавтаст хэрэгт авагдсан аливаа дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг цахим хэлбэрээр цахим хавтаст хэргийн системд болон биет байдлаар эд мөрийн баримт хадгалах тусгай зориулалт бүхий эрх бүхий байгууллагын байранд нийтлэг журмын дагуу хадгалдаг байна.

3.3.3. Америкийн Нэгдсэн Улсын сайн туршлага

Нотлох баримтыг хадгалах гэдэг нь засгийн газар нотлох баримтын бүрэн бүтэн байдлыг дараа нь шалгах эсвэл дүн шинжилгээ хийх зорилгоор хадгалах ёстой байдаг. Ингэхийн тулд эд хөрөнгө, нотлох баримтыг хадгалагч нь хадгалалтын бүртгэлийг үнэн зөв, бүрэн гүйцэд хөтөлж, нотлох баримтыг зохих ёсоор хадгалж, нотлох баримтыг бохирдуулах, гэмтээх, устгахаас урьдчилан сэргийлэх ёстой байдаг. Хадгалалтын протокол нь нотлох

⁸⁴ Журмаа мич

баримтын төрлөөс хамаардаг, биологийн дээж эсвэл дижитал нотлох баримтыг хадгалах дүрэм гэх мэт.

Нотлох баримтыг хадгалах үүрэг нь аливаа төрийн байгууллага, эрүүгийн мөрдөн байцаалтын ажиллагааны хүрээнд нотлох баримт цуглуулж, эзэмшиж авснаас хойш эхэлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүгдэгчийн ял хүртэл үргэлжилдэг.

Цагдаа нар ихэвчлэн эрүүгийн хэрэгт ашигласан нотлох баримтыг цуглуулдаг ч нотлох баримтыг хадгалах цорын ганц төрийн байгууллага биш юм. Хадгалах үүрэг нь мөн:

-орон нутаг, муж, муж улсын мөрдөн байцаах агентлагууд—эдгээрт зөвхөн мөрдөгч, мөрдөн байцаагчид төдийгүй захиргааны, бичиг хэргийн болон шүүх эмнэлгийн ажилтнууд ордог.

-Хэргийг хариуцаж байгаа прокурор мөн прокурорын эрх мэдлийн доор ажиллаж байгаа хүмүүс нотлох баримтыг хадгалах үүрэгтэй (жишээлбэл мөрдөн байцаагч, прокурорын томилсон шинжээч)

- Ерөнхий прокурор—ихэнх мужид болон ихэнх тохиолдолд нотлох баримтыг хадгалах үүрэг нь шүүгдэгчийг яллагдсаны дараа ч хэвээр үлдээдэг. Тиймээс, уг үүрэг нь муж улсын Ерөнхий прокурорын газарт (ихэвчлэн давж заалдах болон ял шийтгүүлсний дараах асуудлыг зохицуулдаг) хамаарна.

-Ерөнхий прокурор—ихэнх мужид болон ихэнх тохиолдолд нотлох баримтыг хадгалах үүрэг нь шүүгдэгчийг яллагдсаны дараа ч хэвээр үлддэг. Тиймээс, уг үүрэг нь муж улсын Ерөнхий прокурорын газарт (ихэвчлэн давж заалдах болон ял шийтгүүлсний дараах асуудлыг зохицуулдаг) хамаарна.

Нотлох баримтыг хадгалах үүрэг нь хууль сахиулах байгууллагатай албан ёсны харилцаагүй бол хувь хүмүүс эсвэл агентлагуудад хамаарахгүй. Иймд хэргийн газраас цуглуулсан цусны дээжийг шалгахын тулд ДНХ шинжилдэг хувийн лабораторийг прокурор хөлсөлсөн бол тухайн лаборатори нь нотлох баримт, нотлох баримт дээр хийсэн аливаа шинжилгээний үр дүнг хамгаалж, хадгалах ёстой.

3.3.4. Бүгд Найрамдах Солонгос Улсын сайн туршлага

БНСУ-ын тухайд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг Эрүүгийн процессын хуулийн 311, 312 дугаар зүйлд заасны дагуу нотлох баримтаар тооцдог⁸⁵.

1) Нэгдүгээрт, видео бичлэг нь эх хувь байх ба эсвэл эх хувиас хуулбарласан хуулбарын хувьд хуулбарлах явцад зориудаар засварлах гэх мэт ямар нэгэн зохиомол өөрчлөлтгүйгээр эхийн агуулгын хуулбарлаагүй байх ёстой;

2) Хоёрдугаарт, Эрүүгийн процессын хуулийн 313 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүх хуралдаанд бэлтгэх эсвэл шүүх хурлын товын үеэр гэрчийн мэдүүлэгт үндэслэн видеог хуулбарласан байх ёстой. Дуу бичлэгт бичигдсэн хүн бүрийн мэдүүлгийг яг өөрийнх нь хэлсэнчлэн тэмдэглэж авсан гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой

3) Видео бичлэг нь тухайн сэдэв болон зураг авалтын хүний нөхцөл байдалд тулгуурладаг. Энэ нь хүмүүсийн хөдөлгөөн, яриаг бичиж авдаг бөгөөд бичлэг хийгдэж буй хүний хөдөлгөөнийг байгаагаар нь хуулбарлах боломжтой тул бичлэгийн агуулгад ямар

⁸⁵ 전문법칙 관련 비디오테이프 등의 증거능력, <https://blog.naver.com/duckhee2979/220751969840>

нэгэн зохиомол нөлөө үзүүлээгүй гэж үзвэл анхны мэдүүлэг нь тухайн камерт бичигдэж буй хүний гадаад төрх, дуу хоолойг баталж, бичигддэг. Шүүх хуралдаанд бэлтгэгдэж байх үед видео бичлэгт бичигдсэн хүн бүрийн мэдүүлэг яг хэлсэнчлэн бичигдсэн болохыг гэрчлэгч нарын мэдүүлгээр хүлээн зөвшөөрсөн бол видео бичлэгийг нотлох баримт гэж үзнэ⁸⁶.

БНСУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын хувьд шүүх хуралдаан хүртэлх болон нийтлэг нотлох баримт хадгалах журмын дагуу хадгалдаг байна.

Шүүх хуралдаан хүртэл нотлох баримт хадгалах зохицуулалтыг Эрүүгийн процессын хуулийн 15 дугаар бүлгийн 184, 185 дугаар зүйлээр зохицуулдаг байна. Харин нийтлэг нотлох баримт хадгалах журмыг Прокурорын ерөнхий газраас баталсан Хэргийн бүртгэлийг хадгалах журмаар зохицуулдаг байна.

Шүүх хуралдаан хүртэл нотлох баримт хадгалах зохицуулалтыг Эрүүгийн процессын хуулийн 184, 185 дугаар зүйлд зааснаар дараах байдлаар зохицуулж байна.

Энэ нь шүүх хуралдааны үеэр нотлох баримтыг шалгахыг хүлээж байх хугацаанд нотлох баримтыг ашиглахад хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд прокурор, шүүгдэгч (сэжигтэн), өмгөөлөгчийн хүсэлтээр шүүх хуралдаан болохоос өмнө түүнийг шалгах боломжийг олгодог тогтолцоог хэлнэ. Суурь журам нь бол нотлох баримтын шалгалтыг шүүх хурлын өдөр бүх процедурыг дуусгасны дараа хийдэг. Гэхдээ шүүх хурал болтол хүлээвэл нотлох баримтыг ашиглахад хүндрэлтэй байж болно. Тухайлбал, тодорхой хадгалах хугацаатай камерын бичлэгийн хувьд шүүх хурлын товыг хүлээвэл бичлэг алга болох тул шүүх хурлын тов гарахаас өмнө ч нотлох баримтыг шалгаж болно⁸⁷. Үүнийг нарийвчлан авч үзье.

184 дүгээр зүйл. Хүсэлт гаргах, нотлох баримтыг хадгалах журам

(1) Нотлох баримтыг урьдчилан хадгалахаас бусад тохиолдолд ашиглах боломжгүй нөхцөл байдал үүсвэл прокурор, эрүүгийн шүүгдэгч, эрүүгийн сэжигтэн, түүний өмгөөлөгч анхан шатны шүүх хурал болохоос өмнө мөрдөн шалгах, шалгах, гэрчээс байцаалт авах, шинжээчийн дүгнэлт зэргээр нотлох баримтыг хавсаргах арга хэмжээг авах хүсэлтийг гаргана.

(2) Өмнөх хэсэгт заасан хүсэлтийг хүлээн авсан шүүгч ийм хүсэлтийг шийдвэрлэх талаар шүүх эсвэл даргалагч шүүгчийн эрх мэдэлтэй адил эрх эдэлнэ.

(3) (1)-д дурдсан хүсэлтийг гаргахдаа тухайн хүн үндэслэлийн талаар таамагласан нотлох баримтыг бичгээр гаргаж өгнө.

(4) (1)-д заасан хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан шийдвэрийн эсрэг гомдлыг гурав хоногийн дотор гаргаж болно.

185 дугаар зүйл. Баримт бичгийг шалгах

⁸⁶ 성폭행피해아동의 진술녹화 비디오테이프의 증거능력, <https://www.lawtimes.co.kr/news/104776>

⁸⁷ 증거보전, <https://namu.wiki/w/%EC%A6%9D%EA%B1%B0%EB%B3%B4%EC%A0%84>

Прокурор, эрүүгийн яллагдагч, эрүүгийн сэжигтэн, өмгөөлөгч нь шүүгчийн зөвшөөрлөөр өмнөх зүйлд дурдсан захирамжийн талаарх баримт, нотлох баримтыг шалгаж, хуулбарлаж болно⁸⁸.

Харин нийтлэг нотлох баримт хадгалах журмыг Прокурорын ерөнхий газраас баталсан 2010 онд батлагдсан Хэргийн бүртгэлийг хадгалах журмаар зохицуулдаг байна⁸⁹. Тус журмын зорилго нь прокурорын байгууллагаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэг бүртгэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, бусад баримт бичгийн хадгалалт, зохицуулалттай холбоотой асуудлыг тогтоож, хадгалалтын үйл ажиллагааг хэвийн явуулахад хувь нэмэр оруулахад оршино. Тухайн журамд дараах нэр томъёог тайлбарласныг анхаарч үзэх нь зүйтэй байна.

- "Хэргийн бүртгэл" гэдэгт мөрдөн байцаалтын ажиллагаа, шүүх хурал, түүнтэй холбоотой баримт бичиг (баримт бичиг, холбогдох бусад баримт бичиг, эд зүйл, зураг, гэрэл зураг, диск, соронзон хальс, кино, слайд, видео бичлэг, цахим бичлэг гэх мэт тусгай мэдээллийн хэрэгслээр бүртгэгдсэн бичлэгүүд) хамаарна) гэж тодорхойлдог.
- "Видео бичлэг" гэж Эрүүгийн процессын хуулийн 221 дүгээр зүйл, 244 дүгээр зүйлийн 244-2-т заасны дагуу мөрдөн байцаалтын явцад сэжигтэн, сэжигтнээс бусад этгээдийн мөрдөн байцаалтын ажиллагааны явцыг дүрс бичлэгт буулгаж, хадгалсан бичлэгийг хэлнэ.
- "Хадгалалт" гэж хэргийн материал (өргөдөл, дотоод мөрдөн байцаалтын хэргийн бүртгэлийг оролцуулан) болон шүүхийн баримт бичгийг эдгээр журамд заасан хадгалах хугацааны дагуу зохион байгуулахыг хэлнэ.

Дараах зохицуулалтыг журамд нарийвчлан тодорхойлсон байна.

Хүснэгт 7. БНСУ-ын Хэргийн бүртгэлийг хадгалах журам

Шүүхийн баталгаажуулалтын бүртгэлийг хадгалах	<p>Хадгалах хугацаа: Шүүхийн шийдвэрээр ял оногдуулсан хэргийн материал нь ялын хөөн хэлэлцэх хугацаа дуустал хадгалагдана. Харин баривчлах, хөнгөн торгох ялтай бол 3 жил хэвээр хадгална.</p> <p>Процесс: Хадгалах ажилтан нь шүүхийн баталгаажуулалтын бүртгэлийн хавтасны баруун дээд хэсэгт бүртгэлийн ангиллын хүнийг хэвлэж, шийдвэрийн тэмдэглэлийн дагуу баталгаажуулсан огноо, дүгнэлтийн ангилал (шүүхийн баталгаажуулалтын үр дүн), бүртгэл хадгалах хугацаа, хадгалалтын эцсийн жилийг тэмдэглэнэ. Хадгалалтын асуудал эрхэлсэн ажилтан 1 дэх хэсэгт заасан баримт бичгүүдийг хадгалалтын төрөл, баталгаажсан жилээр нь ангилж, 1-р маягтын дагуу эрүүгийн хэргийн бүртгэлийн хавтас дээр тогтоосон мэдээллийг оруулж, хэд хэдэн бүртгэлийг нэг хадгалах хайрцагт цуглуулна. Тэдгээрийг ангилсны дараа чанарын дугаар олгож, тогтоосон мэдээллийг эрүүгийн хэргийн бүртгэл хадгалах дэвтэрт 2-р маягтаар оруулах ёстой.</p>
---	--

⁸⁸ CRIMINAL PROCEDURE ACT OF KOREAN [Enforcement Date 09. Dec, 2021.] [Act No.17572, 08. Dec, 2020., Partial Amendment], <https://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2§ion=lawNm&query=criminal+procedure&x=0&y=0#liBgcolor1>

⁸⁹ Prosecutor's Office Preservation Rules Partially revised 2021-01-01 Ministry of Justice Ordinance No. 993 amendment, <http://www.yeslaw.com/lms/front/page/fulltext.html?pAct=view&pLawId=2408#:~:text=%E2%91%A0%20%EC%A7%84%EC%A0%95%EC%82%AC%EA%B1%B4%EA%B8%B0%EB%A1%9D%EC%9D%80,%EC%9D%80%203%EB%85%84%EA%B0%84%20%EB%B3%B4%EC%A1%B4%ED%95%9C%EB%8B%A4>.

<p>Яллагдаагүй хэргийн бүртгэлийг хадгалах</p>	<p>Хадгалах хугацаа: Яллагдаагүй хэргийн бүртгэлийг хөөн хэлэлцэх хугацаа дуусах хүртэл хадгална. Харин 2 жил ба түүнээс доош хөөн хэлэлцэх хугацаатай хэрэгт холбогдсон яллах дүгнэлт үйлдээгүй хэргийн бүртгэлийг 3 жил, 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдсон яллах дүгнэлт үйлдээгүй, ахуйн болон олон улсын ач холбогдол, эсвэл прокурорын ажилд онцгой ач холбогдолтой байх нь хагас байнгын хадгалагдана.</p> <p>Процесс: Яллах дүгнэлт үйлдээгүй хэргийн бүртгэлээс яллах ажиллагааг түдгэлзүүлсэн хэргийн бүртгэлийг тусад нь хадгална. Хадгаламжийн ажилтан нь яллах дүгнэлт үйлдээгүй шийдвэрийн баруун дээд захад хадгалалтын эцсийн жил болон хадгалалтын хугацааг зааж өгөх ёстой. 9 дүгээр зүйлийн заалтыг яллагдаагүй хэргийн бүртгэлийг хадгалах журамд <i>mutatis mutandis</i> хэрэглэнэ.</p>
<p>Гомдол, дотоод хэргийн бүртгэлийг хадгалах</p>	<p>Хадгалах хугацаа: Гомдлын хэргийн бүртгэл гурван жилийн турш хадгалагдана. Дотоод хэргийн хэргийн бүртгэлийг хадгалах хугацаанд яллагдаагүй хэрэгтэй адил зохих ёсоор хамаарна.</p> <p>Процесс: Хэрэг эрхэлсэн ажилтан нь гомдол/дотоод хэргийн бүртгэлийн хавтасны баруун дээд хэсэгт тэмдэглэлийн хадгалалтын хугацаа болон хадгалалтын эцсийн жилийг бичнэ. 1 дэх хэсэгт заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх албаны ажилтан тэмдэглэлийг хадгалахдаа тэдгээрийг хадгалалтын төрөл, хадгалалт дууссан жилээр нь ангилж, эрүүгийн хэргийн бүртгэлийн хавсралтад заасан мэдээллийг хавсралтын маягт 1-д оруулж, олон хэргийг хадгална. Бүртгүүлсэн, хянан шийдвэрлэсэн дотоод хэргийн бүртгэлийг дотоод хэргийн хэлтсийн саналын баганад хэргийн ажилтан “Эрүүгийн хэргийн бүртгэлд хавсаргасан” гэж тэмдэглэнэ.</p>
<p>Видео бичлэгийг хадгалах</p>	<p>Хадгалах хугацаа: Хуулийн 244-2-т заасны дагуу прокурор видео бичлэгийг үүсгэсний дараа хадгалалтын ажилтанд нэн даруй хүлээлгэн өгнө. Прокурорын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 3, 4, 6 дахь хэсэгт заасны дагуу хэргийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хэргийн ажилтан аливаа видео бичлэгийг хадгалалтын ажилтанд нэн даруй хүлээлгэн өгөх ёстой. Хадгаламжийн ажилтнууд видео бичлэгийг 1, 2-т заасны дагуу хүлээн авахдаа хавсаргасан баримт бичгийн 3-2 дугаар маягт дахь видео бичлэгийн түр хадгалалтад заасан мэдээллийг оруулж, дараа нь жил бүр бүртгэнэ. Тэдгээрийг тоон дарааллаар зохион байгуулж, түр хадгална. Прокурор яллах, яллахгүй байх, хэргийг өөр шүүхэд шилжүүлэх шийдвэр гаргахдаа хавсаргасан Хүснэгт 2-ын хавсралтад байгаа “Видео бичлэг байна” гэсэн тамга дарж, хэргийн бүртгэлийн хавтасны баруун доод талд байгаа видео бичлэгийн тоог бичнэ. Прокурор яллах дүгнэлт үйлдээгүй хэргийг дахин нээх үед хадгалалтын ажилтан, хэрэв ямар нэгэн дүрс бичлэг байгаа бол түүний шалтгааныг дүрс бичлэгийн хадгалалтын албаны тайлбар багананд бичиж, 3 дахь хэсэгт заасны дагуу түр хадгалах ёстой.</p> <p>Процесс: Яллахгүй байх, шүүх хуралдааныг явуулахгүй байх тухай шийдвэр батлагдсан тохиолдолд хамгаалалтын ажилтан нь бичлэгийг битүүмжлэн, холбогдох тэмдэглэлийг хадгална. Хамгаалалтын ажилтан нь видео бичлэгийг битүүмжилсэн дугуйны баруун дээд захад хадгалалтын хугацаа болон эцсийн оныг бичих ёстой. Видео бичлэгийг хадгалахдаа хадгалалтын ажилчид хадгалалтын төрөл, хадгалалтын эцсийн жилээр нь ангилж, 3-3 дугаар маягтын видео бичлэгийн хадгалалтын шошгон дээр заасан мэдээллийг бичиж, нэг хадгалах хайрцагт олон видео бичлэг хийнэ. Чанарыг ангилсны дараа чанарын дугаар өгч, тогтоосон мэдээллийг 2-р маягтын эрүүгийн хэргийн бүртгэл хадгалах тасгийн видео бичлэгийн хэсэгт оруулна. Жилд хадгалагдах видео бичлэгийн хэмжээ бага, 3-р зүйлд заасны дагуу чанарын ангилал, чанарын дугаар олгох нь тохиромжгүй бол тэдгээрийг орхиж, тусдаа хадгалах хайрцагт хадгалж болно.</p>

Шүүхийн шийдвэрийг хадгалах	<p>Хадгалах хугацаа: Шүүхийн баримт бичгүүдээс 1 дүгээр хавсралтад заасан шүүхийн баримт бичгийг үүрд, шүүхийн бусад баримтыг хэргийн хадгалах хугацааны дагуу хадгална.</p> <p>Процесс: Хадгалах ажилтан нь хавсралт 1-д бичсэн шүүхийн шийдвэрийг хэргийн бүртгэлээс гаргаж авах ёстой. Энэ тохиолдолд хэргийг тусад нь буюу нэгтгэж байгаа эсэхийг шалгаж, шийтгэх тогтоол нь батлагдсан шүүгдэгч нарын шүүх хуралдааны материалыг орхигдуулахгүй байхыг анхаарах шаардлагатай байна. Нэг хэрэгт олон яллагдагч байгаа тохиолдолд хорих ангийн ажилтан шүүгдэгч бүрийн ялыг баталгаажуулсан эсэхийг шалгадаг. Тусдаа шүүх хурал гэх мэт шалтгаанаар ял нь батлагдаагүй хүн байгаа тохиолдолд хадгалалтын асуудал эрхэлсэн ажилтан нь зөвхөн баталгаажуулсан шүүхийн эх хувийг гаргаж, үлдсэн тэмдэглэлийг бүртгэдэг. Хадгалах ажилтан нь эд хөрөнгийн шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэртэй холбогдуулан торгуулийн хэмжээг тохируулсан эсэхийг шалгана. Хамгаалах ажилтан нь шүүлтийн баримтын доод талд анхан шатны шүүхэд харьяалагдах прокурорын хэргийн дугаар, ялтны нэрсийн жагсаалтад байгаа хавтсын тоо, тоог бичнэ. Хадгалах ажилтан нь задлан авсан шүүхийн баримт бичгүүдийг төрлөөр нь ангилж, баталгаажуулсан огнооны дарааллаар эмхлэнэ. Олон шүүгдэгчтэй тохиолдолд шүүгдэгч тус бүрд ялын эцсийн хугацаа өөр өөр байвал эцсийн шийдвэр гарсан өдрөөр ялыг зохион байгуулна. Хадгалах асуудал эрхэлсэн ажилтан нь шийдвэр гарснаас хойш нэг жил өнгөрсөн шүүхийн шийдвэрийн баримт бичгийг жилд нэг удаа хавсаргаж, хавсралтын 4-р маягтын дагуу эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн баримт бичгийн жагсаалтад заасан мэдээллийг оруулна. Хадгалах асуудал эрхэлсэн ажилтан нь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн баримт бичгийн жагсаалтад тухайн хэргийн холбогдох шүүхийн баримт бичгийн хоорондын хамаарлыг тэмдэглэнэ. Хадгалах ажилтан нь задалсан туршилтын файлын хавтсанд серийн дугаар, баталгаажуулсан огноог жилээр нь бичиж, серийн дугаарын дарааллаар жилээр нь эмхэлж, хадгалах ёстой.</p>
-----------------------------	---

Дээрхээс дүгнэвэл, БНСУ-ын тухайд дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, шалгалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ерөнхий зохицуулдаг хэдий ч Ерөнхий прокурорын газраас гаргасан журмаар мөн нарийвчлан зохицуулж байна. Тодруулбал, Шүүхийн баталгаажуулалтын бүртгэлийг хадгалах, яллагдаагүй хэргийн бүртгэлийг хадгалах, гомдол, дотоод хэргийн бүртгэлийг хадгалах, видео бичлэгийг хадгалах, шүүхийн шийдвэрийг хадгалах гэж нарийвчилсан ангиллыг тогтоож өгсөн байна. Мөн түүнчлэн хэргийн төрлөөс хамааруулан баримт бичгийг жилээр, цаашлаад хөөн хэлэлцэх хугацаагаар тогтоон хадгалдаг байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Тус судалгааны хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хавтаст хэрэг, нотлох баримт, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийсэн ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай, тасралтгүй, найдвартай, ил тод байлгах зорилгын үүднээс цахимжуулах, түүний найдвартай байдлыг хангах хүрээнд нөхцөл байдал, хэрэгжилтийн үр дагаврыг үнэллээ. Ийнхүү үнэлэхдээ Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн нөхцөл байдлыг тодорхойлж сөрөг үр дагавар болон сайжруулах хэрэгцээ, шаардлагыг мөн авч үзсэн юм. Түүнчлэн гадаадын сайн туршлага бүхий улс, орнууд болох Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Эстони Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Америкийн нэгдсэн улсын эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн талаар судалж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалтыг сайжруулах арга замыг судаллаа. Тус судалгааны хүрээнд дараах дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэрэг

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.11 дүгээр зүйл буюу хавтаст хэргийн зохицуулалтад цахим хавтаст хэргийн талаар тусгаагүй байна. Гэвч Улсын Их Хурал, Засгийн газар, Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Улсын Ерөнхий Прокурор зэрэг байгууллагаас гаргсан бодлогын баримт бичиг, дүрэм, журамд цахимжуулах талаар олон зохицуулалт, үйл ажиллагааг тусгасан байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хавтаст хэргийг цахим болгосноор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шуурхай, тасралтгүй, найдвартай, ил тод байх ач холбогдолтой. Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас мөрдөгч нотлох баримт цуглуулж, хавтаст хэрэг бүрдүүлдэгээрээ ялгаатай болохын хувьд шүүхийн цахимжилтад цагдаагийн байгууллага, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цахимжилт чухал үр нөлөөтэй. Сүүлийн үеүүдэд цахим хавтаст хэргийн талаар буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь баримт бичгийн цахимжилт, шүүхийн цахимжилтийн талаар хэлэлцүүлэг ихээхэн хийгдэж байгаа нь түүнийг бий болгох хэрэгцээ, шаардлага байгааг харуулж байна.

Монгол Улсын хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим хавтаст хэргийн талаар тусгахдаа ХБНГУ-тай адилаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн зохицуулалтыг захиргааны процесс, иргэний процессын дараа нь зохицуулж байгаа тул ХБНГУ-ын сайн жишгийг баримтлах нь зүйтэй байна. Тодруулбал, цахим хавтаст хэргийн удирдлага, түүнтэй холбоотой хуульд заасан арга хэмжээ, прокурорын байгууллагууд болон шүүхүүдийн цахим харилцаа холбоо, прокурорын байгууллага, шүүхийн ашиглаж буй цахим баримт бичгийг бүрдүүлэх, дамжуулах; хуульд заасан арга хэмжээ, цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувь хүний мэдээллийг ашиглах гэх мэт боловсронгуй зохицуулалтын агуулга, зарчмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн тусгах шаардлагатай.

Бүгд Найрамдах Эстони Улс нь цахим хавтаст хэргийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд чухалчилж авч үздэг болох нь тодорхойлогдсон. Тус улс нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульдаа энэ тухай хуульчилж гэрэл зураг, шүүх

хуралдааны бичлэг, тэмдэглэлийг шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг шүүх хуралдаанд бэлэн болгох, цахим хавтаст хэргийн ерөнхий зохицуулалт, цахим баримт бичгийг дамжуулах, бичгээр зарлан дуудах хуудас хүргэх журам, цахим хавтаст хэргийг боловсруулах мэдээллийн системийн талаар нарийвчлан авч үзсэн нь сайн жишиг болохоор байна. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим хавтаст хэргийн зохицуулалтыг тусгахдаа тус улсын жишгийг харгалзан үзэх нь зүйтэй.

АНУ-ын хэмжээнд шүүхэд цахим мэдүүлэг гаргах, цахим хавтаст хэрэг бүрдүүлэх нь жишиг болж байна. Одоогоор 41 мужид зөвшөөрөгдсөн бөгөөд үлдсэн ихэнх мужид хэрэгжих төлөвтэй байна. Тус шинэчлэлт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хөнгөвчилж, хэргийн оролцогч, өмгөөлөгчдөд бий болох саад бэрхшээлийг арилгах үр дүнтэй өөрчлөлт болсон байна. Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн боловсруулалтыг техник технологи талаас нь боловсронгуй болгосон ба үүнийг ашиглахад ямар нэг төлбөр хураамж авдаггүй нь сайн жишиг болж байна.

БНСУ-ын тухайд 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн БНСУ-ын парламентын чуулганы нэгдсэн хуралдаанаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хуулийг баталж нарийвчилсан хуулиар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хавтаст хэргийг зохицуулж байгаа нь сайн жишиг бүхий боловсронгуй зохицуулалт болж байна. Тус хуульд "цахим хавтаст хэрэг", "цахимжуулсан хавтаст хэрэг" гэх нэр томъёог нарийвчлан тодорхойлсноос гадна эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим баримт бичгээр гүйцэтгэх, компьютержсэн мэдээлэл боловсруулах системийг ажиллуулах, цахим баримт бичгийг хүлээн авах, цахим баримт бичгийг бэлтгэх, цахим баримт бичгийг үзэх, хуулбарлах, цахим баримт бичгийг устгах гэх мэт зохицуулалтыг тусгасан байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим хавтаст хэргийн зохицуулалтыг тусгахдаа дээрх зохицуулалтын агуулгыг тусгах талаар авч үзэх хэрэгтэй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримт

Монгол Улсад иргэн, захиргааны хэрэгт цахим баримтыг нотолгооны хэрэгсэлд хамааруулан авч үзэхээр хуульд тодорхойлон заасан нь цахим нотлох баримтыг цаасан суурьтай нотлох баримттай ижил түвшинд үнэлэх боломжийг бүрдүүлсэн гэж дүгнэж болохоор байгаа. Хэдийгээр одоогоор практикт тус цахим нотлох баримтын үр нөлөө цаасан суурьтай нотлох баримттай харьцуулахад бага байгаа боловч хуульд тусгагдсан учир цаашид цахим нотлох баримт цаасан суурьтай нотлох баримттай адил үнэлэгдэх боломж бүрдэж эхэлсэн гэж үзэж болохоор юм. Мөн цахим орчинд үйлдэгдэж буй гэмт халдлагын талаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх цахим нотлох баримтын хэрэглээ нэмэгдэж байна. Практикт хэрэгт ач холбогдол бүхий цахим, аналог, дижитал (тоон) баримтуудыг хамтад нь "цахим баримт" гэж нэрлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нийтлэг байдлаар хэрэглэж байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.1 дүгээр зүйлд "цахим нотлох баримт"-ыг хуульчлан зохицуулах хэрэгцээ, шаардлага бий болоод байна.

Олон улсын гэрээ, конвенцийн тухайд Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтыг бий болгох, хадгалах журам, Эрүүгийн хэрэг хянан

шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт цуглуулах үүрэг бүхий байгууллагыг үүсгэн байгуулах, түүний хууль ёсны төлөөлөгчдийг томилох зохицуулалтыг ижилтгэх удирдамж, Кибер гэмт хэргийн тухай Будапештийн конвенц, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц ба түүнд заасан протоколууд, Истанбулын протокол (Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг гутаан харьцах, шийтгэхийг үр дүнтэй мөрдөн шалгах, баримтжуулах гарын авлага) зэрэг олон улсын гэрээ, конвенцид “цахим нотлох баримт”-ыг зохицуулж ач холбогдол, агуулгыг нь тодорхойлсон байна.

ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим нотлох баримтыг тусгайлан тодорхойлж зохицуулаагүй ч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримтыг ашиглах, үнэлэхийг хориглосон аливаа хязгаарлалт байхгүй буюу хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд ЭХХША-нд ашиглах боломжтой байна. Нарийвчилсан зохицуулалтын тухайд “Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтыг бий болгох, хадгалах журам”-ыг дагаж мөрддөг байна.

Бүгд Найрамдах Эстони Улсын тухайд нотлох баримтын төрлийг ерөнхийд нь тодорхойлсон тул энэхүү заалтыг үндэслэн цахим хэлбэрийн нотлох баримтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах боломжтой байна. Үүний зэрэгцээ, Эстонийн хууль эрх зүйн орчинд цахим (дижитал) нотлох баримтын талаар тусгай журам, тодорхой заалтууд зайлшгүй шаардлагатай байгаа тухай хэлэлцүүлэг хэсэг хугацаанд явагдсан байна. Цахим мэдээлэл нь олон эрүүгийн хэрэгт нотлох баримт болж, ийм нотлох баримтын ач холбогдол улам бүр нэмэгдсээр байгааг олж тогтоосон бөгөөд Хуульчдын холбооноос цахим (дижитал) нотлох баримтыг олж авах, түүнийг ЭХХША-нд ашиглах асуудлыг уламжлалт нотлох баримтаас тусад нь зохицуулах нь зүйтэй гэж үзсэн байна.

АНУ-д цахим нотлох баримтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах нь түгээмэл болох нь харагдаж байна. Мөн “цахим нотлох баримт” гэдгийг тодорхойлж өгснөөс гадна үзлэг нэгжлэг хийх, баримтжуулах үйл ажиллагааг Wiretap Act (18 U.S.C. §2510 et seq.); the Pen Registers and Trap and Trace Device Statute (18 U.S.C. §3121 et seq.); Цахим харилцааны нууцлалын тухай хууль (ECPA) (18 U.S.C. §2701 гэх мэт); болон Нууцлалыг хамгаалах тухай хууль (PPA) (42 U.S.C. §2000aa ба бусад) гэх хуулиудаар нарийвчлан зохицуулсан нь боловсронгуй зохицуулалт болжээ. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим нотлох баримтыг тусгахдаа дээрх боловсронгуй зохицуулалтыг жишиг болгон авч үзэх нь зүйтэй.

БНСУ-ын тухайд цахим нотлох баримтыг ангилан тодорхойлдог нь сайн жишиг бүхий зохицуулалт байх ба Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нотлох баримттай холбоотой нийтлэг зохицуулалтуудад цахим нотлох баримтыг хамааруулж уялдуулан хуулийг хэрэглэдэг сайн туршлагатай байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим нотлох баримтын талаар тусгахдаа түүний ангилал болон хууль хэрэглээний талаар сайн жишгийг авч үзэх нь зүйтэй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалт

Практикт шүүхийн шийдвэрээр тухайн хэрэгт хураагдан ирсэн эд мөрийн баримтыг цаашид хадгалах эсэхийг хэрхэн шийдвэрлэснээс хамаарч нотлох баримтыг хадгалах эсхүл устгах арга хэмжээг авдаг. Цахим нотлох баримтын хувьд практикт ихэвчлэн CD дээр хуулбарлан хавтаст хэрэгт хавсаргадаг бөгөөд энэ нь тухайн хавтас хэргийг хадгалах хугацаатай ижил хугацаанд хадгалагдаж байна. Хавтаст хэргийн хадгалалт буюу дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалал талаар Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны 5 сарын 20-ны өдрийн А/69 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүгийн хэрэгт хөрөнгө, орлого, эд мөрийн баримт, эд зүйлийг хураан авах, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, шийдвэрлэх журам”, 2019 оны 12 сарын 5-ны өдрийн Дугаар 246, А/80 Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан захирамж, тушаалын нэгдүгээр хавсралтаар “Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”, хоёрдугаар хавсралтаар “Хавтаст хэргийг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх журам”, Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2022 оны 4 сарын 15-ны өдөр дугаар А/42 тушаалын нэгдүгээр хавсралтаар “Эрүүгийн хэргийн тусгай, салбар архивт баримт хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх, хадгалах, ашиглуулах журам”, хоёрдугаар хавсралтаар “Архивт хөтлөгдөх тоо бүртгэлийн баримт бичиг, мэдээний жагсаалт, загвар”, 2022 оны 1 сарын 6-ны өдрийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоолоор батлагдан “Шүүхийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх журам” гэх журмууд хүчин төгөлдөр үйлчилж байна. Иймд эдгээр зохицуулалтыг нэг мөр болгон хуульчилж дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын талаар тогтсон зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

Хувийн мэдээллийг автоматаар боловсруулахтай холбоотой хувь хүнийг хамгаалах тухай Европын зөвлөлийн конвенцийн 5 дугаар зүйлийн е хэсэгт агуулгыг таних боломжтой хэлбэрээр хадгалагдсан өгөгдлийг тухайн өгөгдлийг хадгалах зорилгод шаардагдах хугацаанаас илүүгээр хадгалж болохгүй талаар зохицуулсан байна.

ХБНГУ-ын тухайд дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийг цахим нотлох баримтад хамааруулан зохицуулж, хадгалалт, хамгаалалтын асуудлыг ерөнхий журмаар зохицуулдаг байна. Нарийвчилсан журмын тухайд нотлох баримтаар авагдаагүй эх баримт бичгийг хадгалах журмыг нарийвчлан зохицуулжээ.

Бүгд Найрамдах Эстони Улсад ЭХХША-ны явцад бэхжүүлж авсан болон цахим хавтаст хэрэгт авагдсан аливаа дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг цахим хэлбэрээр цахим хавтаст хэргийн системд болон биет байдлаар эд мөрийн баримт хадгалах тусгай зориулалт бүхий эрх бүхий байгууллагын байранд нийтлэг журмын дагуу хадгалдаг байна.

БНСУ-ын тухайд дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, шалгалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ерөнхий зохицуулдаг хэдий ч Ерөнхий прокурорын газраас гаргасан журмаар мөн нарийвчлан зохицуулж байна. Тодруулбал, Шүүхийн баталгаажуулалтын бүртгэлийг хадгалах, яллагдаагүй хэргийн бүртгэлийг хадгалах, гомдол, дотоод хэргийн бүртгэлийг хадгалах, видео бичлэгийг хадгалах, шүүхийн шийдвэрийг хадгалах гэж нарийвчилсан ангиллыг тогтоож өгсөн байна. Мөн түүнчлэн хэргийн төрлөөс хамааруулан баримт бичгийг жилээр, цаашлаад хөөн хэлэлцэх хугацаагаар тогтоон хадгалдаг байна.

Иймд дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын талаар зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгахдаа хадгалах зорилгод шаардагдах хугацаанаас илүүгээр хадгалж болохгүй талаар зохицуулахаас гадна дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалтыг тусад нь авч үзэн хэргийн төрлөөс хамааруулан баримт бичгийг жилээр, цаашлаад хөөн хэлэлцэх хугацаагаар тогтоон хадгалдаг жишгийг анхаарах нь зүйтэй.

ТАВ. СУДАЛГААНЫ ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж

Монгол хэлээр:

1. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992, №1;
2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2020, №29;
3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №9;
4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №8;
5. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2021, №5;
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №23;
7. Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
8. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
9. Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 5 сарын 18-ны өдрийн А/24 тушаалаар баталсан “Цахим үндэстэн” баримтлах чиглэл (2022-2027);
10. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 332 дугаар тогтоол;
11. 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол, Дугаар 31, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар;
12. 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн УДШ-ийн Ерөнхий шүүгч, ХЗДХ-ийн Сайд, УЕП-ын хамтарсан Дугаар А/18, 34, А/31 “Заавар батлах тухай”;
13. 2019 оны 12 сарын 5-ны өдрийн Дугаар 246, А/80 Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан захирамж, тушаал;
14. 2022 оны 1 сарын 6-ны өдрийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоол Дугаар 1 “Журам батлах тухай”
15. Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны 5 сарын 20-ны өдрийн А/69 дугаар тушаал;
16. Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2022 оны 4 сарын 15-ны өдөр дугаар А/42 тушаал
17. 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол, Дугаар 31, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар

Гадаад хэлээр:

1. Шүүх байгууллагын цахим үйл ажиллагааг дэмжих тухай хууль (Gesetz zur Förderung des elektronischen Rechtsverkehrs mit den Gerichten, 2013)
2. Gesetzentwurf der Bundesregierung BT-Drucksache 17/12634 vom 6. März 2013, S. 3 ff, Verfügbar um <https://dserver.bundestag.de/btd/17/126/1712634.pdf>
3. ХБНГУ-ын Шүүхийн үйл ажиллагаанд цахим хавтаст хэргийг нэвтрүүлэх, цаашид цахим хууль зүйн үйл ажиллагааг дэмжих тухай хууль (Gesetz zur Einführung der

- elektronischen Akte in der Justiz und zur weiteren Förderung des elektronischen Rechtsverkehrs, 2017).
4. Beschlussempfehlung und Bericht des Ausschusses für Recht und Verbraucherschutz (6. Ausschuss) zu dem Gesetzentwurf der Bundesregierung, Deutscher Bundestag, Drucksache 18/12203, Wahlperiode 28.04.2017. Verfügbar um <https://dserver.bundestag.de/btd/18/122/1812203.pdf>
 5. ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Strafprozeßordnung – StPO, 1987)
 6. БНЭСУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Kriminaalmenetluse seadustik, 2003) <https://www.riigiteataja.ee/akt/104102013004>
 7. Framework act on electronic documents and transactions of Korea, https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=27334&type=part&key=28
 8. Framework act on electronic documents and transactions of Korea, https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=27334&type=part&key=28
 9. Act on the Use of Electronic Documents in Criminal Judicial Procedures [Enforced into force on October 20, 2024] [Law No. 18485, enacted on October 19, 2021], [https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EC%82%AC%EC%82%AC%EB%B2%95%EC%A0%88%EC%B0%A8%EC%97%90%EC%84%9C%EC%9D%98%EC%A0%84%EC%9E%90%EB%AC%B8%EC%84%9C%EC%9D%B4%EC%9A%A9%EB%93%B1%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2%95%EB%A5%A0/\(18485,20211019\)](https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EC%82%AC%EC%82%AC%EB%B2%95%EC%A0%88%EC%B0%A8%EC%97%90%EC%84%9C%EC%9D%98%EC%A0%84%EC%9E%90%EB%AC%B8%EC%84%9C%EC%9D%B4%EC%9A%A9%EB%93%B1%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2%95%EB%A5%A0/(18485,20211019))
 10. Regulation (EU) 2023/1543 of the European Parliament and of the Council of 12 July 2023 on European Production Orders and European Preservation Orders for electronic evidence in criminal proceedings and for the execution of custodial sentences following criminal proceedings, <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv%3AOJ.L.2023.191.01.0118.01.ENG>
 11. Directive (EU) 2023/1544 of the European Parliament and of the Council of 12 July 2023 laying down harmonised rules on the designation of designated establishments and the appointment of legal representatives for the purpose of gathering electronic evidence in criminal proceedings, <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv%3AOJ.L.2023.191.01.0181.01.ENG>
 12. Details of Treaty No.185, <https://www.coe.int/en/web/conventions/full-list?module=treaty-detail&treatynum=185>
 13. Convention on Cybercrime Budapest, 23.XI.2001, <https://rm.coe.int/1680081561>
 14. United Nations Convention against Transnational Organized Crime and the Protocols Thereto, <https://www.unodc.org/unodc/en/organized-crime/intro/UNTOC.html>
 15. Manual on the Effective Investigation and Documentation of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, https://www.ohchr.org/sites/default/files/documents/pub_lications/2022-06-29/Istanbul-Protocol_Rev2_EN.pdf
 16. Convention for the Protection of Individuals with regard to Automatic Processing of Personal Data Strasbourg, 28.I.1981, <https://rm.coe.int/1680078b37>
 17. Convention for the Protection of Individuals with regard to Automatic Processing of Personal Data Strasbourg, 28.I.1981, <https://rm.coe.int/1680078b37>

18. CRIMINAL PROCEDURE ACT OF KOREAN [Enforcement Date 09. Dec, 2021.] [Act No.17572, 08. Dec, 2020., Partial Amendment], <https://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2§ion=lawNm&query=criminal+procedure&x=0&y=0#liBgcolor1>
19. Prosecutor's Office Preservation Rules Partially revised 2021-01-01 Ministry of Justice Ordinance No. 993 amendment, <http://www.yeslaw.com/lms/front/page/fulltext.html?pAct=view&pLawId=2408#:~:text=%E2%91%A0%20%EC%A7%84%EC%A0%95%EC%82%AC%EA%B1%B4%EA%B8%B0%EB%A1%9D%EC%9D%80,%EC%9D%80%203%EB%85%84%EA%B0%84%20%EB%B3%B4%EC%A1%B4%ED%95%9C%EB%8B%A4>

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол хэлээр:

1. 2023 оны 3 сарын 23-24-ний өдөр зохион байгуулагдсан “Монгол Улсын Шүүхийн цахимжуулалт” ОУБХ-д ЦХХХ-ны дэд сайд Ж.Эрхэмбаатарын хэлэлцүүлсэн “Монгол Улсын шүүхийн болон хуулийн байгууллагуудыг цахимжуулах мэдээлэл технологийн үүрэг” сэдэвт илтгэл
2. ГХУСЗ, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном, УБ, 2022, 2023, 86 дахь тал.
3. 2023 оны 3 сарын 23-24-ний өдөр зохион байгуулагдсан “Монгол Улсын Шүүхийн цахимжуулалт” ОУБХ-д Н.Отгончимэгийн хэлэлцүүлсэн “Шүүхийн санхүүжилтийн механизмыг шинэчлэх шаардлага” сэдэвт илтгэл
4. Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын төсөлд хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ /Хөндлөнгийн судалгаа/, УБ, 2023
5. Л.Галбаатар, Кибер гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх нь, УБ, 2015
6. ННФ, Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа /Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд/, УБ, 2022
7. Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (Кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа, УБ., 2019
8. Монгол Улсад үйлдэгдэж байгаа кибер гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, түүнтэй тэмцэх арга зам, үндсэн чиглэл /Суурь судалгааны тайлан/, УБ, 2015
9. Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (Кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа, УБ, 2019
10. Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын төсөлд хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ /Хөндлөнгийн судалгаа/, УБ, 2023
11. Нотолгооны өнөөгийн практик, арга зүй, техник хэрэгсэл, анхаарах асуудал /Судалгааны тайлан/, ННФ, УБ., 2021

Гадаад хэлээр:

1. Manual on the Effective Investigation and Documentation of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, https://www.ohchr.org/sites/default/files/documents/publications/2022-06-29/Istanbul-Protocol_Rev2_EN.pdf

2. European Judicial Network, Fiches Belges on electronic evidence Germany. Available at <https://www.ejn-crimjust.europa.eu/ejnupload/DynamicPages/FB-EEGermany.pdf>
3. Эрик Хилгендорф, “Цахим нотлох баримт танилцуулга” сургалтын орчуулга, 2023.09.15
4. Eneli Lauritis, “Criminal procedure and digital evidence in Estonia”, Digital Evidence and Electronic Signature Law Review, 13 (2016)
5. Digital Evidence and the U.S. Criminal Justice System: Identifying Technology and Other Needs to More Effectively Acquire and Utilize Digital Evidence. Sean E. Goodison, Robert C. Davis, and Brian A. Jackson. <https://www.ojp.gov/pdffiles1/nij/grants/248770.pdf>

Цахим эх сурвалж

Монгол хэлээр:

1. Г.Даваадорж: Шүүхийн цахимжилтад хууль эрх зүйн орчин ус агаар мэт хэрэгтэй байна, https://www.judcouncil.mn/site/news_full/13818
2. Цахим орчин дахь гэмт хэргийн ул мөрийг баримтжуулж авах нь, <https://www.mnb.mn/i/92447>
3. М.Бямбасүрэн, Цахим баримт бичгийг нотлох баримтын хэмжээнд үнэлдэг байх шаардлагатай нийтлэл, 2024.01.29, <https://business.mn/2024/01/29/m-byambasuren-tсахим-баримт-бичгийг-нотлох-баримтын-хэмжээнд-үнэлдэг-байх-шаардлагатай-нийтлэл>
4. Ш.Мөнхжаргал, Л.Уянга, Б.Нямцэрэн нар, Нотлох баримт, түүнийг үнэлэхтэй холбоотой эрх зүйн эх сурвалжуудыг судалж бичсэн, асуудал дэвшүүлсэн өгүүлэл, <https://legaldata.mn/buteel/pdf?id=1761>
5. “Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”, “Хавтаст хэргийг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх журам” <http://old.supremecourt.mn/act/view/266>

Гадаад хэлээр:

1. Beschlussempfehlung und Bericht des Rechtsausschusses zu dem Gesetzentwurf der Bundesregierung Drucksache 17/12634 – vom 12. Juni 2013, Verfügbar um <https://dserver.bundestag.de/btd/17/139/1713948.pdf>
2. Verordnung über die elektronische Aktenführung in der Hamburger Justiz (HmbEAktFVO, 2019) Verfügbar um <https://www.landesrecht-hamburg.de/bsha/document/jlr-JElektAktfVHAV9Anlage1/partX>
3. Elektronische Akte in der Justiz, 2024.02.28, <https://justiz.hamburg.de/e-justice/elektronische-akte-in-der-justiz-zuletzt-besucht-2024.03.20>.
4. Factsheet E-Justice. Available at <https://e-estonia.com/wp-content/uploads/2020mar-facts-a4-v04-e-justice.pdf>
5. БНЭСУ-ын Шүүхийн мэдээлийн системийн, <https://www.rik.ee/en/international/court-information-system>
6. БНЭСУ-ын Шүүхийн олон нийттэй харилцах порталын вебийн <https://www.rik.ee/en/international/public-e-file>
7. Electronic Filing in Criminal Actions and Proceedings: A REPORT TO THE GOVERNOR, LEGISLATURE AND CHIEF JUDGE, page 10

- https://ww2.nycourts.gov/sites/default/files/document/files/2018-06/eFile_Criminal_Report%20April%2019.pdf
8. Electronic Filing (CM/ECF), <https://www.uscourts.gov/court-records/electronic-filing-cmecf>
 9. Electronic Filing in Criminal Actions and Proceedings: A REPORT TO THE GOVERNOR, LEGISLATURE AND CHIEF JUDGE, page 8
https://ww2.nycourts.gov/sites/default/files/document/files/2018-06/eFile_Criminal_Report%20April%2019.pdf
 10. 미리 보는 형사전자소송, https://help.scourt.go.kr/nm/min_9/min_9_9/index.html
 11. E-evidence - cross-border access to electronic evidence Improving cross-border access to electronic evidence, https://commission.europa.eu/law/cross-border-cases/judicial-cooperation/types-judicial-cooperation/e-evidence-cross-border-access-electronic-evidence_en
 12. European Judicial Network, Fiches Belges on electronic evidence Estonia. Available at <https://www.ejn-crimjust.europa.eu/ejnupload/DynamicPages/EE%20electronic%20evidence%20fb.pdf>
 13. 형사절차상 digital evidence에 관한 연구 - 압수, 수색을 중심으로 - Digital Evidence in Criminal Procedure, pp.21, https://www.kicj.re.kr/boardDownload.es?bid=0001&list_no=9714&seq=1
 14. 형사절차상 digital evidence에 관한 연구 - 압수, 수색을 중심으로 - Digital Evidence in Criminal Procedure, pp.21, https://www.kicj.re.kr/boardDownload.es?bid=0001&list_no=9714&seq=1
 15. 전문법칙 관련 비디오테이프 등의 증거능력, <https://blog.naver.com/duckhee2979/220751969840>
 16. 성폭행피해아동의 진술녹화 비디오테이프의 증거능력, <https://www.lawtimes.co.kr/news/104776>
 17. 증거보전, <https://namu.wiki/w/%EC%A6%9D%EA%B1%B0%EB%B3%B4%EC%A0%84>

ХАВСРАЛТ. ХБНГУ-ын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн цахим хавтаст хэргийн зохицуулалт (албан бус орчуулга)

**ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
(Strafprozeßordnung – StPO)**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Гарчиг 4

**Хавтаст хэргийн удирдлага ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь харилцаа
холбоо**

32-р хэсэг

**Цахим хавтаст хэргийн удирдлага, түүнтэй холбоотой хуульд заасан арга хэмжээ
авах бүрэн эрх**

- (1) Хавтаст хэргийг цахим хэлбэрээр (цахим хэлбэрт шилжүүлэн) хадгалж болно. Холбооны болон муж улсын (орон нутгийн) засгийн газар тус бүр өөрийн харьяалах нутаг дэвсгэртээ хавтаст хэргийн цахимаар хадгалагдах хугацааг хуульд заасан арга хэрэгслээр тогтооно. Засгийн газрууд нь цахим хавтаст хэргийн удирдлагыг зарим бие даасан шүүх, прокурорын байгууллага, ерөнхий тодорхойлсон процесс ажиллагаанд нэвтрүүлэхийг хязгаарлах, цаасан хэлбэрээр хадгалагдаж байсан хавтаст хэрэгт цахим хэлбэрийг нэвтрүүлсэн ч үргэлжүүлэн цаасан хэлбэрээр хадгалах зэрэг хязгаарлалт хийнэ. Ийм хязгаарлалт хийж байгаа тохиолдолд олон нийтэд ямар мэдэгдэл илгээх, ямар процесс ажиллагаанд ямар материалыг цахим хэлбэрээр хадгалах зэргийг хуульд нийцүүлэн гаргасан захиргааны журам батлан зохицуулж болно. Уг журам боловсруулах, тогтоох, мөрдүүлэх бүрэн эрхийг хуульд заасан арга хэрэгслээр (хуульд нийцүүлэн) эрх бүхий холбооны эсхүл муж улсын (орон нутгийн) яамдад шилжүүлж болно.
- (2) Холбооны засгийн газар болон муж улсын (орон нутгийн) засгийн газар тус бүр өөрийн харьяалах нутаг дэвсгэртээ холбогдох хууль тогтоомжийн мэдээллийн хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдал, мөрдлөг болгох хүртээмжтэй байдлын шаардлагууд зэргийг багтаасан орчинса үеийн дэвшилтэт байдал, байгууллагын болон техникийн үзүүлэлтийг хангасан цахим хавтаст хэргийн удирдлагыг батлан дагж мөрдүүлнэ. Уг эрхээ холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий холбооны эсхүл муж улсын (орон нутгийн) яамдад шилжүүлж болно.
- (3) Холбооны засгийн газар хуульд заасны дагуу Бундесратаас шаардлагатай зөвшөөрлийг авсаны үндсэн дээр прокурорын байгууллага болон шүүхийн хооронд цахим хавтаст хэрэг дамжуулахад мөрдөх стандартыг батлана. Энэ нь Бундесратын зөвшөөрөл авах шаардлагагүй хуульд заасан арга хэрэгсэл байвал энэ бүрэн эрхийг холбооны эрх бүхий яамдад шилжүүлнэ.

Хэсэг 32а

**Прокурорын байгууллагууд болон шүүхүүдийн цахим харилцаа хобоо;
хуульд заасан арга хэмжээ авах бүрэн эрх**

- (1) Прокурорын байгууллага, шүүхүүд нь цахим баримт бичгийг дараах дэд зүйлд заасны дагуу гаргаж болно.
- (2) Цахим баримт бичиг нь прокурорын байгууллага эсвэл шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэхэд тохиромжтой байх ёстой. Холбооны засгийн газар Бундесратаас хуульд заасан шаардлагатай зөвшөөрлийг авсаны үндсэн дээр цахим баримт бичгийг дамжуулах техникийн үзүүлэлтүүд, тэдгээрийг прокурорын байгууллага болон шүүхүүдийн хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэхэд тохиромжтой байдал зэргийг тогтооно.
- (3) Баримт бичгийг цахим хэлбэрээр хадгалахад тэдгээрийг хариуцах этгээдийн мэргэжлийн цахим гарын үсэгтэй эсхүл хариуцах этгээдийн гарын үүсгээ зурж дамжуулах аюулгүй аргаар ирүүлсэн бичмэл хувь байх шаардлагатай.
- (4) 'Дамжуулах аюулгүй арга' гэдэг нь
 1. De-Mail бүртгэлтэй холбогдсон шуудангийн хайрцаг болон шуудангийн үйлчилгээ бол илгээгч нь шуудангийн тухай хуулийн (De-Mail-Gesetz) 4 (1) хэсгийн 2-т заасны дагуу шууданг илгээх үед аюулгүй нэвтрэлт хийсэн бол шуудангийн тухай хуулийн 5 (5) дахь хэсэгт заасны дагуу аюулгүй нэвтэрсэн эсэхээ баталгаажуулсан,
 2. Холбооны хуульчдын тухай хуулийн (Bundesrechtsanwaltsordnung) 31a, 31b хэсэгт заасан хууль зүйн тусгай шуудан эсхүл хуулийн дагуу байгуулагдсан цахим шуудан болон эрх бүхий байгууллага, шүүх хоорондын цахим шуудангийн сүлжээгээр ,
 3. Эрх бүхий байгууллага болон шүүхийн цахим шууданг зохицуулах сүлжээгээр баталгаажуулсан эрх бүхий байгууллага болон нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн хоорондын шуудан дамжуулах аргаар,
 4. Эрх бүхий байгууллага, шүүхийн цахим шуудангийн сүлжээгээр баталгаажуулах ажиллагаа хийсний үндсэн дээр байгуулагдсан хувь хүн, хуулийн этгээд болон бусад этгээд хоорондын цахим шуудан амжуулах аргаар,
 5. Онлайн хандалтын тухай хуулийн (Onlinezugangsgesetz) 2(5)-д заасны дагуу хэрэглэгчийн бүртгэл болон эрх бүхий байгууллага эсвэл шүүхийн цахим шуудангийн сүлжээнд холбогдсон, баталгаажуулах ажиллагаа хийж баталгаажуулсаны үндсэн дээр байгуулагдсан шуудангийн хаяг болон шуудангийн үйлчилгээ хооронд дамжуулах аргаар,
 6. Холбооны улсын хэмжээнд стандартчилагдсан, Бундесратаас зөвшөөрөл аван Холбооны Засгийн газраас гаргасан хууль тогтоомжоор тогтоосон мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдлыг баталгаажуулсан дамжуулах бусад аргууд.
- (5) Цахим баримт бичгийг эрх бүхий байгууллага, шүүх хүлээн авахаар заасан төхөөрөмжид хадгалмагц хүлээн авсанд тооцно. Илгээгч нь хүлээн авсан огноо, цагийг автоматаар баталгаажуулах болно.

- (6) Хэрэв илгээгдсэн баримт бичиг нь эрх бүхий байгууллага болон шүүх боловсруулах, ашиглагдах боломжгүй байвал энэ талаар илгээгчид нэн даруй мэдэгдэл илгээх ёстой бөгөөд баримт бичгийг хүлээн авах боломжгүй шалтгааныг мэдэгдэлд дурдана. Цахим баримт бичгийг илгээгч нь эрх бүхий байгууллага, шүүх боловсруулахад тохиромжтой хэлбэрээр нэн даруй дахин ирүүлсэн бөгөөд илгээгч нь анх ирүүлсэн баримт бичгийн агуулгатай дахин ирүүлсэн баримт бичгийн агуулга таарч байгааг хангалттай нотолсон тохиолдолд түүнийг өмнө нь ирүүлсэн өдөр, цагт хүлээн авсанд тооцно.

Хэсэг 32b

Прокурорын байгууллага, шүүхийн ашиглаж буй цахим баримт бичгийг бүрдүүлэх, дамжуулах; хуульд заасан арга хэмжээ авах эрх

- (1) Прокурорын байгууллага, шүүхээс ашигласан баримт бичгийг цахим баримт бичиг болгон бүрдүүлсэн бол уг баримт бичгийг хариуцаж буй бүх хүмүүс уг баримт бичигт нэрээ нэмж оруулах ёстой. Гарын үсэг зурах шаардлагатай баримт бичиг нь тэдгээрийг хариуцах бүх хүмүүсийн мэргэшсэн цахим гарын үсэгтэй байх ёстой.
- (2) Цахим баримт бичгийг түүнийг хариуцах эрх бүхий этгээд цахим хавтаст хэрэгт нэмсэн болон ийм этгээд хадгалуулсан даруйд уг хавтаст хэрэгт нэмэгдсэнд тооцно.
- (3) Хэрэв хавтаст хэргийг цахим хэлбэрээр хөтөлж байгаа бол прокурорын байгууллага болон шүүх нь журмын дагуу баримт бичгийг өөр хоорондоо цахим хэлбэрээр дамжуулна. Яллах дүгнэлт, үндсэн хуралдаанаас гадуур шийтгэл оногдуулах тухай хүсэлт, баримт болон хууль хэрэглээний асуудлаар давж заалдах гомдол, тайлбар, хариу тайлбар, шүүхийн аливаа шийдвэрүүд цахим хэлбэрээр бүрдүүлэгдсэн бол цахим хэлбэрээр дамжуулна. Техникийн шалтгаанаар үүнийг түр хугацаанд хийх боломжгүй бол цаасан хэлбэрээр дамжуулахыг зөвшөөрнө; хүсэлтийн дагуу цахим баримт бичгийг дараа нь ирүүлнэ.
- (4) Хуулбар болон баталгаат хуулбарыг цахим эсхүл цаасан хэлбэрээр гаргаж болно. Цахимаар баталгаажуулсан хуулбар нь хуулбарыг баталгаажуулсан хүний цахим гарын үсэгтэй байх ёстой. Мэргэшсэн цахим гарын үсэг бүхий цахим баримт бичгийг шилжүүлэх, эсвэл найдвартай дамжуулах замаар баталгаажуулсан хуулбарыг цаасан хэлбэрээр олгосон бол уг баримт бичгийг баталгаажуулсан тэмдэглэлд цахим баримт бичгийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг шалгасны үр дүнг тусгасан байх ёстой.
- (5) Холбооны засгийн газар хуульд заасны дагуу Бундесратаас шаардлагатай зөвшөөрлийг авсаны үндсэн дээр цахим баримт бичгийг бүрдүүлэх, түүнийг прокурорын байгууллага болон шүүх хооронд дамжуулахад хамаарах стандартыг тогтооно. Энэ нь Бундесратын зөвшөөрөл авах шаардлагагүй хуульд заасан арга хэрэгсэл байвал энэ бүрэн эрхийг холбооны эрх бүхий яамдад шилжүүлнэ.

Хэсэг 32c

Цахим хэлбэр; хуульд заасан арга хэмжээ авах эрх

Холбооны засгийн газар хуульд заасны дагуу Бундесратаас шаардлагатай зөвшөөрлийг авсаны үндсэн дээр цахим хэлбэрийг нэвтэрүүлж болно. Хуульд заасан арга хэрэгслээр маягтанд агуулагдах мэдээллийг бүтнээр эсхүл хэсэгчлэн, бүтцээр нь болон машинд уншигдахуйц хэлбэрээр дамжуулах зэрэг асуудлыг зохицуулж болно. Маягт нь хууль тогтоомжид заасан интернет харилцааны платформ дээр ашиглах боломжтой хэлбэрт байна. Хуулийн 32a(3) дахь хэсэгт

зааснаас бусад тохиолдолд иргэний үнэмлэхний тухай хуулийн (Personalausweisgesetz) 18-р зүйл, цахим иргэний үнэмлэхний тухай хуулийн 12-р хэсэг (eID-Karte-Gesetz), Оршин суух тухай хуулийн (Aufenthaltsgesetz) 78 (5) дахь хэсэгт заасны дагуу маягтын хэрэглэгч нь үнэмлэхээ цахим үнэмлэхээр гаргаж болно. Холбооны засгийн газар нь Бундесратын зөвшөөрөл авах шаардлагагүй хуульд заасан арга хэрэгсэл байвал энэ бүрэн эрхийг холбооны эрх бүхий яамдад шилжүүлнэ.

Хэсэг 32d

Цахим дамжуулалтын үүрэг

Хуульч, өмгөөлөгч нь бичгээр өгсөн тайлбар, түүний хавсралт, хүсэлт, мэдэгдэл зэрэг цахим баримт бичгийг холбогдох журамд заасны дагуу прокурорын байгууллага болон шүүхэд цахим хэлбэрээр гаргана. Хуульч, өмгөөлөгч нь баримт болон хууль хэрэглээтэй холбоотой давж заалдах гомдол, хууль зүйн үндэслэлтэй холбоотой давж заалдах гомдол, тэдгээрийн үндэслэл, хариу тайлбар, хувийн яллах ажиллагаа ба яллах ажиллагааны нэмэлт гомдолын мэдэгдэл зэргийг шүүхэд цахим хэлбэрт оруулан ирүүлнэ. Хэрэв техникийн шалтгаанаар үүнийг түр хугацаанд хийх боломжгүй бол цаасан хэлбэрээр ирүүлэхийг зөвшөөрнө. Ийнхүү шалтгаанаар баримт бичгийг цахим хэлбэрээр гаргах боломжгүй шалтгаанаар баримт бичгийг цаасан хэлбэрээр гаргахдаа тайлбар, хүсэлт гарган нотлох шаардлагатай бөгөөд уг хүсэлтийг үндэслэн цахим баримт бичгийг дараа нь нөхөн ирүүлнэ.

Хэсэг 32e

Хавтаст хэргийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор баримт бичгийг хувиргах (хөрвүүлэх)

- (1) Тухайн хавтаст хэргийг хадгалж буй хэлбэртэй (эх баримт бичигтэй) баримт бичиг нь тохирохгүй байвал тохирох хэлбэрт тус баримт бичгийг хөрвүүлж болно. Нотлох баримт болгон баталгаажуулсан эх баримт бичгийг зохих шаардлагатай хэлбэрт шилжүүлж болно.
- (2) Баримт бичгийг хөрвүүлэхдээ хөрвүүлсэн баримт бичиг нь харагдах байдал болон агуулгын хувьд эх баримт бичгийн агуулгатай тохирох байдлыг хангахуйц хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглана.
- (3) Цахим бус эх баримт бичгийг цахим баримт бичиг болгон хөрвүүлэхдээ хөрвүүлэхэд ямар процедур ашигласан, энэ нь эх баримт бичигтэй харагдах байдал болон агуулгатай тохирч байгаа зэргийг нотлох баримтыг хавсаргана. Прокурорын байгууллага болон шүүхэд хэрэглэгдэж байсан, хариуцах үүрэг бүхий этгээдийн гарын үсэг зурсан баримт бичгийг хөрвүүлэх тохиолдолд хөрвүүлэлтийг нотлох баримт нь прокурорын газар, шүүхийн бүртгэлийн ажилтны мэргэшсэн цахим гарын үсэгтэй байх ёстой. Мэргэшсэн цахим гарын үсэг бүхий эсхүл дамжуулах аюулгүй аргаар ирүүлсэн цахим эх баримт бичгийг уг баримт бичигт хийсэн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг шалгасан шалгалтын дүнгийн хаитаар хавтаст хэрэгт бичилт хийн оруулна.

- (4) Үргэлжилж буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтаар хадгалагдаагүй эх баримт бичгийг хөрвүүлснээс хойш дор хаяж зургаан сар хадгална. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссан, эсхүл хугацаа хэтэрсэн тохиолдолд нотлох баримтаар хадгалагдаагүй эх баримт бичгийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссанаас хойшхи хуанлийн хоёр дахь жилийг дуустал хадгалах боломжтой.
- (5) Нотлох баримтаар хадгалагдаагүй эх баримт бичгийг баталгаатай нотлох баримтад хамаарах нөхцөлөөр шалгаж болно. Хавтаст хэргийг шалгах эрх бүхий этгээд нь энэ төрлийн шалгалтыг хийх бүрэн эрхтэй.

Хэсэг 32f

Хавтаст хэргийн шалгалт (Танилцах буюу хандах эрх); хуульд заасан арга хэмжээ авах эрх

- (1) Цахим хавтаст хэрэгт хандах эрхийг хэргийн хяналт шалгалт гэдэг нь хавтаст хэргийн агуулгыг сэргээх эсхүл аюулгүй дамжуулах аргыг ашиглан хавтаст хэргийн агуулгыг дамжуулах замаар олгоно. Тусгай хүсэлтийн дагуу албан байранд хадгалагдаж буй цахим хавтаст хэрэгт хандах эрхийг олгож болно. Тодорхой шалтгаан буюу хүсэлт гаргагчийн ашиг сонирхол байгаа гэсэн үндэслэл бүхий хүсэлтийн дагуу хавтаст хэргийн хэвлэмэл хуулбарыг олгох эсхүл цахим хавтаст хэргийн агуулгыг агуулсан өгөгдөл зөөгчийг дамжуулна. Хэрэв 1 дүгээр өгүүлбэрт заасан журмаар хавтаст хэрэгт хандах (шалгахад) саад болж байгаа чухал шалтгаан бол 2, 3 дугаар өгүүлбэрт заасан журмаар хүсэлт гаргахгүйгээр шалгалтыг хийж болно.
- (2) Цаасан хэлбэрээр байгаа хавтаст хэрэгт хандах (хандах) эрхийг албаны байранд хадгалагдаж буй хавтаст хэргийг шалгах замаар олгоно. Хориглох чухал шалтгаан байхгүй бол хавтаст хэргийн агуулгыг сэргээх, аюулгүй дамжуулах аргыг ашиглан хавтаст хэргийн агуулгыг дамжуулах, хавтаст хэргийн хуулбарыг авч явах боломжтой болгох замаар хавтаст хэрэгт хандах эрхийг олгож болно. Өмгөөлөгч болон хуульчид нь хориглох онцгой шалтгаан байхгүй бол хүсэлт гарган өөрийн аж ахуйн нэгж, хувийн байрандаа хавтаст хэрэгтэй танилцах зорилгоох (шалгах) авч болно.
- (3) (1) ба (2)-т заасны дагуу хавтаст хэрэгт хандах эрх олгох хэлбэрийн талаархи шийдвэрийг давж заалдах боломжгүй.
- (4) Хавтаст хэргийг шалгах (танилцах зорилгоор хандах буюу нэвтрэх) үед нээлттэй байхад гуравдагч этгээд хавтаст хэргийн агуулгын талаарх мэдээлэл олж авах боломжгүй байлгахын тулд техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг авна. Хавтаст хэрэгт хандах эрх олгосон хүний нэрийг техникийн арга хэрэгслийг ашиглан нэвтэрсэн файлууд болон дамжуулсан цахим баримт бичигт орчин үеийн шаардлагад нийцүүлэн таних боломжтой болгоно.
- (5) Хавтаст хэрэгтэй танилцах эрх авсан этгээд нь (1) эсвэл (2) дэд хэсгийн дагуу өөрт нь хүлээлгэн өгсөн хавтаст хэрэг, баримт бичиг, цаасан хуулбар, хуулбарыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн олон нийтэд түгээх болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бусад зорилгоор гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно. Хавтаст хэрэгтэй танилцах эрх авсан этгээд нь (1) эсвэл (2) дахь дэд хэсэгт заасны дагуу олж авсан хувийн мэдээллээ зөвхөн хавтаст хэрэгт хандах зөвшөөрөл

олгосон зорилгоор ашиглаж болно. Хавтаст хэрэгт хандах эрх олгосон хүмүүс уг зорилгын хязгаарлалтыг.

- (6) Холбооны Засгийн газар Бундесратаас зөвшөөрөл авсны үндсэн дээр цахим хавтаст хэрэгт шалгахад (танилцах буюу хандах эрх олгоход) хамаарах стандартыг журмаар тогтооно. Бундесратаас зөвшөөрөл авалгүйгээр тус бүрэн эрхийг холбооны эрх бүхий яамдад хуулийн дагуу шилжүүлж болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН ХАМГААЛАЛТ БА ХЭРЭГЛЭЭ

Гарчиг 4

Цахим хавтаст хэрэг дэх хувийн мэдээллийг хамгаалах; цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувийн мэдээллийг ашиглах

496-р хэсэг

Цахим хавтаст хэрэг дэх хувийн мэдээллийг ашиглах

- (1) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай бол цахим хавтаст хэрэг эсхүл хавтаст хэргийн цахим хуулбар дахь хувийн мэдээллийг боловсруулах, ашиглахыг зөвшөөрнө.
- (2) Ийнхүү хувийн мэдээллийг ашиглахдаа,
1. Мэдээллийн хамгаалалт, мэдээлийн аюулгүй байдалын тусгай шаардлагыг хангахад шаардлагатай зохион байгуулалтын болон техникийн зохих арга хэмжээг авах, мөн
 2. Мэдээллийг (өгөгдлийг) зөв боловсруулах зарчмуудыг дагаж мөрдөх, тэр дундаа өгөгдлийг байнга бэлэн байлгах, мэдээлэл алдагдхаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.
- (3) Цахим хавтаст хэрэг болон хавтаст хэргийн цахим хуулбар гэдэгт энэ бүлгийн гарчиг 2 дахт хавтаст хэргийн систем хамаарахгүй.

497-р хэсэг

Мэдээллийг (өгөдөлийг) түүний хянах этгээдийн нэрийн өмнөөс боловсруулах

- (1) Төрийн байгууллага цахим хавтаст хэрэг хадгалагдаж буй мэдээлэл (өгөгдөл) боловсруулах төрөөрөмжид нэвтрэх болон нэвтрэх эрхийг хуульд заасны дагуу бодитоор болон дагнан хянаж байгаа бол хувийн хуулийн этгээдээр хуульд заасны дагуу цахим файлыг байнгын хадгалах үүрэг өгч болно.
- (2) Хэрэв үйлчлүүлэгч өмнө нь хувь хүний хувьд зөвшөөрсөн бол хувийн хуулийн этгээдийг цахим хавтаст хэргийг хуульд заасны дагуу байнгын хадгалахтай холбоотой туслан гүйцэтгэх харилцаанд орохыг зөвшөөрнө. Мэдээлэл боловсруулах төхөөрөмжид нэвтрэх, нэвтрэх эрхийг энэ хэсгийн (1)-т заасны дагуу туслан гүйцэтгэх гэрээгээр зохицуулсан тохиолдолд л зөвшөөрлийг олгоно.
- (3) Төрийн бус байгууллагын нэрийн өмнөөс мэдээлэл боловсруулдаг хувийн хуулийн этгээдийн мэдээлэл боловсруулдаг төхөөрөмжийг хураан авах, битүүмжлэхийг

хориглоно. Ийм төхөөрөмжийг хураан авах ажиллагааг хийхийн тулд төлөөлүүлэн мэдээлэл боловсруулах ажилаа гүйцэтгүүлж буй төрийн байгууллагын зөвшөөрлийг заавал авсан байна.

498-р хэсэг

Цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувь хүний мэдээллийг ашиглах

- (1) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд ашиглахыг зөвшөөрсөн эсхүл хуульд заасны дагуу гаргасан шийдвэрээр зөвшөөрсөн бол цахим хавтаст хэрэг эсхүл хавтаст хэргийн цахим хуулбараас гаргаж авсан хувийн мэдээллийг боловсруулах, ашиглахыг зөвшөөрнө.
- (2) Дан хавтаст хэрэг эсхүл түүний хуулбараас болон анх хувьчилсан хавтаст хэргийг ашиглан хийгээгүй тохиолдолд уг хуулийн 98с хэсэгт заасны дагуу хувийн мэдээллийг цахим хавтаст хэрэг эсхүл хавтаст хэргийн цахим хуулбартай автоматаар тохируулахыг хориглоно.

499-р хэсэг

Хавтаст хэргийн цахим хуулбарыг устгах

Хавтаст хэргийн цахим хуулбарыг шаардлагагүй болсон даруйд цаг алдалгүй устгана.